XVI.1.22	Сумын төвийн 0.4 кВТ-ын СИП шугамын шинэчлэл /Увс, Бөхмөрөн сум/	2020	2021	400.0	100.0
XVI.1.23	Сумын төвийн 0.4 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын өргөтгөл, шинэчлэлийн үргэлжлэл /Увс, Наранбулаг сум/	2020	2020	100.0	100.0
XVI.1.24	Сумын төвийн цахилгаан дамжуулах агаарын шугам /Ховд, Булган сум/	2020	2020	100.0	100.0
XVI.1.25	Эрчим хүчний хүчин чадлыг өргөтгөх, ухаалаг тарифт тоолуур нэвтрүүлэх /Баянхонгор, Баянхонгор сум, 2, 7 дугаар баг/	2020	2020	290.0	290.0
XVI.1.26	Эрчмийн 60 айлын орон сууцны инженерийн шугам сүлжээний үргэлжлэл /Хэнтий, Хэрлэн сум, 4 дүгээр баг/	2020	2021	800.0	300.0
XVI.4	IV. ТЭЗҮ			100.0	100.0
	<i>Шинэ</i>			<i>100.0</i>	<i>100.0</i>
XVI.4.1	Төвлөрсөн эрчим хүчний 10 кВТ шугам сүлжээг 35 кВТ-аар солих ажлын зураг төсөв /Дорнод, Дашбалбар сум/	2020	2020	100.0	100.0
XVII	ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД			240,445.6	117,806.1
XVII.1	I. Барилга байгууламж			213,251.4	91,800.1
	<i>Шилжих</i>			<i>183,683.7</i>	<i>81,705.1</i>
XVII.1.1	Ахмад настан, хүүхдийн эмнэлгийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2019	2020	7,000.0	4,000.0
XVII.1.2	Бүсийн оношилгоо эмчилгээний хүчилтөрөгчийн станц /Өвөрхангай, Арвайхээр сум/	2018	2020	870.7	370.7
XVII.1.3	Геронтологийн төвийн барилга, дэд бүтэц, 60 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	2011	2020	7,392.9	1,768.3
XVII.1.4	Дүүргийн эрүүл мэндийн төвийн амбулаторийн барилгын өргөтгөл /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 13 дугаар хороо, Хайлааст салбар/	2018	2020	10,000.0	5,000.0
XVII.1.5	Нийслэлийн ахмадын эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төвийн 3 дугаар амбулаторийн өргөтгөл, 150-200 ор /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2019	2020	5,800.0	2,800.0
XVII.1.6	Нэгдсэн эмнэлгийн амбулаторийн өргөтгөлийн барилга /Баянхонгор, Баянхонгор сум/	2019	2020	3,750.0	2,050.0
XVII.1.7	Нэгдсэн эмнэлгийн барилга, 100 ор /Баян-Өлгий, Өлгий сум/	2019	2021	17,364.9	6,252.9
XVII.1.8	Нэгдсэн эмнэлгийн барилга, 100 ор /Говьсүмбэр, Сүмбэр сум/	2018	2020	8,500.0	6,500.0
XVII.1.9	Нэгдсэн эмнэлгийн барилга, 100 ор /Дундговь, Сайнцагаан сум/	2019	2020	8,752.9	6,252.9
XVII.1.10	Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2018	2020	600.0	97.2
XVII.1.11	Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 12 дугаар хороо/	2019	2020	2,000.0	600.0
XVII.1.12	Өрхийн эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 16 дугаар хороо/	2019	2020	1,600.0	800.0

XVII.1.13	Сумын эрүүл мэндийн төв, боловсрол, соёлын байгууллагын ариун цэврийн байгууламж /Дорнод/	2019	2020	800.0	400.0
XVII.1.14	Сумын төвийн шинэчлэлт хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эмнэлэг, 100 ор /Дорноговь, Замын-Үүд сум/	2013	2020	6,356.0	1,200.0
XVII.1.15	Сүрьеэгийн эмнэлгийн барилга /Улаанбаатар/	2019	2021	10,000.0	7,070.0
XVII.1.16	Сэргээн засах төвийн барилга, 36 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 10 дугаар хороо/	2018	2020	4,000.0	3,500.0
XVII.1.17	Төрөх эмнэлэг, 50 ор /Дорноговь, Сайншанд сум/	2011	2020	8,274.8	2,350.0
XVII.1.18	Халдварт өвчин судлалын үндэсний төвийн III шатлалын лабораторийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2013	2020	20,000.0	3,822.7
XVII.1.19	Хүүхдийн эмнэлгийн барилга, 50 ор /Баян-Өлгий, Өлгий сум/	2018	2020	5,019.7	2,259.0
XVII.1.20	Хүүхдийн эмнэлгийн барилга, 50 ор /Өвөрхангай, Арвайхээр сум/	2019	2020	5,019.0	3,019.0
XVII.1.21	Хүүхдийн эмнэлгийн барилга, 50 ор /Увс, Улаангом сум/	2019	2020	5,019.6	3,019.6
XVII.1.22	Хүүхдийн эмнэлгийн барилга, 50 ор /Ховд, Жаргалант сум/	2018	2020	5,019.7	2,259.8
XVII.1.23	Эмнэлгийн барилга, 50 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 21 дүгээр хороо/	2019	2020	5,000.0	2,000.0
XVII.1.24	Эрүүл мэндийн төвийн барилга /Архангай, Хайрхан сум/	2019	2020	1,200.0	600.0
XVII.1.25	Эрүүл мэндийн төвийн барилга /Архангай, Эрдэнэмандал сум/	2019	2020	1,600.0	800.0
XVII.1.26	Эрүүл мэндийн төвийн барилга /Говь-Алтай, Төгрөг сум/	2019	2020	1,400.0	700.0
XVII.1.27	Эрүүл мэндийн төвийн барилга /Говь-Алтай, Халиун сум/	2019	2020	1,400.0	700.0
XVII.1.28	Эрүүл мэндийн төвийн барилга /Говь-Алтай, Цээл сум/	2013	2020	2,020.0	79.7
XVII.1.29	Эрүүл мэндийн төвийн барилга /Говь-Алтай, Шарга сум/	2019	2020	1,397.4	697.4
XVII.1.30	Эрүүл мэндийн төвийн барилга /Дорнод, Хэрлэн сум, 7 дугаар баг/	2019	2020	1,500.0	600.0
XVII.1.31	Эрүүл мэндийн төвийн барилга /Завхан, Алдархаан сум/	2019	2020	1,189.9	689.9
XVII.1.32	Эрүүл мэндийн төвийн барилга /Хөвсгөл, Бүрэнтогтох сум/	2014	2020	1,557.0	27.5
XVII.1.33	Эрүүл мэндийн төвийн барилга /Хөвсгөл, Галт сум/	2018	2020	450.0	189.3
XVII.1.34	Эрүүл мэндийн төвийн барилга /Хөвсгөл, Эрдэнэбулган сум/	2019	2020	1,800.0	800.0
XVII.1.35	Эрүүл мэндийн төвийн барилга, 10 ор /Сэлэнгэ, Мандал сум, Түнхэл тосгон/	2019	2020	1,200.0	550.0
XVII.1.36	Эрүүл мэндийн төвийн барилга, 10 ор /Сэлэнгэ, Хүдэр сум/	2019	2020	1,200.0	900.0
XVII.1.37	Эрүүл мэндийн төвийн барилга, 15 ор /Хөвсгөл, Цагаан-Уул сум/	2019	2020	1,400.0	700.0
XVII.1.38	Эрүүл мэндийн төвийн барилга, 20 ор /Хөвсгөл, Тосонцэнгэл сум/	2019	2020	1,800.0	900.0
XVII.1.39	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2018	2020	8,250.5	2,750.5
XVII.1.40	Эрүүл мэндийн төвийн их засвар, өргөтгөл /Баянхонгор, Баацагаан сум/	2019	2020	827.3	127.3
XVII.1.41	Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга /Баянхонгор, Жинст сум/	2019	2020	826.7	426.7
XVII.1.42	Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга /Баянхонгор, Өлзийт сум/	2019	2020	824.7	424.7
XVII.1.43	Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга /Улаанбаатар, Багануур дүүрэг/	2019	2020	2,400.0	1,000.0
XVII.1.44	Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга, 10 ор /Дундговь, Хулд сум/	2019	2020	1,300.0	650.0
	Шинэ			29,567.7	10,095.0
XVII.1.45	Нэгдсэн эмнэлгийн барилга, 100 ор /Хөвсгөл, Мөрөн сум/	2020	2022	8,700.0	1,000.0
XVII.1.46	Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга /Орхон, Баян-Өндөр сум/	2020	2020	1,500.0	1,500.0
XVII.1.47	Сум дундын эмнэлгийн амбулаторийн барилга /Завхан, Завханмандал сум/	2020	2021	2,135.0	1,000.0
XVII.1.48	Сумын эрүүл мэндийн төвийн барилга /Ховд, Алтай сум/	2020	2021	694.1	200.0
XVII.1.49	Сумын эрүүл мэндийн төвийн барилга, 15 ор /Өмнөговь, Номгон сум/	2020	2021	1,527.8	500.0
XVII.1.50	Сумын эрүүл мэндийн төвийн барилга, 20 ор /Дорнод, Баянтүмэн сум/	2020	2021	1,537.0	500.0
XVII.1.51	Сүрьеэгийн эмнэлгийн барилга /Хэнтий, Хэрлэн сум/	2020	2021	2,400.0	1,400.0
XVII.1.52	Уламжлалт анагаах ухааны нэгдсэн төвийн барилга /Өвөрхангай, Арвайхээр сум/	2020	2021	1,500.0	400.0
XVII.1.53	Шэжиддүг өрхийн эрүүл мэндийн төвийн барилга /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 12 дугаар хороо/	2020	2020	40.0	40.0
XVII.1.54	Эрүүл мэндийн төвийн барилга /Баянхонгор, Хүрээмарал сум/	2020	2021	1,200.0	300.0
XVII.1.55	Эрүүл мэндийн төвийн барилга /Төв, Өндөрширээт сум/	2020	2021	1,300.0	400.0
XVII.1.56	Эрүүл мэндийн төвийн барилга /Увс, Тэс сум, Хар үзүүр, Таван улиас баг/	2020	2021	200.0	100.0
XVII.1.57	Эрүүл мэндийн төвийн барилга /Хэнтий, Хэрлэн сум, Өлзийт тосгон/	2020	2021	1,055.0	555.0
XVII.1.58	Эрүүл мэндийн төвийн барилга, 10 ор /Ховд, Дөргөн сум/	2020	2021	1,500.0	600.0
XVII.1.59	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл /Дархан-Уул, Орхон сум/	2020	2020	280.0	280.0
XVII.1.60	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл /Сэлэнгэ, Сайхан сум/	2020	2020	120.0	120.0
XVII.1.61	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл /Төв, Эрдэнэсант сум/	2020	2021	744.6	300.0
XVII.1.62	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл /Хэнтий, Батширээт сум/	2020	2021	500.0	100.0

XVII.1.63	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл, 10 ор /Архангай, Ихтамир сум/	2020	2021	1,000.0	200.0
XVII.1.64	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл, их засвар /Сэлэнгэ, Алтанбулаг сум/	2020	2020	50.0	50.0
XVII.1.65	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл, их засвар, 5 ор /Сэлэнгэ, Жавхлант сум/	2020	2021	284.2	50.0
XVII.1.66	Эрүүл мэндийн төвийн өргөтгөл /Баян-Өлгий, Улаанхус сум/	2020	2021	350.0	150.0
XVII.1.67	Эрүүл мэндийн төвийн өргөтгөл /Увс, Өмнөговь сум/	2020	2021	450.0	150.0
XVII.1.68	Эрүүл мэндийн төвийн өргөтгөл /Хэнтий, Дархан сум/	2020	2021	500.0	200.0
XVII.2	II. Их засвар			9,935.2	9,347.1
	<i>Шилжих</i>			<i>400.0</i>	<i>100.0</i>
XVII.2.1	Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Архангай, Булган сум/	2019	2020	200.0	50.0
XVII.2.2	Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Архангай, Жаргалант сум/	2019	2020	200.0	50.0
	<i>Шинэ</i>			<i>9,535.2</i>	<i>9,247.1</i>
XVII.2.3	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн ариутгалын тасгийн их засвар /Булган, Булган сум/	2020	2020	152.3	152.3
XVII.2.4	Сум дундын эмнэлгийн барилгын их засвар /Баян-Өлгий, Дэлүүн сум/	2020	2020	105.0	105.0
XVII.2.5	Эрүүл мэндийн салбарын их засвар /Улсын хэмжээнд/	2020	2020	6,000.0	6,000.0
XVII.2.6	Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Баян-Өлгий, Буянт сум/	2020	2020	165.0	165.0
XVII.2.7	Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Баянхонгор, Баянговь сум/	2020	2020	150.0	150.0
XVII.2.8	Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Баянхонгор, Баян-Өндөр сум/	2020	2020	274.0	274.0
XVII.2.9	Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Булган, Баяннуур сум/	2020	2020	251.3	251.3
XVII.2.10	Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Булган, Дашинчилэн сум/	2020	2020	152.3	152.3
XVII.2.11	Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Дорнод, Чулуунхороот сум/	2020	2020	150.0	150.0
XVII.2.12	Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Завхан, Дөрвөлжин сум/	2020	2020	200.0	200.0
XVII.2.13	Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Өвөрхангай/	2020	2021	300.0	60.0
XVII.2.14	Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Сэлэнгэ, Зүүнбүрэн сум/	2020	2020	84.0	84.0
XVII.2.15	Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Сэлэнгэ, Шаамар сум, Дулаанхаан тосгон/	2020	2021	78.1	30.0
XVII.2.16	Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Төв, Баянчандмань сум/	2020	2020	200.0	200.0
XVII.2.17	Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Ховд, Ховд сум/	2020	2020	270.0	270.0
XVII.2.18	Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Хөвсгөл, Чандмань-Өндөр сум/	2020	2020	150.0	150.0
XVII.2.19	Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Хэнтий, Баян-Овоо сум/	2020	2020	294.0	294.0
XVII.2.20	Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Хэнтий, Жаргалтхаан сум/	2020	2020	250.2	250.2
XVII.2.21	Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгын их засвар /Хэнтий, Баянхутаг сум/	2020	2020	309.0	309.0
XVII.3	III. Тоног төхөөрөмж			17,259.0	16,659.0
	<i>Шинэ</i>			<i>17,259.0</i>	<i>16,659.0</i>
XVII.3.1	Багийн эмч нарын мотоцикл /Өмнөговь/	2020	2020	30.0	30.0
XVII.3.2	Багийн эмч нарын мотоцикл /Хөвсгөл, Алаг-Эрдэнэ, Баянзүрх, Улаан-Уул, Ренчинлхүмбэ, Цагааннуур, Цэцэрлэг, Чандмань-Өндөр, Ханх сум, Хатгал тосгон/	2020	2020	40.0	40.0
XVII.3.3	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн багаж, тоног төхөөрөмжийн шинэчлэл /Өвөрхангай, Арвайхээр сум/	2020	2020	300.0	300.0
XVII.3.4	Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн нуруу бэхлэх аппарат, түнх болон өвдөгний үе солих мэс заслын суурь багаж /Дорнод/	2020	2020	200.0	200.0
XVII.3.5	Өрхийн эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж /Дархан-Уул, Дархан сум, 10, 11, 12, 13, 14, 15, 16 дугаар баг/	2020	2020	200.0	200.0
XVII.3.6	Өрхийн эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 11, 15, 16, 17, 18, 19 дүгээр хороо/	2020	2020	300.0	300.0
XVII.3.7	Өрхийн эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 4, 5, 14 дүгээр хороо/	2020	2020	100.0	100.0
XVII.3.8	Өрхийн эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 13, 14 дүгээр хороо/	2020	2020	50.0	50.0
XVII.3.9	Сумын эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж /Өмнөговь, Даланзадгад, Цогт-Овоо, Цогтцэций, Баян-Овоо, Манлай, Ханбогд, Номгон сум/	2020	2020	184.0	184.0
XVII.3.10	Төрөх эмнэлгийн тоног төхөөрөмж /Дархан-Уул, Дархан сум/	2020	2021	800.0	200.0
XVII.3.11	Түргэн тусламжийн автомашин /Дундговь, Өлзийт сум/	2020	2020	35.0	35.0
XVII.3.12	Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/	2020	2020	15,000.0	15,000.0
XVII.3.13	Яаралтай түргэн тусламжийн автомашин /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 14 дүгээр хороо/	2020	2020	20.0	20.0
XVIII	АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА			1,120.7	1,120.7

XVIII.2	II. Их засвар			75.2	75.2
	Шинэ			75.2	75.2
XVIII.2.1	Авлигатай тэмцэх газрын барилгын их засвар /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2020	2020	75.2	75.2
XVIII.3	III. Тоног төхөөрөмж			1,045.5	1,045.5
	Шинэ			1,045.5	1,045.5
XVIII.3.1	Авлигатай тэмцэх газрын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2020	2020	1,045.5	1,045.5
XIX	ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА			650.7	650.7
XIX.3	III. Тоног төхөөрөмж			650.7	650.7
	Шинэ			650.7	650.7
XIX.3.1	Үндэсний статистикийн хорооны автомашин, тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2020	2020	650.7	650.7
XX	УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР			26,888.5	9,188.1
XX.1	I. Барилга байгууламж			23,469.7	5,769.3
	Шилжих			18,931.1	4,500.0
XX.1.1	Дүүргүүдийн прокурорын нэгдсэн байр /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	2013	2021	18,931.1	4,500.0
	Шинэ			4,538.6	1,269.3
XX.1.2	Прокурорын газрын барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2020	2021	4,538.6	1,269.3
XX.2	II. Их засвар			1,918.8	1,918.8
	Шинэ			1,918.8	1,918.8
XX.2.1	Улсын ерөнхий прокурорын газрын харьяа байгууллагуудын барилгын их засвар /Улсын хэмжээнд/	2020	2020	1,918.8	1,918.8
XX.3	III. Тоног төхөөрөмж			1,500.0	1,500.0
	Шинэ			1,500.0	1,500.0
XX.3.1	Улсын ерөнхий прокурорын газрын тоног төхөөрөмж /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2020	2020	1,500.0	1,500.0
XXI	УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ			19,000.0	4,480.0
XXI.1	I. Барилга байгууламж			19,000.0	4,480.0
	Шинэ			19,000.0	4,480.0
XXI.1.1	Шүүхийн сургалт, мэдээлэл, архивын цогцолборын барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	2020	2022	19,000.0	4,480.0
XXII	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР			1,000.0	1,000.0
XXII.2	II. Их засвар			600.0	600.0
	Шинэ			600.0	600.0
XXII.2.1	Үндэсний аудитын газрын их засвар /Улсын хэмжээнд/	2020	2020	600.0	600.0
XXII.3	III. Тоног төхөөрөмж			400.0	400.0
	Шинэ			400.0	400.0
XXII.3.1	Үндэсний аудитын газрын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/	2020	2020	400.0	400.0
	НИИТ			3,639,744.8	1,658,697.7

**МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2020 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ “БАРИХ-ШИЛЖҮҮЛЭХ” КОНЦЕССЫН
ТӨРЛӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН
ЖАГСААЛТ**

/сая төгрөг/

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	Санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
I	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД			1,073,708.5	323,583.4
I.1	Үндэсний хөгжлийн газар			1,073,708.5	323,583.4
	Концессын төслийн эргэн төлөлт			1,073,708.5	323,583.4
I.1.1	I.Барилга байгууламж			1,073,708.5	323,583.4
	<i>Шилжих</i>			<i>564,185.2</i>	<i>121,557.1</i>
I.1.1.1	Алтай-Дарви чиглэлийн 98км хатуу хучилттай авто зам төсөл	2015	2020	142,560.2	31,987.5
I.1.1.2	Алтай-Дарви чиглэлийн 165 км хатуу хучилттай авто зам төсөл	2015	2020	220,499.9	53,874.1
I.1.1.3	"Чойр" дэд станцын өргөтгөл, шинэчлэлт	2017	2020	81,767.3	30,516.5
I.1.1.4	Оюутолгой-Цагаан суварга чиглэлийн агаарын шугам, дэд станц төсөл/ Цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц	2017	2020	85,525.6	2,500.0
I.1.1.5	Сургуулийн барилга /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 38 дугаар сургууль/	2017	2020	17,245.2	2,587.9
I.1.1.6	Сургуулийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 14 дугаар сургууль/	2016	2020	10,787.0	71.1
I.1.1.7	Сургуулийн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 32 дугаар дунд сургууль/	2016	2020	5,800.0	20.0
	<i>Шинэ</i>			<i>509,523.3</i>	<i>202,026.3</i>
I.1.1.8	Баянхонгор аймгийн Өлзийт суманд баригдах 100 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөл	2016	2020	1,159.7	1,159.7
I.1.1.9	Нийслэлийн Хан-Уул дүүрэгт баригдаж байгаа 300 ор бүхий төрөх эмнэлгийн барилгын ажлыг дуусган, дэд бүтэц	2017	2021	25,724.6	8,000.0
I.1.1.10	Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто зам	2017	2021	231,172.5	130,000.0
I.1.1.11	Тосонцэнгэлийн 4 замын уулзвар-Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км хатуу хучилттай авто зам	2016	2020	251,466.5	62,866.6

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай
хуулийн 4 дүгээр хавсралт

Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс 2020 онд сумдын орон нутгийн
хөгжлийн санд олгох урамшуулал, дэмжлэг

		/мянган төгрөг/			
Д/д	Аймаг, сум	Дэмжлэг	Урамшуулал	Нийт	
1	Архангай	187,689.5	247,700.3	435,389.8	
	1	Батцэнгэл сум	8,217.3		8,217.3
	2	Булган сум	6,012.9	14,257.1	20,270.0
	3	Жаргалант сум	12,523.9		12,523.9
	4	Ихтамир сум	10,301.9		10,301.9
	5	Өгийнуур сум	6,162.2	14,611.3	20,773.5
	6	Өлзийт сум	7,169.2		7,169.2
	7	Өндөр-Улаан сум	13,322.6	31,589.4	44,912.0
	8	Тариат сум	12,226.6	28,990.5	41,217.1
	9	Төвшрүүлэх сум	4,476.7	10,614.8	15,091.5
	10	Хайрхан сум	9,577.8	22,710.1	32,288.0
	11	Хангай сум	11,403.6	27,039.3	38,442.9
	12	Хашаат сум	8,511.8		8,511.8
	13	Хотонт сум	8,315.8	19,717.6	28,033.4
	14	Цахир сум	8,892.2	21,084.4	29,976.7
	15	Цэнхэр сум	8,974.2		8,974.2
	16	Цэцэрлэг сум	10,494.8	24,884.3	35,379.1
	17	Чулуут сум	10,410.5		10,410.5
	18	Эрдэнэбулган сум	17,114.8		17,114.8
19	Эрдэнэмандал сум	13,580.7	32,201.3	45,782.1	
2	Баян-Өлгий	236,009.3	74,650.3	310,659.6	
	1	Алтай сум	13,942.2		13,942.2
	2	Алтанцөгц сум	6,822.5		6,822.5
	3	Баяннуур сум	14,090.7		14,090.7
	4	Бугат сум	6,898.3		6,898.3
	5	Булган сум	29,111.9		29,111.9
	6	Буянт сум	7,780.6		7,780.6
	7	Дэлүүн сум	28,381.9	74,650.3	103,032.2
	8	Өлгий сум	32,789.8		32,789.8
	9	Ногооннуур сум	24,859.3		24,859.3
	10	Сагсай сум	11,434.0		11,434.0
	11	Толбо сум	11,861.8		11,861.8
	12	Улаанхус сум	21,506.3		21,506.3
13	Цэнгэл сум	26,529.9		26,529.9	
	Баянхонгор	188,866.9	462,568.8	651,435.6	
	1	Баацагаан сум	9,630.3	23,582.8	33,213.1
	2	Баянбулаг сум	6,199.5	15,180.5	21,380.0
	3	Баянговь сум	9,251.0	22,653.0	31,904.0
	4	Баянлиг сум	14,599.1	35,750.2	50,349.3
	5	Баян-Овоо сум	4,326.9	10,596.3	14,923.2
	6	Баян-Өндөр сум	15,259.3	37,438.1	52,697.4
	7	Баянхонгор сум	26,815.5	65,667.9	92,483.4
	8	Баянцагаан сум	11,320.4	27,720.2	39,040.6
9	Богд сум	7,182.3	17,587.7	24,769.9	

Д/д	Аймаг, сум	Дэмжлэг	Урамшуулал	Нийт	
3	10	Бөмбөгөр сум	6,505.7	15,930.9	22,436.7
	11	Бууцагаан сум	10,466.9	25,630.5	36,097.4
	12	Галуут сум	8,108.1	19,855.4	27,963.5
	13	Гурванбулаг сум	7,532.5	18,444.9	25,977.4
	14	Жаргалант сум	7,722.7	18,910.9	26,633.6
	15	Жинст сум	5,846.6	14,317.7	20,164.4
	16	Заг сум	5,614.1	13,747.4	19,361.5
	17	Өлзийт сум	5,606.9	13,731.0	19,337.9
	18	Хүрээмарал сум	6,254.5	15,315.7	21,570.2
	19	Шинэжинст сум	14,163.9	34,686.0	48,849.9
	20	Эрдэнэцогт сум	6,460.7	15,821.6	22,282.3
	Булган	116,653.4	117,363.2	234,016.6	
4	1	Баян-Агт сум	7,275.3	16,582.9	23,858.2
	2	Баяннуур сум	3,933.7	8,963.0	12,896.7
	3	Бугат сум	4,518.8		4,518.8
	4	Булган сум	9,562.6		9,562.6
	5	Бүрэгхангай сум	5,949.5		5,949.5
	6	Гурванбулаг сум	6,817.9	15,540.0	22,357.9
	7	Дашинчилэн сум	6,444.2	14,687.2	21,131.3
	8	Могод сум	6,035.8	13,430.8	19,466.6
	9	Орхон сум	6,164.3		6,164.3
	10	Рашаант сум	7,017.9	15,987.3	23,005.2
	11	Сайхан сум	6,340.4	14,770.0	21,110.4
	12	Сэлэнгэ сум	8,782.2		8,782.2
	13	Тэшиг сум	13,230.4		13,230.4
	14	Хангал сум	7,638.0	17,402.1	25,040.1
	15	Хишиг-Өндөр сум	5,314.5		5,314.5
	16	Хутаг-Өндөр сум	11,627.9		11,627.9
	Говь-Алтай	153,201.1	146,428.7	299,629.8	
5	1	Алтай сум	13,548.1	31,588.0	45,136.1
	2	Баян-Уул сум	8,282.7		8,282.7
	3	Бигэр сум	5,336.5		5,336.5
	4	Бугат сум	8,985.4		8,985.4
	5	Дарви сум	5,951.7		5,951.7
	6	Дэлгэр сум	7,487.6		7,487.6
	7	Есөнбулаг сум	20,406.7	53,039.5	73,446.3
	8	Жаргалан сум	4,454.3		4,454.3
	9	Тайшир сум	3,486.4	9,105.9	12,592.3
	10	Тонхил сум	8,202.1		8,202.1
	11	Төгрөг сум	6,135.6		6,135.6
	12	Халиун сум	5,783.2		5,783.2
	13	Хөхморьт сум	8,289.3	21,826.2	30,115.5
	14	Цогт сум	14,079.5		14,079.5
	15	Цээл сум	6,763.4	17,810.3	24,573.7
	16	Чандмань сум	6,915.4		6,915.4
	17	Шарга сум	4,986.6	13,058.7	18,045.3
	18	Эрдэнэ сум	14,106.5		14,106.5
	Дорноговь	147,556.1	370,986.5	518,542.6	
	1	Айраг сум	9,222.6	24,147.9	33,370.6
	2	Алтанширээ сум	4,818.8	12,617.3	17,436.1
	3	Даланжаргалан сум	6,560.7	17,178.2	23,739.0
	4	Дэлгэрэх сум	5,096.2	13,343.5	18,439.7
	5	Замын-Үүд	38,907.3	101,872.6	140,779.9

Д/д	Аймаг, сум	Дэмжлэг	Урамшуулал	Нийт	
6	6	Иххэт сум	5,745.8	15,044.3	20,790.1
	7	Мандах сум	8,185.1	21,431.3	29,616.4
	8	Өргөн сум	6,025.1	15,775.9	21,801.0
	9	Сайншанд сум	22,371.6	58,576.6	80,948.2
	10	Сайхандулаан сум	5,868.3		5,868.3
	11	Улаанбадрах сум	7,106.4	18,606.9	25,713.3
	12	Хатанбулаг сум	13,984.0	36,614.9	50,598.9
	13	Хөвсгөл сум	6,320.8	16,549.9	22,870.6
	14	Эрдэнэ сум	7,343.3	19,227.3	26,570.6
	Дорнод	184,021.3	455,557.5	639,578.8	
7	1	Баяндун сум	12,093.9	29,939.3	42,033.2
	2	Баянтүмэн сум	6,303.1	15,603.7	21,906.8
	3	Баян-Уул сум	16,092.4	39,837.9	55,930.4
	4	Булган сум	5,996.6	14,845.0	20,841.6
	5	Гурванзагал сум	5,656.5	14,003.1	19,659.6
	6	Дашбалбар сум	13,320.6	32,976.0	46,296.6
	7	Матад сум	16,749.7	41,465.0	58,214.6
	8	Сэргэлэн сум	5,127.2	12,692.7	17,820.0
	9	Халхгол сум	26,232.6	64,940.7	91,173.4
	10	Хөлөнбуйр сум	5,826.8	14,424.6	20,251.3
	11	Хэрлэн сум	42,112.8	104,253.3	146,366.1
	12	Цагаан-Овоо сум	10,664.5	26,400.8	37,065.3
	13	Чойбалсан сум	8,629.1	21,361.8	29,990.9
	14	Чулуунхороот сум	9,215.5	22,813.6	32,029.1
	Дундговь	94,486.1	217,036.8	311,523.0	
8	1	Адаацаг сум	6,218.1	15,708.1	21,926.2
	2	Баянжаргалан сум	3,683.6	9,305.6	12,989.2
	3	Говь-Угтаал сум	3,688.5	9,317.9	13,006.4
	4	Гурвансайхан сум	5,103.6		5,103.6
	5	Дэлгэрхангай сум	6,711.3	16,954.1	23,665.5
	6	Дэлгэрцогт сум	2,942.0	7,432.0	10,374.0
	7	Дэрэн сум	4,226.6	10,677.2	14,903.8
	8	Луус сум	3,457.4	8,734.0	12,191.3
	9	Өлзийт сум	9,711.2	24,532.5	34,243.7
	10	Өндөршил сум	5,188.8	13,108.0	18,296.9
	11	Сайнцагаан сум	13,928.9	35,187.1	49,116.0
	12	Сайхан-Овоо сум	7,176.7	18,129.8	25,306.5
	13	Хулд сум	5,969.9	15,081.1	21,051.1
	14	Цагаандэлгэр сум	3,468.0		3,468.0
	15	Эрдэнэдалай сум	13,011.4	32,869.3	45,880.8
	Завхан	160,735.6	289,404.9	450,140.5	
9	1	Алдархаан сум	7,198.7		7,198.7
	2	Асгат сум	2,423.9	6,471.2	8,895.1
	3	Баянтэс сум	8,657.5	19,526.6	28,184.1
	4	Баянхайрхан сум	5,578.2	14,892.8	20,471.0
	5	Дөрвөлжин сум	7,782.8		7,782.8
	6	Завханмандал сум	4,003.2	10,689.0	14,692.2
	7	Идэр сум	5,315.1	14,191.2	19,506.3
	8	Их-Уул сум	14,697.8	39,239.2	53,937.0
	9	Нөмрөг сум	4,955.2	13,230.2	18,185.4
	10	Отгон сум	7,545.6	20,147.0	27,692.6
	11	Сантмаргаз сум	4,926.8	13,153.8	18,080.6
	12	Сонгино сум	4,796.5	12,805.9	17,602.4

Д/д	Аймаг, сум	Дэмжлэг	Урамшуулал	Нийт
	13 Тосонцэнгэл сум	19,227.5	47,225.8	66,453.4
	14 Түдэвтэй сум	5,011.0	14,587.5	19,598.5
	15 Тэс сум	4,586.8	20,719.1	25,306.0
	16 Тэлмэн сум	9,387.5	23,031.5	32,419.0
	17 Ургамал сум	4,660.1		4,660.1
	18 Улиастай сум	14,519.7		14,519.7
	19 Цагаанхайрхан сум	2,971.9	7,935.1	10,906.9
	20 Цагаанчулуут сум	3,158.0		3,158.0
	21 Цэцэн-Уул сум	4,903.3		4,903.3
	22 Шилүүстэй сум	4,329.4	11,559.1	15,888.4
	23 Эрдэнэхайрхан сум	4,866.6		4,866.6
	24 Яруу сум	5,232.7		5,232.7
	Өвөрхангай	220,902.3	542,175.3	763,077.6
10	1 Арвайхээр сум	24,232.5	59,475.3	83,707.8
	2 Бат-Өлзий сум	15,114.8	37,097.3	52,212.2
	3 Баянгол сум	9,055.9	22,226.6	31,282.6
	4 Баян-Өндөр сум	9,755.9	23,944.5	33,700.4
	5 Баруунбаян-Улаан сум	9,895.7	24,287.8	34,183.5
	6 Богд сум	23,136.4	56,785.2	79,921.5
	7 Бүрд сум	7,920.8	19,440.6	27,361.4
	8 Гучин-Ус сум	8,361.1	20,521.2	28,882.2
	9 Есөнзүйл сум	6,996.5	17,172.0	24,168.4
	10 Зүүнбаян-Улаан сум	7,355.0	18,051.9	25,406.9
	11 Нарийнтээл сум	9,276.3	22,767.5	32,043.9
	12 Өлзийт сум	5,342.4	13,112.3	18,454.7
	13 Сант сум	8,161.0	20,030.0	28,191.0
	14 Тарагт сум	7,020.5	17,230.9	24,251.4
	15 Төгрөг сум	9,799.9	24,052.5	33,852.4
	16 Уянга сум	14,833.9	36,407.8	51,241.7
	17 Хайрхандулаан сум	8,907.3	21,861.8	30,769.1
	18 Хархорин сум	24,605.2	60,390.1	84,995.3
	19 Хужирт сум	11,131.2	27,320.0	38,451.2
	Өмнөговь	156,241.1	334,265.6	490,506.7
11	1 Баяндалай сум	6,221.5	16,335.4	22,556.9
	2 Баян-Овоо сум	6,532.5	17,151.8	23,684.3
	3 Булган сум	5,563.1	14,606.5	20,169.6
	4 Гурвантэс сум	23,184.3	60,873.4	84,057.8
	5 Даланзадгад сум	23,805.4		23,805.4
	6 Мандал-Овоо сум	4,877.5	12,806.4	17,683.9
	7 Манлай сум	9,908.4	26,015.7	35,924.1
	8 Ноён сум	6,370.1	16,725.4	23,095.5
	9 Номгон сум	9,838.4	25,832.0	35,670.4
	10 Сэврэй сум	7,138.3	18,742.4	25,880.7
	11 Ханбогд сум	22,831.1	59,945.6	82,776.7
	12 Ханхонгор сум	5,070.8	13,322.6	18,393.4
	13 Хүрмэн сум	5,691.5	14,943.9	20,635.4
	14 Цогт-Овоо сум	5,129.7		5,129.7
	15 Цогтцэций сум	14,078.5	36,964.5	51,043.0
	Сүхбаатар	130,820.3	310,275.5	441,095.8
	1 Асгат сум	5,600.9		5,600.9
	2 Баруун-Урт сум	17,989.0	44,574.1	62,563.1
	3 Баяндэлгэр сум	12,810.6	31,742.7	44,553.3
	4 Дарьганга сум	8,601.3	21,312.9	29,914.2

Д/д	Аймаг, сум	Дэмжлэг	Урамшуулал	Нийт	
12	5	Мөнххаан сум	11,107.0	27,521.6	38,628.6
	6	Наран сум	5,531.4	13,705.9	19,237.3
	7	Онгон сум	10,664.2	26,424.4	37,088.6
	8	Сүхбаатар сум	10,034.0	24,862.8	34,896.8
	9	Түвшинширээ сум	8,153.3	20,202.7	28,356.0
	10	Түмэнцогт сум	5,612.7	13,907.5	19,520.2
	11	Уулбаян сум	6,495.4	16,094.7	22,590.1
	12	Халзан сум	4,052.7	10,041.9	14,094.5
	13	Эрдэнэцагаан сум	24,167.9	59,884.5	84,052.4
13	Сэлэнгэ	188,452.8	400,739.7	589,192.5	
	1	Алтанбулаг сум	6,922.1	17,111.4	24,033.5
	2	Баруунбүрэн сум	8,996.8	22,179.8	31,176.6
	3	Баянгол сум	10,697.7	26,356.4	37,054.1
	4	Ерөө сум	18,485.7	45,665.5	64,151.3
	5	Жавхлант сум	3,721.2	9,190.6	12,911.8
	6	Зүүнбүрэн сум	4,149.9		4,149.9
	7	Мандал сум	51,552.8	126,844.0	178,396.7
	8	Орхон сум	5,176.7	12,760.7	17,937.4
	9	Орхонтуул сум	10,442.8	25,734.1	36,176.9
	10	Сайхан сум	14,560.1	36,021.3	50,581.4
	11	Сант сум	5,128.7	12,010.5	17,139.2
	12	Сүхбаатар сум	15,940.7		15,940.7
	13	Түшиг сум	5,942.6	12,909.3	18,851.9
	14	Хушаат сум	4,887.2		4,887.2
	15	Хүдэр сум	7,288.3	17,986.7	25,275.0
	16	Цагааннуур сум	10,595.8	26,163.5	36,759.3
17	Шаамар сум	3,963.6	9,805.9	13,769.6	
14	Төв	167,133.1	368,526.7	535,659.7	
	1	Алтанбулаг сум	6,826.9	15,539.0	22,365.9
	2	Аргалант сум	2,857.2	6,503.3	9,360.6
	3	Архуст сум	2,118.6	4,822.1	6,940.7
	4	Батсүмбэр сум	10,290.4	23,439.4	33,729.8
	5	Баян сум	4,236.2	9,642.1	13,878.2
	6	Баяндэлгэр сум	3,186.8	7,253.5	10,440.3
	7	Баянжаргалан сум	3,773.3	8,588.5	12,361.8
	8	Баян-Өнжүүл сум	6,034.1	13,734.4	19,768.5
	9	Баянхангай сум	2,694.4	6,132.7	8,827.1
	10	Баянцагаан сум	6,590.6	15,001.3	21,592.0
	11	Баянцогт сум	3,460.4	7,876.2	11,336.7
	12	Баянчандмань сум	5,348.1	12,172.6	17,520.7
	13	Борнуур сум	7,578.3	17,249.7	24,828.1
	14	Бүрэн сум	7,283.6	16,578.3	23,861.9
	15	Дэлгэрхаан сум	4,537.3	10,327.4	14,864.8
	16	Жаргалант сум	10,801.2	24,584.3	35,385.5
	17	Заамар сум	11,521.3	26,223.3	37,744.5
	18	Зуунмод сум	12,011.2	27,338.0	39,349.2
	19	Лүн сум	5,463.1	12,434.4	17,897.5
	20	Мөнгөнморьт сум	7,694.2	17,513.1	25,207.3
	21	Өндөрширээт сум	5,247.6	11,944.0	17,191.6
	22	Сүмбэр сум	3,096.8	7,048.4	10,145.2
	23	Сэргэлэн сум	4,172.0	9,496.0	13,667.9
	24	Угтаалцайдам сум	5,229.5		5,229.5
25	Цээл сум	5,415.0	12,324.9	17,739.9	

Д/д	Аймаг, сум	Дэмжлэг	Урамшуулал	Нийт
	26 Эрдэнэ сум	9,612.9	21,880.3	31,493.3
	27 Эрдэнэсант сум	10,052.1	22,879.4	32,931.5
	Увс	195,165.0	307,919.2	503,084.2
15	1 Баруунтуруун сум	9,407.7	24,155.2	33,562.9
	2 Бөхмөрөн сум	8,382.2	21,522.2	29,904.4
	3 Давст сум	8,720.8	22,391.6	31,112.4
	4 Завхан сум	9,783.5		9,783.5
	5 Зүүнговь сум	9,013.0	23,141.9	32,155.0
	6 Зүүнхангай сум	10,809.3	27,754.0	38,563.3
	7 Малчин сум	7,654.2		7,654.2
	8 Наранбулаг сум	11,495.2		11,495.2
	9 Өлгий сум	6,357.2		6,357.2
	10 Өмнөговь сум	11,011.7		11,011.7
	11 Өндөрхангай сум	14,245.8	36,577.7	50,823.6
	12 Сагил сум	6,699.7		6,699.7
	13 Тариалан сум	7,941.3	20,390.2	28,331.5
	14 Түргэн сум	4,572.1	11,739.3	16,311.3
	15 Тэс сум	13,991.0		13,991.0
	16 Улаангом	29,271.2	75,157.0	104,428.1
	17 Ховд сум	8,248.2		8,248.2
	18 Хяргас сум	8,601.9	22,086.3	30,688.2
	19 Цагаанхайрхан сум	8,959.2	23,003.7	31,962.8
	Ховд	205,887.2	222,391.9	428,279.1
16	1 Алтай сум	19,247.7	49,343.4	68,591.2
	2 Булган сум	39,736.2	101,867.8	141,604.0
	3 Буянт сум	6,934.9		6,934.9
	4 Дарви сум	10,804.0		10,804.0
	5 Дуут сум	4,551.8		4,551.8
	6 Дөргөн сум	8,046.7	20,628.4	28,675.1
	7 Зэрэг сум	7,450.4		7,450.4
	8 Манхан сум	9,504.7	24,366.3	33,871.0
	9 Мянгад сум	6,974.4		6,974.4
	10 Мөст сум	9,294.3		9,294.3
	11 Мөнххайрхан сум	6,069.7		6,069.7
	12 Үенч сум	17,649.7		17,649.7
	13 Ховд сум	6,272.4		6,272.4
	14 Цэцэг сум	9,692.0		9,692.0
	15 Чандмань сум	10,214.5	26,186.0	36,400.5
	16 Эрдэнэбүрэн сум	5,292.8		5,292.8
	17 Жаргалант сум	28,151.0		28,151.0
	Хөвсгөл	278,756.0	502,687.1	781,443.2
17	1 Алаг-Эрдэнэ сум	11,920.6		11,920.6
	2 Арбулаг сум	8,096.9	18,985.2	27,082.1
	3 Баянзүрх сум	10,160.9	23,731.2	33,892.1
	4 Бүрэнтогтох сум	8,319.7	19,316.6	27,636.3
	5 Галт сум	13,438.7	28,801.8	42,240.5
	6 Жаргалант сум	12,704.3	27,147.9	39,852.2
	7 Их-Уул сум	8,078.8	18,702.2	26,781.0
	8 Рашаант сум	8,501.9	20,099.2	28,601.1
	9 Рэнчинлхүмбэ сум	18,888.5	41,758.0	60,646.5
	10 Тариалан сум	14,330.4	29,934.5	44,264.9
	11 Тосонцэнгэл сум	7,113.8	16,447.9	23,561.6
	12 Төмөрбулаг сум	7,788.5	17,973.9	25,762.4

Д/д	Аймаг, сум	Дэмжлэг	Урамшуулал	Нийт
	13 Түнэл сум	7,749.6	18,117.0	25,866.6
	14 Улаан-Уул сум	16,727.1	38,676.9	55,404.0
	15 Ханх сум	11,843.8	28,005.3	39,849.1
	16 Цагаан-Уул сум	14,609.4	31,851.5	46,460.9
	17 Цагааннуур сум	9,480.8	22,420.0	31,900.8
	18 Цагаан-Үүр сум	12,383.2		12,383.2
	19 Цэцэрлэг сум	15,995.8	36,192.6	52,188.4
	20 Чандмань-Өндөр сум	8,987.0	21,251.0	30,238.0
	21 Шинэ-Идэр сум	7,363.2	17,408.0	24,771.2
	22 Эрдэнэбулган сум	10,939.5	25,866.3	36,805.8
	23 Мөрөн сум	33,333.9		33,333.9
	Хэнтий	156,442.3	349,272.7	505,715.0
	1 Батноров сум	10,912.7	23,506.2	34,419.0
	2 Батширээт сум	8,778.6	21,161.3	29,939.9
	3 Баян-Адарга сум	6,231.0	14,882.8	21,113.9
	4 Баянмөнх сум	3,873.2	9,298.5	13,171.7
	5 Баян-Овоо сум	4,881.2	11,729.9	16,611.1
	6 Баянхутаг сум	5,795.3		5,795.3
	7 Биндэр сум	10,869.2	25,967.7	36,836.9
	8 Бор-Өндөр сум	17,895.5	39,644.8	57,540.4
18	9 Галшар сум	7,553.8	18,253.6	25,807.4
	10 Дадал сум	10,106.4	24,127.0	34,233.4
	11 Дархан сум	5,834.0	14,038.5	19,872.6
	12 Дэлгэрхаан сум	6,282.4	13,106.5	19,389.0
	13 Жаргалхаан сум	4,704.2	11,269.0	15,973.3
	14 Мөрөн сум	3,169.7	7,617.0	10,786.7
	15 Норовлин сум	8,133.9	19,525.1	27,659.0
	16 Өмнөдэлгэр сум	15,077.4	34,703.9	49,781.3
	17 Хэрлэн сум	21,126.5	47,934.3	69,060.7
	18 Цэнхэрмандал сум	5,217.2	12,506.5	17,723.7
	Дархан-Уул	161,081.4	331,104.4	492,185.7
19	1 Дархан сум	54,806.8	112,656.0	167,462.9
	2 Орхон сум	16,982.6	34,907.8	51,890.4
	3 Хонгор сум	48,402.7	99,492.3	147,895.0
	4 Шарын гол сум	40,889.2	84,048.2	124,937.5
	Орхон	174,413.8	408,121.8	582,535.6
20	1 Баян-Өндөр сум	82,569.5	182,060.4	264,629.9
	2 Жаргалант сум	91,844.3	226,061.4	317,905.7
	Говьсүмбэр	28,590.4	75,193.4	103,783.8
21	1 Баянтал сум	3,985.4	10,481.8	14,467.2
	2 Сүмбэр сум	14,186.1	37,309.8	51,496.0
	3 Шивээговь сум	10,418.8	27,401.8	37,820.6
	НИЙТ	3,533,105.0	6,534,370.3	10,067,475.3

МОНГОЛ УЛСЫН 2020 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

УЛААНБААТАР ХОТ
2019 он

АГУУЛГА

1. МАКРО ЭДИЙН ЗАСАГ	1
1.1. Дэлхийн эдийн засаг, гадаад орчин	1
1.2. Монгол Улсын эдийн засаг	4
2. 2020 ОНД БАРИМТЛАХ ТӨСВИЙН БОДЛОГО	12
3. НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	18
3.1. Төсвийн нэгдсэн үзүүлэлтүүд	18
3.2. Төсвийн тусгай шаардлага	19
4. ТӨСВИЙН ОРЛОГО	20
4.1. Монгол Улсын 2019 оны 8 дугаар сарын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл	20
4.2. Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн нийт орлого	20
4.3. Төсвийн тогтворжуулалтын сангийн орлого	20
4.4. Ирээдүйн өв сангийн орлого	21
4.5. Уул уурхайн салбарын орлого	21
4.6. Эдийн засаг дахь татварын ачаалал болон татварын орчин	21
4.7. Татварын орлого	22
4.8. Татварын бус орлого	27
4.9. Төсвийн орлогын гүйцэтгэлд учирч болзошгүй эрсдэл	28
4.10. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт	29
5. ТӨСВИЙН УРСГАЛ ЗАРЛАГА	30
5.1. 2020 оны нэгдсэн төсвийн урсгал зардлын тойм	30
5.2. Урсгал зардлын өөрчлөлт	30
5.3. Хөдөлмөр, нийгмийн хамгаалал	31
5.4. Байгаль орчин, аялал жуулчлал	32
5.5. Эрчим хүч	32
5.6. Эрүүл мэнд	32
5.6. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт	34
5.7. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр	35
5.8. Аюулгүй байдал	35
5.9. Төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа	36
5.10. Орон тооны өөрчлөлт	37
5.11. Төрийн бусад үйлчилгээ	38
5.12. Засгийн газрын тусгай сан	39
5.13. Эргэж төлөгдөх зээл	41
6. ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	42
7. ОРОН НУТГИЙН ТӨСӨВ	47
8. ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖ	49
8.1. Гадаад зээл, тусламжийн ашиглалтын мэдээлэл	49
8.2. Төслүүдийг санхүүжүүлэхэд баримтлах зарчим	49
8.3. Гадаад зээл, тусламжийн төслүүдийг санхүүжүүлэхэд тулгарч буй асуудал	49
8.4. Гадаад зээл, тусламжийн бодлогын хүрээнд 2020 онд гадаадын зээл, тусламжийг нийгэм, эдийн засгийн үр ашигтай дараах чиглэлийн төслүүдэд ашиглана:	50
9. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР	56
9.1. Засгийн газрын өрийн удирдлага	56
9.2. Болзошгүй Өр Төлбөр	59

1. МАКРО ЭДИЙН ЗАСАГ



1.1. Дэлхийн эдийн засаг, гадаад орчин

1.1.1. Дэлхийн эдийн засгийн төлөв

Дэлхийн эдийн засаг 2020 онд 3.5 хувиар өсөхөөр байна.

АНУ болон БНХАУ-ын хоорондын худалдааны маргаан, хөгжиж буй орнуудын эдийн засгийн идэвхжлийн бууралт зэргээс шалтгаалан дэлхийн хэмжээнд хөрөнгө оруулалт болон худалдааны эргэлт 2019 онд буурч байна. Иймд ОУВС 2019 оны 7 дугаар сард нийтэлсэн “Дэлхийн эдийн засгийн төсөөлөл” тайландаа 2019 оны төсөөллийг 0.1 хувиар бууруулж, 3.2 хувь болгов. Харин 2020 онд дэлхийн эдийн засгийн өсөлт 3.5 хувь болохоор байна.

Хүснэгт №1. Дэлхийн эдийн засгийн өсөлт, хувь

Бүс нутаг	2018	2019*	2020**
Дэлхий	3.6	3.2	3.5
Өндөр хөгжилтэй орнууд	2.2	1.9	1.7
АНУ	2.9	2.6	1.9
Евро бүс	1.9	1.3	1.6
Япон	0.8	0.9	0.4
Хөгжиж буй орнууд	4.5	4.1	4.7
Хөгжиж байгаа азийн орнууд	6.4	6.2	6.2
ОХУ	2.3	1.2	1.9
БНХАУ	6.6	6.2	6.0

Эх үүсвэр: ОУВС-гийн 7 дугаар сард нийтэлсэн “Дэлхийн эдийн засгийн төсөөлөл” тайлан.

АНУ-ын эдийн засгийн өсөлт 2019 онд 2.6 хувь, 2020 онд 1.9 хувь байхаар төсөөлж байна.

2018 онд 2.9 хувиар өссөн АНУ-ын эдийн засаг 2019 оны эхний улиралд 3.1 хувь, 2-р улиралд 2.0 хувиар өслөө. Үүнд хувийн хэрэглээний өсөлт голлон нөлөөлсөн ба ажилгүйдлийн түвшин нь 4 дүгээр сарын байдлаар 3.6 хувь болж буурсан нь 1969 оноос хойших хамгийн бага үзүүлэлт болсон байна. Эдийн засгийн өсөлтийг дэмжиж буй төсвийн тэлэх бодлогын нөлөөлөл ирэх онуудад саарах төлөвтэй байгаагаас шалтгаалан 2020 онд тус улсын эдийн засгийн өсөлтийг 1.9 хувь гэж ОУВС таамаглаж байна. АНУ-ын хувьд дэлхийн санхүүгийн хямралаас хойш анх удаа энэ оны 7 болон 9 дүгээр саруудад бодлогын хүүгээ бууруулаад байгаа¹ ба тус улсын БНХАУ-тай өрнүүлж буй худалдааны маргааныг тойрсон тодорхой бус байдал нь дэлхийн эдийн засгийн өсөлтийг сааруулж болзошгүй гол эрсдэлд тооцогдож байна.

БНХАУ-ын эдийн засгийн өсөлт саарахаар байна.

БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 2018 онд сүүлийн 28 жилийн доод түвшин буюу 6.6 хувьд хүрсэн. Цаашид гадаад эрэлтийн бууралтын нөлөөгөөр тус улсын эдийн засгийн өсөлт үргэлжлэн саарч 2019 онд 6.2 хувь, 2020 онд 6.0 хувьд хүрэх төлөвтэй байна. БНХАУ-ын засгийн газраас эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилгоор татварын хөнгөлөлт үзүүлэх, дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх,

¹ АНУ бодлогын хүүгээ 7 дугаар сард бууруулж, 2.25 хувь, 9 дүгээр сард 2.0 хувь болгов.

банкуудын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг бууруулах зэрэг төсөв, мөнгөний бодлогын арга хэмжээг хэрэгжүүлж байгаа хэдий ч худалдааны маргаантай холбоотой тодорхой бус байдал хэвээр байгаа нь эдийн засгийн өсөлт үргэлжлэн саарах гол хүчин зүйл болж байна.

Евро бүсийн эдийн засаг 2020 онд 1.6 хувиар өсөхөөр байна.

Худалдааны маргаан, БНХАУ-ын эдийн засгийн бууралт, Германы үйлдвэрлэлийн салбарын сааралт, Брекситтэй холбоотой тодорхой бус байдал зэрэг нь Евро бүсийн 2019 оны эдийн засгийн өсөлтийг сааруулж буй гол хүчин зүйлс болж байна. ОУВС-гийн зүгээс 2019 оны сүүлч, 2020 онд Германы автомашин үйлдвэрлэлийн бууралт болон Францын үймээн зэрэг асуудлууд намжиж, гадаад эрэлт сэргэснээр евро бүсийн эдийн засаг 1.6 хувиар өснө гэж үзэж байна. Мөн Европын Төв банк нь 2018 оны сүүлчээс зогсоогоод байсан бондын худалдан авалтын хөтөлбөрөө 2019 оны 11 дүгээр сараас дахин эхлүүлэхээр шийдвэрлээд байна.

ОХУ-ын эдийн засгийн өсөлт 2020 онд 1.9 хувьд хүрнэ.

2018 онд 2.3 хувиар өссөн ОХУ-ын эдийн засаг энэ оны 2 дугаар улиралд 0.9 хувиар өсөв. Ийнхүү өсөлт саарсан нь хувийн хэрэглээ болон жижиглэнгийн худалдааны өсөлт доогуур байсантай холбоотой юм. Тус улсын хувьд татварын шинэчлэл хийхээс гадна эрүүл мэнд, боловсрол, дэд бүтцийн салбарт чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг дэмжих бодлого хэрэгжүүлж байна. Гэвч газрын тосны үнийн хэлбэлзэлээс шалтгаалан тус улсын эдийн засаг 2019 онд 1.2 хувиар өсөхөөр байна. Харин 2020 онд 1.9 хувь өснө гэж шинжээчид дүгнэж байна.

Япон Улсын эдийн засгийг 2019 онд 0.9 хувиар, 2020 онд 0.4 хувиар өсөхөөр таамаглаж байна.

Японы улсын ДНБ-ий 60 орчим хувийг бүрдүүлдэг хувийн хэрэглээний өсөлт өндөр байсан нь 2019 оны 2 дугаар улиралд эдийн засгийн өсөлт 1.8 хувьд хүрэхэд нөлөөлсөн байна.

Гэвч 2019 оны 10 дугаар сараас хэрэглээний татварыг 8 хувиас 10 хувь болгон нэмэгдүүлэх тус улсын бодлого нь эдийн засгийн идэвхжлийг бууруулж болзошгүй байна гэж ОУВС үзэж байна.

Дэлхийн санхүү, хөрөнгийн зах зээл.

АНУ-ын Холбооны нөөцийн банк болон Европын төв банк зэрэг дэлхийн томоохон төв банкууд мөнгөний зөөлөн бодлого хэрэгжүүлж байгаа нь санхүүгийн зах зээлд хүү буурах таатай нөхцөл үүсгэж байна. Харин худалдааны маргааныг тойрсон тодорхой бус байдал үргэлжилсээр байгаа нь санхүүгийн зах зээлийн эмзэг байдлыг нэмэгдүүлж байна. АНУ болон БНХАУ улсууд худалдааны хэлэлцээрт хүрэх хүлээлттэй байсан 2019 оны эхний хагаст хөрөнгийн зах зээлийн гол индексүүд оны эхнээс өссөн үзүүлэлттэй байсан ч 5 болон 8 дугаар сард худалдааны маргаан хурцадсанаар хөрөнгийн зах зээл хүчтэй савлахад хүргэв.

Дэлхийн эдийн засагт тулгараад буй тодорхой бус байдлаас үүдэн засгийн газрын бондуудын өгөөж буурч байна. Энэ оны 8-р сард АНУ-ын 10 жилийн хугацаатай бондын өгөөж 2 жилийн хугацаатай бондын өгөөжөөс бага болсноос гадна 30 жилийн хугацаатай бондын өгөөж 1.97 хувь болж түүхэнд анх удаа 2 хувиас доош түвшинд хүрсэн байна. Түүнчлэн Их Британийн (UK) 30 жилийн хугацаатай засгийн газрын бондын өгөөж анх удаа 1 хувиас бага болсон нь 2019 оны дэлхийн эдийн засгийн сааралт

хөрөнгө оруулагчдын итгэлд хүчтэй нөлөөлж байгааг харуулж байна.

1.1.2. Уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн хандлага

Зэс. БНХАУ-ын зэсийн хэрэглээ тогтворжиж байгаа бөгөөд 2019 онд огцом нэмэгдэхээргүй байна.

Блүүмбергийн платформ дээрх мэргэжлийн судалгааны байгууллагууд 2020 оны зэсийн үнийн төсөөллөө бууруулаад байна. Энэ нь худалдааны дайнаас үүдэлтэй тодорхой бус байдалтай холбоотой юм. Дэлхийн зах зээл дээрх зэсийн үнэ 2020 онд дундажаар 5,991.0 ам.доллар байхаар төсөөлж байна.


График №1. Зэсийн үнийн хөдөлгөөн, төсөөлөл, ам.доллар/тонн



Эх үүсвэр: Блүүмбэрг

Алт. АНУ болон БНХАУ-ын худалдааны маргаан, хөгжингүй орнуудын Төв банкуудын хэрэгжүүлж буй мөнгөний зөөлөн бодлого, Их Британи улс Европын холбооноос гарах шийдвэр зэрэг дэлхийн эдийн засагт үүсээд байгаа тодорхойгүй байдлууд нь хөрөнгө оруулагчдын алт худалдан авах сонирхолыг нэмэгдүүлж байна. Үүнээс үүдэн алтны үнэ 2019 онд өсөөд байна.

График №2. Алтны үнийн хөдөлгөөн, төсөөлөл, ам.доллар/трой унци




Эх үүсвэр: Блүүмбэрг

Олон улсын шинжээчид алтны үнийг 2020 онд үргэлжлэн өсч 1,545.0 ам.долларт хүрэхээр таамаглаж байна.

Төмрийн хүдэр. БНХАУ болон бусад хөгжиж буй орнууд дэд бүтцийн зардлаа өсгөж байгаа нь 2018-2019 онд гангийн эрэлтийг нэмэгдүүлсэн байна. Нөгөөтэйгүүр төмрийн хүдрийн томоохон нийлүүлэгч болох Бразиль, Австрали зэрэг улсуудад байгалийн гамшигт үзэгдэл тохиолдож, зах зээлд хомсдол үүсэж, 2019 онд үнэ огцом өссөн.

График №3. Төмрийн хүдрийн үнийн хөдөлгөөн, төсөөлөл, ам.доллар/тонн



Эх үүсвэр: Блүүмбэрг


Ирэх 2020 онд төмрийн хүдрийн нийлүүлэлт эргэн сэргэх тул олон улсын

байгууллагуудаас үнийг 2019 оноос бууруулж төсөөллөөд байна. Ингэснээр төмрийн хүдрийн үнэ 73 ам.доллар болохоор байна.

Нүүрс. БНХАУ-ын Засгийн газраас Шаньси, Өвөрмонгол, Шэньси, Ниншя, Хүбэй зэрэг мужууд дах бага хүчин чадалтай, өрсөлдөх чадвар, үр ашиг муутай жижиг уурхайнуудын үйл ажиллагааг зогсоож байгаа, түүнчлэн, дэд бүтцийн хөрөнгө оруулалт нэмэгдсэнтэй холбоотойгоор тус улсын нүүрсний импорт нь сүүлийн 3 жил дараалан өсөөд байна.

Харин БНХАУ-ын эдийн засгийн өсөлт саарч байгаа, худалдааны маргааны улмаас шинжээчид Австралийн коксжих нүүрсний үнийг цаашид буурч, 2020 онд 154 ам.долларт хүрнэ гэж төсөөлж байна.

График №4. Нүүрсний үнийн хөдөлгөөн, төсөөлөл, ам.доллар/тонн




Эх үүсвэр: Блүүмбэрг

Газрын тос. 2019 оны эхний 8 сарын байдлаар дэлхийн эдийн засгийн өсөлт саарсантай холбоотойгоор газрын тосны үнэ 2018 оноос 12 орчим хувиар буурсан.

Харин Саудын Арабын газрын тосны байгууламж руу хийсэн дайралтын улмаас газрын тосны үнэ 2019 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр огцом өссөн ч тус улс

нийлүүлэлтийн доголдол үүсгэхгүйн тулд нөөцөөсөө нийлүүлж, зах зээлд үнийн савалгаа үүсгээгүй бөгөөд ойрын хугацаанд үйлдвэрлэл хэвийн түвшинд хүрэх талаар мэдээллээд байна. Иймд судлаачдын таамгаар газрын тосны үнэ 2019 онд өмнөх оноос бага байхаар байна.

График №5 Газрын тосны үнийн хөдөлгөөн, төсөөлөл, ам.доллар/тонн



Эх үүсвэр: Блүүмбэрг

Харин газрын тосны үнэ² 2020 онд 64 ам.долларт хүрэх төлөвтэй байгааг шинжээчид илэрхийлж байна.

1.2. Монгол Улсын эдийн засаг

1.2.1. 2018 оны гүйцэтгэл

Эдийн засгийн өсөлт. 2018 онд Монгол Улсын эдийн засаг сүүлийн дөрвөн жилийн хугацаанд хамгийн өндөр буюу 7.2 хувиар өсөв.

Засгийн газар 2018 онд төсвийн сахилга батыг сайжруулснаар Монгол Улсын нэгдсэн төсөв ашигтай гарлаа. Мөн Засгийн газрын бонд гаргаж арилжааны банкнуудаас хөрөнгө татдаг байсныг зогсоосноор хувийн хэвшилд олгох зээл, хөрөнгө оруулалт нэмэгдэж, зээлийн хүү 16.9 хувь хүртэл буураад байна.

² Brent маркийн газрын тосны үнэ

Түүнчлэн, бизнесийн орчин сайжирч Монгол Улсад оруулсан хөрөнгө оруулалт 2018 онд 30 хувиар нэмэгдэж, экспортын хэмжээ 13.1 хувиар өслөө.

Макро эдийн засгийн тогтвортой орчин бүрдэж байгаагийн үр дүнд эдийн засгийн өсөлт нэмэгдлээ.

Өсөлтийн дүнд бизнес эрхлэгчдийн орлого нэмэгдэж, ашигт ажиллагаа сайжирч, улсын төсөвт төвлөрүүлсэн аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 2017 оноос 32 хувиар нэмэгдсэн байна. Мөн эдийн засгийн өсөлтийн нөлөөгөөр ажил эрхлэлт нэмэгдэж, өрхийн орлого 15 хувиар³ өсөөд байна.

Эдийн засгийн өсөлтийг салбаруудаар авч үзвэл боловсруулах аж үйлдвэрийн салбар 2017-2018 онд 16-20 хувиар өсөж, эдийн засгийн бүтцийг сайжруулсан.

Хүснэгт №2. Эдийн засгийн өсөлт, салбаруудаар

	2015	2016	2017	2018
Эдийн засгийн өсөлт	2.4	1.2	5.3	7.2
Хөдөө аж ахуй	10.7	6.2	1.8	4.5
Үйлдвэрлэл	9.9	-0.4	0.7	7.4
Уул уурхай	14.1	0.2	(5.5)	5.7
Боловсруулах аж үйлдвэр	2.6	(0.8)	19.9	15.7
Цахилгаан	3.1	1.5	5.0	8.2
Барилга	(0.2)	(4.9)	11.4	2.4
Үйлчилгээ	0.6	1.1	7.7	5.0
Худалдаа	(8.1)	(2.6)	6.8	3.4
Тээвэр	5.1	11.5	14.2	7.6
Мэдээлэл, холбоо	(2.5)	(6.6)	13.3	7.8
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	5.8	1.1	5.4	4.8
Цэвэр татвар	(22.1)	0.5	18.5	20.1

Эх үүсвэр: Үндэсний Статистикийн Хороо

Нүүрс, жонш, алтны үйлдвэрлэл нэмэгдсэний зэрэгцээ Оюутолгойн алтны агууламж сайжирснаар уул уурхайн салбарын өсөлт нэмэгдэж, 5.7 хувьд хүрэв.


Уул уурхайн бус салбар 2018 онд 7.7 хувиар өсөөд байна.

Ургацын хэмжээ 2018 онд нэмэгдэж, 453 мянган тонн үр тариа, 170 мянган тонн төмс, 100 мянган тонн хүнсний ногоо хураан авснаар хөдөө аж ахуйн салбар 4.5 хувиар өссөн байна.

Зээлийн хэмжээ нэмэгдэж, санхүү, үл хөдлөх болон үйлчилгээний бусад салбаруудын өсөлт эрчимжиж, 4.8 хувьд хүрсэн.

Гадаад худалдаа. Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2018 онд 12.9 тэрбум ам.доллар болж, өмнөх оноос 22.5 хувиар өссөн бол гадаад худалдааны тэнцэл 1153.7 сая ам.долларын ашигтай гарлаа.

График №6 Гадаад худалдааны гүйцэтгэл, тэрбум ам.доллар



Эх үүсвэр: Үндэсний Статистикийн Хороо

Монгол Улс 2018 онд 7.0 тэрбум ам.долларын бараа, түүхий эд экспортолсон нь 2017 оноос 13.4 хувиар өссөн байна. Уг өсөлтөд нүүрс, зэсийн баяжмал, жонш зэрэг уул уурхайн бүтээгдэхүүний экспорт өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Импортоор 2018 онд 5.9 тэрбум ам.долларын бараа, түүхий эд авсан нь 2017 оноос 35.5 хувиар өсжээ. Импортын өсөлтөд

³ Нэг өрхийн сарын дундаж орлого 2017 оны 4 дүгээр улиралд 1,041 мянган төгрөг байсан бол 2018 оны 4 дүгээр улиралд 1,202 мянган төгрөг болсон.

мал, амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүн, хүнсний зүйл, дизелийн түлш, машин, механик тоног төхөөрөмж, төмөрлөг бүтээгдэхүүн, бүх төрлийн автомашины өсөлт голлон нөлөөлсөн байна.

Төлбөрийн тэнцэл. Төлбөрийн тэнцэл нь 2018 онд 141.7 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Дансуудаар авч үзвэл, урсгал данс 2,206.8 сая ам.долларын алдагдалтай, санхүүгийн данс 2,091.0 сая ам.долларын ашигтай гарсан байна.

Эдийн засгийн идэвхжил сэргэсэнтэй холбоотойгоор импорт 35.5 хувиар өссөн нь 2018 онд урсгал тэнцлийн алдагдал нэмэгдэхэд голлон нөлөөлсөн байна. Харин Чингис-1 болон Дим сам бондын төлбөрийг эргүүлэн төлсөнтэй холбоотойгоор багцын хөрөнгө оруулалтын ашиг буурсан нь санхүүгийн дансны ашиг өмнөх оноос буурахад нөлөөлсөн байна. АХБ болон БНСУ-аас орж ирсэн санхүүгийн эх үүсвэр, МУХБ-ны 500 сая ам.долларын гадаад бондын эх үүсвэр зэрэг нь санхүүгийн дансны ашигт эергээр нөлөөлсөн байна.

График №7. Төлбөрийн тэнцэл, тэрбум ам.доллар



Эх үүсвэр: Монголбанк

Монгол Улсад 2018 онд цэвэр дүнгээр 2,173.7 сая ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалт орж ирсэн байна. Оюутолгой төслийн хүрээнд 2018 онд 1,304.3 сая ам.долларын хөрөнгө оруулалт орж

ирснээс 1,213.8 сая ам.долларын хөрөнгийг далд уурхайн бүтээн байгуулалтад оруулсан байна.

Мөнгөний нийлүүлэлт. Мөнгөний нийлүүлэлтийн хэмжээ 2018 оны гүйцэтгэлээр өмнөх онтой харьцуулахад 22.8 хувиар өсөж 19.5 их наяд төгрөгт хүрэв. Үүнд, гадаад валютын харилцах 20.6 хувь, төгрөгийн харилцах 51.8 хувь, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 9.6 хувь, төгрөгийн хадгаламж 17.8 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ. Мөнгөний нийлүүлэлт ийнхүү өсөхөд эдийн засгийн идэвхжилт, аж ахуйн нэгжүүдийн ашигт ажиллагааны өсөлт, ажил эрхлэлтийн өсөлт, зээлийн өсөлт зэрэг эдийн засгийн эерэг үзүүлэлтүүд дэмжлэг болов.

Монголбанк бодлогын хүүг 2018 оны 3 дугаар сард 1 нэгжээр бууруулсан нь хөрөнгө оруулалт, бодит секторын идэвхжилд дэмжлэг үзүүлсэн бол төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн сулрал болон инфляцийн идэвхжилттэй холбоотойгоор 11 дүгээр сараас бодлогын хүүг 1 нэгжээр эргүүлэн өсгөсөн болно.


График №8. Мөнгөний нийлүүлэлт /тэрбум төгрөг/



Эх үүсвэр: Монголбанк

Актив талаас авч үзвэл 2017 оны турш мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн дийлэнх хэсгийг гадаад цэвэр актив (ГЦА) бүрдүүлж байсан бол 2018 онд дотоод цэвэр актив (ДЦА) ихээр өссөн нь мөнгөний нийлүүлэлт 22.8 хувиар өсөхөд нөлөөлсөн байна.

График №9. Мөнгөний нийлүүлэлт, гадаад болон дотоод цэвэр активын жилийн өөрчлөлт



Эх үүсвэр: Монголбанк

Инфляц. Инфляцын түвшин 2018 оны сүүлийн саруудад өсөж, жилийн эцэст 8.1 хувьд хүрлээ. 2018 онд нийлүүлэлтийн шалтгаантай үнийн өсөлт давамгайлсан байна. Тухайлбал, хатуу түлш буюу түлээ, нүүрсний үнийн өсөлт 2.4 нэгж хувь, махны үнийн өсөлт 1.7 нэгж хувь, шатахууны үнийн өсөлт 1.3 нэгж хувийг бүрдүүлсэн.

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2017 оны мөн үеэс суларсаны зэрэгцээ дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ өсөлттэй байсан нь шатахууны хилийн үнэ 9.9-30.8 хувиар өсөхөд нөлөөлсөн байна. Харин хатуу түлшний үнэ улирлын онцлогтойгоор өссөн бол махны бүлгийн үнийн өсөлтөд малын зүй бус хорогдол болон махны экспортын өсөлт нөлөөлжээ.

Ажилгүйдэл. Ажиллах хүчний түүвэр судалгаагаар 2018 онд ажиллах хүчний оролцооны түвшин 61 хувьтай, ажилгүйдлийн түвшин 7.8 хувьтай байв.

2018 онд эдийн засгийн идэвхтэй хүн ам 1,359 мянга болж, ажиллагчдын тоо 1253

мянгад хүрч өслөө. Ажилгүй иргэдийн тоо 13.4 мянгаар буурсан байна.

График №10. Ажилгүйдлийн түвшин, улирлаар



Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо

1.2.2. 2019 оны хүлээгдэж буй гүйцэтгэл

Эдийн засгийн өсөлт. Монгол Улсын эдийн засаг 2019 оны эхний хагас жилд 7.3 хувиар өсөж, өмнөх оны мөн үеэс 0.7 нэгжээр нэмэгдсэн байна.

Засгийн газар эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх хүрээнд дотоод үнэт цаасны үлдэгдлийг тогтмол бууруулж, хувийн хэвшлийн зээл авах боломжийг нэмэгдүүлэх бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэв.

Түүнчлэн, улсын төсөв, зээл тусламжаар хийгдэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлж байна. Монгол Улсын нэгдсэн төсвийн хөрөнгийн зардал 2019 оны эхний 8 сарын байдлаар 70 орчим хувиар өсөж, эдийн засгийн өсөлтийг дэмжиж байна.

Газрын тос боловсруулах үйлдвэр, төв цэвэрлэх байгууламж, төмөр зам, авто зам зэрэг хүнд үйлдвэр, дэд бүтцийн томоохон бүтээн байгуулалт хийж, эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлж байна.

Мөн цалин, тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх замаар өрхийн хэрэглээг


дэмжиж, нийт эдийн засаг дахь эрэлтийг өсгөх бодлогыг хэрэгжүүлж байна.

Гадаад худалдаа. Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2019 оны 8 дугаар сард 9.5 тэрбум ам.доллар болж, гадаад худалдааны тэнцэл 1295.7 сая ам.долларын ашигтай гарсан.

Экспортоор 5.4 тэрбум ам.долларын бараа, түүхий эд гаргасан нь 2018 оны мөн үетэй харьцуулахад 15.3 хувиар өссөн. Экспортын өсөлтөд чулуун нүүрс, төмрийн хүдэр болон боловсруулаагүй алтны экспорт өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Импортоор 4.1 сая ам.долларын бараа, түүхий эд авсан нь 2018 оны мөн үеэс 7.4 хувиар өссөн байна. Уг өсөлтөд авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд, анги, эрдэс бүтээгдэхүүн, хуванцар болон түүгээр хийсэн бүтээгдэхүүний импорт өссөн нь голлон нөлөөлжээ.

График №11. Гадаад худалдаа, жил бүрийн эхний 8 сарын байдлаар, тэрбум ам.доллар



Эх үүсвэр: Үндэсний Статистикийн Хороо

Хүлээгдэж буй гүйцэтгэлээр 2019 онд гадаад худалдааны нийт эргэлт 13.9 тэрбум ам доллар, гадаад худалдааны тэнцэл 1.5 тэрбум ам.долларт хүрэхээр байна.

Чулуун нүүрс, төмрийн хүдэр, боловсруулаагүй алтны дэлхийн зах зээлийн үнэ өссөнтэй холбоотойгоор манай улсын экспортын хэмжээ 2018 оны түвшнээс 10 орчим хувиар өсөж 7.7 тэрбум ам.доллар болохоор байна.

Ачааны болон суудлын автомашин, машин механизм, механик тоног төхөөрөмж ба эд анги, автобензин, дизелийн түлшний импорт өссөнөөр нийт импортын хэмжээ 2018 оноос 7.0 хувиар өсөхөөр байна.

Төлбөрийн тэнцэл. Төлбөрийн тэнцэл нь 2019 оны эхний хагас жилд 456.0 сая ам.долларын ашигтай гарсан байна (өмнөх оны мөн үед 172.0 сая ам.долларын алдагдалтай байжээ). Мөн хугацаанд урсгал данс 722.2 сая ам.долларын алдагдалтай гарсан бол хөрөнгө болон санхүүгийн данс 1,083.2 сая долларын ашигтай гарсан байна.

Харин 2019 оны 2 дугаар сард МИК гадаад зах зээлд 300 сая ам.долларын үнэт цаас гаргасантай холбоотойгоор санхүүгийн дансны ашиг нэмэгдэж байна.

График №12. Төлбөрийн тэнцэл, 2019 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, сая ам.доллар



Эх үүсвэр: Монголбанк, Сангийн яам

2019 онд уул уурхай, олборлолт, бөөний болон жижиглэн худалдааны салбарт хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр Монгол Улсад орж ирэх гадаадын шууд хөрөнгө

оруулалт 2 тэрбум ам.доллар давах төлөвтэй байна.

Гадаад худалдааны тэнцэл сайжирч байгаа нь урсгал тэнцэлд эергээр нөлөөлж байгаа бөгөөд төлбөрийн тэнцэл 2019 онд ашигтай гарах төлөвтэй байна.

Инфляц. Инфляцын түвшин 2019 оны 8 дугаар сард 8.9 хувийн өсөлттэй гарлаа. Цалин болон төсвийн зардлын нөлөөгөөр дотоод эрэлт нэмэгдэх төлөвтэй байгаа бол нийлүүлэлтийн шинжтэй өсөөд байсан хатуу түлш, шатахуун зэргийн үнийн өсөлт саармагжиж байгаа нь инфляц 2019 онд зорилтот түвшинд хадгалагдахаар байна. Харин цаг уурын өөрчлөлтийн нөлөө нь хүнсний бүлгийн зарим бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтэд нөлөөлж болзошгүй.

1.2.3. Макро эдийн засгийн 2020-2022 оны төсөөлөл

Эдийн засгийн өсөлт. Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг 2020-2022 онд урт хугацааны өсөлтийн түвшинд буюу 6 хувьд байлгах аар зорьж байна.


Дунд хугацаанд худалдааны маргааны улмаас гадаад орчинд тодорхой бус байдал нэмэгдэж байгаа ч эдийн засгийн өсөлтийн зорилтод түвшинг хангахын тулд Засгийн газар дараах бодлогуудыг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- 1) Төсөв, санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх, үр ашиггүй зардлыг бууруулах бодлогыг тууштай хэрэгжүүлж, макро эдийн засгийн орчны тогтвортой байдлыг хангана. Ингэснээр Монгол Улсын зээлжих зэрэглэлийг сайжруулж, хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх замаар Монгол Улсад орж ирэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
- 2) Татвар, гаалийн шинэчлэлийг хэрэгжүүлэн бизнесийн орчныг

сайжруулж, гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлнэ.

- 3) Банкны салбарт шинэчлэл хийж, тус салбарыг либералчлах эрхзүйн орчинг бүрдүүлж шударга өрсөлдөөнийг нэмэгдүүлнэ. Банк, санхүүгийн зах зээлд финтекийн дэвшлүүдийг нэвтрүүлж, санхүүгийн үйлчилгээний хүртээмж, үр нөлөөг сайжруулах замаар зээлийн хүүг бууруулж эдийн засгийн идэвхжилтийг дэмжинэ.
- 4) Эдийн засгийн өрсөлдөх чадварыг сайжруулах, үндэсний бүтээмжийг дээшлүүлэх төмөр зам, авто зам, цахилгаан эрчим хүч, цэвэрлэх байгууламж, газрын тос боловсруулах үйлдвэр зэрэг томоохон дэд бүтэц, үйлдвэрийн бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх замаар эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийг хангана.
- 5) Аялал жуулчлалын бүс нутгуудыг хөгжүүлж, үндэсний өв соёл, урлагийн үзвэрүүдийн барилга, байгууламжийг сайжруулж, иргэнийг агаарын тээврийг либеральчлах замаар нислэгийн тийзний үнийг бууруулж, аялал жуулчлалын салбараас орох орлогыг нэмэгдүүлж, эдийн засгийн бүтцийг сайжруулах бодлогыг хэрэгжүүлнэ.

График №13. ДНБ-ий хэмжээ, их наяд төгрөгөөр, эдийн засгийн өсөлт, хувиар



Эх үүсвэр: Сангийн яам

Гадаад худалдаа. Монгол Улсын гадаад худалдааны нийт бараа эргэлт 2020 онд 14.5 тэрбум ам.долларт, 2021 онд 15.0 тэрбум ам.долларт, 2022 онд 15.7 тэрбум ам.долларт тус тус хүрч, гадаад худалдааны тэнцэл 2020-2022 онд дундажаар 1.6 тэрбум ам.долларын ашигтай гарахаар төсөөлж байна.

График №14. Гадаад худалдаа




Эх үүсвэр: Сангийн яам

Экспорт 2020 онд 7.8 тэрбум ам.долларт хүрэхээр төсөөлж байна. Дэлхийн зах зээл дэх алтны үнэ өндөр байх тул 2020 онд алтны экспортыг нэмэгдэхээр төсөөлж байна. Импорт 2020 онд 6.7 тэрбум ам.долларт хүрэхээр байна.

Төлбөрийн тэнцэл. Дунд хугацаанд уул уурхайн болон дэд бүтцийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилттэй холбоотойгоор импортын хэмжээ өсөх хүлээлттэй байна.

График №15. Төлбөрийн тэнцэл, 2020-2022 оны төсөөлөл



Эх үүсвэр: Сангийн яам

Дунд хугацаанд хөрөнгө, санхүүгийн дансны өөрчлөлтөд нөлөөлөх гол хүчин зүйлс нь гадаадын шууд хөрөнгө оруулалт, гадаад үнэт цаас, Олон Улсын Валютын сангийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд орж ирэх төсвийн дэмжлэг зэрэг байна.

Оюутолгой төслийн далд уурхайн бүтээн байгуулалттай холбоотой хөрөнгө оруулалт тасралтгүй өсөх төлөвтэй байна.

Олон Улсын Валютын Сангийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, ЖАЙКА зэрэг байгууллагуудаас төсвийн дэмжлэгт зориулсан санхүүжилт орж ирэхээр байна.

Инфляц. Инфляцын түвшин дунд хугацаанд буюу 2020-2022 онд 8 орчим хувьд байхаар байна. Засгийн газраас татварын багц хуулийн шинэчлэл хийж, бизнесийн орчныг сайжруулах, 1.5 тэрбумаас бага орлоготой аж ахуйн нэгжүүдийн орлогын албан татварыг 90 хувиар хөнгөлөх бодлого хэрэгжүүлнэ. Энэ нь бизнесийн зардлыг бууруулж, үйлдвэрлэл, нийт нийлүүлэлтийг нэмэгдүүлэх тул инфляцын түвшнийг зорилтод хэмжээнд, тогтвортой байлгах боломж бүрдэнэ.

1.2.4. Макро эдийн засгийн төсөөлөлд учирч болзошгүй эрсдэл

Нэг. АНУ болон БНХАУ-ын хоорондын худалдааны маргаан цаашид хэрхэн үргэлжлэх, БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн сааралт түүхий эдийн эрэлтэд хэрхэн нөлөөлөх, мөн БНХАУ болон бусад томоохон орнуудын хэрэгжүүлж буй бодлого өөрчлөгдөх зэрэг гадаад орчны тодорхой бус хүчин зүйлүүд нь экспортын түүхий эдийн үнэ, эрэлтэд нөлөөлөх эрсдэл байна.

Хоёр. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Ази, номхон далайн бүсийн байгууллага/АНДББ/-ын Монгол

Улсад өгсөн зөвлөмжийн үнэлгээнүүдийг сайжруулж, тодорхой ахиц гаргаж байгаа хэдий ч 2019 оны 10 дугаар сард болох ФАТФ-ын хуралдаанаар Монгол Улс тус байгууллагын хяналт/саарал жагсаалт/-д орох өндөр эрсдэлтэй хэвээр байна. Саарал жагсаалтад орсон тохиолдолд гадаад гүйлгээ хүндрэлтэй болох, хөрөнгө оруулагчдын итгэл сулрах, зээлжих зэрэглэл буурах, гадаад төлбөр тооцооны зардал нэмэгдэж, хугацаа удаашрах эрсдэл үүсэж болзошгүй байна.

Гурав. Арилжааны банкуудад хийсэн активын чанарын үнэлгээний мөрөөр банкнуудын өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх ажлын хэрэгжилт хангалтгүй байна. Монголбанкнаас банкуудын өөрийн хөрөнгийг нэмэгдүүлсэн эх үүсвэрийн гарал үүсэл, өөрийн хөрөнгөнд тооцогдох боломжтой эсэхийг магадлан шалгах шалгалтыг олон улсын мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн. Шалгалтын үр дүнд үндэслэн банкуудад өөрийн хөрөнгөө өсгөх шаардлагыг тавьж, хэрэгжүүлж чадахгүй нөхцөлд санхүүгийн салбарт хүндрэл үүсэх эрсдэлтэй байна.

Дөрөв. Цаг уурын урьдчилсан судалгаагаар энэ өвөл хур тунадасны хэмжээ олон жилийн дунджаас өндөр байх магадлалтай байгаа тул өвөлжилт хүндэрч болзошгүй юм.

Тав. Махны нийлүүлэлтийн сүлжээг сайжруулахад чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээ шуурхай хэрэгжүүлэхгүй бол экспортод гаргах махны хэмжээ нэмэгдэх, дотоодын зах зээлд худалдаалагдах махны үнэд огцом нөлөөлж болзошгүй байна.

1.2.5. Макро эдийн засгийн төсөөлөл боловсруулахад ашигласан аргачлал, тооцооны товч танилцуулга

Макро эдийн засгийн төсөөллийг боловсруулахдаа үндсэн үзүүлэлтүүд болох бодит ба нэрлэсэн ДНБ, инфляц, экспорт, импорт, ажилгүйдлийн түвшин зэргийг Олон Улсын Валютын Сангийн боловсруулсан Санхүүгийн програмчлал /Financial Programming/ макро эдийн засгийн загвар болон бусад макро эконометрик прогнозийн загваруудыг суурь болгон ашиглав.

2. 2020 ОНД БАРИМТЛАХ ТӨСВИЙН БОДЛОГО



Засгийн газраас авч хэрэгжүүлж буй “Цахим, ил тод, үр ашигтай” төсвийн бодлогын үр дүнд эдийн засгийн өсөлт сэргэж 2019 оны эхний хагас жилийн байдлаар 7.3 хувьд хүрч, 2018 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр төсвийн тэнцэл 27.8 тэрбум төгрөгийн ашигтай гарсан нь 2010 оноос хойш Монгол Улсын нэгдсэн төсөв 8 жилийн дараа анх удаа гарсан эерэг үзүүлэлт боллоо.

Ирэх онд Эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих “Цахим, ил тод, үр ашигтай” төсвийн бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. Үүнд:

1

Төсвийн сахилга батыг тууштай үргэлжлүүлэн, төсвийг эрүүлжүүлэх, алдагдлыг үе шаттай бууруулах бодлогыг хэрэгжүүлнэ

2

Засгийн газрын 2012-2016 онд гаргасан бондуудыг эргэн төлөхтэй холбогдуулан төсвийн алдагдлыг хуульд заасан хэмжээнээс сайжруулж, 2023 оноос ашигтай гаргах бодлого баримтална.

3

Засгийн газрын зүгээс 2021-2024 онуудад төлөгдөх нийт 2.9 тэрбум ам.долларын өндөр хүүтэй гадаад үнэт цаасны төлбөрийг эдийн засаг, төсөвт дарамт үүсгэхгүй байх өрийн менежментийг хэрэгжүүлнэ

4

Бизнес, хөрөнгө оруулалт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн татварын шинэчлэлийг хэрэгжүүлнэ

5

Гаалийн шинэчлэлийг хэрэгжүүлж дуусгаснаар гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлж, байгалийн баялгаас татварыг бүрэн хураах боломжийг бүрдүүлнэ.

6

Зарлагын реформыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, үр ашиг, хүртээмжийг нэмэгдүүлнэ

7

Өмнөх жилүүдэд эхлүүлсэн хөрөнгө оруулалтын ажлуудыг дуусгаж, нийгэмд тулгамдсан төсөл хөтөлбөрүүдийг эхлүүлнэ

8

“Сумын төвийн шинэчлэл”-ийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, бүс тус бүрээс нэг сумыг хамруулна

ТӨСВИЙН ОРЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР:

Бизнес, хөрөнгө оруулалтын орчныг дэмжих, гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, татварын тэгш шударга, ил тод байдлыг хангахад чиглэсэн төсвийн орлогын дараах бодлогын арга хэмжээг 2020 онд авч хэрэгжүүлнэ. Үүнд:

Гаалийн шинэчлэл:



Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Гаалийн шинэчлэл”-ийн хүрээнд БНХАУ-ын буцалтгүй тусламж болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Замын-Үүд, Алтанбулаг, Гашуунсухайт боомтуудыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, хүчин чадлыг нэмэгдүүлж зорчигч тээвэр, ачаа тээврийн барилга байгууламж, иж бүрэн шугам сүлжээ, дэд бүтэц, зам талбай, ногоон байгууламжийн цогцолборууд барьж байгуулах бүтээн байгуулалтын ажлыг 2020 онд хэрэгжүүлж дуусгана. Улмаар Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Бичигт, Боршоо боомтын шинэчлэлийн ажлыг 2020 онд эхлүүлнэ.



Газрын тосны бүтээгдэхүүн импортолдог, ашигт малтмал экспортолдог гол боомтуудад олон улсын шаардлагад нийцсэн өндөр хүчин чадлын тоног төхөөрөмж бүхий гаалийн төрөлжсөн лабораториудыг байгуулж, Гаалийн төв лабораторийг олон улсын итгэмжлэлд хамруулна.



Уул уурхайн бүтээгдэхүүн экспортолж буй тээврийн хэрэгслээс ашигт малтмалын дээжийн агууламж, чанарыг богино хугацаанд автоматаар тодорхойлох орчин үеийн дэвшилтэт технологи бүхий тоног төхөөрөмжүүдийг хилийн боомтууд дээр суурилуулан байгалийн баялгаас татварын бүрэн хураадаг болно.



Түүнчлэн, Гаалийн шуурхай удирдлагын төвийн өндөр хүчин чадлын телехяналтын системд

холбогдсон орчин үеийн камержуулалт болон тээврийн хэрэгслийг автоматаар бүртгэж хил нэвтрүүлэх ухаалаг гарцуудыг хилийн боомтуудад суурилуулна. Түүнчлэн, цагт 100 гаруй тээврийн хэрэгслийг хянаж нэвтрүүлэх хүчин чадал бүхий орчин үеийн өндөр технологийн рентген тоног төхөөрөмжүүдийг боомтуудад нэвтрүүлнэ.

Гаалийн шинэчлэлийн үр дүнд Замын-Үүд боомтын талбайн хэмжээ 8 дахин, өдөрт нэвтрүүлэх зорчигчдын тоо 4 дахин, суудлын тээврийн хэрэгслийн тоо 7 дахин, Гашуунсухайт боомтын экспортлох хүчин чадал 3 дахин, Алтанбулаг боомтын тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх хүчин чадал 4 дахин нэмэгдэх бөгөөд зорчигч, тээврийн хэрэгсэл хилийн боомтоор түргэн шуурхай нэвтрэн, ая тухтай үйлчлүүлэх боломж бүрдэж Монгол Улсын гадаад худалдаа, эдийн засгийн хөгжилд томоохон нөлөө үзүүлнэ. Түүнчлэн, гаалийн шинэчлэлийг хэрэгжүүлснээр хууль бус, чанарын шаардлага хангахгүй бараа, бүтээгдэхүүн хилээр нэвтрэхээс урьдчилан сэргийлж иргэдийн эрх ашгийг хамгаалахад чухал ач холбогдолтой юм.

Татварын шинэчлэл:



Эдийн засаг, хөрөнгө оруулалт, бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдөр баталсан Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татвар татварын тухай хуулийн шинэчилсэн найруулга болон дагалдах бусад хуулийн

шинэчлэлийг 2020 оноос хэрэгжүүлэн ажиллана.

Татварын шинэчлэлийн хүрээнд татвар төлөгч иргэн, аж ахуйн нэгжийн татварын ачаалал буурч, татварын хялбаршуулсан горим хэрэгжиж, татварын бүртгэл, тайлагнал цахим хэлбэрт бүрэн шилжинэ.



Жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор татварын хялбаршуулсан горимыг нэвтрүүлэн татварын тайлангийн тоог цөөрүүлж, жилийн 1.5 тэрбум төгрөгөөс бага борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийн төлсөн татварын 90 хувийг буцаан олгож, 300 сая төгрөгөөс доош борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүд 1 хувийн татвар төлнө.



Агаарын бохирдлыг бууруулах, иргэдийг орон сууцжуулах бодлогын хүрээнд анх удаа амьдран суух зориулалтаар орон сууц худалдан авсан иргэдэд үзүүлэх татварын хөнгөлөлтийн хэмжээг 2 дахин нэмэгдэнэ.

Нэмэгдсэн өртгийн албан татварын 20 хувийн буцаан олголтыг улирал тутам иргэдэд олгож эхэлнэ.



Татварын суурийг багасгах, ашиг шилжүүлэхийн эсрэг олон улсын стандарт, дүрмүүд 2020 оноос

хэрэгжиж эхэлнэ. Татварын ил тод байдлыг хангах чиглэлээр дэлхийн 150 гаруй улс орнууд болон төрийн бусад байгууллага, банк санхүүгийн байгууллагатай татварын зорилгоор мэдээлэл харилцан солилцож эхэлнэ.



Татвар төлөгч иргэдийн татварын боловсролыг дээшлүүлэх, татварын хууль тогтоомжийг сурталчлах ажлыг эрчимтэй зохион байгуулна.

Газрын бүртгэлийг цахимжуулж, ил тод болгох



Монгол Улсын Засгийн газраас газрын бүртгэлийн мэдээллийг ил тод болгох, газрын төлбөр ногдуулалт, төлөлтийг цахимжуулах замаар газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгжүүд газрын төлбөрөө хялбараар төлөх боломжийг бүрдүүлж, газрын төлбөрийн орлогыг бүрэн хураадаг болно.



Газар хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой үүсэж буй хүндрэлийг сум, дүүрэг нь бие даан шийдвэрлэх боломжийг олгох зорилгоор газрын төлбөрийн орлогын 40 хувийг тухайн сум, дүүргийн төсөвт хуваарилах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР:

Нийгмийн суурь үйлчилгээний чанар, хүртээмж, иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлэх, төсвийн урсгал зарлагын реформыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж төсвийн үр ашиг, хүртээмжийг сайжруулах бодлогын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

Боловсролын эрэлт, нийлүүлэлтийг зохистой хангах, чанартай боловсролын тогтолцоог дэмжинэ:



Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт шаардлагад нийцсэн мэргэжилтэн бэлтгэх зорилгоор МСҮТ-д суралцагчид 2019 оноос олгож эхэлсэн 100.0 мянган төгрөгийн тэтгэлгийг 2 дахин нэмэгдүүлж 200.0 мянган төгрөгт хүргэнэ. Өнөөдөр төрийн болон хувийн хэвшлийн 85 МСҮТ-дэд мэргэжлийн боловсролын 1 ба 2.5 жилийн, техникийн боловсролын 1.5 ба 3 жилийн хөтөлбөрт 40 орчим мянган суралцагч хамрагдаж, тэдэнд төрөөс сар бүр 100.0 мянган төгрөгийн тэтгэлэг олгож байна.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаанаас харахад хөдөлмөрийн зах зээлд 2019 онд 69.4 мянган ажлын байр бий болохоор байна. Үүний дийлэнх хувь нь барилга, бөөний болон жижиглэн худалдаа, боловсруулах үйлдвэр, аялал жуулчлалын салбарт бий болох хандлагатай байна.

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт шаардлагад нийцсэн, иргэдийн хэрэгцээ, авьяас сонирхолд тохирсон мэргэжлийн боловсролын тогтолцоог хөгжүүлэх бодлогыг дэмжих хөшүүрэг бий болгох шаардлагатай байна.

Их дээд сургууль төгсөгчдийн 25 хувь нь ажлын байртай болдог бол мэргэжлийн

сургалт үйлдвэрлэлийн төвийн төгсөгчдийн 80-аас дээш хувь нь ажлын байртай болж байна⁴. Гэвч элсэгчид болон төгсөгчдийн тооны харьцааны хувьд мэргэжлийн боловсролын байгууллагынх их дээд сургуулийнхаас 3 дахин бага байна. Энэ нь дээд боловсролын сургалтын чанар, нийлүүлэлт нь суралцагч, ажил олгогч, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд тохирохгүй байгааг харуулж байна.

Иймд өнгөрсөн онд Засгийн газраас хэрэгжүүлж эхэлсэн бодлогыг үргэлжлүүлэх, хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй байгаа ажлын байрыг дотоодоосоо хангах, дээд боловсролын зохиомол эрэлтийг бууруулж мэргэжлийн боловсролын сургуульд элсэгчдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор суралцагчдад олгох сарын тэтгэлгийн хэмжээг 200.0 мянган төгрөгт хүргэнэ .



2012 оноос хойш нэмэгдүүлээгүй цэцэрлэгийн хүүхдийн хоол болон ЕБС-ийн Үдийн цай хөтөлбөр, дотуур байрны хоолны зардлыг 50 хувиар тус тус нэмэгдүүлнэ. Цэцэрлэгийн хүүхдийн хоол, ЕБС-ийн сурагчдын үдийн цай, дотуур байрны хоолны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлдэг. Ингэхдээ бага ангийн сурагчийн үдийн цайг 600 төгрөг, цэцэрлэгийн хүүхдийн нэг өдрийн хоолыг 1,650 төгрөг, дотуур байрны хоолыг 2,315 төгрөгөөр тооцож олгож байна. Эдийн засаг, төсвийн боломжоос шалтгаалан 2012 оноос хойш шинэчлээгүй дээрх тарифыг 50 хувиар

⁴ Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн түүвэр судалгаа-2016, ХНХ-ын судалгааны институт; Ажиллах хүчний судалгааны тайлан, УСГ

тус тус өсгөнө. Энэхүү арга хэмжээнд давхардсан тоогоор нийт 660 орчим мянган хүүхдийг хамруулна.

Эрүүл мэндийн салбарт чанартай үйлчилгээг бий болгох нөхцөлийг бүрдүүлж, санхүүжилтийн ялгавартай байдлыг арилгана:



Төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээний тарифыг ижил тогтоож, нэмэгдүүлнэ. Төрийн өмчийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад ЭМД-аас олгодог эмнэлгийн тусламж үйлчилгээний нөхөн төлбөр тооцох тариф харилцан адилгүй байна. Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлдэг төрийн өмчийн эмнэлгүүдэд нэг иргэнээр тооцож 300.0 мянган төгрөгийн тарифаар санхүүжилт олгодог бол харин хувийн эмнэлэгт энэ нь 175.0 мянган төгрөг байна. Гэвч үзүүлж байгаа тусламж үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж нь төрийн өмчийн эмнэлгүүдийн хувьд хангалтгүй байна.

Анхан шатлалын тусламж үйлчилгээ үзүүлдэг улсын төсвийн байгууллагууд болох сумын эрүүл мэндийн төвийн нэг иргэнээр тооцсон тариф 37.7 мянган төгрөг байхад хувийн хэвшил бие даан хэрэгжүүлж байгаа өрхийн эрүүл мэндийн төвд 17.0 мянган төгрөг буюу 2 дахин бага байна. Харин эсрэгээрээ өрхийн эрүүл мэндийн төвийн үзүүлсэн үйлчилгээний тоо хэмжээ нь сумын эрүүл мэндийн төвийнхөөс 2.8 дахин их байна.

Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудад давуу боломж олгосон бүх шатны тусламж үйлчилгээний тарифыг шинэчлэн тогтоож, нэмэгдүүлэх замаар хувийн болон төрийн эмнэлгүүдэд адил боломж олгосон өрсөлдөөн бүхий иргэнд

ээлтэй, хүртээмжтэй эмнэлгийн тусламж үйлчилгээг бий болгоно.



Иргэн амбулаторийн оношилгоо, хөнгөлөлттэй эм, хэвтүүлэн эмчлэх үйлчилгээг нэг дор цогц байдлаар авах боломж олгоно. Амбулаторийн оношилгоо-үзлэг, эмийн сан, эмнэлэг хоорондоо харилцан уялдаа муутайгаас болж үйлчлүүлэгчид эдгээр байгууллагуудын хооронд чирэгдэж, хугацаа алдаж мөнгөө үр ашиггүй зарлагдаж байна. Эдгээр гурван үйлчилгээг нэг дороос, бодит өртөг шингэсэн тарифын дагуу ЭМД-ын сангаас санхүүжүүлнэ. Ингэснээр иргэн эрүүл мэндийн цогц үйлчилгээг нэг доороос, санхүүгийн нэмэлт дарамтгүйгээр авах боломжтой болно.



Төрийн өмчийн эмнэлгүүд үзүүлсэн тусламж үйлчилгээний тоо хэмжээ, чанарт тохирсон санхүүжилт авч, төсвийн менежментээ бие даан хэрэгжүүлдэг болно. Бодит өртгийн судалгаанд үндэслэн ЭМД-аас санхүүждэг 118 оношны хамааралтай бүлгийг 303 бүлэгт, улсын төсвөөс санхүүжих тусламж үйлчилгээг 101 оношны хамааралтай бүлэгт тус тус шилжүүлж, суурь тарифыг нэмэгдүүлнэ. Эмнэлгүүд улсын төсөв болон ЭМД-аас авч байгаа санхүүжилт, төлбөрт үйлчилгээний орлогоо бие даан зарцуулах эрхтэй болж менежментээ үр ашигтай хэрэгжүүлдэг болно.

Ахмад настан, эхчүүд, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, болон төрийн албан хаагчийн бодит орлогыг нэмэгдүүлнэ



2014 оноос хойш нэмэгдүүлээгүй байсан цалин, тэтгэвэр, тэтгэмжийг инфляцтай уялдуулж 2018 оноос жил бүр нэмэгдүүлж байгаа Засгийн газрын бодлогыг үргэлжлүүлнэ. Ирэх онд төрийн албан хаагчдын цалингийн санг 8 хувиар нэмэгдүүлнэ. Түүнчлэн

нийгмийн даатгалын сангаас олгох бүх төрлийн тэтгэвэр болон нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг инфляцтай уялдуулан нэмэгдүүлнэ.



Төрийн үйлчилгээний албан хаагч нь төрийн захиргааны албан хаагчийн нэгэн адил төрд ажилласан хугацаагаараа тооцуулж цалингийн нэмэгдэл, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж авах боломжийг 2020 оноос эхлэн олгоно. Төрийн албаны тухай хууль(шинэчилсэн найруулга)-ийн дагуу ирэх 2020 оноос эхлэн төрийн үйлчилгээний албан хаагчид ажилласан жилийн хугацаанаас хамаарсан цалингийн нэмэгдэл болон өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийг авч эхэлнэ.



Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид 1995-2019 оны хооронд төлж чадаагүй шимтгэлээ 2020 онд нэг удаа нөхөн төлж, тэтгэвэр авах боломжтой болно. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийг Монгол Улсын Их Хурал 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдөр баталж, 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр шийдвэрлэсэн. Малчид хувиараа хөдөлмөр эрхлэгчид шимтгэл нөхөн төлсөн жилээсээ эхлэн тэтгэвэр тогтоолгох боломжийг хамтад нь олгож байгаатай холбогдуулан тэтгэврийн сангийн эх үүсвэрийг тогтвортой байлгахад чиглэсэн зарим өөрчлөлтүүдийг холбогдох хуульд өөрчлөлт оруулах замаар зохицуулна.



Эхчүүдийн хамгааллыг нийгмийн сайжруулна. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар өөрчлөлт хийгдсэн дараах зардлыг 2020 оны 01 дүгээр сарын 01-ээс эхлэн Нийгмийн даатгалын

тэтгэвэр, тэтгэмжийн сангаас санхүүжүүлнэ. Үүнд:

- 1/ Төрүүлсэн болон гурав хүртэл настайд нь үрчлэн авч зургаан нас хүртэл хүүхдээ өсгөсөн эхийн НДШ төлсөн нийт хугацаан дээр төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэд бүрийн тоогоор нэг жил зургаан сарыг нэмж тооцох;
- 2/ Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан эхийн жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг цалин хөлснийх нь 70 хувиар тооцож байсныг 100 хувиар тооцож олгох;
- 3/ Нийгмийн даатгалд даатгуулаагүй эх хүүхдээ асрах хугацаанд төлбөл зохих шимтгэлийн 50 хувийг өөрөө, үлдэх 50 хувийг төрөөс;
- 4/ Сайн дураар даатгуулсан эхийн хүүхдээ асрах хугацаанд төлбөл зохих шимтгэлийг өөрөө хариуцаж байсныг холбогдох хуульд өөрчлөлт оруулж 50 хувийг өөрөө, үлдэх 50 хувийг тэтгэмжийн даатгалын сангаас;



Хөнгөлөлттэй нөхцөлөөр эрт тэтгэвэр тогтоолгосон зарим эхчүүд, эмэгтэйчүүдийн тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлнэ. Улсын Бага Хурлаас 1990 оны 11 дүгээр сард “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Тэтгэврийн хууль”-ийг шинэчлэн баталсан бөгөөд энэхүү шинэчлэлийн нэг өөрчлөлт нь олон хүүхэд төрүүлсэн эхчүүд болон улсанд олон жил ажилласан хүмүүсийг онцгойлон үзэж хөнгөлөлттэй нөхцөлөөр эрт тэтгэвэр тогтоолгох эрхийг хуульчилсан явдал байв. Гэвч хөнгөлөлттэй нөхцөлөөр залуу насандаа тэтгэвэр тогтоолгосон, олон хүүхэд төрүүлсэн эхчүүдийн ажилласан жил цөөн, тэтгэвэр тогтоолгосон цалингийн хэмжээ бага байгааг харгалзан тэтгэврийн хэмжээг нь нэг удаа тусгайлан нэмэгдүүлэх арга хэмжээ авна.

3. НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



3.1. Төсвийн нэгдсэн үзүүлэлтүүд

Монгол Улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхийн зэрэгцээ, төсвийн нэгдмэл, тэнцвэртэй байдлыг хангах, сахилга батыг сайжруулах, төсвийн тогтвортой байдлыг хангах замаар макро эдийн засгийн жигд өндөр өсөлтийг дэмжихэд чиглэсэн дунд хугацаанд баримтлах бодлого стратегийн хүрээнд төсвийн үндсэн үзүүлэлтүүдийг боловсрууллаа.

Төсвийн алдагдлыг үе шаттайгаар жил дараалан бууруулснаар 2020 онд төсвийн алдагдлыг тогтвортой байдлын тухай хуулийн хязгаарт багтаан ДНБ-ий -5.1 хувь байхаар төлөвлөлөө. Харин 2021 онд ДНБ-ий -2.8 хувь, 2022 онд ДНБ-ий -1.4 хувьд тус тус хүргэн, 2023 оноос ашигтай байхаар төлөвлөөд байна. Энэ нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн алдагдлын хязгаараас 1.2-1.4 хүртэлх пунктээр бага байхаар төлөвлөлөө.

График №16. Нэгдсэн төсвийн алдагдал 2016-2022 оноор



Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь -2,074.7 тэрбум төгрөг байгаагаас гадаад зээлийн ашиглалтын 1,296.3 тэрбум төгрөг нь эх үүсвэртэй алдагдал юм. Мөн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн дагуу төсвийн тогтворжуулалтын сангаас нийт 478.8 тэрбум төгрөгийг төсвийн алдагдлыг нөхөхөд ашиглахаар тусгасан. Монгол Улсын Засгийн газар 2020 онд алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор дотоод бонд гаргахгүй.

3.2. Төсвийн тусгай шаардлага

“Төсвийн тогтвортой байдлын тухай хууль”-ийн 6 дугаар зүйлд заасны дагуу дараах 4 тусгай шаардлагыг 2020 оны төсвийн төсөл дараах байдлаар бүрэн хангаж байна:

Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон байх

Ирэх 2020 онд нүүрс болон зэсийн баяжмалаас төсөвт төвлөрөх орлогын хэмжээ нэгдсэн төсвийн орлогын 3 хувиас давахаар байгаа тул хуульд заасны дагуу зэс, нүүрсний үнийг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон. Нэг тонн цэвэр зэсийн тэнцвэржүүлсэн үнийг 6,290.5 ам.доллар, нэг тонн нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг 75.5 ам.доллараар тооцлоо.

График №18. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого /2016-2020 он, тэрбум төгрөгөөр/





График №17. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /2016-2022 он, ДНБ-д эзлэх хувиар/




Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал 2020 онд тухайн жилийн ДНБ-ий 5.1 хувиас илүүгүй байх

Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл -2,074.7 тэрбум төгрөг буюу ДНБ-ий -5.1 хувьтай тэнцэхээр төлөвлөлөө.

Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдэл нь ДНБ-ий 75.0 хувиас хэтрэхгүй байх

Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа нь 49.9 хувьд хүрэх төлөвтэй байгаа нь Засгийн газрын өрийн тухай төсвийн тусгай шаардлагыг бүрэн хангаж байна.

График №19. Засгийн газрын өр /2016-2020 он/



2020оны эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлт 13.6 хувьтай, 2008-2019 оны эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн дундаж 19.8 хувьтай тус тус тэнцэж байна. 2020 оны төсвийн төсөлд нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлт 19.7 хувь буюу тусгай шаардлагыг хангаж байна.

Тухайн жилийн нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хувь нь тухайн жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн хувь тухайн жилийн өмнөх 12 жилийн эрдэс баялгийн бус ДНБ-ий өсөлтийн дунджийн аль ихээс хэтрэхгүй байх

4. ТӨСВИЙН ОРЛОГО



4.1. Монгол Улсын 2019 оны 8 дугаар сарын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүн 2019 оны эхний 8 сарын гүйцэтгэлээр 7,688.8 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөсөн хэмжээнээс 3.5 хувь буюу 260.9 тэрбум төгрөгөөр давж биелжээ. Орлогын гүйцэтгэл төлөвлөсөн хэмжээнээс давахад аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татварын гүйцэтгэл голлох нөлөөг үзүүлж байгаа нь эдийн засгийн өсөлт болон бизнес эрхлэгчдийн орлого, ашигт ажиллагааны түвшин сайжирч байгаатай холбоотой байна.

4.2. Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн нийт орлого



Ирэх онд гааль, татварын шинэчлэлийг хэрэгжүүлж, газрын бүртгэлийг цахимжуулж газрын төлбөр хураалтыг сайжруулан, төсвийн орлогын эх үүсвэрийг бүрэн дайчилж нэгдсэн төсвийн нийт орлогыг энэ оны батлагдсан нийт дүнгээс 1.8 их наяд төгрөг буюу 16.6 хувиар нэмэгдүүлэн 12.9 их наяд төгрөг байхаар тооцлоо. Үүнээс Төсвийн тогтворжуулалтын санд 125.2 тэрбум төгрөгийг, Ирээдүйн өв санд 977.0 тэрбум төгрөгийг тус тус төвлөрүүлнэ.

График №20. Нийт орлого ба тусламжийн дүн /их наяд төгрөг/



Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагын дагуу тооцсон тэнцвэржүүлсэн нийт орлого 2020 онд 11.8 их наяд төгрөг байна. Үүний 89.8 хувь буюу 10.7 их наяд төгрөгийг татварын орлого, 10.2 хувь буюу 1.1 их наяд төгрөгийг татварын бус орлогоос бүрдүүлнэ.

Хүснэгт №3. 2020 оны нэгдсэн төсвийн нийт орлого

ҮЗҮҮЛЭЛТ	тэрбум ₮
Нийт орлого ба тусламжийн дүн	12,900
Тогтворжуулалтын сан	125
Ирээдүйн өв сан	977
Төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	11,798
1.Татварын орлого	10,657
1.1.Орлогын албан тавар	2,765
1.2.Нийгмийн даатгалын орлого	2,403
1.3.Хөрөнгийн албан татвар	165
1.4.Нэмэгдсэн өртгийн албан тавар	2,626
1.5.Онцгой албан тавар	953
1.6.Тусгай зориулалтын орлого	16
1.7.Гадаад үйл ажиллагааны орлого	875
1.8.Бусад татвар	854
2.Татварын бус орлого	1,141
2.1.Нийтлэг татварын бус орлого	991
2.2.Тусламжийн орлого	150

4.3. Төсвийн тогтворжуулалтын сангийн орлого



Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т заасны дагуу зэс, нүүрснээс 2020 оны төсөвт төвлөрөх орлогын хэмжээ нэгдсэн төсвийн орлогын гурваас дээш хувийг бүрдүүлэх тул эдгээр бүтээгдэхүүн гол нэр төрлийн эрдэс баялагт тооцогдож байна. Иймд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3.а-д заасны дагуу тооцоход 2020 оны гол нэр төрлийн эрдэс баялаг зэсийн тэнцвэржүүлсэн үнэ тонн тутамд 6,290.5 ам.доллар, нүүрсний

тэнцвэржүүлсэн үнэ тонн тутамд 75.5 ам.доллар байна.



Ирэх онд зэсийн зах зээлийн үнэ 5,991 ам.доллар буюу тэнцвэржүүлсэн үнээс 4.7 хувиар

бага байх төлөвтэй байгаа тул 2020 онд зэсийн орлогоос Төсвийн тогтворжуулалтын санд хуваарилахгүй, зөвхөн нүүрснээс 125.2 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээр тооцлоо.

4.4. Ирээдүйн өв сангийн орлого



Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу Ирээдүйн өв санд уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн төрийн эзэмшилд ногдох хувьцааны ногдол ашгийн орлогоор 155.0 тэрбум төгрөг, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр 792.0 тэрбум төгрөг, хүүгийн орлогоор 30.0 тэрбум төгрөг, нийт 977.0 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлэхээр тооцлоо.

4.5. Уул уурхайн салбарын орлого



Засгийн газраас хэрэгжүүлж буй гааль, татварын шинэчлэл болон экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдийн үр дүнд уул уурхайн салбарын орлого 2019 оны батлагдсан дүнгээс 194.5 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, нийт 3.2 их наяд төгрөгт хүрэхээр тооцлоо. Энэ нь төсвийн нийт орлогын 24.8 хувийг бүрдүүлж байна.

График №21. Уул уурхайн болон бусад салбараас төвлөрүүлэх орлого /их наяд төгрөг/



Гаалийн шинэчлэлийг хэрэгжүүлж дуусгаснаар боомтын нэвтрэх хүчин чадлыг нэмэгдүүлэн ирэх онд 42 сая тонн нүүрс экспортолж, 1.5 их наяд төгрөгийн орлого нүүрснээс төсөвт төвлөрүүлэхээр тооцлоо.

Зэсийн зах зээлийн үнийг олон улсын нэр хүнд бүхий банк, санхүүгийн байгууллагуудын төсөөлөлд үндэслэн тонн тутамд 5,991 ам.доллар, экспортын хэмжээг олон улсын зах зээлийн хандлага, аж ахуйн нэгжүүдийн борлуулалтын төлөвлөгөөнд үндэслэн 1.2 сая тонн байхаар тооцож, 2020 онд 1.2 их наяд төгрөгийн орлогыг зэсийн баяжмалаас төсөвт төвлөрүүлнэ.

Хүснэгт №4. Уул уурхайн салбараас орох орлогын төлөвлөгөө /тэрбум төгрөг/


Үзүүлэлт	Эс	Нүүрс	Алт	Цайр	Томор	Бусад	Нийт
АМНАТ	493	594	126	29	27	24	1,294
ААНОАТ	223	670	22	40	7	39	1,001
Ногдол ашиг	150	23	-	-	-	5	178
Гаалийн татвар, хураамж	104	102	-	2	23	77	308
Бусад	190	105	18	5	14	83	415
Нийт	1,160	1,494	166	75	71	228	3,195

4.6. Эдийн засаг дахь татварын ачаалал болон татварын орчин



Олон улсын жишгээр дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх татварын орлогын хувиар эдийн засаг дахь татварын ачааллыг тооцоход манай улсын хувьд 2020 онд 22 хувь байхаар байгаа нь бусад улс орнуудын дундаж түвшинтэй ойролцоо байна.

График №22. Эдийн засаг дахь татварын ачаалал /хувиар/






Дэлхийн банкнаас жил бүр улс орнуудын бизнесийн орчинд үнэлгээ хийж эрхлэн гаргадаг “Бизнес эрхлэхүй 2019” буюу “Doing business 2019” судалгаагаар манай улсын татварын хувь хэмжээ 212 улсаас 185 дугаар байрт буюу 27 дахь хамгийн бага татварын хувь хэмжээтэй улсаар нэрлэгджээ.



Уг судалгааны татварын орчны таатай байдлын үнэлгээгээр манай улс 2019 онд нийт 212 орноос 61 дүгээр байранд шалгарсан байгаа нь 2016 онтой харьцуулахад 11 байр урагшилсан эерэг үзүүлэлттэй гарсан байна.

Түүнчлэн, 112 улс орнуудын аж ахуйн нэгжийн болон хувь хүний орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг харьцуулсан 2019 оны судалгаанаас⁵ үзэхэд Монгол Улс татварын хувь хэмжээгээр 95 дугаар байр буюу татварын хувь хэмжээ багатай улсын ангилалд орж байна

График №23. Татварын хувь хэмжээ, улсуудаар /хувиар/



Эх үүсвэр: tradingeconomics.com

Тухайлбал, өрхийн орлого, иргэдийн амьжиргаанд гол нөлөөлөл үзүүлдэг хувь

⁵ www.tradingeconomics.com

хүний орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ манай улсын хувьд бусад улсуудтай харьцуулахад бага байгаа нь уг судалгаанаас харагдаж байна.

Хүснэгт №5. Олон улсын дундаж татварын хувь хэмжээ

Үзүүлэлт	ХХОАТ	ААНОАТ	НӨАТ	НДШ
Дундаж /татварын хувь хэмжээ/	30	23	16	24
Монгол Улс /татварын хувь хэмжээ/	10	10/25	10	26
Татварын хувь хэмжээгээр /Ихээс бага руу жагсаавал/	101	93	104	97


Энэ нь манай улсын татварын орчин, хувь хэмжээ бусад улс орнуудтай харьцуулахад тааламжтай бөгөөд татварын ачаалал дундаж түвшинд байгааг илэрхийлж байна

4.7. Татварын орлого



Ирэх онд татварын нийт орлого энэ оны батлагдсан дүнгээс 2.0 их наяд төгрөгөөр буюу 24 хувиар нэмэгдүүлэн 10.6 их наяд төгрөг байхаар тооцлоо. Үүнээс 26 хувийг орлогын албан татвар, 23 хувийг нийгмийн даатгалын орлого, 25 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 9 хувийг онцгой албан татвар, үлдсэн 17 хувийг бусад татвар эзэлж байна.

График №24. Тэнцвэржүүлсэн орлогын бүтэц /хувиар/



4.7.1 Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар



Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, уул уурхайн гол нэр төрлийн эрдэс бүтээгдэхүүний үнийн таамаглал, биет хэмжээ, аж ахуйн нэгжүүдийн ашигт ажиллагааны түвшин, татварын шинэчлэлийн бодлогын нөлөөлөл зэрэгт үндэслэн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого 2020 онд энэ оны батлагдсан дүнгээс 28.3 хувиар өсөж 1.9 их наяд төгрөгийн орлогыг төсөвт, үүнээс 50.0 тэрбум төгрөгийг Төсвийн тогтворжуулалтын санд төвлөрүүлэхээр тооцлоо.

График №25. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого /уул уурхай, уул уурхайн бус салбараар, тэрбум төгрөгөөр/




Засгийн газраас бизнесийн орчин, хөрөнгө оруулалтыг дэмжих, зээлийн хүүг бууруулах бодлогыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжүүдийн орлого, ашигт ажиллагаа, төлбөрийн чадвар мэдэгдэхүйц сайжирч байгаа нь аж ахуйн нэгжийн орлогын албан татварын энэ оны эхний 8 сарын гүйцэтгэлээс харагдаж байна. Эдийн засгийн бодит өсөлт энэ оны эхний хагаст 7.3 хувьд хүрсэн, тэр дундаа аж ахуйн нэгжийн орлогын албан татварын ихэнх хувийг бүрдүүлэгч уул уурхайн салбарын бодит өсөлт 13.0 хувьд хүрсэн нь тус орлогын өсөлтөд голлох нөлөөллийг үзүүлж байна.

Мөн энэ оны эхний хагаст гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 21.2 тэрбум ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс

10.8 орчим хувиар өссөн, төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү 17.1 хувьд хүрч өнгөрсөн оны мөн үеэс 1 пунктээр буурсан зэргээс хамаарч аж ахуйн нэгжүүдийн ашигт ажиллагаа, төлбөрийн чадвар сайжирсан зэрэг эерэг үзүүлэлтийн үр дүнд 2019 оны эхний 8 сарын байдлаар аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого 1.1 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 27.8 хувиар өссөн байна.

График №26. Төгрөгийн болон валютын зээлийн жигнэсэн дундаж хүү /хувиар/



Эх үүсвэр: Монголбанк

Аж ахуйн нэгжүүдийн борлуулалт, ашигт ажиллагаа, төлбөрийн чадварын эерэг үзүүлэлтүүд ирэх онд үргэлжлэх бөгөөд бизнес, хөрөнгө оруулалтын дэмжсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн шинэчлэл хэрэгжиж эхэлснээр орлогын татварын суурь нэмэгдэхээр тооцлоо.


4.7.2 Хувь хүний орлогын албан татвар



Эдийн засгийн идэвхжилтээс шалтгаалан улсын хэмжээнд дундаж цалингийн хэмжээ 2015 оноос 40 гаруй хувиар нэмэгдэж байгаа бөгөөд энэ оны 8 сарын байдлаар нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 7.5 хувиар буурсан байна. Түүнчлэн, төрийн албан хаагчдын цалинг инфляцын түвшинтэй уялдуулан үе шаттай нэмэгдүүлж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 420.0 мянган төгрөг болгох зэрэг бодлогын арга хэмжээний үр дүнд ирэх онд хувь хүний орлогын албан татварын орлогоор 914.7

тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр тооцлоо.

График №27. Хувь хүний орлогын албан татварын орлого, тэрбум төгрөг



4.7.3 Дотоодын барааны нэмэгдсэн өртгийн албан татвар



Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, өнгөрсөн жилүүдийн гүйцэтгэл, цахим төлбөрийн е-баримтын хамрагдалтын түвшин, гааль, татварын шинэчлэлийн бодлогын нөлөөлөл зэргийг харгалзан 2020 онд дотоодын барааны нэмэгдсэн өртгийн албан татварын орлого энэ оны батлагдсан түвшнээс 22.1 хувиар өсөж 1.3 их наяд төгрөгт хүрэхээр тооцлоо.



Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын систем, е-баримтын бүртгэлийн системийн шинэ хувилбаруудыг нэвтрүүлэн, ашиглахад илүү энгийн хялбар болгож, хамрах хүрээг өргөтгөх бодлогын үр дүнд далд эдийн засаг буурч, татварын бүртгэл, хяналтын тогтолцоо эрс сайжран нэмэгдсэн өртгийн албан татварын орлого сүүлийн 2 жилд дунджаар 21 хувиар өссөн байна.



Тухайлбал, цахим төлбөрийн баримтын системд бүртгэгдсэн баримтын тоо 2019 оны эхний 8 сарын байдлаар 327.4 саяд хүрч өмнөх оноос 29.2 хувиар өсжээ.

График №28. НӨАТ-ын татвар төлөгч болон орлого



Цахим төлбөрийн баримтаар бүртгэгдсэн нийт гүйлгээний хэмжээ 2019 оны 8 сарын байдлаар 31.6 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оноос мөн 1.4 дахин нэмэгдсэн байна.



Ирэх онд цахим төлбөрийн баримтын системийг татвар, гаалийн байгууллагуудын бүртгэлийн системтэй холбож, төрийн үйлчилгээг хялбарчлах, бэлэн бус төлбөрийн баримтыг е-баримттай нэгтгэх, импортоор орж ирж буй барааг эцсийн хэрэглэгч хүртэл, үйлдвэрлэгчээс экспортоор гарах хүртэл тус тус олон улсын стандарт зураасан кодыг ашиглан бүртгэх системийг хөгжүүлэх зэрэг ажлыг хэрэгжүүлнэ.

Мөн нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын буцаан олголтыг улирал тутам иргэдэд олгож эхэлнэ.

4.7.4 Автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар



Автобензин, дизелийн түлшний импорт, хэрэглээ болон үнийн хандлага зэрэгт үндэслэн ирэх онд автобензин, дизелийн түлшний онцгой албан татварын орлогоор 280.6 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр тооцлоо.

Энэ оны эхний 8 сарын байдлаар автобензин, дизелийн түлшний импортын хэмжээ өмнөх оны мөн үеэс 31.9 хувиар нэмэгдэж 1.1 сая тоннд хүрсэн байна.

4.7.5. Суудлын автомашины онцгой албан татвар



Өнгөрсөн жилүүдэд импортолсон суудлын автомашины насжилт, хөдөлгүүрийн төрөл, багтаамж болон импортын төлөв байдал зэрэг хүчин зүйлийг харгалзан ирэх онд суудлын автомашины онцгой албан татварын орлогоор 264.4 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр тооцлоо.

Монгол Улсад импортолж байгаа нийт тээврийн хэрэгслийн тоонд эзлэх хос тэжээлт, шингэрүүлсэн хийгээр ажилладаг автомашины тоо дунджаар 35 орчим хувийг эзэлж байна.

График №29. Суудлын автомашины импортын тоо



Эх үүсвэр: ГЕГ-ын статистик мэдээ

4.7.6 Сөгтууруулах ундаа, тамхины онцгой албан татвар



Хэрэглээний түвшин болон өмнөх онуудын орлогын гүйцэтгэл зэргийг үндэслэн 2020 онд тамхи, согтууруулах ундаанаас нийт 408.4 тэрбум төгрөгийг төсөвт төвлөрүүлэх бөгөөд энэ нь 2019 оны төлөвлөсөн хэмжээнээс 3.5 хувь буюу 13.9 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр байна.

4.7.7 Импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын орлого



Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт болон импортын барааны бүтцийн өөрчлөлт, өмнөх жилүүдийн орлогын гүйцэтгэлийн хэмжээтэй уялдуулан ирэх онд гаалийн албан татварын орлогоор 875.0 тэрбум төгрөг, импортын барааны нэмэгдсэн өртгийн албан татварын орлогоор 1.8 их наяд төгрөгийг тус тус төсөвт төвлөрүүлнэ.


График №30. Импортын гаалийн болон НӨАТ, тэрбум төгрөг



Засгийн газраас үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх, гааль, татварын шинэчлэлийг хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээний үр дүнд эдийн засгийн өсөлт сайжирч, хөрөнгө оруулалтын шинж чанартай болон нефтийн бүтээгдэхүүний импорт өсөж байна.

Тухайлбал, 2019 оны эхний 8 сарын гүйцэтгэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт импорт 7 хувиар өссөн байна. Цаашид энэ хандлага үргэлжлэх төлөвтэй байгаа нь улсын хилээр нэвтэрч буй импортын бараа, бүтээгдэхүүнээс төвлөрүүлэх татварыг нэмэгдүүлэхэд нөлөөллөө.

График №31. Импортын хэмжээ /сая ам.доллар/



Эх үүсвэр: Гаалийн статистик мэдээ

4.7.8. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр



Олон улсын нэр хүнд бүхий банк, санхүүгийн байгууллагаас гаргасан эрдэс бүтээгдэхүүний үнийн таамаглал, уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа томоохон аж ахуйн нэгжүүдийн 2020 оны олборлолтын төлөвлөгөө, өмнөх онуудын гүйцэтгэл зэрэгт үндэслэн ирэх онд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоор 1.3 их наяд төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр тооцлоо.



Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 38.1 хувь буюу 493.4 тэрбум төгрөгийг зэсийн баяжмалаас, 45.9 хувь буюу 593.6 тэрбум төгрөгийг нүүрснээс, 9.8 хувь буюу 126.2 тэрбум төгрөгийг алтнаас төвлөрөх орлого эзэлж байна.

Ирэх онд нүүрсний экспорт 42 сая тонн, зэсийн баяжмалын экспорт 1.2 сая тонн, Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд тушаах алтны хэмжээ 19.0 тонн байхаар, эрдэс бүтээгдэхүүний үнийн хувьд нүүрсний жигнэсэн дундаж үнэ тонн тутамд 74.7 ам.доллар, зэсийн үнэ тонн тутамд 5,991.0 ам.доллар, алтны үнэ унц тутамд 1,545.0 ам.доллар байхаар төсөөллөө.

График №32. Зэсийн баяжмалын экспорт, мянган тонн



4.7.9 Агаарын бохирдлын төлбөр



Агаарын бохирдлын төлбөрийн орлогыг ирэх онд 44.0 тэрбум төгрөг байхаар тооцлоо. Үүний 95 орчим хувь буюу 42.0 тэрбум төгрөгийг олборлосон түүхий нүүрсэнд ногдуулах төлбөрөөр, 2.0 тэрбум төгрөгийг автотээврийн болон өөрөө явагч хэрэгслээс ялгарах нүүрсхүчлийн хийнд ногдуулах төлбөрөөр тус тус төсөвт төвлөрүүлэхээр тооцлоо.



Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх, ойжуулах бодлогыг дэмжих, энэ чиглэлээр орон нутгийн төсвийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх бодлогын арга хэмжээг үргэлжлүүлэн 2020 онд олборлосон түүхий нүүрсэнд ногдуулах агаарын бохирдлын төлбөрийн 50 хувь буюу 21.0 тэрбум төгрөгийг олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа тухайн орон нутгийн төсөвт хуваарилна.

4.7.10 Газрын төлбөрийн орлого



Засгийн газраас газрын бүртгэлийн мэдээллийг ил тод болгох, газрын төлбөр ногдуулалт, төлөлтийг цахимжуулах замаар газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгжүүд газрын төлбөрөө хялбараар төлөх боломжийг бүрдүүлж, төлбөрийн орлогыг бүрэн хураах чиглэлээр бодлогын арга хэмжээ авсны үр дүнд ирэх онд төсөвт газрын төлбөрийн орлогоор 107.5 тэрбум төгрөг, газрын дуудлага худалдааны орлогоор 2.3 тэрбум төгрөг, нийт 109.8 тэрбум төгрөгийг төвлөрүүлнэ.

Зураг №1. Газрын бүртгэл, мэдээллийн технологийн шинэчлэл



Түүнчлэн, газрын төлбөрийн орлогын 40 хувийг тухайн сум, дүүргийн төсөвт хуваарилах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Газрын төлбөрийн орлогыг аймаг, нийслэл болон сум, дүүргээр харуулбал:

Зураг №2. Газрын төлбөрийн орлого /сая төгрөг/



4.7.11 Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн төлбөр

Монгол Улсын хэмжээнд 7.9 сая га талбайд ашигт малтмалын ашиглалтын 1,683, хайгуулын 1,239 нийт 2,922 тусгай зөвшөөрөл бүртгэлтэй байна. Ашигт малтмалын тухай хуулийн 32 дугаар зүйлд заасан хувь хэмжээгээр тусгай зөвшөөрлийн төлбөрөөр ирэх онд 36.0 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр тооцсон.

График №33. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл



Эх үүсвэр: АМГТГ-ын статистик мэдээлэл

4.8. Татварын бус орлого



Ирэх онд нийт татварын бус орлогыг энэ оны батлагдсан дүнгээс 51 тэрбум төгрөгөөр буюу 5 хувиар нэмэгдүүлэн 1.1 их наяд төгрөг байхаар тооцлоо. Тус орлого нь газрын тосны орлого, навигацийн орлого болон бусад орлогоос бүрдэнэ.


4.8.1 Газрын тосны орлого



Монгол Улсын Засгийн газраас нийт 25 талбайд 21 гэрээлэгч аж ахуйн нэгжтэй бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулан, газрын тосны хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагаа явуулж байна.

Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүдээс “Петрочайна дачин тамсаг” ХХК “Тосон-Уул 19”, “Тамсаг 21” талбайд, “Доншен газрын тос” ХХК, “Зүүнбаян 97” талбайд олборлолтын үйл ажиллагаа явуулж байна. Газрын тосны нийт экспортын 95 гаруй хувийг “Петрочайна дачин тамсаг” ХХК, 5 орчим хувийг “Доншен газрын тос” ХХК хийж байна.

График №34. Газрын тосны экспортын хэмжээ, үнэ



Ирэх онд газрын тосны нийт экспортын хэмжээг 6.6 сая баррель, нэг баррель газрын тосны үнийг 63.9 ам.доллар байхаар төсөөлж, нийт 266.0 тэрбум төгрөгийн газрын тосны орлогоор төвлөрүүлэхээр тооцлоо.

4.8.2 Навигацийн орлого



Ирэх онд Хөшигийн хөндийн олон улсын нисэх онгоцны шинэ буудал ашиглалтад орж, орон нутаг болон олон улсын нислэгийн тоо хэмжээг нэмэгдүүлснээр Монгол Улсын агаарын зайд үйлдэгдэх нислэгийн тоо 136 мянгад хүрнэ. Ингэснээр өнгөрөлт, буулт хөөрөлтөд үзүүлэх навигацйн орлогоор төсөвт 165.0 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлнэ.

4.8.3 Хувьцааны ногдол ашиг



Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хагас жилийн болон жилийн эцсийн санхүүгийн тайлан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 229 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ирэх онд төрийн өмчит хуулийн этгээдээс улсын төсөвт 18.0 тэрбум төгрөг, Ирээдүйн өв санд 155.0 тэрбум төгрөгийн ногдол ашгийг тус тус төвлөрүүлнэ.


Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-т зааснаар ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд болон төрийн өмчийн үйлдвэрийн газрын төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг Ирээдүйн сангийн эх үүсвэрт хамаардаг. Үүний дагуу Ирээдүйн өв санд “Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ-аас 150.0 тэрбум төгрөг, “Монголросцветмет” ТӨҮГ-аас 5.0 тэрбум төгрөг тус тус төвлөрүүлэхээр тооцлоо.

4.9. Төсвийн орлогын гүйцэтгэлд учирч болзошгүй эрсдэл



Зэс. Дэлхийн эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан зэсийн үнийн хэлбэлзэл өндөр байгаа нь ирэх оны төсвийн орлогын голлох эрсдэл байхаар байна.

График №35. Дэлхийн зах зээл дэх зэсийн үнэ, /тонн. ам доллар/



Эх үүсвэр: Лондонгийн металлын бирж

Тухайлбал, 2019 оны 3 дугаар сард нэг тонн зэсийн үнэ Лондонгийн металлын бирж дээр 6,450.3 ам.доллар байсан бол 5 дугаар сард 6,027.7 ам.доллар, 9 сарын 18-ны өдрийн байдлаар 5,745.0 ам.доллар хүртэл буурсан байна. Зэсийн үнийн хэлбэлзэлд 2018 оны 7 дугаар сараас эхэлсэн АНУ болон БНХАУ хоорондын “худалдааны дайн” болон ам.доллартай харьцах юанийн ханшийн сулралт, БНХАУ-ын үйлдвэрлэгчийн үнийн индексийн бууралт зэрэг голлох нөлөөллийг үзүүлж байна.



Дээрх хүчин зүйлс ирэх онд зэсийн үнэд нөлөөлж болзошгүй тул олон улсын нэр хүнд бүхий банк, санхүүгийн байгууллагаас зарласан үнийн төсөөллүүд тогтмол өөрчлөгдөж байна.



Нүүрс. Энэ оны эхний 8 сарын байдлаар манай улсын экспортолж буй нүүрсний жигнэсэн дундаж үнэ 85.7 ам.доллар буюу өмнөх оны мөн үеэс 10.4 хувиар өссөн байна. БНХАУ-ын Засгийн газраас дотоодын эдийн засгийг дэмжих

зорилгоор хэрэгжүүлж байгаа бодлогын нөлөөгөөр гангийн үйлдвэрлэл энэ онд өсөх төлөвтэй байгаа ч Австрали Улсын Аж үйлдвэр, инновац, шинжлэх ухааны яамнаас нийтэлсэн судалгаагаар ирэх онд БНХАУ-ын гангийн үйлдвэрлэл буурах таамаглал гаргасан нь БНХАУ-ын коксжих нүүрсний эрэлт буурч, манай улсын экспортын нүүрсний үнэд нөлөөлж болзошгүй байна. ⁶

4.10. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт

Татварын шинэчлэлийн хүрээнд татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор аж ахуйн нэгжүүд татвараа тайлагнаж төлсний дараа төлсөн татварыг буцаан олгох замаар татварын хөнгөлөлт эдлүүлэх бодлогыг 2020 оноос хэрэгжүүлнэ.



Улмаар татварын хууль тогтоомжийн дагуу олгосон татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн нийт татварын орлогод эзлэх хувь хэмжээ 2018 онд 5.9 хувь, 2019 оны батлагдсан түвшин 5.5 хувь байсан бол 2020 онд 5.4 хувь болж жил дараалан буурахаар байна.

Хүснэгт №6. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэмжээ

Үзүүлэлт	2018	2019 бат	2020 төс	2021 төс	2022 төс
Татварын орлого	8,207.1	8,585.8	10,656.1	11,429.3	12,502.6
Татварын орлогод эзлэх хувь	5.9	5.5	5.4	5.6	5.5
Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт	487.0	473.4	571.6	636.0	690.4
ААНОАТ	42.4	33.1	49.8	113.4	127.2
НӨАТ	173.0	185.7	226.0	180.5	207.4
Гааль	24.0	28.5	34.8	36.0	36.2
ХХОАТ	142.9	147.7	161.4	204.9	211.0
ОАТ	104.7	78.4	99.7	101.3	108.6

⁶ Австрали Улсын Аж үйлдвэр, инновац, шинжлэх ухааны яам, “Байгалийн баялаг болон эрчим хүчний 2019 оны 2 улирлын тайлан”

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бүртгэл, ангилал, тайлагналыг олон улсын жишиг аргачлалд нийцүүлэн Дэлхийн банктай хамтран 2019 онд Сангийн сайдын баталсан “Татварын зарлагад шинжилгээ хийх, гүйцэтгэлийг тайлагнах журам”-ын дагуу 2020-2022 оны татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн төсөөлөл, 2018-2019 оны татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг тооцлоо.

5. ТӨСВИЙН УРСГАЛ ЗАРЛАГА



5.1. 2020 оны нэгдсэн төсвийн урсгал зардлын тойм

Нэгдсэн төсвийн нийт урсгал зардлыг 2020 онд дараах байхаар тооцлоо.

Хүснэгт №7. Урсгал зардлын бүтэц /урсгал зардалд эзлэх хувиар/

№	Зардлын томгосон ангилал	2019	2020
		Төсөв	Төсөл
Урсгал зарлага		100%	100%
1.	Цалин хөлс	27%	26%
2.	Бараа үйлч.бусад зардал	21%	22%
3.	Зээлийн хүү	11%	10%
4.	Татаас, шилжүүлэг	41%	42%

Нийт урсгал зардлыг бүтцийн хувьд авч үзвэл цалин хөлс 26.4 хувь, бараа үйлчилгээний бусад зардал 21.7 хувь, зээлийн хүүгийн зардал 9.6 хувь, татаас ба урсгал шилжүүлгийн зардал 42.3 хувийг тус тус эзэлж байна.

5.2. Урсгал зардлын өөрчлөлт

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх болон иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардал нь нэгдсэн төсвийн урсгал зардлын өөрчлөлтөд голлон нөлөөлж байна.

Урсгал зардлын өөрчлөлтийг ангилж үзвэл нийт өөрчлөлтийн 63.1 хувь нь цалин, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэхэд, 13.1 хувь нь агаарын бохирдлыг бууруулах, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардал болон нэг удаагийн шинж чанартай УИХ, орон нутгийн ээлжит сонгууль 2020

Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн урсгал зардлын төсөл боловсруулахад баримталсан зарчим:

- Цалин, тэтгэвэр, тэтгэмжийг инфляцтай уялдуулж нэмэгдүүлнэ;
- Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхтэй холбоотой нийгмийн хамгаалал, боловсрол, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зардлыг төсөвт тусгана;
- Шинээр батлагдсан хууль тогтоомж болон шинэ хөрөнгө оруулалттай холбоотой нэмэгдэх шаардлагатай орон тоо, урсгал зардлыг тусгана;
- Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа төсвийн байгууллагын тээвэр шатахуун, түлш халаалтын зардлыг индексжүүлэн нэмэгдүүлнэ;
- УИХ, орон нутгийн ээлжит сонгууль, хүн ам, орон сууцны тооллого, 2020 оны Токиогийн олимпод оролцох зэрэг нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлыг тусгана;

оны олимп, хүүхдийн спортын наадам зэрэг арга хэмжээний зардлыг тусгахад, 8.0 хувь нь мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн суралцагчдын тэтгэмжийг сард 200.0 мянган төгрөг болгох, цэцэрлэгийн хүүхдийн хоол, ерөнхий боловсролын сургуулийн үдийн цай, дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг 50 хувь нэмэгдүүлэх болон аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудын хоол мөн бусад нормативт зардлыг нэмэгдүүлэхэд, түүнчлэн 5.6 хувь нь төсөвт байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах дулаан, цахилгаан, цэвэр, бохир ус, шатахуун, бичиг хэрэг зэрэг зардлын өсөлт, 5.4 хувь нь

зээлийн хүүгийн төлбөрт, 3.6 хувь нь Дарханы аж үйлдвэрийн паркийн зээлийн хүүгийн татаас, Баруун бүсийн эрчим хүчний системийн эрчим хүчний алдагдлын татаас, махны зээлийн хүүгийн татаас, улаан буудайн урамшуулал зэрэг татаас, урамшууллын зардлын өсөлтөөс шалтгаалж байна.

5.3. Хөдөлмөр, нийгмийн хамгаалал



Төрийн албан хаагчдын цалин хөлсийг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлнэ. Ирэх 2020 онд цалин хөлсний зардал 18.6 хувиар өсөж байна. Цалин хөлсний зардлын өсөлтөд дараах хүчин зүйлс голлон нөлөөлж байна. Үүнд:

1/ 2020 онд төрийн албан хаагчийн цалин хөлсийг инфляцтай уялдуулан 8 хувиар нэмэгдүүлэхэд 159.8 тэрбум төгрөг,

2/ Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын 57.2.4-т заасны дагуу төрийн үйлчилгээ (ТҮ)-ний албан хаагчдад төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 2020 оноос шинээр олгож эхлэхтэй холбоотойгоор 142.7 тэрбум төгрөг.



Тэтгэвэр, тэтгэмжийг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх. Ирэх 2020 онд нийгмийн даатгалын сангаас олгох бүх төрлийн тэтгэврийг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэхэд 150.6 тэрбум төгрөг, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэхэд 17.5 тэрбум төгрөг нийт 168.1 тэрбум төгрөгийг тусгалаа. Ингэснээр нийгмийн даатгалын 418.4 мянга, нийгмийн халамжийн 137.5 мянга, нийт 555.9 мянган тэтгэвэр, тэтгэмж авагчийн орлого дунджаар 8 хувиар нэмэгдэнэ.

Хүснэгт №8. Тэтгэвэр, тэтгэмж нэмэх тооцоолол /тэрбум төгрөг/

Арга хэмжээ	Өөрчлөлт
Тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх	168.1
<i>Нийгмийн даатгалын сан</i>	150.6
<i>Нийгмийн халамжийн сан</i>	17.5
Тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо	555.9
<i>Нийгмийн даатгалын сан</i>	418.4
<i>Нийгмийн халамжийн сан</i>	137.5

МСҮТ-ийн суралцагчдын тэтгэлгийг 2 дахин нэмэгдүүлж сард 200.0 мянган төгрөг



олгоно. Хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй, ажил олгогчийн шаардлагад нийцсэн мэргэжилтэй ажилтан бэлтгэх, залуучуудын мэргэжлийн сургалтын байгууллагад суралцах сонирхлыг нэмэгдүүлэх зорилгоор мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд суралцаж байгаа 40.0 мянган суралцагчид сар бүр олгох тэтгэмжийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлж 200 мянган төгрөгт хүргэхээр тооцож 79.9 тэрбум төгрөгийг төсөвт тусгав. Ингэснээр сул ажлын байран дахь гадаад ажилчдын тоог бууруулж үндэсний мэргэжилтэй ажилчдыг түлхүү ажиллуулах, улмаар ажилгүйдлийн түвшнийг бууруулахад дэмжлэг болно .



Олон улсын хүүхдийн Найрамдал зусланг улсын төсөвт буцааж авна. Засгийн газрын 2019 оны 209 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор олон улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит аж ахуйн тооцоот “Найрамдал” зусланг улсын төсөвт буцааж авахаар тооцож нийт 158 орон тоо, 5.2 тэрбум төгрөгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцад тусгав.

5.4. Байгаль орчин, аялал жуулчлал



Агаар орчны бохирдлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

Ирэх онд агаар, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээний зардлыг энэ оноос 41.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж нийт 137.6 тэрбум төгрөгт хүргэхээр тооцлоо. Агаарын бохирдлыг бууруулахад зориулан нэмэгдүүлж байгаа хөрөнгийг нийслэл Улаанбаатар хотод сайжруулсан түлшний түгээлт, борлуулалтыг зохион байгуулах болон агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлэх бусад арга хэмжээнд зарцуулна.



Аялал жуулчлалыг хөгжүүлэхэд хөрөнгө нэмж зарцуулна. Аялал жуулчлалын салбарын дэд бүтцийг

сайжруулах, гадаад сурталчилгаа, маркетингийн ажлуудыг эрчимжүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах, Монгол Улсад жуулчин хүлээж авах хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээний санхүүжилтийг 2019 оны түвшнээс 2.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж нийт 8.1 тэрбум төгрөг зарцуулна.

График №36. Аялал жуулчлалын салбарын орлого /сая ам.доллар/



Эх үүсвэр: Байгаль орчин, аялал жуулчлалын яам

2018 оны байдлаар аялал жуулчлалын салбарын нийт орлого 569.0 сая ам.долларт хүрсэн ба өмнөх оноос 169.0 сая ам.доллараар өссөн байна.



Байгаль орчны тогтвортой хөгжлийг хангах бодлогын зорилтуудыг хэрэгжүүлж эхэлнэ.

Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 д экосистемийн тэнцвэрт байдлыг хангах зорилгын хүрээнд “цөлжилтийг сааруулж, цөлжилтөд өртсөн газар нутгийн хэмжээг бууруулах, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 21 хувьд хүргэх” эхний үе шатны зорилтыг хангахад зориулж тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтыг сайжруулах арга хэмжээг 3.9 тэрбум төгрөгөөр, газрын доройтлыг бууруулах, нөхөн сэргээх арга хэмжээг 1.3 тэрбум төгрөгөөр, хуурайшилт, гал түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний санхүүжилтийг 1.3 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлж тооцлоо.

5.5. Эрчим хүч



ОХУ-аас импортолж байгаа цахилгаан эрчим хүчний үнэ тариф сүүлийн жилүүдэд тогтмол нэмэгдэж байна. Үнэ тарифын нэмэгдэл нь Баруун бүсийн эрчим хүчний системийн алдагдлыг нэмэгдүүлэхэд голлон нөлөөлж байна. Иймд Баруун бүсийн эрчим хүчний системийн хэвийн үйл ажиллагааг хангахад зориулж олгох татаасны хэмжээг 4.9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлнэ.

“Өвлийн хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх арга хэмжээний тухай” Засгийн газрын 2018 оны 324 дүгээр тогтоолын дагуу өвлийн хүлэмжийн аж ахуйн шөнийн цагт хэрэглэсэн цахилгааны үнийг хөнгөлөх зорилгоор нийт 2.5 тэрбум төгрөгийн зардлыг нэмж тусгалаа.

5.6. Эрүүл мэнд

“Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоог бүрдүүлэн, оношилгоо үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хүн амын дундаж

наслалтыг уртасгах талаар тодорхойлсон зорилтыг хангах хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:



Анхан шатлалын тусламж, үйлчилгээний зардлын тарифын ялгааг арилгана.

Эрүүл мэндийн анхан шатлалын тусламж, үйлчилгээ буюу Өрхийн эрүүл мэндийн төв, Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн санхүүжилтийг эрүүл мэндийн суурь тусламж, үйлчилгээний нэг иргэнээр тооцсон тарифаар бодож олгодог.



Сумын эрүүл мэндийн төвийн нэг иргэнээр тооцсон тариф 37.7 мянган төгрөг байхад хувийн хэвшил бие даан хэрэгжүүлж байгаа өрхийн эрүүл мэндийн төвийн тариф 17.0 мянган төгрөг буюу сумынхаас 2.2 дахин бага байна. Харин эсрэгээрээ өрхийн эрүүл мэндийн төвийн үзүүлсэн үйлчилгээний тоо хэмжээ нь сумын эрүүл мэндийн төвийнхөөс 2.8 дахин их байна. Иймд өрхийн эрүүл мэндийн төвийн нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн тарифыг сумын эрүүл мэндийн төвийн түвшинд буюу 30.0 мянган төгрөгт хүргэхэд 26.7 тэрбум төгрөг нэмж зарцуулна. Ингэснээр Улаанбаатар хот болон аймгийн төвийн сум, тосгон зэрэг хүн амын нягтрал өндөр суурин газарт анхан шатлалын тусламж үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэх боломжтой болж байна.



Төр хариуцах тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Агаар, орчны бохирдол, улирлын чанартай өвчний дэгдэлтээс иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор томуу, уушгины хатгааны эсрэг вакцины зардалд 6.3 тэрбум, эрхтэн шилжүүлэх хагалгаа, түүнийг хийлгэсэн хүмүүст төрөөс үнэ төлбөргүй олгох дархлаа дарангуйлах эмийн зардал 6.6 тэрбум, цус бүлэгнэлтийн хүчин зүйл төрөлхийн дутагдалтай хүмүүст гемофилин эсрэг факторын эмийн зардалд

3.3 тэрбум, эрүүл мэндийн тухай хуульд заасан сүрьеэ, чихрийн шижин, бамбай зэрэг оноштой өвчтөнд амбулаториор эмчлүүлэхэд үнэгүй олгох эмийн зардал 8.2 тэрбум, гемодиализийн эмийн зардалд 2.5 тэрбум, хэвтэн эмчлүүлэгсдэд олгох эмийн зардалд 72.9 тэрбум төгрөг тус тус төсөвлөсөн байна.

Эрүүл мэндийн байгууллагын бие даасан байдлыг нэмэгдүүлэх замаар эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй тогтолцоог бий болгоно. Тусламж үйлчилгээний өртгийн нарийвчилсан тооцоололд үндэслэн ирэх 2020 онд эмнэлгийн тусламж, үйлчилгээг тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар санхүүжүүлнэ.

Ингэснээр эмнэлгүүд бие даан төсвөө зарцуулах, үзүүлж байгаа тусламж, үйлчилгээний онцлог, ажлын ачаалалтайгаа уялдуулан бүтэц орон тоогоо тогтоох, эмч эмнэлгийн ажилтны цалин хөлс, нийгмийн баталгаа сайжрах боломжтой болох юм.



“Эрүүл шүд-эрүүл хүүхэд хөтөлбөр”-ийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Засгийн газрын 2018 оны 255 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл шүд-эрүүл хүүхэд” үндэсний хөтөлбөрийн зорилго нь хүүхдийн шүдний тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, санхүүжилтийн тогтвортой байдлыг хангаж, салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар хүүхдийн шүдний өвчний тархалтыг 30 хувиар, цоорлын эрчмийг 4 нэгжээр бууруулахад оршиж байна.

2019 оноос хэрэгжүүлж эхэлсэн хөтөлбөрийн хамрах хүрээг нэмэгдүүлэх, оношилгоо эмчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах зорилгоор санхүүжилтийн хэмжээг ирэх онд 5.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 10.0 тэрбум төгрөгт хүргэнэ.

5.6. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт



Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.

“Турван ээлжгүй сургууль, Хүүхэд бүр цэцэрлэгт,” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор баригдаж 2020 онд шинээр ашиглалтад орох 61 цэцэрлэг, 32 ерөнхий боловсролын сургуулийн шаардлагатай орон тоо болох 1,838 багш, ажиллагсдыг 7.0 тэрбум төгрөгийн цалин хөлсний зардлын хамт төсөвт тусгалаа.



2012 оноос хойш нэмэгдүүлээгүй цэцэрлэгийн хүүхдийн хоол болон ЕБС-ийн Үдийн цай хөтөлбөр, дотуур байрны хоолны зардлыг 50 хувиар тус тус нэмэгдүүлнэ. Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчийн үдийн цайг 600 төгрөг, цэцэрлэгийн хүүхдийн нэг өдрийн хоолыг 1,650 төгрөг, дотуур байрны хоолыг 2,315 төгрөгөөр тооцож олгож байна. Эдийн засаг, төсвийн боломжоос шалтгаалан 2012 оноос хойш шинэчлээгүй дээрх тарифыг 50 хувиар тус тус өсгөхөд 57.1 тэрбум төгрөг нэмж тусгалаа. Энэхүү арга хэмжээнд давхардсан тоогоор нийт 660 орчим мянган хүүхдийг хамруулна.



Соёлын салбарт хийх хөрөнгө оруулалттай уялдуулж урсгал зардлыг нэмэгдүүлнэ. Соёлын салбарт 2020 онд бүтээн байгуулалтын томоохон ажлууд хийхээр төлөвлөж байна. Үндэсний номын сан, Чингис хааны музей, Чингис хааны өв соёлын хүрээлэн, Монгол Алтайн хадны зургийн цогцолборын хамгаалалтын захиргаа, Бурхан халдун, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутгийн хамгаалалтын захиргаа зэрэг шинээр байгуулагдах байгууллагын 79 орон тоо,

үйл ажиллагааны урсгал зардалд 1.4 тэрбум төгрөг төсөвлөв.



Шинжлэх ухааны байгууллагад үйл ажиллагааны орлогоо захиран зарцуулах эрхийг олгоно.

Соёл, урлаг, спортын байгууллагуудад 2019 оны төсвийн жилээс эхлэн улсын төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээлгэхгүйгээр үндсэн үйл ажиллагааны орлогоо бие даан зарцуулах эрхийг олгосон. Ингэснээр эдгээр байгууллагууд ажиллагчдын цалин урамшууллыг нэмэх, шаардлагатай техник тоног төхөөрөмж худалдан авах зэрэг тулгамдсан асуудлуудаа бие даан шийдвэрлэх боломжтой болсон. Хамгийн гол нь эдгээр байгууллагуудад орлогоо нэмэгдүүлэх урам зориг бий болсон явдал юм.

Ирэх 2020 онд шинжлэх ухааны салбарын байгууллагуудыг энэ зарчмаар ажиллуулах ба ингэснээр эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд өөрийн орлогоороо шаардлагатай зардлаа бие даан санхүүжүүлэх боломжтой болно.



“Токио-2020” зуны олимп, параолимп-д оролцох Монгол Улсын шигшээ багийн зардлыг токио 2020 санхүүжүүлнэ. 2020 онд Япон Улсын Токио хотноо зохион байгуулагдах “Токио-2020” зуны олимп, параолимпын их наадамд оролцох Монгол Улсын шигшээ багийн үйл ажиллагааны зардлыг 20.0 тэрбум төгрөг байхаар төсвийн төсөлд тусгалаа. Монгол Улсын шигшээ баг олимпын 32 төрлөөр 500 тамирчинтай байгуулагдаж ажиллахаар төлөвлөсөн бөгөөд, олимпын наадмаас 6-7 медаль авах зорилго тавьж байна.

Хүүхдийн спортын наадмыг зохион байгуулна. 2020 онд хүүхдийн спортын наадмын зохион байгуулалтын үйл ажиллагааны зардал 9.6 тэрбум төгрөг төлөвлөв.

5.7. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр



Хөдөө аж ахуйн салбарт олгох дэмжлэг, урамшууллын арга хэмжээг нэгтгэн зохион байгуулна. Иргэн, хуулийн этгээдэд олгодог улаан буудай, ноос, арьс шир, нөөцийн махны хүүгийн хөнгөлөлтийн урамшууллыг өөр өөр байгууллагаас тус тусад нь төлөвлөдөг байсныг өөрчилж салбарын яам тухайн жилд хэрэгжүүлэх бодлогодоо нийцүүлэн эрэмбэлэх замаар санхүүжилтийг хуваарилдаг болно. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, үйлдвэрлэлд олгох дэмжлэг, урамшууллыг нэгдсэн байдлаар төлөвлөж, зарцуулснаар хөдөө аж ахуйн салбарын өсөлтийг дэмжихэд олгох хөрөнгийн үр ашиг сайжирна. Түүнчлэн, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор улаанбуудайн урамшууллыг 10.0 тэрбум төгрөгөөр, махны зээлийн хүүгийн хөнгөлөлтийг 4.5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнд олгох нийт дэмжлэг, урамшууллыг 66.6 тэрбум төгрөгөөр төсөвлөлөө.



Дарханы аж үйлдвэрийн паркийн бүтээн байгуулалтад дэмжлэг үзүүлнэ. Ажлын байр шинээр бий болгох, экспортыг дэмжих, малчид үйлдвэрлэл эрхлэгчдийн орлогыг нэмэгдүүлэх, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх зорилгоор Дарханы аж үйлдвэрийн паркийн бүтээн байгуулалтын төсөлд олгогдох зээлийн хүүгийн татааст 15.0 тэрбум төгрөг тусгав.



Бэлчээрийн ургамал хамгаалах талбайн хэмжээ болон хамрагдах сумын тоог нэмэгдүүлнэ. Уулын хээр болон тал хээрийн бүс нутгийн 17 аймгийн 38.6 сая га талбайд үлийн цагаан оготно, өндөр уулын бүсийн 1.0 сая га талбайд царцааны тархалт хэвийн байх

хэмжээнээс хэтэрсэн нь нийт бэлчээрийн 40 орчим хувийг хамарсан байна. Тархалтын хүрээ цаашид улам тэлэх хандлагатай байна. Иймд бэлчээрийн ургамал нөхөн ургах боломж бий болгох, малын тэжээлийн хангамж хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор үлийн цагаан оготно, царцаатай тэмцэх арга хэмжээний зардлыг 3.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 5.0 тэрбум төгрөгт хүргэж байна.

5.8. Аюулгүй байдал



Шинээр ашиглалтад орох барилга байгууламжийн ашиглалттай холбоотойгоор нэмэгдэх урсгал зардал. Хууль сахиулахын их сургууль, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, Гадаад иргэн, харьяатын газар, Хил хамгаалах ерөнхий газар, Хууль зүй, дотоод хэргийн яамны төсөвт нийт 2.4 тэрбум төгрөг тус тус нэмэгдүүлэн тусгав. Мөн Батлан хамгаалахын салбарын шинэ хөрөнгө оруулалтын улмаас нэмэгдэх урсгал зардалд 874.7 сая төгрөг нэмж тусгав.



Зэвсэгт хүчний анги, салбарын эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулна. Зэвсэгт хүчний анги, салбарын анхан шатны эмнэлгүүдийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд шаардагдаж байгаа эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардлыг 151.0 сая төгрөгөөр, багаж техник хэрэгслийн зардлыг 373.4 сая төгрөг, нийт 524.4 сая төгрөг нэмэгдүүлэн тусгав.



Тусгай эмнэлгүүдэд ЭМД-ын сангаас олгох санхүүжилтийг нэмэгдүүлнэ. Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн зардлыг 2,191.7 сая төгрөгөөр, Цэргийн төв эмнэлгийн зардлыг 2,189.7 сая төгрөгөөр тус тус өмнөх оноос нэмэгдүүлэв.



Цэрэг, цагдаагийн алба хаагчдын хоол хүнс, дүрэмт хувцасны хангалтын зардлыг нэмэгдүүлнэ.

Батлан хамгаалах салбарын цэргийн алба хаагчдын хоол хүнсний зардлыг үнийн өсөлтийг тооцож өмнөх оноос 6,345.3 сая төгрөгөөр, дүрэмт хувцасны хангалтын зардлыг 2,850.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэв. Ман Хууль зүй, дотоод хэргийн салбарын цэрэг, цагдаагийн алба хаагчдын хоол хүнсний зардлыг 3.410.1 сая төгрөгөөр, дүрэмт хувцасны зардлыг 6,701.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэв.



Гал унтраах анги, салбар, бүлгүүдийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ.

Засгийн газрын 2019 оны 331 дүгээр тогтоолын дагуу Сэлэнгэ, Баянхонгор, Хэнтий, Увс, Өвөрхангай аймагт шинээр байгуулагдах гал унтраах 1 анги, эрэн хайх, аврах 4 салбар, эрэн хайх, аврах 1 бүлгийн үйл ажиллагааг 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлүүлэхтэй холбогдуулан нийт 139 орон тоо, 2.2 тэрбум төгрөгийн урсгал зардал нэмж тусгав.



Мэргэжлийн хяналтын чадавх хүртээмжийг сайжруулна.

Дэд бүтэц, уул уурхайн салбарын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаанд тавих төрийн хяналт шалгалтын чадавх, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор геологи уул уурхай, өргөх механизм, ус хангамж ариутгах татуурга, эм биобэлдмэл, газрын тос хийн хяналтын байцаагчийн 69 орон тоо, урсгал зардлыг 1.5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүллээ.



Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог сайжруулах

чиглэлээр эрчимтэй арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаарх Харилцан үнэлгээний тайлангаар өгсөн зөвлөмж, арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн хангаж,

мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоодын тогтолцоог сайжруулах зорилгоор нийт 207 орон тоо, урсгал зардалд 9,903.8 сая төгрөгийг Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Шүүхийн ерөнхий зөвлөл, Гаалийн ерөнхий газрын төсөвт тусгасан. Ингэснээр, санхүүгийн бус бизнесийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн эрсдэлийг тодорхойлох, хяналт шалгалт хийх, үнэлгээний мөрөөр шаардлагатай зохицуулалтыг баталж мөрдүүлэх, олон улсын хурал, зөвлөгөөнд холбогдох байгууллагуудын төлөөлөлтэйгөөр бэлтгэлтэй оролцох, хүний нөөцийн чадавхыг бүрдүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

5.9. Төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа



1/ Төрийн албаны тухай хууль, Боловсролын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу өндөр насны тэтгэвэрт гарч байгаа төрийн албан хаагчид олгох нэг удаагийн буцалтгүй тусламжид 141.1 тэрбум төгрөг тусгасан нь 2019 онтой харьцуулахад 38.4 тэрбум төгрөгөөр буюу 37 хувиар нэмэгдэхээр байна.

Хүснэгт №9. Тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжид хамрагдах хүний тоо, зарцуулах хөрөнгийн өөрчлөлт

Хууль	2019	2020	Өөрчлөлт	
	Төсөв	Төс	Тоо	%
1. Нийт хүний тоо	5,341	5,732	391	7%
1.1. Төрийн албаны тухай	719	1,404	685	95%
1.2. Боловсролын тухай	1,198	1,654	456	38%
1.3. Эрүүл мэндийн тухай	663	928	265	40%
1.4. Цэргийн албан хаагчийн Т.Т тухай	1,604	1,308	-296	-18%

1.5. Бусад хууль	1,157	438	-719	-62%
2. Зарцуулах хөрөнгө /тэрбум төгрөг/	102.8	141.1	38.4	37%

Ирэх онд нийт 5.7 мянган албан хаагч төрийн албанаас тэтгэвэрт гарах ба үүний 24.5% нь төрийн албаны тухай, 22.9% цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай, 28.9% нь боловсролын тухай, 16.2% нь эрүүл мэндийн тухай, 7.6% нь бусад хуулиар тус тус тэтгэвэрт гарч байна.

2/ 2020 оны төсвийн төсөлд хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжид нийт 5 салбарын 7.3 мянган хүн хамрагдахаар тооцож 39.6 тэрбум төгрөг тусгалаа.

Хүснэгт №10. Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжид хамрагдах хүний тоо, зарцуулах хөрөнгө /тэрбум төгрөг/

№	ТЕЗ	Хүний тоо	Нийт зардал
1	БХС	127	1.0
2	ЭМС	2,247	9.7
3	ХЗДХС	810	11.1
4	БСШУСС	3,752	15.6
5	ХНХС	341	2.3
	НИЙТ	7,277	39.6

5.10. Орон тооны өөрчлөлт



Төрийн албан хаагчдын тооны өсөлт 2020 онд 3.3 мянгаар нэмэгдэхээр байна. Орон тооны өөрчлөлттэй холбоотойгоор урсгал зардлыг 52 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Орон тооны нэмэгдлийг шалтгаанаар нь авч үзвэл шинэ хөрөнгө оруулалттай холбоотойгоор шинээр ашиглалтад орж байгаа сургууль, цэцэрлэгт 1,838 орон тоо, эмнэлэгт 403 орон тоо, мэргэжлийн хяналтын лабораторид 18 орон тоо нэмэгдэхээр байна.

Орон тооны нэмэгдлийг шалтгаанаар нь авч үзвэл шинэ хөрөнгө оруулалттай холбоотойгоор шинээр ашиглалтад орж байгаа сургууль, цэцэрлэгт 1,838 орон тоо, эмнэлэгт 403 орон тоо, мэргэжлийн хяналтын лабораторид 18 орон тоо нэмэгдэхээр байна.

Шинэ хууль, тогтоомж батлагдсантай холбогдуулан байгаль орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх экологийн цагдаа 228 орон тоо, олон улсын хүүхдийн Найрамдал

зусланг улсын төсөвт эргүүлэн татахтай холбоотой 158 орон тоо, шинэ гал унтраах аврах анги, эрэн хайх, аврах бүлэгт 139 орон тоо, хяналт шалгалтын чадавх хүртээмжийг нэмэгдүүлэхтэй холбоотой мэргэжлийн хяналтын байгууллагад 69 орон тоо, Татварын шинэ багц хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой 61 орон тоо, мөнгө угаах, терроризмтой тэмцэх үйл ажиллагаатай холбоотойгоор авлигатай тэмцэх мөрдөгч 60 орон тоо, прокурорын 50 орон тоо, Хил хамгаалах ерөнхий газарт 43 орон тоо, шүүгчийн 20 орон тоо, гаалийн лабораторид 19 орон тоо, Санхүүгийн зохицуулах хороонд 10 орон тоо, Цагдаагийн ерөнхий газарт 5 орон тоо, шинээр байгуулагдсан хилийн заставт 12 орон тоо, хар тамхитай тэмцэх мөрдөгч 46 орон тоо, аймаг, нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд 39 орон тоо, Төрийн албаны зөвлөлийн бүтцийг өргөжүүлэхтэй холбоотой 16 орон тоо, Нийслэлийн Сонгинохайрхан, Хан-Уул, Налайх дүүрэгт шинэ хороо байгуулагдсантай холбоотой 22 орон тоо, Япон улс дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын төв байгуулахтай холбоотой 3 орон тоо нэмэгдэж байна.

Хүснэгт №11. Орон тооны өөрчлөлтийн судалгаа /тэрбум төгрөг/

ХҮЧИН ЗҮЙЛС	Орон тоо	Урсгал зардал
НИЙТ	3,370	52
1.Шинэ сургууль, цэцэрлэг	1,838	8.0
2.Шинэ эмнэлэг	403	14.3
3.Байгаль орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх экологийн цагдаа	228	4.8
4.Мөнгө угаах терроризмтой тэмцэх	207	8.3
<i>Үүнээс: Авлигатай тэмцэх газарт</i>	<i>60</i>	<i>2.9</i>
<i>Улсын прокурорын ерөнхий газарт</i>	<i>50</i>	<i>1.7</i>
<i>Хил хамгаалах ерөнхий газарт</i>	<i>43</i>	<i>0.3</i>
<i>Шүүхийн ерөнхий зөвлөлд</i>	<i>20</i>	<i>0.7</i>
<i>Гаалийн ерөнхий газарт</i>	<i>19</i>	<i>2.4</i>
<i>Санхүүгийн зохицуулах хороонд</i>	<i>10</i>	<i>0.2</i>
<i>Цагдаагийн ерөнхий газарт</i>	<i>5</i>	<i>0.1</i>
5.Олон улсын хүүхдийн Найрамдал зусланг улсын төсөвт буцааж татах	158	5.2
6.Шинэ гал унтраах анги, салбар, эрэн хайх, аврах бүлэг	139	2.2

7.Хяналт шалгалтын чадавх хүртээмжийг нэмэгдүүлэх, шинээр ашиглалтад орох хяналтын лабораторийн барилгатай холбоотой нэмэгдэх	87	2.2
8. Соёлын байгууллагууд	79	1.4
9.Татварын шинэ багц хуулийг хэрэгжүүлэх	61	1.2
10.Хар тамхитай тэмцэх мөрдөгч	46	1.3
11.Аймаг, нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв, шинэ хөрөнгө оруулалт	39	0.5
12.Малын эмийн сорилт баталгаажуулалтын улсын төв лаборатори	32	0.2
13.Нийслэлийн зарим дүүрэгт шинэ хороо байгуулагдсантай холбоотой	22	0.4
14. Төрийн албаны шинэ хууль хэрэгжихтэй холбогдуулан ТАЗ-ын бүтцийн өөрчлөлт	16	0.7
15.Шинээр байгуулагдсан хилийн заставт	12	0.1
16.Япон улс дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын төв	3	0.9

5.11. Төрийн бусад үйлчилгээ



Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх тогтолцоог бий болгоно Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг

хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газрын 2018 оны 366 дугаар тогтоолоор Удирдлагын академийг Засгийн газрын харьяа төрийн албаны сургалтын байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэхээр дүрмийг шинэчлэн баталсан. 2020 оноос эхлэн Удирдлагын академи нь зөвхөн төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх багц сургалт, төрийн албанд шинээр томилогдсон иргэнийг сургах богино болон дунд хугацааны сургалтыг зохион байгуулна.



Худалдан авах ажиллагааны агентлаг байгуулна. Төрийн

болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай тухай хуулийн 53.1-д заасны дагуу Засгийн газрын худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн агентлаг болон Засгийн газрын төрийн өмчийн

бодлогын асуудал эрхэлсэн агентлаг нь тус тусдаа байгуулагдахаар болсон. Иймд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын орон тоо болон урсгал зардлыг чиг үүрэг, ажлын ачааллыг үндэслэн төсвийг нь хоёр салгах зохицуулалт хийхээр тусгасан.



Байгаль орчны эсрэг гэмт хэрэгт хяналт тавих Экологийн цагдаагийн алба байгуулна.

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, уг гэмт хэргийн улмаас байгаль экологид учрах хохирлыг бууруулах чиглэлээр 170 экологийн цагдааг уул уурхайн зөрчил, байгаль орчны эсрэг гэмт хэрэг гарч байгаа аймаг, сумдад ажиллуулна.

Түүнчлэн “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” Засгийн газрын 2018 оны 62 тоот тогтоолыг хэрэгжүүлэхэд түүхий нүүрсний борлуулалт хэрэглээнд хяналт тавих үүрэг бүхий 58 цагдаагийн орон тоог шинээр санхүүжүүлнэ.



Төрийн албан хаагчдын цахим бүртгэлийг нэгтгэж орон тоо, цалин хөлсний зардлын хяналтыг сайжруулна. Төсөвт

байгууллагын орон тооны хязгаарыг цалингийн сангаар хянадаг ба орон тооны хязгаараас давсан ажилчдыг төсөвт байгууллагын үйл ажиллагааны хэмнэгдсэн зардлаас цалинжуулж гэрээгээр ажиллуулж байна. Иймд төсвийн сахилга батыг сайжруулах, төсөвт байгууллагын ажиллах хүч, хүний нөөцийг үр дүнтэй байлгах зорилгоор төрийн албан хаагчдын хүний нөөцийн бүртгэлийн системийг нэвтрүүлнэ.

Ингэснээр төрийн байгууллагын нийт орон тоо, цалингийн зардлын төлөвлөлт, зарцуулалтыг бүрэн хяналтад оруулж төсвийн үргүй зардлыг эрс бууруулна.



Түлш халаалт, шатахууны зардлыг индексжүүлнэ.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа төсвийн байгууллагын тээвэр шатахуун, түлш халаалтын хэрэглээ, зах зээлийн үнэ тарифын нарийвчилсан судалгаанд үндэслэн холбогдох зардлыг индексжүүлэхээр тооцов.



Сонгуулийн зардлыг тусгана.

Улсын Их Хурлын болон орон нутгийн ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдуулан нийт 43.0 тэрбум төгрөг, үүнээс УИХ-ын сонгууль зохион байгуулахад 24.3 тэрбум төгрөг төлөвлөв.

Ирэх 2020 оны сонгуульд зарцуулах хөрөнгийн хэмжээ 2016 оны сонгуулийн арга хэмжээний төсвөөс 12.6 тэрбум нэмэгдэж байгаа нь сонгуулийн насны хүн амын тоо 112.6 мянгаар нэмэгдсэн, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдсэнтэй холбогдуулан хэсгийн хороодод ажиллах албан хаагчдад тооцож олгодог урамшууллын хэмжээ нэмэгдсэн, сонгуулийн санал тоолох төхөөрөмж 300 ширхгийг шинээр худалдан авах шаардлагатай болсон зэрэгтэй холбоотой байна.



Хэлмэгдэгсдэд нөхөх олговрыг бүрэн олгож дуусгана.

Улс төрийн хилс хэргээр хэлмэгдэгсдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн 13.2.1 дэх заалтын дагуу нийт 385 хүнд 30.8 тэрбум төгрөг, 13.2.2 дахь заалтын дагуу 578 хүнд 23.1 тэрбум төгрөг нийт 963 хүнд 53.9 тэрбум төгрөг олгохоор төлөвлөсөн ба хуульд заасан нөхөн олговрыг ирэх онд бүрэн олгож дуусна.

5.12. Засгийн газрын тусгай сан

Засгийн газрын тусгай сангуудын үйл ажиллагааг цэгцэлж, оновчтой зохион байгуулан, санхүүжилт, зарцуулалтыг ил тод, хяналттай болгох, олон нийтийн оролцоог

хангах замаар тусгай сангуудын эдийн засаг, нийгэмд үзүүлэх үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулав. Уг хуулийн өөрчлөлтөөр чиглэл, зорилгын давхардал үүсгэж байсан Мал хамгаалах сан, Тариаланг дэмжих сан болон Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих санг нэгтгэн Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих сан болгон зохион байгуулж, үйл ажиллагаа явуулдаггүй, тусдаа сан байх шаардлагагүй Үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан, Олон улсын хамтын ажиллагааны сан, Монгол судлалыг дэмжих сан, Ирээдүйн тэтгэврийн нөөц сан, Эрдэлийн сан, Засгийн газрын өрийн баталгааны сан зэрэг 7 тусгай санг татан буулгана. Мөн кино урлагийн салбарын хөгжлийг төрөөс дэмжих, кино үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилготой Кино урлагийг дэмжих санг шинээр байгуулна. Түүнчлэн нийт тусгай сангуудын хөрөнгийн зарцуулалт, ажлын албаны үйл ажиллагаанд тавих хяналтыг боловсронгуй болгож, олон нийтэд нээлттэй, ил тод, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зохицуулалтуудыг тусгаж мөрдүүлнэ.

Монгол Улсын 2020 оны төсвийн жилд Засгийн газрын тусгай сангуудаар дамжин нийт 4,295.9 тэрбум төгрөгийн зардал санхүүжүүлэх бол үүний 88.0 хувь буюу 3,773.8 тэрбум төгрөг нь Нийгмийн даатгал, Нийгмийн халамж, Эрүүл мэндийн даатгалын сангуудын зарлага, 12.0 хувь буюу 512.1 тэрбум төгрөг нь бусад тусгай сангийн зардалд хамаарч байна.

Хүснэгт №12. Засгийн газрын тусгай сангийн зардлын төсөл /тэрбум төгрөг/

#	ЗГ-ын тусгай сан	2020
		Төсөл
НИЙТ		4,295.9
1	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан	3.9

2	Хилийн чанадад байгаа МУ-ын иргэдэд туслах сан	0.2
3	Засгийн газрын нөөц сан	25
4	Зэвсэгт хүчний хөгжлийн сан	35
5	Эрүүл мэндийг дэмжих сан	3
6	Байгаль орчин, уур амьсгалын сан	1.9
7	Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан	0.6
8	Боловсролын зээлийн сан	76.6
9	Соёл, урлагийг дэмжих сан	2.0
10	Шинжлэх ухаан, технологийн сан	13.5
11	Спортыг дэмжих сан	2.0
12	Кино урлагийг дэмжих сан	10.0
13	Улсын авто замын сан	55.0
14	Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих сан	84.9
15	Нийгмийн халамжийн сан	756.6
16	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	120.1
17	Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан	88.4
18	Нийгмийн даатгалын сан	2,510.7
19	ЭМД -ын сан	506.5

Боловсролын зээлийн сан



Боловсролын зээлийн санд нийт 76.6 тэрбум төгрөг төсөвлөснөөс оюутны хөгжлийн зээлд 33.0 тэрбум төгрөг, дэлхийн шилдэг 100 сургуульд суралцагчдын сургалтын төлбөрийн зээлд 14.5 тэрбум төгрөг, зарим суралцагчдад олгох сургалтын төлбөрийн тэтгэлэгт 12.6 тэрбум төгрөг, Засгийн газрын гэрээгээр гадаадад суралцагчдад олгох зээлд 7.3 тэрбум төгрөг, багш мэргэжлээр суралцаж буй оюутан, магистрантуудад олгох сургалтын төлбөрт 2.8 тэрбум төгрөг, бусад зээл, арга хэмжээний зардалд 2.9 тэрбум төгрөг тусгасан.

Кино урлагийг дэмжих сан



Үндэсний кино контент бүтээх, кино үйлдвэрлэл, дэд бүтцийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, олон улсын кино наадам, үзэсгэлэнд Монгол киног оролцуулах, төрийн захиалгаар уран сайхны болон баримтат кино, хүүхэд залуучуудад зориулсан кино бүтээл туурвихад дэмжлэг үзүүлэх зэрэг үйл ажиллагааг санхүүжүүлэх зориулалт бүхий

Засгийн газрын тусгай санг шинээр байгуулахаар тооцож төрөөс санхүүжилтийн эх үүсвэрт эхлэлийн хөрөнгө болгож 10.0 тэрбум төгрөг олгохоор тусгав. Цаашид уг сан өөрөө өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллана.



Нийгмийн халамжийн сан.

Халамжийн сангийн нийт зарлага 756.6 тэрбум төгрөг байгаа нь урьд оноос 62.1 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байгаа ба энэхүү нэмэгдсэн хөрөнгийн 21.1 тэрбум төгрөг нь хүүхдийн мөнгөн тэтгэмжийг хүсэлт гаргасан хүүхэд бүрд олгохоор тооцсонтой, 17.5 тэрбум төгрөг нь халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг инфляцтай уялдуулан нэмэгдүүлэхэд, 13.8 тэрбум төгрөг нь “Цалинтай ээж” хөтөлбөрийн хэрэгжилтийг үргэлжлүүлэн хангахад, 12.7 тэрбум төгрөг нь Засгийн газрын 2019 оны 227 дугаар тогтоолоор хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа иргэнд олгох асаргааны тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлсэнтэй тус тус холбоотой байна.

Хүснэгт №13. Нийгмийн халамжийн сангийн зарлага /тэрбум төгрөг/

Халамжийн сан	2020 төсөл
Халамжийн тэтгэвэр	117.6
Жирэмсэн эхийн тэтгэмж	18.1
Ахмад дайчин, алдар цолтон	6.4
Алдарт эхийн тэтгэмж	29.4
Хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	240
Асаргааны тэтгэмж	50.2
Олон нийтийн оролцоо	1.8
Амьжиргааг дэмжих тусламж	27.8
Асрамжийн үйлчилгээ	0.3
Хүнсний талон	42.2
ХБИ тэтгэмж	12.3
Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт	26.1
Цалинтай ээж	110.7
Насны хишиг	22.3
Халамжийн бусад хөнгөлөлт	31.1
Тэтгэвэр, тэтгэмж нэмэгдүүлэх	17.5
Үйл ажиллагааны зардал	2.7
НИЙТ	756.6



Халамжийн сангийн удирдлагыг цахимжуулна.

Халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт

үйлчилгээнд зарцуулж байгаа хөрөнгийн хяналт, зарцуулалтын үр ашгийг сайжруулах зорилгоор сангийн төлөвлөлт, зарцуулалтын удирдлагыг 2020 оноос эхлэн цахим систем ашиглан хэрэгжүүлнэ. Цахим систем нэвтрүүлснээр халамжийн сангийн зардлыг оновчтой, үр ашигтай төлөвлөж санхүүжүүлэх боломжтой болохын зэрэгцээ халамж авагчдыг бодитоор тодорхойлох, төсвийн сахилга бат, хуваарилалтын үр ашиг сайжирч, иргэд халамжийн үйлчилгээг цаг тухай бүр нь хүндрэл, чирэгдэлгүйгээр авах боломж бүрдэнэ.



Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн нийт зардлыг 120.1 тэрбум төгрөгөөр тооцсон нь өмнөх оноос 36.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна. Монгол Улсын Засгийн газар, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний зөвлөлөөс баталсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний зардалд 40.0 тэрбум төгрөг, гадаад ажиллагчдын төлбөрөөс мэргэжлийн боловсролыг дэмжих санд 79.9 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр тооцов.

Мэргэжлийн боловсролыг дэмжих сан. Мэргэжлийн боловсролыг дэмжих сангийн 2020 оны төсвийн нийт зардлыг 88.3 тэрбум төгрөгөөр тооцсон нь 2019 оноос 39.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна. Сангийн зардлыг арга хэмжээгээр нь ангилж үзвэл мэргэжлийн боловсролын сургалтын төвд суралцагчдад сар бүр олгох тэтгэлгийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлж 200.0 мянган төгрөгт хүргэхээр тооцож нийт 40 мянган суралцагчдад 79.9 тэрбум төгрөг, хувийн мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагуудын хувьсах зардалд 8.4 тэрбум төгрөг олгохоор тус тус тусгасан.



Улсын авто замын сан. Улсын авто замын сангийн төсвийг 2020 онд нийт 55.0 тэрбум төгрөгөөр

тооцсон ба 40.0 тэрбум төгрөгийг улсын төсвөөс, 15.0 тэрбум төгрөгийг өөрийн үйл ажиллагааны орлогоос тус тус санхүүжүүлэхээр тусгалаа. Ингэснээр Улсын авто замын сангийн орлогын эх үүсвэрийг замын засвар, арчлалтад бүрэн зарцуулах нөхцөл бүрдэнэ.



Үндэсний үйлдвэрлэлийг

дэмжих сан. Засгийн газрын тусгай сангуудын талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын 2019 оны 87 дугаар тогтоолоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын төсвийн багцын харьяа Мал хамгаалах сан, Тариаланг дэмжих санг Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн үйл ажиллагаатай нэгтгэн зохион байгуулахаар болсон.

Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих сангаас ирэх 2020 онд жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх, газар тариалан, мал аж ахуйг дэмжих зориулалтаар хөнгөлөлттэй зээл олгох, зөвлөгөө мэдээллээр хангах, сургалт, давтан сургалтад хамруулах зэрэг арга хэмжээнд нийт 84.9 тэрбум төгрөг зарцуулахаар тусгав.

5.13. Эргэж төлөгдөх зээл



Ипотекийн зээлийг зорилтот бүлэгт үргэлжлүүлэн олгоно.

Ипотекийн зээлийн санхүүжилтийн эх үүсвэрт зориулж 2020 онд 60.0 тэрбум төгрөгийг улсын төсвөөс олгохоор тусгалаа. Улсын төсвөөс олгож байгаа эх үүсвэрийн хүүг бууруулах замаар арилжааны банкны эх үүсвэрийг татан оролцуулна.

Түүнчлэн ипотекийн зээлийн багцыг үнэт цаасжуулахтай холбоотой гарах зардлыг бууруулах чиглэлээр холбогдох хууль журамд шаардлагатай өөрчлөлт оруулж, одоогийн орон сууцны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн схемийг боловсронгуй болгоно.


6. ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ



УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ /2016-2019/

Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2016-2019 онд нийт 4,290.9 тэрбум төгрөгийн бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээ батлагдан хэрэгжүүлснээс 2016-2018 онд нийт 2,350.9 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарсан, 2019 онд батлагдсан 1,698.1 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл одоогийн байдлаар 36.9 хувьтай хэрэгжиж байна.

График №37. Улсын төсвийн хөрөнгө оруулалт /тэрбум төгрөг/




УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ 2019 ОНД



Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хуульд хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 1,553.4 тэрбум төгрөгийн 1281 төсөл, арга хэмжээ, концессын “Барих-Шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлсэн 12 төсөл, арга хэмжээний эргэн төлөлтөд 144.7 тэрбум төгрөг, нийт 1,698.1 тэрбум төгрөгийн 1293 төсөл, арга хэмжээ батлагдсан.

График №38. Эдийн засгийн ангиллаар, тэрбум төгрөг



Энэ онд 193.3 тэрбум төгрөгийн санхүүжилт бүхий 124 сургууль баригдаж сургуулийн хүчин чадлыг 55818 суудлаар, 180.6 тэрбум төгрөгийн санхүүжилт бүхий 176 цэцэрлэг баригдаж цэцэрлэгийн хүчин чадлыг 26490 ороор, 34.2 тэрбум төгрөгийн санхүүжилт бүхий 43 дотуур байр баригдаж дотуур байрны хүчин чадлыг 4460 ороор тус тус нэмэгдүүлнэ.

ШИНЭЧЛЭЛИЙН ТОМООХОН АЖЛУУД



Засгийн газраас сүүлийн 2 жилийн хугацаанд улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг сайжруулах, олон нийтэд нээлттэй ил тод болгох чиглэлээр томоохон шинэчлэлийн ажлуудыг хэрэгжүүлснээр Монгол улсын төсвийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа олон улсын түвшинд үнэлэгдэж, хөгжиж буй орнуудаас нэг алхам урагшиллаа.



Тухайлбал төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн үйл ажиллагааг онлайн болгож, <https://publicinvestment.gov.mn/> веб хуудас болон гар утасны “төсвийн хөрөнгө оруулалт” аппликэйшныг ашиглалтад орууллаа. Ингэснээр санхүүжилтийн үйл ажиллагааг түргэн шуурхай хэрэгжүүлэх, иргэд, олон нийтийг мэдээллээр ил тод, нээлттэй хангах, төрийн үйлчилгээнд хувийн

хэвшил, олон нийт хяналт тавих боломжийг бүрдүүлж, гүйцэтгэгч аж ахуй нэгж гэрээт ажлын санхүүжилтийг ямар үе шатанд явж байгааг нээлттэй харах, хянах, иргэд тухайн орон нутагт хийгдэж буй хөрөнгө оруулалтын талаар мэдээлэл авах боломжтой болсноороо онцлог юм.

Зураг №3. “Төсвийн хөрөнгө оруулалт” аппликэйшн



Мөн Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааны журам болон аргачлалууд”-ыг баталсан, ингэснээр төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг

тооцож, эрэмбэлсний үндсэн дээр цахим системээр хүлээн авч төсвийн төсөлд тусгадаг боллоо.

Зураг №4. Хөрөнгө оруулалтын төлөвлөлт



Төсвийн төсөлд аргачлалын дагуу боловсруулсан 2774 төслийн саналыг цахим системээр ирүүлсэн байна.

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР 2020 ОНД

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийгмийн ач холбогдол бүхий эдийн засгийн үр ашигтай төсөл, арга хэмжээг дараах бодлого, зарчмын дагуу хэрэгжүүлнэ. Үүнд:

1. ЭХЛҮҮЛСЭН ТӨСЛҮҮДИЙГ ДУУСГАНА.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эхлүүлсэн төслүүдийг 2020 онд дуусгана.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018-2019 онд эхлүүлсэн 424 төслийн үлдэгдэл 987.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг төсвийн төсөлд тусгаж, 2020 онд боловсрол, соёл, спорт, шинжлэх ухааны салбарын 304.8 тэрбум төгрөгийн 205, эрүүл мэндийн салбарын 75.4 тэрбум төгрөгийн 41, зам тээврийн салбарын 252.4 тэрбум төгрөгийн 59, барилга хот байгуулалтын салбарын 121.4 тэрбум төгрөгийн 43, байгаль, орчин аялал жуулчлалын салбарын 15.3 тэрбум төгрөгийн 9, эрчим хүчний салбарын 46.4 тэрбум төгрөгийн 10, хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын 11.2 тэрбум төгрөгийн 10, батлан хамгаалах салбарын 8.4 тэрбум төгрөгийн 4, хууль зүй, дотоод хэргийн салбарын 23.3 тэрбум төгрөгийн 6 төсөл тус тус хэрэгжинэ.

2018 оны Төсвийн тухай хуульд батлагдсан, санхүүжилтээ бүрэн аваагүй төслүүдийн хураагдсан санхүүжилтийг шийдвэрлэнэ

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд хэрэгжихээр батлагдсан боловч ажлаа эхлүүлж чадаагүй боловсролын салбарын 21.0 тэрбум төгрөгийн 23, зам тээврийн салбарын 5.3 тэрбум төгрөгийн 7, барилга, хот байгуулалтын салбарын 1.1 тэрбум төгрөгийн 4 төсөл, эрүүл мэндийн салбарын 7.3 тэрбум төгрөгийн 4 төсөл, нийт **34.8** тэрбум төгрөгийн **35** төслийн хураагдсан санхүүжилтийн төсвийн төсөлд тусгаж, төслүүдийг ашиглалтад оруулна.

Царцаагдсан төслүүдийг дуусгахад шаардлагатай санхүүжилтийг тусгаж, олон жил үргэлжилсэн төслүүдийг бүрэн дуусгана.

Ажил нь зогсож удааширсан, царцаагдсан төслүүдээс 2018-2019 онд нийт 28.8 тэрбум төгрөгийн 41 төсөл, арга хэмжээг төсөвт тусгаж шийдвэрлэсэн бол 2020 оны төсвийн төсөлд **23** царцаагдсан төслийг бүрэн дуусгахад шаардлагатай **22.8** тэрбум төгрөгийг тусгасан.

II. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ, НИЙГМИЙН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГАД НИЙЦСЭН ТӨСЛҮҮДИЙГ ХЭРЭГЖҮҮЛНЭ.

Эдийн засаг, нийгмийн дэд бүтцийг сайжруулах төслүүдийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлнэ.

Соёл, урлагийн салбарын хөрөнгө оруулалтын нэмэгдүүлж, ач холбогдол бүхий төслүүдийг хэрэгжүүлнэ.

Үндэсний болон сонгодог урлагийг төрийн ивээлд байлгах, соёл урлагийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, соёл урлагийн аялал жуулчлал, гадаадад монголын үндэсний соёл урлагийг

сурталчлах зорилтын хүрээнд соёл, урлаг, спортын салбарын 8 төслийг хэрэгжүүлэхэд 2020 онд шаардлагатай 135.0 тэрбум төгрөгийн төсвийн төсөлд тусгалаа.



Чингис хааны музейн барилга: 2020 онд 53.0 тэрбум төгрөг.

Үндэсний урлагийн их театр: 2020 онд 30.0 тэрбум төгрөг.



Байгалийн түүхийн музейн барилга: 2020 онд 31.9 тэрбум төгрөг.

Төв номын сангийн барилга: 2020 онд 4.0 тэрбум төгрөг.



Дуурь бүжгийн эрдмийн театрын барилга: 2020 онд 4.0 тэрбум төгрөг.

Улсын драмын эрдмийн театрын барилга: 2020 онд 4.0 тэрбум төгрөг.





Үндэсний төв цэнгэлдэх хүрээлэн: 2020 онд 5.0 тэрбум төгрөг.

Шинжлэх ухаан, инновацын төвийн кластер: 2020 онд 3.0 тэрбум төгрөг.



Гаалийн шинэчлэлийг хэрэгжүүлнэ.

Гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлж, байгалийн баялгаас татварыг бүрэн хураах



боломжийг бүрдүүлэхэд шаардлагатай 80.4 тэрбум төгрөгийн төсвийн төсөлд тусгасан. Ингэснээр боомтын шинэчлэл хийгдэж, зорчигч тээвэр, ачаа тээврийн барилга байгууламж, иж бүрэн шугам сүлжээ, дэд бүтэц, зам талбай, ногоон байгууламжийн цогцолборууд баригдана.

Мөн экспортын гол боомтууд дээр олон улсын шаардлагад нийцсэн гаалийн төрөлжсөн лабораториудыг байгуулж, гаалийн төв лабораторийг олон улсын итгэмжлэлд хамруулна.

Гаалийн хүчин чадлыг нэмэгдүүлж дэвшилтэт тоног төхөөрөмж, өндөр хүчин чадлын рентген, орчин үеийн телехяналтын системийг бүрдүүлнэ.

“Сумын төвийн шинэчлэл” бүтээн байгуулалтыг улс орон даяар хэрэгжүүлнэ.



Орон нутгийн иргэдийн амьдрах таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн “Сумын төвийн шинэчлэл”-ийн бүтээн

байгуулалтын зураг төсөл, ТЭЗҮ, хөрөнгө оруулалтыг тухайн орон нутгийн иргэдийн

санал дээр үндэслэн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх чиглэлийг баримтална. Улсын төсвөөс 2020 онд “Сумын төвийн шинэчлэл”-ийн бүтээн байгуулалтад 4 жишиг сум тус бүрд 5 тэрбум төгрөг, нийт 20 тэрбум төгрөгийг зарцуулна.

Концессын “Барих-Шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний эргэн төлөлтийг тусгана.

Концессын “Барих-Шилжүүлэх” төрлөөр 2015-2017 онд гэрээ байгуулсан төслүүдийн эргэн төлөлт болох 323.6 тэрбум төгрөгийг дараах зарчмыг баримтлан төсвийн төсөлд тусгав. Үүнд:

- ✓ 2020 оны төсвийн хязгаарт багтаах
- ✓ Эргэн төлөлтийг 3-4 жилд хуваан төлөх
- ✓ Ажлын гүйцэтгэлээр эргэн төлөлт хийх

Концессын төслүүдийн эргэн төлөлтийг хийснээр 2020 онд Улаанбаатар хотыг аймгуудтай холбож дуусгах 565.5 км авто зам, 300 ортой төрөх эмнэлэг зэрэг томоохон төслүүдийг улсад хүлээн авна.

Боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж дуусгана.



Боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж 3 ээлжтэй сургуулийг 2 ээлжид

шилжүүлэх, хүүхэд бүрийг цэцэрлэгт хамруулах зорилтыг бүрэн хэрэгжүүлж, хүүхэд бүрийг цэцэрлэгт хамруулж, 3 ээлжтэй сургуулиуд 2 ээлжид шилжинэ. Мөн их засвар болон шинээр ашиглалтад орох сургууль, цэцэрлэгийн тоног төхөөрөмжийг хангахад шаардлагатай 39.0 тэрбум төгрөгийг зарцуулна.

Эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмжийг иргэдэд хурдан шуурхай хүргэх, эмнэлгийн орчин нөхцөлийг сайжруулна.



Хүн амд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эхлүүлсэн эмнэлгүүдийг ашиглалтад оруулах, яаралтай түргэн тусламж, мэс засал, оношилгоо болон нярайн шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авахад шаардлагатай санхүүжилтийг төсвийн төсөлд тусгасан.

Хууль эрх зүй, батлан хамгаалах салбарын хөрөнгө оруулалтын нэмэгдүүлж ард иргэдийн амгалан тайван байдлыг сахин хамгаална.

Улс орныг баглан хамгаалах чадавхыг бэхжүүлэх чиглэлээр 11.9 тэрбум төгрөг, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг хангах чиглэлээр хууль зүй, дотоод хэргийн салбарт 47.7 тэрбум төгрөгийг тус тус төсвийн төсөлд төлөвлөсөн.

Аялал жуулчлалын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх төслүүдийг хэрэгжүүлнэ.



Эдийн засгийг төрөлжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй дэд бүтцийг сайжруулах, байгаль орчныг хамгаалах, орон нутгийн иргэдийн эдийн засгийн боломжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд өмнөх жилүүдээс байгаль орчин, аялал жуулчлалын салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бодлого баримталж байна. Энэ чиглэлээр 2020 оны төсвийн төсөлд соёл, урлагийн салбарын томоохон төслүүдийг хэрэгжүүлэхээс гадна орон нутгийн аялал жуулчлалын бүсийг хөгжүүлнэ.



7. ОРОН НУТГИЙН ТӨСӨВ



Ирэх онд төрийн албан хаагчдын цалинг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 100.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 420.0 мянган төгрөг болгох зэрэг арга хэмжээний хүрээнд хувь хүний орлогын албан татварын орлого нэмэгдсэнтэй холбоотойгоор орон нутгийн суурь орлого 2019 оны түвшнээс 225.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэж нийтдээ 1,348.9 тэрбум төгрөг болсон.

Засгийн газраас тогтоосон газрын суурь үнэлгээ, орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон итгэлцүүр, эзэмшил, ашиглалтад байгаа газрын мэдээлэл болон ирэх онд авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээний нөлөөлөл зэрэгт үндэслэн газрын төлбөрийн орлогоор ирэх онд төсөвт 109.8 тэрбум төгрөгийг төвлөрүүлнэ.

Монгол Улсын Засгийн газраас газрын бүртгэлийг бүрэн цахимжуулах, мэдээллийг ил тод болгож төлбөр ногдуулах, төлбөр төлөх харилцааг автоматжуулах замаар газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгжүүд газрын төлбөрөө цаг тухайд нь амар хялбараар төлдөг байх боломжийг бүрдүүлэх мэдээллийн технологийн цогц шийдлийг нэвтрүүлнэ.

Ирэх 2020 онд төрийн албан хаагчийн цалин хөлсийг инфляцын түвшинтэй уялдуулан 8 хувиар нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээний албан хаагчдад төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл болон тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийг төрийн захиргааны албан хаагчийн нэгэн адилаар 2020 оноос эхлэн тооцож олгох, түлш халаалт, шатахууны үнэ, тарифын өсөлттэй уялдуулан орон нутгийн байгууллагын халаалтын зардлыг 8 хувь,

шатахууны зардлыг 20 хувиар тус тус нэмэгдүүлж байгаатай холбоотойгоор 2020 оны суурь зарлага өмнөх оны түвшнээс 148.1 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 857.7 тэрбум төгрөгт хүрэхээр байна.

Орон нутгийн төсвийн суурь орлого, зарлагын дээрх өөрчлөлт нь аймгуудад олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг өмнөх оноос нийтдээ 46.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхэд нөлөөлж байна.

Хүснэгт №14. Орон нутгийн суурь төсөв

	2019 он	2020 он	Өөрчлөлт
Суурь орлого	1,123.3	1,348.9	+225.6
Суурь зарлага	709.6	857.7	+148.1
Санхүүгийн дэмжлэг	161.0	207.4	+46.4

Орон нутгийн нийт хөрөнгө оруулалтын эх үүсвэр. Орон нутгийн хөрөнгө оруулалтын эх үүсвэр 2020 онд 624.7 тэрбум төгрөг болж 2019 оноос 120 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна. Үүнд:

- Улсын төсвөөс аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн хэмжээ 44.5 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 188.4 тэрбум төгрөг;
- Төсвийн тухай хуулийн 56.2.2 дах заалтын дагуу үндсэн тэнцлийн ашгийн 70 хувийг 2020 онд орон нутагт үлдээснээр орон нутгийн хөрөнгө оруулалт 87.6 тэрбумаар өсөж 294.0 тэрбум төгрөг байхаар төсвийн төсөлд тусгалаа.


Хүснэгт №15. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт

	2019 он	2020 он	Өөрчлөлт
Орон нутгийн хөгжлийн сан	143.9	188.4	+44.5
Орон нутгийн суурь болон нийт орлогын зөрүү	115.0	101.3	-13.7
Үндсэн тэнцлийн ашигас орон нутагт үлдсэн зарлага	206.4	294.0	+87.6
Орон нутгийн авто зам засвар	39.0	41.0	+2.0

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН САН

Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хуулийн 17 дугаар зүйлд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 143.8 тэрбум төгрөгөөр баталсан бөгөөд 2020 онд 188.4 тэрбум төгрөг гэж төлөвлөсөн нь өмнөх оны түвшнээс 24 хувь буюу 44.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

График №39. ОНХНС-н өөрчлөлт



Монгол Улсын 2020 оны төсвийн жилд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн нэг эх үүсвэрийн хувь нэмэгдэж, хоёр эх үүсвэр шинээр нэмэгдэж байна.

Зураг №5. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэр



Хувь нэмэгдсэн:

- Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлого - **50 хувь** байснаас **100 хувь** болж нэмэгдсэн;
/уг орлогын 50-аас доошгүй хувийг тухайн тусгай зөвшөөрөл олгогдсон талбай байрших сумын орон нутгийн хөгжлийн санд олгоно/

Шинээр нэмэгдсэн:

- Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлого - **50 хувь**.
/уг орлогын 50-аас доошгүй хувийг тухайн тусгай зөвшөөрөл олгогдсон талбай байрших сумын орон нутгийн хөгжлийн санд олгоно/
- Ашигт малтмалын тухай хуулийн 473 дугаар зүйлд зааснаас бусад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоос улсын чанартай томоохон төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч хуулийн этгээдийн төлсөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг хассан зөрүүний **10 хувь**
/уг орлогын 33-аас доошгүй хувийг тухайн олборлолт хийсэн сумын орон нутгийн хөгжлийн санд олгоно/



8. ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖ

8.1. Гадаад зээл, тусламжийн ашиглалтын мэдээлэл

Монгол Улсын Засгийн газар хөгжлийн түнш улс, олон улсын байгууллагуудаас 1991-2018 онд нийт 5.1 тэрбум ам.долларын гадаад зээл, 2.7 тэрбум ам.долларын тусламжийг авч ашиглажээ. Монгол Улсын 2019 оны төсөвт гадаад төслийн зээлийн ашиглалт 1096.3 тэрбум төгрөг, тусламжийн ашиглалт 146.0 тэрбум төгрөгөөр батлагдсан бол 2020 онд нийт 1,446.6 тэрбум төгрөгийн зээл, тусламж авч ашиглахаар тооцлоо. Үүнээс 608.3 тэрбум төгрөг буюу 42.1 хувийг Азийн хөгжлийн банк, 216.6 тэрбум төгрөг буюу 15.0 хувийг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөнгөлөлттэй зээл, тусламж эзэлж байна.

Хүснэгт №16. Засгийн газрын гадаад зээл, тусламжийн 2020 оны ашиглалт /тэрбум төгрөг/

Хөгжлийн түнш	Зээл ашиглалт	Тусламж ашиглалт	Нийт дүн
АХБ	553.5	54.8	608.3
Хятад	178.4	38.2	216.6
Дэлхийн банк	175.0	14.9	189.9
БНСУ	115.4	-	115.4
Япон	98.5	-	98.5
АНУ	-	15.0	15.0
Австри	32.3	-	32.3
Энэтхэг	52.7	-	52.7
Беларусь	18.5	-	18.5
Герман	10.2	15.2	25.4
ЕСБХБ	26.0	1.3	27.3
Польш	7.6	-	7.6
ХААХОУС	10.6	-	10.6
ЕХОБ	10.0	-	10.0
Кувейт	-	7.6	7.6
Франц	5.7	-	5.7
Швейцар	-	1.7	1.7
Люксембург	-	1.6	1.6
Унгар	1.0	-	1.0
Бельги	1.0	-	1.0
Нийт дүн	1,296.3	150.3	1,446.6

Эх үүсвэр: Сангийн яам

Засгийн газрын гадаад зээл, тусламжийн 2020 оны ашиглалтын 196.6 тэрбум төгрөг буюу 14.0 хувь нь урсгал зардалд, 966.1 тэрбум төгрөг буюу 67.0 хувь нь хөрөнгө оруулалтын зардалд, 283.9 тэрбум төгрөг буюу 19.0 хувь нь орон нутаг, эрчим хүч, ус хангамжийн салбарын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг дэмжих зорилгоор дамжуулан зээлдүүлэхэд зарцуулагдана.

8.2. Төслүүдийг санхүүжүүлэхэд баримтлах зарчим



Монгол Улсын 2020 оны төсвийн төсөлд гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилтийг тооцохдоо ОУВС-тай хамтран хэрэгжүүлж буй “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд тохирсон төсвийн алдагдлын хэмжээг харгалзан, шинээр эхлэх төслүүдийн хувьд зээлийн ерөнхий хэлэлцээр хийгдсэн, 2019 онд тусгайлсан зээлийн хэлэлцээрийг хийж эх үүсвэрийг баталгаажуулах боломжтой, нийгэм, эдийн засгийн үр ашигтай төслүүд байх, үргэлжилж буй төслүүдийн хувьд үр ашигтай, сайн хэрэгжиж буй төслүүдийг дэмжих, тэргүүлэх ач холбогдолтой төслүүдийн санхүүжилтийг түлхүү суулгах, 2020 онд дуусах төлөвлөгөөтэй төслүүдийн санхүүжилтийг бүрэн тусгах зарчим баримталсан.

8.3. Гадаад зээл, тусламжийн төслүүдийг санхүүжүүлэхэд тулгарч буй асуудал



Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн хэрэгжилтийг бүрэн хангах, төсвийг үр ашигтай ашиглах, төслүүдийн санхүүжилтийг уян хатан, шуурхай

шийдвэрлэх зорилгоор 2019 оноос эхлэн гадаад зээл, тусламжийн санхүүжилт болон гэрээ, хэлэлцээрийн дагуу Монгол Улсын Засгийн газрын хариуцах санхүүжилтийн зардлыг нэг төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад буюу Сангийн сайдын багцад тусгаж, Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүний үр дүнд амжилттай хэрэгжиж буй төслийн төсөвт тусгасан зардлын хязгаартаа хүрснээр санхүүжилт гаргах боломжгүй болдог хүндрэл арилж 2019 онд төслийн хэрэгжилт, гүйцэтгэл сайн төслүүдийн ашиглалт нэмэгдэж байна.



Гэвч Засгийн газрын гадаад зээл, тусламжийн төслүүдийн хэрэгжилт удаашрахад төслийн бэлтгэл ажил, газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлт удаашрах, худалдан авалтын үйл ажиллагаанд маргаан гарах, зураг төслийг экспертизээр батлуулах, төрөл бүрийн тусгай зөвшөөрөл авахад цаг алдах, төслийн онцлог, нарийн төвөгтэй байдал, тухайн гадаад түншийн дотоод процедур, хоёр талын төрийн байгууллагын дотоод журмын дагуу гэрээ, хэлэлцээр байгуулж, хүчин төгөлдөр болсон хугацаа болон бодит барилгын улирлын уялдаа, мөн бусад олон хүчин зүйлс нөлөөлсөөр байна.

8.4. Гадаад зээл, тусламжийн бодлогын хүрээнд 2020 онд гадаадын зээл, тусламжийг нийгэм, эдийн засгийн үр ашигтай дараах чиглэлийн төслүүдэд ашиглана:

Гадаадын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийн хөрөнгөөр 115 төсөл, тусламжийн эх үүсвэрийн хөрөнгөөр 40 төслийг:

- байгаль орчныг хамгаалах, агаарын бохирдлыг бууруулах, бохир ус цэвэрлэх байгууламжуудыг шинэчлэх, аялал жуулчлалыг дэмжих,

- сургууль, цэцэрлэг, эмнэлгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах,
- нефть бүтээгдэхүүн, эрчим хүчний хангамжийн найдвартай байдлыг нэмэгдүүлэх, дэд бүтцийн бүтээн байгуулалт хийх,
- нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, худалдаа, бизнесийн орчныг сайжруулах болон
- бусад чиглэлээр санхүүжүүлнэ.



Байгаль орчныг хамгаалах, агаарын бохирдлыг бууруулах, бохир ус цэвэрлэх байгууламжуудыг шинэчлэх, аялал жуулчлалыг дэмжих чиглэлээр гадаад зээлийн хөрөнгөөр 292.3 тэрбум төгрөг, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 49.4 тэрбум төгрөг тусгасан нь нийт гадаад зээл, тусламжийн 26%-ийг эзэлж байгаа бөгөөд 2020 онд гадаад зээлийн 4, буцалтгүй тусламжийн 1 төсөл хэрэгжиж дуусна. Шинээр гадаад зээлийн 15, буцалтгүй тусламжийн 11 төсөл хэрэгжиж эхэлнэ.



Улаанбаатар хотын цэвэр усны хангамжийн асуудлыг цогц байдлаар шийдвэрлэх төслийг АНУ-ын Мянгань сорилтын сантай байгуулсан 350 сая ам.долларын буцалтгүй тусламжийн хоёр дахь компакт гэрээний хүрээнд хэрэгжүүлж эхлээд байна. Төслийг 5 жилийн хугацаанд хэрэгжүүлэх бөгөөд Улаанбаатар хотын цэвэр усны хангамжийг газрын доорх усны эх үүсвэрээс байгаль орчинд нөлөөлөхгүйгээр урт хугацаанд, тогтвортой байдлаар нэмэгдүүлэх, унд-ахуйн зорилгоор ашиглахын тулд дэвшилтэт технологитой ус цэвэршүүлэх үйлдвэр барих, шинээр байгуулсан эх үүсвэрүүдийг төвлөрсөн шугам сүлжээнд холбох шугам хоолой тавих, Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн хаягдал усыг гүн цэвэршүүлж дулааны цахилгаан

станцуудын техникийн усны зориулалтаар эргүүлэн ашиглаж цэвэр усыг хэмнэх зэрэг бүтээн байгуулалт хийнэ.



Байгаль орчныг хамгаалах, бохир ус цэвэрлэх байгууламжийг шинэчлэх хүрээнд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газрын 262.7 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр 2019-2023 оны хугацаанд Улаанбаатар хотод хоногт 250,000 м³ бохир усыг цэвэрлэх хүчин чадал бүхий төв цэвэрлэх байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэхээс гадна Баян-Өлгий аймгийн Өлгий, Говьсүмбэр аймгийн Чойр, Дорнод аймгийн Чойбалсан, Увс аймгийн Улаангом, Завхан аймгийн Улиастай сумдад цэвэрлэх байгууламж шинээр барих, өргөтгөл хийх ажлыг Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлнэ. Мөн АХБ-ны 39.2 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлээр 2016-2022 оны хооронд хэрэгжиж буй Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжил төслийн хүрээнд 9 аймагт хоногт 3000м³ бохир ус цэвэрлэх байгууламжийг барих бөгөөд Архангай, Өмнөговь, Өвөрхангай Дорноговь аймгуудын цэвэрлэх байгууламжийн барилгын ажлыг дуусгаж, Булган, Дундговь, Сүхбаатар, Хөвсгөл, Хэнтий аймгийн цэвэрлэх байгууламж барих ажлыг үргэлжлүүлнэ.



Сүүлийн жилүүдэд Улаанбаатар хотын хүн амын өсөлт, барилгажилтын үр дүнд их хэмжээгээр үүсэж буй барилга болон барилга нураалтын хатуу хог хаягдлыг зөв зохистойгоор булж устгах, дахин боловсруулах үйлдвэрийг Улаанбаатар, Эрдэнэт хотуудад Европын сэргээн босголт, хөгжлийн банкны зээл болон буцалтгүй тусламж, Бүгд Найрамдах Польш Улсын

Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр барина.



Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор гэр хорооллын дахин төлөвлөлтийг дэмжиж, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн “1008 айлын түр суурьшуулах орон сууц” төслөөр түрээсийн болон түр суурьшуулах орон сууцны хорооллыг барилгын ажлыг, мөн “Эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагааны сангаас 2017-2019 онд авах зээлийн тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын ерөнхий хэлэлцээр”-ийн хүрээнд нийт 7026 айлын “Солонго 1,2”, “Баянголын ам” орон сууцны хорооллуудын барилгын ажлыг эхлүүлнэ. Түүнчлэн, АХБ-ны зээлийн эх үүсвэрээр Улаанбаатар хотын Сэлбэ, Баянхошуу, Дамбадаржаа, Дэнжийн 1000 дэд төвүүдийн төлбөрийн чадварт нийцсэн, байгаль орчинд ээлтэй, агаар болон хөрсний бохирдлыг бууруулах, иргэдийн амьдрах орчныг сайжруулах зорилгоор 10,000 айлын ногоон орон сууцыг барих төслийг шинээр хэрэгжүүлж эхэлнэ.



Сургууль, цэцэрлэг, эмнэлгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах чиглэлээр 2020 оны төсөвт гадаад зээлийн хөрөнгөөр 180.6 тэрбум төгрөг, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 25.1 тэрбум төгрөг тусгасан нь нийт гадаад зээл, тусламжийн 14%-ийг эзэлж байгаа бөгөөд 2020 онд гадаад зээлийн 6 төсөл, буцалтгүй тусламжийн 5 төсөл хэрэгжиж дуусна. Шинээр гадаад зээлийн хөрөнгөөр 5, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 3 төсөл хэрэгжиж эхэлнэ.



Азийн хөгжлийн банкны 50.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр 2018-2022 онд Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар ба хүртээмжийг дэмжих төслийг хэрэгжүүлж

байна. Энэхүү төслөөр Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэг, Дархан-Уул аймгийн Дархан суманд нийт 2 шинэ сургууль, Улаанбаатар хотын Баянзүрх, Сонгинохайрхан, Налайх дүүрэг, Дорноговь аймгийн Сайншанд сумдад нийт 5 шинэ цэцэрлэг барих, Улаанбаатар хотын Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан, Сүхбаатар, Налайх дүүрэг, Говь-Алтай аймгийн Алтай суманд 8 сургуулийн өргөтгөл, Улаанбаатар хотын Баянгол, Баянзүрх, Чингэлтэй, Хан-Уул, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүрэг болон Говьсүмбэр аймагт нийт 17 цэцэрлэгийн өргөтгөлийн ажлыг эхлүүлнэ. Эдгээр ажлын үр дүнд боловсролын салбарын сургуулийн нийт хүчин чадал 4360 суудлаар, цэцэрлэгийн нийт хүчин чадал 3795 хүүхдийн ороор нэмэгдэнэ.



Япон Улсын 2.4 тэрбум иенийн буцалтгүй тусламжийн санхүүжилтээр 2018-2021 онд ерөнхий боловсролын сургууль барих төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд Улаанбаатар хотын Хан-Уул, Чингэлтэй дүүргүүдэд шинэ сургууль барих, Баянзүрх дүүргийн 53 дугаар сургууль болон Налайх дүүргийн 109 дүгээр сургуулийн өргөтгөлийн барилгын ажлыг үргэлжлүүлснээр дээрх 4 сургуулийн хүчин чадал нийтдээ 2440 суудлаар нэмэгдэнэ.



Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 250.2 сая юанийн ерөнхий боловсролын сургууль барих буцалтгүй тусламжийн санхүүжилтээр 2018-2020 онд Улаанбаатар хотын Баянзүрх, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргүүдэд нийт 5,680 хүүхдийн багтаамжтай 7 сургууль, Архангай аймгийн Цэцэрлэг суманд 100 хүүхдийн багтаамжтай цэцэрлэгийн барилгын ажил бүрэн дуусгаж хүлээлгэн өгнө.



Эрүүл мэндийн чанар, үйлчилгээг сайжруулах зорилгоор Азийн хөгжлийн банкны 25.0 сая

ам.долларын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр 2013-2020 онд хэрэгжиж буй “Эрүүл мэндийн салбарын хөгжил 4-нэмэлт санхүүжилт” төслийн хүрээнд Сонгинохайрхан дүүрэгт эрүүл мэндийн олон мэргэжлийн тусламжийг нэг цэгээс 157,000 оршин суугчдад үзүүлэх, 200 ортой амбулаторид хэвтүүлэн эмчлүүлэх хэсэгтэй жишиг нэгдсэн эмнэлэг барилгын ажлыг дуусгаж, бүрэн ашиглалтанд оруулна. Түүнчлэн, Азийн хөгжлийн банкны 18.2 сая ам.долларын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлгийг оношилгоо, эмчилгээний тоног, төхөөрөмжөөр хангаж, мэс засал, эхийн эрүүл мэндийн үйлчилгээг нэмж, сувилгааны загвар тусламж, үйлчилгээ, эмнэлгийн хог хаягдлын боловсруулалт, халдвараас урьдчилан сэргийлэх, хянах арга хэмжээг боловсронгуй болгоно.



Арабын эдийн засгийн хөгжлийн Кувейтийн сангийн 8.0 сая ам.долларын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр 2017-2020 онд Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэгт түлэгдэлт, хөлдөлт, нөхөн сэргээх мэс заслын төрөлжсөн нарийн мэргэжлийн үйлчилгээг үзүүлэх, олон улсын чанар стандартад бүрэн нийцсэн, орчин үеийн оношилгоо эмчилгээний багаж тоног төхөөрөмжөөр иж бүрэн тоноглогдсон, 250 ортой Түлэнхийн төвийн цогцолборыг барьж дуусгана.



Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, олон улсын стандартад нийцүүлэх зорилгоор АХБ-тай 3 үе шаттай эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх бөгөөд 1 дүгээр үе шатын хүрээнд 76.1 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл, 3.5 сая ам.долларын буцалтгүй тусламжийн эх

үүсвэрээр Хан-Уул дүүргийн эмнэлгийг жишиг эмнэлэг болгох, Ховд, Увс аймгийн нэгдсэн эмнэлгийг өргөтгөх, Улаанбаатар хотын гэр хорооллын 4 өрхийн эрүүл мэндийн төв, 5 сумын эрүүл мэндийн төвийг загвар төв болгож, орчин үеийн тоног төхөөрөмжөөр иж бүрнээр тоноглон, эмнэлгийн бие даасан байдлыг бэхжүүлэх төслийг 2020 оноос эхлүүлнэ.



Нефть бүтээгдэхүүн, эрчим хүчний хангамжийн найдвартай байдлыг нэмэгдүүлэх, дэд бүтцийн бүтээн байгуулалт хийх чиглэлээр 2020 оны төсөвт гадаад зээлийн хөрөнгөөр 461.0 тэрбум төгрөг, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 42.1 тэрбум төгрөг тусгасан нь нийт гадаад зээл, тусламжийн 35%-ийг эзэлж байгаа бөгөөд 2020 онд гадаад зээлийн 12 төсөл, буцалтгүй тусламжийн 2 төсөл хэрэгжиж дуусна. Шинээр гадаад зээлийн 10, буцалтгүй тусламжийн 2 төсөл хэрэгжиж эхэлнэ. Тухайлбал, импортоос 100% хараат газрын тосны бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээг хангах, нефть-химийн үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэх зорилгоор Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт Бүгд Найрамдах Энэтхэг Улсын 1 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжих жилд 1.5 сая тн дотоодын түүхий газрын тос боловсруулах хүчин чадал бүхий үйлдвэрийн барилгын ажлыг эхлүүлнэ.



Эрчим хүчний хангамжийн найдвартай байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр Баянхонгор, Завхан, Өвөрхангай, Архангай, Дундговь, Хэнтий, Төв, Говь-Алтай, Говьсүмбэр, Сүхбаатар аймгуудад нийт 255Гкал/ц -аар хүчин чадлыг нэмэгдүүлэх дулааны станцын барилгын ажил, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй

Эрдэнэтийн дулааны цахилгаан станцыг хүчин чадлыг 35Мвт-аар өргөтгөх барилгын ажлыг эрчимжүүлнэ.



Мөн Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 113.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр Улаанбаатар-Мандалговь хооронд 249 км цахилгаан дамжуулах шугам, 500 Мв хүчин чадалтай дэд станцуудыг барих төсөл, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын 20.0 сая еврогийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр Дарханы дулааны цахилгаан станцын турбины шинэчлэл төслүүдийн бүрэн санхүүжүүлж, ашиглалтанд оруулна.



Япон Улсын 65.6 тэрбум иений хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр Улаанбаатар хотод 6 терминалтай, жилд 1.7 сая зорчигч хүлээн авах, 18 100 онгоц хөөрөх болон буулгах хүчин чадалтай Улаанбаатар хотын шинэ олон улсын нисэх онгоцны буудлыг бүрэн ашиглалтанд оруулж, Кувейтын сангийн 3.5 сая ам.долларын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Хэнтий аймгийн Өндөрхаан хааны нисэх онгоцны буудлыг шинэчлэх, нисэхийн зурвас барих төслийн барилгын ажлыг эхлүүлнэ.



Монгол Улсын дэд бүтцийг сайжруулах, орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, хот хоорондын зорчигч, тээвэр, бараа эргэлтийг нэмэгдүүлэх зорилгоор Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөнгөлөлттэй зээлээр Улиастай-Тосонцэнгэлийн 67 км автозам, Гачууртын уулзвараас Налайх чиглэлийн 20.9 км авто зам, Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.1 км авто замыг засварлан шинэчлэх, Ховд – Баян-Өлгий чиглэлийн 189 км авто замыг бүрэн ашиглалтанд оруулж, төслийн үлдэгдэл зардлыг санхүүжүүлнэ.



Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, худалдаа, бизнесийн

орчинг сайжруулах чиглэлээр 2020 оны төсөвт гадаад зээлийн хөрөнгөөр 207.9 тэрбум төгрөг, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 20.7 тэрбум төгрөг тусгасан нь нийт гадаад зээл, тусламжийн 17%-ийг эзэлж байгаа бөгөөд 2020 онд гадаад зээлийн 4 төсөл, буцалтгүй тусламжийн 1 төсөл дуусаж, шинээр гадаад зээлийн 7 төсөл, буцалтгүй тусламжийн 1 төсөл хэрэгжиж эхэлнэ.



Тус чиглэлээр Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 357.2 сая юанийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 2019 оноос Замын-Үүд, Гашуун сухайт боомтуудыг өргөтгөн шинэчилнэ. Төслийн хүрээнд Замын-Үүд боомтод зорчигч тээврийн 30, ач тээврийн 28 барилга, дэд бүтэц, ногоон байгууламж барих бөгөөд шинэчлэлийн хүрээнд нийт талбай 8 дахин, өдөрт нэвтрэх зорчигчийн тоо 4 дахин, том оврын ачаа тээврийн хэрэгслийн тоо 3 дахин, суудлын тээврийн хэрэгслийн тоо 7 дахин нэмэгдэнэ.

Гашуунсухайт боомтын зам талбайг өргөтгөж шинэчилснээр эрдэс баялгийн экспортын 2 эгнээ, нүүрсний экспортын 10 эгнээ, импортын 6 эгнээтэй болж, олон улсын жишигт нийцсэн ухаалаг гарц, авто пүү, хүнд даацын авто зам, рентген, ариутгал, лабораторийн иж бүрэн цогцолбор ашиглалтад орно.

Боомтын бүтээн байгуулалт нь Монгол Улсын гадаад худалдаа, эдийн засаг болон бүс нутгийн хөгжилд эерэг нөлөө үзүүлэхийн зэрэгцээ хууль бус, чанарын шаардлага хангахгүй бараа, бүтээгдэхүүн хилээр нэвтрэхээс урьдчилан сэргийлж, иргэдийн эрх ашгийг хамгаалахад чухал ач холбогдолтой юм.



Азийн хөгжлийн банкны 40.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр хүнсний ногооны тариалалт, усалгаатай газар тариаланг дэмжих төслийг 2020-2025 онд хэрэгжүүлнэ.

Төслийн хүрээнд усалгын системийг шинээр барих, төрийн болон орон нутгийн өмчийн усалгын системийг сэргээн засварлах, үйлдвэрлэлд шинэ нэр төрлийн тарималын технологи нэвтрүүлэх, өвлийн хүлэмж байгуулах, хөгжүүлэх, хүнсний ногооны агуулах, борлуулалтын сүлжээ, сав баглаа боодлын үйлдвэр барих, тариалангийн талбайд ойн зурвас байгуулах үйл ажиллагаа хийгдэнэ.



Дэлхийн банкны 20.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр 2016-2021 онд уул уурхайн бус салбарын жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн экспортын чадавхыг бэхжүүлэх болон экспортын зах зээлд нэвтрэх боломжийг өргөжүүлэх зорилготой “Экспортыг дэмжих төсөл”, Азийн хөгжлийн банкны 60 сая, ам долларын хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр урт хугацаат хадгаламжийн зах зээлийг бүрдүүлэх замаар жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд урт хугацаатай, батлан даалттай санхүүжилт авах боломжийг бүрдүүлэх зорилготой “Зээлийн батлан даалтын системийг дэмжих төсөл” тус тус хэрэгжиж байна. Төслүүдийг хэрэгжүүлснээр жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд урт хугацаатай зээл авах боломж бүрдэн, үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний өрсөлдөх чадвар сайжирч, ажлын байр бий болж, гадаад болон дотоодын зах зээлд нийлүүлж буй бараа бүтээгдэхүүн нэмэгдэж экспортын зах зээл тэлэх боломж бүрдэнэ.



Бусад чиглэлээр 2020 оны төсөвт гадаад зээлийн хөрөнгөөр 154.5 тэрбум төгрөг, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 13.0 тэрбум төгрөг тусгасан нь нийт гадаад зээл, тусламжийн 8%-ийг эзэлж байгаа бөгөөд 2020 онд гадаад зээлийн 5, буцалтгүй тусламжийн 1 төсөл хэрэгжиж дуусна. Шинээр гадаад зээлийн 4,

буцалтгүй тусламжийн 2 төсөл хэрэгжиж эхэлнэ.



Хөдөлмөр, хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын чиглэлээр Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 135.0 сая юанийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр олон улсын шаардлагад нийцсэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон спортын тамирчдад зориулсан 2500 хүний суудалтай тусгай тоноглол бүхий спортын төвийг Буянт-Ухаа спорт цогцолборын хажууд барина. Мөн, Азийн хөгжлийн банкны 25.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр 2018-2022 онд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүрэх үйлчилгээг сайжруулж, оролцоог нэмэгдүүлэх төсөл” хэрэгжүүлж байгаа бөгөөд тус төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдүүдэд хүрэх үйлчилгээг сайжруулах, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Улаанбаатар хот, Дархан-Уул, Дундговь,

Дорнод, Архангай, Хөвсгөл, Ховд аймгуудад 7 жишиг хөгжлийн төвийг байгуулна. Төслийн хүрээнд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тулгарч буй нийгмийн саад бэрхшээлийг бууруулна.



Гамшгаас хамгаалах, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Онцгой байдлын ерөнхий газарт 2020 онд Бүгд Найрамдах Беларус Улсын 15.4 сая еврогийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр гал түймэр унтраах, аврах, эрэн хайх зориулалттай 15 нэр төрлийн 72 нэгж автомашин худалдан авч, Бүгд Найрамдах Франц Улсын 58.0 сая еврогийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр онцгой байдлын байгууллагад агаараас аврах ажиллагаа явуулах нэгж байгуулах, 3 нисдэг тэрэг, холбогдох тоног төхөөрөмж, гал унтраах тусгай зориулалтын 42 автомашин худалдан авах төслийг эхлүүлнэ.

9. ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР



9.1. Засгийн газрын өрийн удирдлага

Засгийн газрын өр⁷-ийн үлдэгдэл 2018 оны жилийн эцсийн байдлаар 22.4 их наяд төгрөг, өнөөгийн үнэ цэнээр ДНБ-ний **58.9** хувьд хүрсэн бол 2019 оны II улирлын байдлаар **54.4** хувьд хүрээд байна. Засгийн газрын өрийн эдийн засагт үзүүлэх дарамт ийнхүү буурахад Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааг зогсоож, Засгийн газрын

өрийн баталгаа болон “Барих-шилжүүлэх” төрлийн концессын гэрээгээр шинээр өр үүсгээгүй, шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг урт хугацаатай, хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр бүрдүүлсэн зэрэг арга хэмжээг хэрэгжүүлсэн нь голлон нөлөөлсөн.

Засгийн газрын өр 2020 онд өнөөгийн үнэ цэнээр ДНБ-ий 49.9 хувьд хүрнэ.

Хүснэгт №17. Засгийн газрын өрийн бүтэц /тэрбум төгрөг/

ӨРИЙН БҮТЭЦ, ӨРИЙН ХЭРЭГСЭЛ		2017.12.31	2019.06.30
I. Засгийн газрын дотоод өр		3,461.9	1,485.8
1.1	Үнэт цаас	3,461.9	1,485.8
II. Засгийн газрын гадаад өр		16,857.8	19,289.2
2.1	Үнэт цаас	7,701.6	7,707.5
2.2	Зээл	9,156.2	11,581.7
III. Засгийн газрын бусад өр		2,431.9	1,910.3
3.1	Засгийн газрын өрийн баталгаа	1,663.7	1,104.3
3.2	"Барих-шилжүүлэх" төрлийн концесс	768.2	806.0
ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР (I+II+III)		22,751.6	22,685.3
ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ)		20,212.1	19,561.4
Хуулиар тогтоосон өрийн хязгаар		85.0%	75.0%
Засгийн газрын өр (ӨҮЦ) / ДНБ		72.5%	54.4%

Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжаа шударга, өрсөлдөөнт зах зээлийн зарчимд нийцээгүй, банкны систем дэх мөнгөн хөрөнгийн байдал болон Монголбанкны шийдвэрийн нөлөөлөл өндөр байсан тул арилжааг зогсоож, 370.5 тэрбум төгрөгийн үнэт цаасыг хугацаанаас өмнө буцаан худалдан авсан. Засгийн газрын үнэт цаасны арилжааг 2017 оны 10 дугаар сараас зогсоосон бөгөөд үнэт цаасны үлдэгдэл 4.6 их наяд төгрөгөөс 2019 оны жилийн эцэст 1.5 их наяд төгрөгт хүрч буурсан.

Засгийн газар шинээр өрийн баталгаа гаргахгүй байх, “Барих-шилжүүлэх” төрлийн концессын гэрээг шинээр байгуулахгүй байх бодлогыг баримталснаар Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдэл 2016 оны жилийн эцсийн байдлаар 3.5 их наяд төгрөгт хүрээд байсныг 2019 оны эхний хагас жилийн байдлаар 1.1 их наяд төгрөг болгон бууруулсан.

Түүнчлэн Монгол Улсын нэгдсэн төсвийн алдагдлыг нөхөх шаардлагатай эх үүсвэрийг урт хугацаатай, хөнгөлөлттэй гадаад зээлээр бүрдүүлж нийгэм, эдийн


⁷ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4.1.8-д “Засгийн газрын өр” гэж I) өрийн хэрэгслээр үүсгэж, Монгол Улсын Засгийн газар, аймаг нийслэлээс бусдын өмнө хүлээсэн төлбөрийн

үүргийг, II) хууль болон гэрээнд заасны дагуу гаргасан Засгийн газрын өрийн баталгааны дүнг гэж заасан

засгийн өндөр ач холбогдол бүхий “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төсөл”, “Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх төсөл”, “10 аймгийн төвд дулааны станц барих төсөл”, “Бүс нутгийн автозамыг хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл”, “Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах, хийн хоолой байгуулах төслийн нарийвчилсан ТЭЗҮ боловсруулах төсөл”, “Эрчим хүчний II төсөл” зэрэг дэд бүтэц, бүтээн байгуулалтын томоохон төслүүдийг хэрэгжүүлж байна.

Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегид тусгасан зорилтууд, бодлогын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлснээр Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн үлдэгдэлийг тухайн жилийн нэрлэсэн ДНБ-д харьцуулсан харьцаа 2019 онд **56.3** хувь, 2020 онд **49.9** хувь, 2021 онд **44.1** хувь, 2022 онд **39.1** хувьд тус тус хүрэхээр байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Засгийн газрын өрийн тухай төсвийн тусгай шаардлагыг хангахын зэрэгцээ, уг харьцааг 40 хувьд хүргэх бодлогын зорилтот түвшинд хүрэхээр байна.

График №40. Засгийн газрын өрийн тусгай шаардлагын төсөөлөл



Арилжааны нөхцөлтэй зээлээс татгалзаж, хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлийн эх үүсвэрээр нийгэм, эдийн засагт зайлшгүй шаардлага бүхий төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх бодлогын үр дүнд Засгийн газрын өрийн багц дахь арилжааны зээлийн

эзлэх хувь 60 хувиас 45 хувь хүртэл буурсан бөгөөд дунд хугацаанд буюу 2022 онд 35 хувьд хүрч буурахаар байна.

График №41. Засгийн газрын өрийн багцын хөдөлгөөн



Эдгээр арга хэмжээний үр дүнд 2017 онд 1,155.9 тэрбум төгрөгт хүрч, тухайн оны төсвийн орлогын 16.4 хувь, төсвийн зарлагын 13.3 хувийг эзэлж байсан зээлийн хүүгийн зардлын төсөвт үзүүлэх дарамт буурч, 2020 онд хүү, шимтгэлийн зардалд **959.8** тэрбум төгрөг төлөгдөх тооцоололтой байна. Хүүгийн зардал 2020 оны төсвийн орлогын 10.0 хувь, төсвийн зарлагын 7.4 хувийг эзлэхээр байна.


График №42. Хүүгийн зардлын нэгдсэн төсөвт үзүүлэх нөлөөлөл



Хүү, шимтгэлийн зардалд 2020 онд төлөхөөр тооцоолсон зардлын 59 хувийг гадаад үнэт цаасны хүү, 25 хувийг гадаад

зээлийн хүү, үлдэх 16 хувийг дотоод үнэт цаасны хүүгийн зардал тус тус эзэлж байна.

График №43. Хүүгийн зардлын 2020 оны задаргаа



Засгийн газрын гадаад үнэт цаасны үндсэн төлбөрт 2021-2024 онд 2.9 тэрбум ам.доллар төлөгдөх хуваарьтай байгаа бөгөөд өрийн үйлчилгээний төлбөр 2020 онд төсвийн орлогын 19.0 хувь, 2021 онд 29.2 хувь, 2022 онд 38.4 хувьд хүрч, 2019 онтой харьцуулахад 2019 онтой харьцуулахад төсөвт үзүүлэх дарамт 2 дахин нэмэгдэхээр байна.

Хүснэгт №18. Засгийн газрын гадаад үнэт цаасны үлдэгдэл /сая ам.доллар/

№	Гадаад үнэт цаас	Дүн	Купон	Төлөгдөх огноо
1	Мазаалай	500\$	10.875%	2021.04.06
2	Чингис	1,000\$	5.125%	2022.12.05
3	Гэрэгэ	800\$	5.625%	2023.04.26
4	Хуралдай	600\$	8.750%	2024.03.09

Нэгдсэн төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь буурч, төсвийн сахилга бат сайжирч байгаа хэдий ч их хэмжээний гадаад өрийг дотоод эх үүсвэрээр санхүүжүүлэх боломж хязгаарлагдмал байна. Иймд эдгээр өр төлбөрийг эдийн засаг, төсөвт дарамт багатайгаар төлөх өрийн зохицуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичигт тусгасан.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2019-2022 ОНЫ СТРАТЕГИ



Макро эдийн засгийн тогтворгой байдлыг хадгалж, Засгийн газрын санхүүгийн хэрэгцээг боломжит эрсдэлийн түвшинд хамгийн бага зардлаар санхүүжүүлэхэд чиглэнэ.

ЗОРИЛТ 1.

Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас, зээлийн төлбөрүүдийг эдийн засаг, төсөвт дарамт учруулахгүйгээр төлж дахин санхүүжилтийн эрсдэлийг бууруулна.

ЗОРИЛТ 2.

Гадаад зээллэгээр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдэд зардал, үр өгөөжийн тооцооллыг хийж, зөвхөн үр ашигтай төслүүдийг санхүүжүүлэх зарчмыг баримталж, тэдгээрийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулна.

ЗОРИЛТ 3.

Орчин үеийн технологийн дэвшлийг ашигласан Засгийн газрын үнэт цаасны арилжааны дэд бүтцийг бүрдүүлнэ. Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын арилжаанд оролцох боломжийг нэмэгдүүлж, зах зээлийн нээлттэй, өрсөлдөөнт, хүртээмжтэй байдлыг хангаж, Засгийн газрын үнэт цаасны хөрвөх чадварыг сайжруулна.

ЗОРИЛТ 4.

Болзошгүй өр төлбөрийн төсөвт үзүүлэх нөлөөллийг үнэлэх, болзошгүй эрсдэлээс сэргийлэх тогтолцоог хөгжүүлнэ.

ЗОРИЛТ 5.

Засгийн газрын өрийн удирдлагын тогтолцоог сайжруулж, орчин үеийн чиг хандлагад нийцүүлэх.

Монгол Улсын Их Хурлын 2019 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 55 дугаар тогтоолоор батлагдсан.

График №44. Өрийн үйлчилгээний төсөвт үзүүлэх нөлөөлөл/хувиар, их наяд төгрөгөөр/



Өрийн зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлснээр өрийн нийт төлбөрийн эдийн засаг, төсөвт үзүүлэх дарамтыг нэмэхгүйгээр тулгамдсан өр төлбөрийг шийдвэрлэх юм.

9.2. Болзошгүй Өр Төлбөр

Монгол Улсын Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдэл 2018 оны жилийн эцсийн байдлаар **2,123.8** тэрбум төгрөгт хүрч 2017 онтой харьцуулахад 20.0 хувиар буурсан. Үүнээс Худалдаа хөгжлийн банк /ХХБ/-ны олон улсын зах зээлд арилжаалсан 500.0 сая ам.долларын үнэт цаасны баталгаа **993.1** тэрбум бол үлдэх **1,130.7** тэрбум төгрөг нь Монгол Улсын Хөгжлийн банк /МУХБ/, МИАТ ТӨХК болон Эрдэнэс Монгол ТӨХК-уудын зээллэгт гаргасан Засгийн газрын баталгаа байна. Монгол Улсын Засгийн газар төсвийн сахилга батыг сайжруулах, төсвийн болзошгүй өр төлбөрийн төсөвт үзүүлэх нөлөөллийг бууруулах үүднээс 2016 оноос хойш нэмж Засгийн газрын баталгаа гаргаагүй.

Хүснэгт №19. Засгийн газрын өрийн баталгаа

№	Баталгаа гаргуулагч	Зээлдүүлэгч	Дүн /сая нэгж/	Валют	Баталгаа гаргасан огноо	Хүүгийн хувь	Төлөгдөж дуусах огноо	2020 оны төлбөр /тэрбум төгрөг/
1	МИАТ ТӨХК	АНУ ЭСХК	77.5	Ам.доллар	2013.12.24	2.52%	2023.12.24	23.4
	МИАТ ТӨХК	Ай Эн Жи капитал	24.0	Ам.доллар	2013.12.24	5.3+Libor	2020.12.24	7.1
2	МУХБ	Японы зах зээл	30,000.0	Иен	2014.01.06	1.52%	2023.12.25	11.3
3	МУХБ	БНХАУ-ын Хөгжлийн Банк	162.0	Ам.доллар	2014.09.03	6.00%	2022.09.02	79.8
4	“Эрдэнэс Монгол” ХХК	Азийн хөгжлийн банк	35.0	Ам.доллар	2016.04.01	0.6+Libor	2031.04.01	0.9
Засгийн газрын үнэт цаас барьцаалсан баталгаа								
5	ХХБ	ОУ-ын зах зээл	500.0	Ам.доллар	2015.04.28	9.375%	2020.05.19	1,034.4



МИАТ ТӨХК-д гаргасан Засгийн газрын баталгаа.

1. Бойнг агаарын хөлөг худалдан авсан зээл: МИАТ ТӨХК нь 2013 оны 12 сарын 24-ний өдөр 121.4 сая ам.долларын 5, 7, 10 жилийн хугацаатай 3 дэд хэсгээс бүрдэх зээллэг хийсэн бөгөөд Засгийн газрын 2013

оны 319 дүгээр тогтоолоор Засгийн газар баталгаа гаргасан. МИАТ ТӨХК нь зээлийн эх үүсвэрээр Боинг 767-300ER агаарын хөлгийг худалдаж авсан бөгөөд зээлийн үлдэгдэл 2019 оны эхний хагас жилийн байдлаар 92.6 тэрбум төгрөг байна. Үүнээс АНУ-ын Экспорт Санхүүжилтийн хувийн корпораци (ЭСХК) 77.4 сая ам.долларын

зээлийн үлдэгдэл 30.6 сая ам.доллар буюу 81.3 тэрбум төгрөг, Ай Эн Жи Капиталаас авсан 23.9 сая ам.долларын зээлийн үлдэгдэл 4.3 сая ам.доллар буюу 11.4 тэрбум төгрөг байна. Харин Ай Эн Жи банкнаас зээлсэн 5 жилийн хугацаатай 20.0 сая ам.долларын зээл бүрэн төлөгдөж дууссан. Үлдэгдэл хоёр дэд зээлийн төлбөрийг 2020 болон 2023 онд төлж дуусах бөгөөд 2020 онд 10.7 сая ам.доллар буюу 28.6 тэрбум төгрөгийн үндсэн төлбөр, 0.7 сая ам.доллар буюу 1.9 тэрбум төгрөг хүүгийн төлбөр төлөгдөх хуваарьтай байна.



МУХБ-д гаргасан Засгийн газрын баталгаа.

2. “Самурай” үнэт цаас - МУХБ 2014 оны 01 сарын 06-ны өдөр Японы зах зээл дээр 30.0 тэрбум иенийн “Самурай” үнэт цаасыг 10 жилийн хугацаатай, жилийн 1.52 хувийн хүүтэй арилжаалсан бөгөөд Засгийн газрын 2013 оны 417 дугаар тогтоолоор Засгийн газар баталгаа гаргасан. МУХБ нь “Самурай” үнэт цаасны эх үүсвэрийг “ТОСК” ТӨҮГ, Эрэл ХХК, “Хөтөл” ХХК зэрэг байгууллагуудын 5 төрлийн төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэхэд ашигласан байдаг. МУХБ гэрээний дагуу “Самурай” үнэт цаасыг 2023 онд хөрөнгө оруулагч нарт төлөх бөгөөд 2020 онд 456.0 сая японы иен буюу 11.3 тэрбум төгрөгийн хүүгийн төлбөр төлөгдөх хуваарьтай байна.

3. БНХАУ-ын Хөгжлийн банкны зээл – МУХБ 2014 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр БНХАУ-ын Хөгжлийн банкнаас 162.0 сая ам.долларын 8 жилийн хугацаатай, 6.0 хувийн хүүтэй, зээл авсан бөгөөд Засгийн газрын 2014 оны 116 дугаар тогтоолын дагуу Засгийн газар баталгаа гаргасан. МУХБ уг зээлийн эх үүсвэрийг Амгалан дулааны станц, Баянхонгор-Алтай чиглэлийн 128 км авто зам, Улаангом-Наранбулаг чиглэлийн

90 км авто зам зэрэг нийт 11 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулсан. Зээлийн үлдэгдэл 2019 оны эхний хагас жилийн байдлаар 94.5 сая ам.доллар буюу 251.2 тэрбум төгрөг байна. МУХБ зээлийн төлбөрийг 2022 онд төлж дуусах бөгөөд 2020 онд 27.0 сая ам.доллар буюу 72.1 тэрбум төгрөгийн үндсэн төлбөр, 4.5 сая ам.доллар буюу 12.1 тэрбум төгрөгийн хүүгийн төлбөр төлөгдөх хуваарьтай байна.



“Эрдэнэс монгол” ХХК-д гаргасан Засгийн газрын баталгаа.

4. Азийн хөгжлийн банкнаас авч буй хөнгөлөлттэй техник туслалцааны зээл – “Эрдэнэс Монгол” ХХК 2016 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр 35.0 сая ам.долларын Libor+0.6 хувийн хүүтэй, 15 жилийн хугацаатай зээлийг Азийн хөгжлийн банкнаас авсан бөгөөд Засгийн газрын 2016 оны 138 дугаар тогтоолоор Засгийн газрын баталгаа гаргасан. “Эрдэнэс Монгол” ХХК уг зээлийн эх үүсвэрийг компанийн үйл ажиллагааны эрсдэлийн болон санхүүгийн нэгдсэн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх төсөлд ашиглаж байна. Зээлийн үлдэгдэл 2019 оны эхний хагас жилийн байдлаар 8.0 сая ам.доллар бөгөөд 2031 онд зээл төлөгдөж дуусна. “Эрдэнэс Монгол” ХХК 2020 онд 0.1 сая ам.доллар буюу 0.3 тэрбум төгрөгийн үндсэн төлбөр, 0.2 сая ам.доллар буюу 0.6 тэрбум төгрөгийн хүүгийн төлбөр төлөх хуваарьтай.



Худалдаа хөгжлийн банканд гаргасан Засгийн газрын баталгаа.

5. Олон улсын зах зээлд арилжаалсан үнэт цаас – ХХБ 2015 оны 5 дугаар сарын 19-ний өдөр 500.0 сая ам.долларын 9.375 хувийн хүүтэй, 5 жилийн хугацаатай үнэт цаасыг олон улсын зах зээлд арилжаалсан бөгөөд Засгийн газрын 2015 оны 163 дугаар

тогтоолын дагуу ХХБ-ны эзэмшиж байсан нийт 1,001.6 тэрбум төгрөгийн Засгийн газрын үнэт цаасыг барьцаалан Засгийн газар баталгаа гаргасан.⁸ ХХБ үнэт цаасны эх үүсвэрийг Монголбанканд худалдан, үнэт цаасны төлбөрийг төлөхөд буцаан худалдан авах своп хэлцлийг Монголбанкттай хийсэн. Барьцаалсан Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдэл 2019 оны 6 дугаар сарын байдлаар 993.1 тэрбум төгрөг байгаа бөгөөд 2010-2023 онд төлөгдөх нөхцөлтэй, жилийн 12.8-16.3 хувийн хүүтэй байна. ХХБ 500.0 сая ам.долларын гадаад үнэ цаасны төлбөрийг 2020 оны 5 дугаар сард төлж дуусах бөгөөд үндсэн төлбөрт 500.0 сая ам.доллар, хүүгийн төлбөрт 23.4 сая ам.доллар, нийт 523.4 сая ам.доллар буюу своп ханшаар тооцвол 1,034.4 тэрбум төгрөгийн төлбөр төлнө.

Хүснэгт №20. ХХБ-ны барьцаалсан Засгийн газрын үнэт цаасны мэдээлэл

Дүн (тэрбум төгрөг)	Хүүгийн хувь	Төлөгдөх он
47.00	15.75%	2019
206.00	15.88%	2020
216.00	16.00%	2021
291.60	16.13%	2022
232.50	12.8%-16.3%	2023

⁸ Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.3-т “Засгийн газрын дотоод үнэт цаасаар бүрэн баталгаажсан буюу барьцаа тавьсан өрийн баталгааны үлдэгдлийг “Засгийн газрын

өрийн хязгаар”-г оруулж тооцохгүй” гэж заасан тул тус баталгаа нь өрийн хязгаарын тооцоонд ордоггүй болно.

Графикууд

График №1. Зэсийн үнийн хөдөлгөөн, төсөөлөл, ам.доллар/тонн.....	3
График №2. Алтны үнийн хөдөлгөөн, төсөөлөл, ам.доллар/трой унци.....	3
График №3. Төмрийн хүдрийн үнийн хөдөлгөөн, төсөөлөл, ам.доллар/тонн.....	3
График №4. Нүүрсний үнийн хөдөлгөөн, төсөөлөл, ам.доллар/тонн.....	4
График №5 Газрын тосны үнийн хөдөлгөөн, төсөөлөл, ам.доллар/тонн.....	4
График №6 Гадаад худалдааны гүйцэтгэл, тэрбум ам.доллар.....	5
График №7. Төлбөрийн тэнцэл, тэрбум ам.доллар.....	6
График №8. Мөнгөний нийлүүлэлт /тэрбум төгрөг/.....	6
График №9. Мөнгөний нийлүүлэлт, гадаад болон дотоод цэвэр активын жилийн өөрчлөлт.....	7
График №10. Ажилгүйдлийн түвшин, улирлаар.....	7
График №11. Гадаад худалдаа, жил бүрийн эхний 8 сарын байдлаар, тэрбум ам.доллар.....	8
График №12. Төлбөрийн тэнцэл, 2019 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, сая ам.доллар.....	8
График №13. ДНБ-ий хэмжээ, их наяд төгрөгөөр, эдийн засгийн өсөлт, хувиар.....	9
График №14. Гадаад худалдаа.....	10
График №15. Төлбөрийн тэнцэл, 2020-2022 оны төсөөлөл.....	10
График №16. Нэгдсэн төсвийн алдагдал 2016-2022 оноор.....	18
График №17. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /2016-2022 он, ДНБ-д эзлэх хувиар/.....	19
График №18. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого /2016-2020 он, тэрбум төгрөгөөр/.....	19
График №19. Засгийн газрын өр /2016-2020 он/.....	19
График №20. Нийт орлого ба тусламжийн дүн /их наяд төгрөг/.....	20
График №21. Уул уурхайн болон бусад салбараас төвлөрүүлэх орлого /их наяд төгрөг/.....	21
График №22. Эдийн засаг дахь татварын ачаалал /хувиар/.....	21
График №23. Татварын хувь хэмжээ, улсуудаар /хувиар/.....	22
График №24. Тэнцвэржүүлсэн орлогын бүтэц /хувиар/.....	22
График №25. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого /уул уурхай, уул уурхайн бус салбараар, тэрбум төгрөгөөр/.....	23
График №26. Төгрөгийн болон валютын зээлийн жигнэсэн дундаж хүү /хувиар/.....	23
График №27. Хувь хүний орлогын албан татварын орлого, тэрбум төгрөг.....	24
График №28. НӨАТ-ын татвар төлөгч болон орлого.....	24
График №29. Суудлын автомашины импортын тоо.....	25
График №30. Импортын гаалийн болон НӨАТ, тэрбум төгрөг.....	25
График №31. Импортын хэмжээ /сая ам.доллар/.....	26
График №32. Зэсийн баяжмалын экспорт, мянган тонн.....	26
График №33. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл.....	27
График №34. Газрын тосны экспортын хэмжээ, үнэ.....	27
График №35. Дэлхийн зах зээл дэх зэсийн үнэ, /тонн. ам доллар/.....	28
График №36. Аялал жуулчлалын салбарын орлого /сая ам.доллар/.....	32
График №37. Улсын төсвийн хөрөнгө оруулалт /тэрбум төгрөг/.....	42
График №38. Эдийн засгийн ангиллаар, тэрбум төгрөг.....	42
График №39. ОНХНС-н өөрчлөлт.....	48
График №40. Засгийн газрын өрийн тусгай шаардлагын төсөөлөл.....	57
График №41. Засгийн газрын өрийн багцын хөдөлгөөн.....	57
График №42. Хүүгийн зардлын нэгдсэн төсөвт үзүүлэх нөлөөлөл.....	57
График №43. Хүүгийн зардлын 2020 оны задаргаа.....	58
График №44. Өрийн үйлчилгээний төсөвт үзүүлэх нөлөөлөл/ хувиар, их наяд төгрөгөөр/.....	59

Хүснэгтүүд

Хүснэгт №1. Дэлхийн эдийн засгийн өсөлт, хувь	1
Хүснэгт №2. Эдийн засгийн өсөлт, салбаруудаар	5
Хүснэгт №3. 2020 оны нэгдсэн төсвийн нийт орлого	20
Хүснэгт №4. Уул уурхайн салбараас орох орлогын төлөвлөгөө /тэрбум төгрөг/.....	21
Хүснэгт №5. Олон улсын дундаж татварын хувь хэмжээ	22
Хүснэгт №6. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэмжээ.....	29
Хүснэгт №7. Урсгал зардлын бүтэц /урсгал зардалд эзлэх хувиар/	30
Хүснэгт №8. Тэтгэвэр, тэтгэмж нэмэх тооцоолол /тэрбум төгрөг/.....	31
Хүснэгт №9. Тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжид хамрагдах хүний тоо, зарцуулах хөрөнгийн өөрчлөлт	36
Хүснэгт №10. Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжид хамрагдах хүний тоо, зарцуулах хөрөнгө /тэрбум төгрөг/.....	37
Хүснэгт №11. Орон тооны өөрчлөлтийн судалгаа /тэрбум төгрөг/	37
Хүснэгт №12. Засгийн газрын тусгай сангийн зардлын төсөл /тэрбум төгрөг/.....	39
Хүснэгт №13. Нийгмийн халамжийн сангийн зарлага /тэрбум төгрөг/.....	40
Хүснэгт №14. Орон нутгийн суурь төсөв	47
Хүснэгт №15. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	47
Хүснэгт №16. Засгийн газрын гадаад зээл, тусламжийн 2020 оны ашиглалт /тэрбум төгрөг/.....	49
Хүснэгт №17. Засгийн газрын өрийн бүтэц /тэрбум төгрөг/.....	56
Хүснэгт №18. Засгийн газрын гадаад үнэт цаасны үлдэгдэл /сая ам.доллар/.....	58
Хүснэгт №19. Засгийн газрын өрийн баталгаа.....	59
Хүснэгт №20. ХХБ-ны барьцаалсан Засгийн газрын үнэт цаасны мэдээлэл	61

Зургууд

Зураг №1. Газрын бүртгэл, мэдээллийн технологийн шинэчлэл.....	27
Зураг №2. Газрын төлбөрийн орлого /сая төгрөг/.....	27
Зураг №3. “Төсвийн хөрөнгө оруулалт” аппликэйшн	43
Зураг №4. Хөрөнгө оруулалтын төлөвлөлт.....	43
Зураг №5. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэр	48

ДАГАЛДАХ ХУУЛИЙН ТӨСЛҮҮД

ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар

Засгийн газраас 2020 онд хэрэгжүүлэх төсвийн бодлогын хүрээнд төсвийн зарлагын шинэчлэлийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Энэ хүрээнд орон нутгийн өмчийн ашиглалт хамгаалалтыг сайжруулах, төсвийн үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр зарим зохицуулалтыг хийхээр төлөвлөж үр дүнг нь Монгол Улсын 2020 оны төсвийн төсөлд тусгаад байна.

А. Газрын төлбөрийн асуудлаар холбогдох хуулийн төсөл

Газрын төлбөрийн тухай хууль 1997 оноос хэрэгжиж эхэлснээс хойш эдийн засаг, хууль, эрх зүйн орчин өөрчлөгдөж байгаатай холбогдуулан газрын бүртгэлийг ил тод болгох, цахимжуулах, газрын төлбөр ногдуулалт, төлөлтийг хялбарчлах, бусад хууль тогтоомжтой нийцүүлэх чиглэлээр холбогдох хуульд дараах өөрчлөлтүүдийг тусгах шаардлагатай байна.

Газрын тухай хууль болон Газрын төлбөрийн тухай хуульд газрын төлбөрийн хэмжээ, төлөх хугацааг газрын суурь үнэлгээ болон итгэлцүүрийг үндэслэн газар эзэмших, ашиглах гэрээнд зааснаар ногдуулан төлөхөөр зохицуулсан байдаг. Гэвч Засгийн газраас суурь үнэлгээ, Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас итгэлцүүр шинэчлэн тогтоох бүр иргэн, аж ахуйн нэгжтэй байгуулсан газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээ, түүнд заасан төлбөрийн хэмжээг тухай бүр шинэчлэх шаардлага үүсдэг байна. Гэрээг нэг бүрчлэн шинэчлэн байгуулах нь иргэн, аж ахуйн нэгжүүдэд хүндрэл учруулах цаг хугацаа шаардсан ажил бөгөөд одоогийн байдлаар улсын хэмжээнд гэрээ шинэчлэн байгуулах ажил 30 орчим хувийн хэрэгжилттэй байна. Үүнээс шалтгаалан Газрын төлбөрийн тухай хууль, Засгийн газраас тогтоосон газрын суурь үнэлгээний дагуу газрын төлбөрийн ногдуулан хураан авах боломжгүй нөхцөл байдал үүсч ирлээ.

Түүнчлэн, Газрын тухай хуульд аймаг, нийслэл, дүүргийн газрын алба, сумдын газрын даамлын эрх хэмжээнд газрын төлбөрийг ногдуулж, хураахаар заасан боловч газрын даамал нь Татварын ерөнхий хуульд заасан татвар ногдуулах, хураах ажиллагааг хэрэгжүүлэх боломжгүй тул газрын төлбөр төлөөгүй, төлөхөөс зайлсхийсэн этгээдээс төлбөрийг хураахад хүндрэлтэй нөхцөл үүсч байна. Иймд газрын болон татварын асуудал эрхэлсэн төрийн байгууллагууд хоорондын эрх, үүргийг оновчтой, тодорхой болгох, газрын бүртгэл, төлбөр ногдуулалт, төлөлтийн цахим мэдээллийн сан үүсгэх, улсын бүртгэлийн дундын мэдээллийн сангаар дамжуулан төрийн байгууллагууд харилцан мэдээлэл солилцох, мэдээллийг ил тод болгох, газрын төлбөр ногдуулах, хураах ажиллагааг боловсронгуй болгох нь зүйтэй байна. Ийнхүү газрын төлбөрийн харилцааг Газрын төлбөрийн хуулиар давхардуулан зохицуулж ирсэн нь Татварын ерөнхий хуульд заасан татварын харилцааг зөвхөн татварын хуулиар зохицуулах зарчимтай зөрчилдөж байгааг өөрчилж газрын төлбөрийн орлогыг бүрэн хураах боломжийг бүрдүүлэхээр төлөвлөж байна.

Өнөөгийн байдлаар газрын төлбөрийг сум, дүүргийн газрын даамал хураан аймаг, нийслэлийн төсөвт орлогыг 100 хувь төвлөрүүлж байгаагийн улмаас тухайн

сум, дүүрэг бие даан газартай холбоотой үүсдэг тулгамдсан асуудлаа шийдэх санхүүгийн боломжгүй болж, орлого төвлөрүүлэх идэвх санаачилгыг бууруулж байна. Иймд газрын асуудлаар үүсээд буй хүндрэлийг сум, дүүрэг нь өөрөө шийдвэрлэх боломжийг олгох, орлого төвлөрүүлэлтийг эрчимжүүлэх зорилгоор газрын төлбөрийн орлогын 40 хувийг тухайн сум, дүүргийн төсөвт хуваарилах нь зүйтэй гэж үзлээ.

Иймд Монгол Улсын Засгийн газраа газрын бүртгэлийг цахимжуулж ил тод болгох, төлбөр ногдуулах, төлөх харилцааг хялбарчлах, сум, дүүрэг бие даан газрын асуудлаа шийдвэрлэх, газрын төлбөр хураах идэвх санаачилгыг нэмэгдүүлэх зорилгоор Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах болон Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүдийг боловсрууллаа.

Б. Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 5.1.5-д заасан “үндэсний баялгийг хүн ам, нийгмийн бүлэг болон өнөө ба хойч үеийнхэнд шударга, тэнцвэртэй хуваарилах” төсвийн удирдлагын зарчмыг хэрэгжүүлж, эрдэс баялгийн өгөөжийг өнөө ба хойч үеийнхэнд хүртээх үүрэг бүхий Ирээдүйн өв сангийн тухай хууль 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдөр батлагдаж, 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжиж байна.

Ирээдүйн өв сан нь Хүний хөгжил сангийн боловсронгуй хэлбэр байхаар байгуулагдсан бөгөөд үүнтэй холбоотойгоор Улсын Их Хурлаас Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөж журмын тухай хуулийг баталж, Ирээдүйн өв сангийн эх үүсвэрээс Хүний хөгжил санд хуримтлагдсан 1 их наяд 71.9 тэрбум төгрөгийн өрийг барагдуулан, 2017-2019 онуудад улсын төсөвт нийт 310 тэрбум төгрөгийг шилжүүлэхээр зохицуулсан. Эдгээр шилжүүлгүүдийг сангийн орлого төвлөрөлттэй уялдуулан гүйцэтгэж, 2019 оны 8 дугаар сарын байдлаар Ирээдүйн өв санд 313 тэрбум төгрөгийг хуримтлуулаад байна.

Хуулийн дагуу Ирээдүйн өв сангийн хөрөнгийн удирдлагыг сангийн хөрөнгийг эзэмшихгүй, зөвхөн олгогдсон эрх хэмжээний хүрээнд хөрөнгө оруулалт хийж, сангийн хөрөнгийн бодит үнэ цэнийг хадгалах, арвижуулах үүрэгтэй мэргэжлийн, бие даасан, 100 хувь төрийн өмчит хуулийн этгээд буюу Ирээдүй өв сан корпораци хэрэгжүүлэхээр заасан.

Ирээдүйн өв сан корпораци бие даасан үйл ажиллагаагаа эхлүүлж, хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх чадавхи, бүтцийг бий болгох хүртэл сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх, түүнтэй холбогдон гарах зардлыг зохистой түвшинд байлгаж, хөрөнгийн удирдлагыг оновчтой хэлбэрээр шийдвэрлэх практик шаардлага үүсээд байна.

Иймд Ирээдүйн өв сан корпораци тогтвортой бие даан үйл ажиллагаа явуулах бүтэц, чадамжтай болох хүртэл хугацаанд сангийн хөрөнгийн удирдлагыг

Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх шилжилтийн үеийн зохицуулалтын шинжтэй холбогдох өөрчлөлтийг Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд оруулахаар тусгалаа.

В. Жолоочийн даатгалын тухай хуулийн зарим хэсэг, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл

УИХ-аас 2017 онд Зөрчлийн тухай хуулийг батлахдаа Жолоочийн даатгалын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хүчингүй болгосон. Гэвч Жолоочийн даатгалын тухай хуулийн 22.1.2-т “энэ хуулийн 28.1-д заасан орлогын 50 хувь;” гэсэн заалтыг үлдээсэн байх тул түүнийг хүчингүй болгохоор хуулийн төсөлд тусгалаа.

Жолоочийн даатгалын тухай хуулийн 22.1.4-т авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын 10 хувийг Жолоочийн даатгалын санд төвлөрүүлэхээр заасныг хүчингүйд тооцохоор мөн хуулийн төсөлд тусгав.

Санд 2013-2018 онуудад нийт 17.7 тэрбум төгрөг, үүнээс сүүлийн 3 жилд дунджаар 3.7 тэрбум төгрөгийг авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын орлогоос буюу орон нутгийн төсвөөс төвлөрүүлсэн. Харин даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг компаниудаас 2011-2018 онуудад жилд дунджаар 391.1 сая төгрөгийг тус санд төвлөрүүлсэн бөгөөд жилд дунджаар 240.3 сая төгрөгийг сангийн үйл ажиллагааны зардалд зарцуулжээ. Мөн тус сангаас олгосон нөхөн төлбөр болон буруутай этгээдээс нэхэмжлэн авсан нөхөн төлбөрийн буцаалтын зөрүү (цэвэр нөхөн төлбөр) нь жилд дунджаар 90.3 сая төгрөг болж байна.

Жолоочийн даатгалын сангийн хөрөнгийн үлдэгдэл 2018 оны жилийн эцсийн байдлаар 11.9 тэрбум төгрөг болсон бөгөөд сангийн нийт зарлага нь жилд дунджаар 330.6 сая төгрөг байгааг даатгалын компаниудаас төвлөрүүлэх шимтгэлийн орлого болон сангийн хөрөнгийн удирдлагын орлогоор бүрэн санхүүжүүлэх нөхцөл бүрдсэн байна.

Жолоочийн даатгалын тухай хуулийн дээрх 22.1.2, 22.1.4 дүгээр заалтууд хүчингүй болсонтой холбоотойгоор тус хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дугаар хэсэг буюу “Энэ хуулийн 22.1.2, 22.1.4-т заасан эх үүсвэрийг Жолоочийн даатгалын сангийн дансанд шилжүүлэх журмыг санхүү, төсвийн болон авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.” гэснийг мөн хүчингүй болгохоор хуулийн төсөлд тусгав.

САНГИЙН ЯАМ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оныдугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын төлбөрийн тухай хуулийн 10 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 5 дахь хэсэг нэмсүгэй:

“5. Газрын төлбөр төлөгч нь жилийн төлбөрийг тэнцүү хэмжээгээр хуваан улиралд ногдох төлбөрийг дараа сарын 20-ны өдрийн дотор төлөх бөгөөд дараа улирлуудын төлбөрийг урьдчилан төлж болно.”

2 дугаар зүйл. Газрын төлбөрийн тухай хуулийн дараахь зүйл, хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 9 дүгээр зүйл:

“9 дүгээр зүйл. Газрын төлбөр ногдуулах

1.Газрын төлбөрийг газар эзэмших, ашиглах эрхийг улсын бүртгэлд бүртгэгдсэн букуу Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9.11-д заасан дундын мэдээллийн санд улсын бүртгэлийн дугаарыг оруулсан өдрөөс эхлэн тооцно.

2.Газрын асуудал эрхэлсэн байгууллага /албан тушаалтан/ нь энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан газрын жилийн төлбөрийг ногдуулж тухайн оны хоёрдугаар сарын 10-ны дотор татварын албанд хүргүүлнэ.

3.Эрхийн улсын бүртгэлд газар эзэмших, ашиглах шинээр бүртгэгдсэн бол газрын асуудал эрхэлсэн байгууллага /албан тушаалтан/ тухайн жилд ногдох газрын төлбөрийн хэмжээг хувь тэнцүүлэн ногдуулж 10 хоногийн дотор татварын албанд хүргүүлнэ.

4.Газрын асуудал эрхэлсэн байгууллага /албан тушаалтан/ нь газрын суурь үнэлгээ, газрын үнэлгээний тойрог, зэрэглэл, бүс, газар эзэмших, ашиглах зориулалтын итгэлцүүр, төлбөрийн хувь, хэмжээ өөрчлөгдсөн тухай бүр уг өөрчлөлттэй холбогдуулан газрын төлбөрийг шинэчлэн ногдуулж 30 хоногийн дотор татварын албанд хүргүүлнэ.

5.Татварын алба нь энэ зүйлийн 2, 3, 4 дэх хэсэгт заасан газрын төлбөрийн ногдуулалтын талаарх мэдээллийг газар эзэмшигч, ашиглагч этгээдэд цахим болон бусад хэлбэрээр мэдэгдэнэ.

6.Газрын нэгж талбарын дугаар, газрын эзэмшил, ашиглалтын төрөл, газрын суурь үнэлгээний тойрог, зэрэглэл, бүс, талбайн хэмжээ, газрын суурь үнэлгээ, төлбөр төлөгч, төлбөрийн хувь хэмжээ, ногдуулалт, төлөлт болон холбогдох бусад мэдээллийг цахим болон бусад хэлбэрээр харилцан солилцох журмыг газрын асуудал эрхэлсэн болон татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга хамтран батална.”

2/ 12 дугаар зүйл:

“12 дугаар зүйл. Газрын төлбөрийн хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

Газрын төлбөрийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд Газрын тухай хууль, Татварын ерөнхий хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль болон Зөрчлийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.”

3/ 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

“3.Газрын асуудал эрхэлсэн байгууллага /албан тушаалтан/ нь газрын төлбөрийн ногдуулалтын жилийн тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны дотор харьяалах татварын албанд тушааж, ногдуулалтын эцсийн тооцоог хийнэ.”

3 дугаар зүйл. Газрын төлбөрийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн “Газрын тухай хуульд заасан нөхцөл, журмын дагуу гэрээ байгуулан” гэснийг “Хууль тогтоомжийн дагуу газар эзэмшүүлэх, ашиглуулахаар шийдвэрлэсний үндсэн дээр” гэж, 4 дүгээр зүйлийн “гэрээний” гэснийг гэж “эрх бүхий этгээдийн шийдвэрийн” гэж, 10 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай” гэснийг “Татварын ерөнхий” гэж, 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтын “тухайн албан тушаалтны дээд шатны байгууллага, албан тушаалтан” гэснийг “Татварын ерөнхий хуулийн 81 дүгээр зүйлийн 81.1 дэх хэсэгт заасан этгээд” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оныдугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдөр баталсан Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оныдугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 33.7 дахь хэсэг нэмсүгэй:

“33.7.Эрх бүхий этгээд газар эзэмшүүлэх, ашиглуулах тухай шийдвэр гаргаснаас хойш ажлын 15 хоногийн дотор энэ тухай мэдээллийг Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9.11-д заасан дундын мэдээллийн санд оруулна.”

2 дугаар зүйл. Газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “зохих хууль тогтоомж, гэрээний” гэснийг “Газрын төлбөрийн тухай хуулийн” гэж, 23 дугаар зүйлийн 23.3.8, 23.4.5 дахь заалтуудын “ногдуулж хураах” гэснийг “тодорхойлж ногдуулах” гэж, 34 дүгээр зүйлийн 34.6.6 дахь заалтын “төлбөрийн хэмжээ, төлөх хугацаа” гэснийг “төлбөр төлөхтэй холбоотой үүрэг” гэж, 35 дугаар зүйлийн 35.3.3 дахь заалтын “тогтоосон” гэснийг “хуульд заасан” тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оныдугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дугаар заалтын “төлбөрийн хэмжээ, төлөх хугацаа” гэснийг “төлбөр төлөхтэй холбоотой үүрэг” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оныдугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 23.8.14 дэх заалт нэмсүгэй:

“23.8.14.газрын төлбөрийн 40 хувь”

2 дугаар зүйл. Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6.2 дахь заалтын “төлбөр” гэснийг “төлбөрийн 60 хувь” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

ИРЭЭДҮЙН ӨВ САНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд дор дурдсан агуулгатай зүйл нэмсүгэй:

1/5¹ дугаар зүйл:

“5¹ дугаар зүйл. Корпораци бие даан тогтвортой үйл ажиллагаа явуулах бүтэц, чадамжтай болох хүртэл сангийн хөрөнгийн удирдлагыг олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.”

2/5² дугаар зүйл:

“5² дугаар зүйл. Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийг энэ хуулийн 5¹ дугаар зүйлд заасны дагуу Корпораци бие даан тогтвортой үйл ажиллагаа явуулах бүтэц, чадамжтай болсноор дагаж мөрдөнө”.

2 дугаар зүйл. Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн “барагдуулж дууссанаар” гэснийг “барагдуулж, энэ хуулийн 5² дугаар зүйлд заасан нөхцөл үүссэнээр” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны . . . дугаар
сарын . . . -ны өдөр


Улаанбаатар
хот

ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ХЭСЭГ, ЗААЛТ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ


1 дүгээр зүйл. Жолоочийн даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2, 22.1.4 дэх заалтууд, мөн зүйлийн 22.3 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ



**3.НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН
2020 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСӨЛ, ТАНИЛЦУУЛГА**





НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2020 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төслийг боловсруулах үндэслэл, шаардлага

Хууль зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 10.1.3-т “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж, мөн хуулийн 8.4.8-д “Улсын Их Хурал жилийн төсвийн төслийг хэлэлцэн жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор батлах” гэж тус тус заасан нь Нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Практик шаардлага

Түүнчлэн дараах хүчин зүйлс нь нийгмийн даатгалын сангийн зардлыг нэмэгдүүлэх шаардлагыг бий болгож байна. Үүнд:

1. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тэтгэврийг үе шаттайгаар нэмэгдүүлнэ гэж заасны дагуу нийгмийн даатгалын сангаас олгож буй бүх төрлийн тэтгэврийг 2020 онд нэмэгдүүлэхээр төлөвлөсөн;
2. Нийгмийн даатгалын сангуудаас олгох дундаж тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ болон тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо нэмэгдэж байгаатай холбоотойгоор сангуудын зардал нэмэгдсэн;

3. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхлэхтэй холбоотойгоор сангийн зардал нэмэгдсэн.
4. УИХ-аар 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхлэхтэй холбоотойгоор сангийн зардал нэмэгдсэн.

Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл 2 бүлэг, 6 зүйлтэй байх бөгөөд доор дурдсан агуулгатай байна.
Үүнд:

Нэгдүгээр бүлэгт: Хуулийн нийтлэг үндэслэл, зорилт, Нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хууль тогтоомжийн тухай;

Хоёрдугаар бүлэгт: Нийгмийн даатгалын санд 2020 оны төсвийн жилд Төсвийн ерөнхийлөн захирагчдын төвлөрүүлэх орлогын хэмжээ, Нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид зарцуулах төсвийн эрх, хэмжээг, Засгийн газрын урт хугацаат бонд худалдан авах хөрөнгийн дээд хэмжээг тогтоох тухай болон хуулийг дагаж мөрдөх хугацааг тус тус тусгана.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар Нийгмийн даатгалын тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн дагуу 2020 оны төсвийн жилд нийгмийн даатгалын сангийн эх үүсвэр бий болгож хуримтлуулах, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжид зориулан хөрөнгө зарцуулах эрх зүйн орчин бүрдэнэ.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай, Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулна.

Хуулийн төсөлтэй хамт Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөнгөлөлттэй нөхцөлөөр эрт тэтгэвэр тогтоолгосон зарим эхчүүд, эмэгтэйчүүдийн тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг тус тус боловсруулна.

--- оОо ---

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2020 ОНЫ ТӨСВИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсөвт нийт орлого 2,291.9 тэрбум төгрөг, нийт зарлага 2,510.7 тэрбум төгрөг байхаар төсөвлөлөө. Энэ нь 2019 онтой харьцуулахад орлого 688.5 тэрбум төгрөг, зарлага 442.1 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж байна.

Хүснэгт №1. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2018 Гүйц	2019 Төсөв	2020 Төсөл
ОРЛОГО	1,480.0	1,603.3	2,291.9
1 Шимтгэлийн орлого	1,403.8	1,534.7	2,217.2
2 Бусад орлого	76.2	68.6	74.7
ЗАРЛАГА	1,816.1	2,068.5	2,510.7
1. Тэтгэврийн даатгалын сан	1,619.4	1,859.9	2,253.0
2. Тэтгэмжийн даатгалын сан	112.1	114.1	143.8
3. ҮОМШӨ-ний даатгалын сан	29.9	32.9	35.0
4. Ажилгүйдлийн даатгалын сан	34.4	36.8	51.1
5. Бусад зарлага	1.6	0.1	0.00
6. Ажиллагааны зардал	18.7	24.7	27.9
Улсын төсвөөс олгох татаас	609.8	605.5	399.4

Нийгмийн даатгалын сангийн орлого



Ирэх 2020 онд 51.1 мянган аж ахуйн нэгж байгууллагын 953.7 мянга гаруй ажилтан албан журмын даатгалд хамрагдахаар байгаа нь 2019 оноос 28.3 мянган хүнээр нэмэгдэхээр байна. Харин албан бус секторт хөдөлмөр эрхэлж байгаа 296.6 гаруй мянган иргэдийн 69.7 хувь буюу 206.9 орчим мянган хүн сайн дурын даатгалд хамрагдахаар тооцлоо.

Нийгмийн даатгалын сангийн орлогын эх үүсвэрийг ангилж үзвэл:

1/ Эдийн засагт гарч байгаа эерэг өөрчлөлттэй уялдан нийгмийн даатгалын хамрах хүрээ нэмэгдэх, дундаж цалин хөлс өсөх, орлогын боломжит бусад эх үүсвэр

нэмэгдэх зэрэг төсөөлөлд үндэслэн 2020 онд нийгмийн даатгалын санд төвлөрөх шимтгэлийн орлогыг 2,217.2 тэрбум төгрөг, хадгаламжийн хүүгийн орлогыг 74.7 тэрбум төгрөг байхаар тус тус тооцлоо.

2/ Цэргийн алба хаасны тэтгэвэр, 1995 оноос өмнө тэтгэвэрт гарсан иргэдийн тэтгэврийн зардлыг хуульд заасны дагуу төр хариуцах болон тэтгэврийн даатгалын сангийн алдагдалд улсын төсвөөс олгох татааст нийт 399.4 тэрбум төгрөгөөр тооцлоо.

3/ Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны 2018 оны 05 дугаар тогтоолын дагуу 2020 онд улсын хэмжээнд мөрдөгдөх хөдөлмөрийн

хөлсний доод хэмжээг 100.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 420.0 мянган төгрөг болгон тогтоосонтой уялдаж нийгмийн даатгалын сангийн орлого 63.9 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр байна.

4/Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тэтгэврийн даатгалыг нөхөн

Нийгмийн даатгалын сангийн зарлага

Нийгмийн даатгалын сангийн нийт зардал 2,510.7 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь 2019 онтой харьцуулахад 442.1 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна.



Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх болон эхчүүдийн нийгмийн хамгааллыг сайжруулах хуулиуд хэрэгжинэ: УИХ-аас 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдөр батлагдаж 2020 оноос хэрэгжиж эхлэхээр шийдвэрлэсэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулиуд нь нийгмийн даатгалын сангийн зарлагыг 2020 онд 127.5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх үр дагавартай байна. Дээрх хуулийн хүрээнд малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч, эхчүүд дараах нийгмийн баталгаагаар хангагдана. Үүнд:

1/ Төрүүлсэн болон гурав хүртэл настайд нь үрчлэн авч зургаан нас хүртэл хүүхдээ өсгөсөн эхийн НДШ төлсөн нийт хугацаанд дээр төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэд бүрийн тоогоор нэг жил зургаан сарыг нэмж тооцно. *Жишээ нь: Иргэн Б нийт 27*

төлүүлэх тухай хууль 2020 онд хэрэгжихтэй холбоотойгоор тэтгэврийн даатгалын сангийн орлого 133.1 тэрбум төгрөгөөр нэмэгдэнэ.

*жил шимтгэл төлсөн 4 хүүхэдтэй бол одоогийн хуулиар сард 444 мянган төгрөгийн тэтгэвэр авна. Харин хуулийн өөрчлөлтөөр түүний шимтгэл төлсөн 27 жил дээр 6 жил($4*1.5=6$) нэмэгдэж нийт 33 жил болох ба түүний тэтгэвэр 48 мянган төгрөгөөр нэмэгдэж 492 мянган төгрөгийн тэтгэвэр тогтоолгоно.*

2/ Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан эхийн жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг цалин хөлснийх нь 70 хувиар тооцож байсныг 100 хувиар тооцож олгоно;

3/ Нийгмийн даатгалд даатгуулаагүй эх хүүхдээ асрах хугацаанд төлбөл зохих шимтгэлийн 50 хувийг өөрөө, үлдэх 50 хувийг төрөөс төлнө;

4/ Сайн дураар даатгуулсан эхийн хүүхдээ асрах хугацаанд төлбөл зохих шимтгэлийг өөрөө хариуцаж байсныг холбогдох хуульд өөрчлөлт оруулж 50 хувийг өөрөө, үлдэх 50 хувийг тэтгэмжийн даатгалын сангаас төлнө;

5/ Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид 1995-2019 оны хооронд төлж чадаагүй шимтгэлээ нэг удаа нөхөн төлнө. *Жишээ нь Малчин А тэтгэвэр тогтоолгох насанд буюу 55 нас хүртлээ НДШ огт төлөөгүй.*

Шинэ хуулийн дагуу 10 жил нөхөн даатгуулахад 5 сая төгрөгийг нэг удаа нөхөн төлснөөр хувь тэнцүүлсэн тэтгэвэр тогтоолгох эрхтэй болж, жилд 3.2 сая (сард 267.0 мянга) төгрөгийн тэтгэвэр авах боломжтой болно.



Хөнгөлөлттэй нөхцөлөөр эрт тэтгэвэрт гарсан зарим эхчүүд, эмэгтэйчүүдийн тэтгэврийн

хэмжээг нэмэгдүүлэх: Улсын Бага Хурлаас 1990 оны 11 дүгээр сард “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Тэтгэврийн хууль”-ийг шинэчлэн баталсан бөгөөд энэхүү шинэчлэлийн нэг өөрчлөлт нь эмэгтэйчүүдийг онцгойлон үзэж хөнгөлөлттэй нөхцөлөөр эрт тэтгэвэр тогтоолгох эрхийг хуульчилсан явдал байв.

Энэхүү хуулиар төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авсан дөрөв ба түүнээс дээш хүүхдээ 6 настай болтол нь өсгөсөн эх 20-оос доошгүй жил ажилласан бол нас харгалзахгүй тэтгэвэр тогтоох болзлыг шинээр оруулснаар 1991 онд 32.8 мянган эх насны тэтгэвэр тогтоолгосон байна. Мөн хуульд зарим иргэдийн тэтгэвэр тогтоолгох насыг наашлуулсан өөрчлөлт орсон ба улсад 27 жил ажилласан эмэгтэйчүүд өөрсдөө хүсвэл нас харгалзахгүйгээр тэтгэвэр тогтоолгох эрхтэй болсон.

Нийгмийн даатгалын багц хууль 1994 онд хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор “Хүн амын нийгмийн хамгааллын талаар авах арга хэмжээний тухай” УИХ-ын 1997 оны 5 дугаар тогтоолоор 1995 оноос өмнө Тэтгэврийн хуулиар насны тэтгэвэр тогтоолгосон бөгөөд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасан

тэтгэврийн насны болзол, нөхцөлийг хангаагүй 44.4 мянган иргэдийн тэтгэврийг түдгэлзүүлж, авч байгаа тэтгэвэр, нөхвөрийн нийлбэрийн хэмжээтэй тэнцэх “нөхөн олговор”-ыг тэдний өндөр насны тэтгэврийн эрх үүсэх хүртэлх хугацаанд хөдөлмөр зохицуулалтын албадаар дамжуулан сар бүр олгох шийдвэрийг гаргасан юм.

Үүнээс хойш 2017 он гэхэд дээр дурдсан 44.4 мянган иргэн өндөр насны тэтгэврийн насанд хүрснээр нийгмийн даатгалын тэтгэвэрт бүрэн шилжиж дууссан. Эдгээр иргэдээс өнөөдөр 21.2 мянган хүн иргэн нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авч байгаа бөгөөд эдгээрийн 14.4 мянга буюу 67.9 хувь нь олон хүүхэд төрүүлсэн эхчүүд, 3.8 мянга буюу 17.9 хувь нь 27 жил ажиллан нас харгалзахгүй тэтгэвэр тогтоолгосон эмэгтэйчүүд эзэлж байна.

Иймд хөнгөлөлттэй нөхцөлөөр залуу насандаа тэтгэвэр тогтоолгосон эхчүүдийн ажилласан жил цөөн, тэтгэвэр тогтоолгосон цалингийн хэмжээ бага байгааг харгалзан тэдний авч байгаа тэтгэврийн хэмжээг нь нэг удаа 50.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэх хуулийн төсөл боловсруулав. Эдгээр тэтгэвэр авагчдын тэтгэврийн хэмжээг 50.0 мянган төгрөгөөр, нэмэгдүүлэхэд жилд 12.7 тэрбум төгрөгийн нэмэлт санхүүжилт шаардлагатай.


Тэтгэврийн даатгалын сан

Тэтгэврийн даатгалын сангийн нийт зардлыг 2,275.3 тэрбум төгрөгөөр, орлогыг 1,876.1 тэрбум төгрөгөөр тооцлоо. Тэтгэврийн даатгалын сангийн зардлын 74.0 хувийг өндөр насны тэтгэвэр, 14.7 хувийг тахир дутуугийн тэтгэвэр, 3.5

хувийг тэжээгчээ алдсаны тэтгэвэр, 6.9 хувийг цэргийн тэтгэвэр тус тус эзэлж байна.

Тэтгэврийн даатгалын сангаас 2020 онд нийт 445.6 мянган хүний тэтгэвэрт 2,251.9 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсөн нь 2019 онтой харьцуулахад 393.1 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна.

График №1. Тэтгэврийн даатгалын сангийн төсөв /тэрбум төгрөг/



Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 26 дугаар тогтоолоор бүх тэтгэврийн хэмжээг 24.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж бүрэн тэтгэврийн доод хэмжээ 280.0 мянган төгрөгөөс 310.0 мянган төгрөгт хүрч 10.7 хувиар, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 243.0 мянган төгрөгөөс 270.0 мянган төгрөгт хүрч 11.1 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Үндэсний статистикийн хорооноос гаргасан “Монгол Улсын хүн амын 2010-2040 оны хэтийн тооцоо” судалгаагаар 2020 онд өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрч байгаа эрэгтэй (60 нас) 11.4 мянга, эмэгтэй (55 нас) 17.0 мянган хүн байна. Дээрх судалгаанд үндэслэн шинээр тэтгэвэр тогтоолгох 43.8 мянган хүн, харин

тэтгэвэр нь зогсох 25.5 мянга хүн, цэвэр өсөлтийг 18.3 мянган хүн байхаар тооцлоо. Ирэх онд улсын төсвөөс тэтгэврийн зардлыг нь хариуцдаг 1/ цэргийн алба хаасны тэтгэвэрт гарах хүний тоо 2020 онд 512 -оор нэмэгдэж нийт 18.7 мянга; 2/ 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон нийт 53.2 мянган иргэн тус тус тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авахаар байна. Тэтгэврийн даатгалын санд улсын төсвөөс олгох татаас 399.4 тэрбум төгрөг байгаагаас цэргийн болон 1995 оноос өмнө тэтгэвэрт гарсан иргэдийн тэтгэвэрт 367.7 тэрбум төгрөг, нийгмийн даатгалын сангийн алдагдлыг хаахад 31.8 тэрбум төгрөг тус тус олгохоор төсөвлөлөө.

Хүснэгт №2. Улсын төсвийн татаас /тэрбум төгрөг/

Арга хэмжээ	2017	2018	2019	2020
Улсын төсвийн татаас	587.3	609.8	601.6	399.4
Үүнээс:				
Цэргийн тэтгэвэр	103.8	107.9	130.5	155.9
1995 оноос өмнөх	227.0	202.6	235.6	211.7
НДС-н алдагдалд	256.5	299.3	235.5	31.8

Нийгмийн даатгалын сангаас олгох бүх төрлийн тэтгэврийг инфляцтай уялдуулан нэмэгдүүлэхээр тооцож нийт 150.6 тэрбум төгрөг тусгалаа. Ингэснээр нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах 418.4 мянган хүний тэтгэвэр 8 орчим хувиар нэмэгдэнэ.

Хүснэгт №3. Тэтгэвэр нэмэгдүүлэх арга хэмжээний тооцоолол /мянган хүн, тэрбум төгрөг/

Тэтгэврийн төрөл	Хүн Тоо	Дундаж тэтгэвэр /мян ₮/		Нэмж шаардагдах
		2019	2020	
НИЙТ	418.4	375.2	405.2	150.6
Өндөр нас	307.1	382.5	412.5	110.6
Тахир дутуу	72.7	290.3	320.3	26.1
Тээж, алдсаны	20.4	298.4	328.4	7.3
Цэргийн тэтгэвэр	18.2	626.0	656.0	6.6

Тэтгэмжийн даатгалын сан



Тэтгэмжийн даатгалын сан 2020 онд 167.1 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлж, 146.1 тэрбум төгрөгийг хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, жирэмсэн, амаржсан эхийн болон оршуулгын тэтгэмжид зарцуулахаар тооцлоо.

Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийг шимтгэл төлсөн хугацаанаас нь хамааруулан хөдөлмөрийн хөлсний 50-75 хувиар олгодог бол жирэмсэн, амаржсан эхийн тэтгэмжийг 4 сарын хугацаагаар хөдөлмөрийн хөлсний 100 хувиар олгож байна. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2016 оны 16 дугаар тогтоолд нэг даатгуулагчид олгох оршуулгын тэтгэмжийг 1.0 сая төгрөгөөр тогтоосны дагуу олгож байна.

Хүснэгт №4. Тэтгэмжийн даатгалын сангийн зарлагын нөлөөлөл /мянган хүн, тэрбум төгрөг/

Тэтгэмж	2019		2020		Өөрчлөлт	
	Хүн тоо	Дүн	Хүн тоо	Дүн	Хүн тоо	Дүн
ХЧТА	139.3	18.7	153.5	28.8	14.2	10.1
Ж.А	62.7	82.3	65.2	99.3	2.5	17.0
Оршуул-гын	14.9	14.9	15.6	15.6	0.7	0.7
Нийт	216.9	115.9	234.3	143.7	17.4	27.8



ҮОМШӨ-ий даатгалын сан

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний (ҮОМШӨ) даатгалын санд 2020 онд 206.7 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого хуримтлуулж тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, сувиллын хувьсах зардал, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал,

ҮОМШӨ-ий улмаас тахир дутуу болсон иргэдийн шимтгэлийн зардалд нийт 37.7 тэрбум төгрөг зарцуулахаар тооцлоо.

Тус сангаас тахир дутуу болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах 4.9 мянган иргэнд нийт 30.0 тэрбум төгрөг, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийг сувилах сувиллын газрын тусламж үйлчилгээний хувьсах зардалд 2.0 тэрбум төгрөг, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 2.0 тэрбум төгрөг тус тус зарцуулахаар тооцлоо.

Ажилгүйдлийн даатгалын сан



Ажилгүйдлийн даатгалын санд 2020 онд 41.9 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого хуримтлагдаж ажилгүйдлийн тэтгэмж болон мэргэжил олгох давтан сургалтын зардалд 51.6 тэрбум төгрөг зарцуулахаар тооцлоо.

Тус сангаас 2020 онд ажилгүйдлийн тэтгэмж авах 24.8 мянган иргэнд 50.9 тэрбум төгрөг, мэргэжил олгох давтан сургалтын зардалд 96.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөлөө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар сарын ...ны өдөр

Улаанбаатар хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2020 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Нийгмийн даатгалын санд 2020 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, төсөв зарцуулах эрх олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хууль тогтоомж

2.1.Нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хууль тогтоомж нь Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2020 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА

3 дугаар зүйл.Нийгмийн даатгалын санд 2020 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчдын төвлөрүүлэх орлогын хэмжээг доор дурдсанаар баталсугай:

Д/д	Орлогын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	2,691,269.6
	1.1 Аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх шимтгэл	870,836.0
	1.2 Ажиллагчдаас төлөх шимтгэл	813,872.3
	1.3 Төсөвт байгууллагаас төлөх шимтгэл	244,520.3
	1.4 Эхийн хүүхэд асрах чөлөөтэй хугацааны шимтгэл	18,923.1
	1.5 Цаатан иргэдийн нийгмийн даатгалын шимтгэл	122.5
	1.6 Сайн дурын даатгуулагчаас төлөх шимтгэл	263,779.8
	1.7 Гадаадад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэдийн төлөх шимтгэл	3,059.5
	1.8 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон даатгуулагчийн төлөх шимтгэл	2,038.5
	1.9 Бусад орлого	74,700.0
	1.10 Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	399,417.6
2	Эрүүл мэндийн сайд	1,100.0
	2.1 Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох шилжүүлэг	1,100.0
Нийт орлого		2,692,369.6

4 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид доор дурдсан төсөв зарцуулах эрх олгосугай:

Д/д	Зарлагын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	2,510,688.7
	1.1 Тэтгэврийн даатгалын сан	2,252,968.7
	1.2 Тэтгэмжийн даатгалын сан	143,758.6
	1.3 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан	35,042.1
	1.4 Ажилгүйдлийн даатгалын сан	51,064.9
	1.5 Үйл ажиллагааны урсгал зардал	27,854.5
Нийт зарлага		2,510,688.7

5 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс Засгийн газрын урт хугацаат / нэг жил болон түүнээс дээш/ бонд худалдан авахад зарцуулах хөрөнгийн дээд хэмжээг 300,000.0 сая төгрөгөөр баталсугай.

6 дугаар зүйл.Энэ хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ДАГАЛДАХ ХУУЛИЙН ТӨСЛҮҮД

ТАНИЛЦУУЛГА

Нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар

Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийг Монгол Улсын Их Хурал 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдөр баталж, 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр шийдвэрлэсэн.

Тус хуулийн 5.1 дэх хэсэгт зааснаар малчин болон хувиараа хөдөлмөр эрхлэгчийн сард нөхөн төлбөл зохих тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ нь тухайн үеийн Засгийн газар болон эрх бүхий этгээдээс батлан мөрдүүлсэн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ(ХХДХ)-ний 10 хувьтай тэнцүү байхаар хуульчилсан.

Хуульд зааснаар иргэн 1995- 2020 он хүртэл хугацааны төлөгдөөгүй шимтгэлийг тухайн үеийн ХХДХ тооцон нөхөн төлнө. Тухайлбал, 1995 онд мөрдөж байсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ (9600 төгрөг)-ээс шимтгэлийг 1 жилээр нөхөн төлүүлэхэд тухайн иргэн 11 520 төгрөг нөхөн төлөхөөр байна. Харин ирэх 2020 онд сайн дурын даатгуулагч ХХДХ болох 420 000 төгрөгөөс 10 хувиар тооцож жилд 504 000 төгрөг төлөхөөр байна. Тухайн үед мөрдөгдөж байсан ХХДХ-ээр тооцож шимтгэл нөхөн төлөх нь ойрын ирээдүйд авах тэтгэврийн зардал болон мөнгөний үнэ цэний өөрчлөлттэй харьцуулахад хэт бага юм. Нөгөөтээгүүр, шимтгэлээ зохих журмын дагуу тухай бүр төлж байсан сайн дураар даатгуулагчтай харьцуулахад шударга бус, давуу байдал үүсгэхээр байна.

Иймд мөнгөний үнэ цэний өөрчлөлт, ирээдүйд төлөх тэтгэврийн зардлын өсөлт, шимтгэлээ тухай бүр төлж байгаагүй хувь хүний хариуцлага зэргийг харгалзан малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх доод цалингийн хязгаарыг эрх бүхий байгууллага болох Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооноос хамгийн сүүлд тогтоосон хэмжээг баримтлахаар хуулийн өөрчлөлтийн төслийг боловсрууллаа.

Хуулийн өөрчлөлтийг хэрэгжүүлснээр иргэн нэг сарын 42 000 төгрөг, жилийн 504 000 төгрөгийн шимтгэл нөхөн төлнө.

Дээрх өөрчлөлттэй уялдуулан уг хуульд дараахь зохицуулалт хийхээр тусгав. Үүнд:

1/ Нөхөн төлөх шимтгэл тооцох доод цалинг 2000 оноос өмнө Засгийн газраас тухай бүр тогтоож байсан ХХДХ-ээр бус харин нэг тогтмол буюу хамгийн сүүлд тогтоосон хэмжээнээс тооцох өөрчлөлт хийж байгаатай уялдуулан хуулийн 3.1.3 дахь заалтаас “тухайн үед мөрдөгдөж байсан” гэснийг “эрх бүхий этгээдээс 2020 онд мөрдүүлэхээр тогтоосон” гэж өөрчлөхөөр тусгав;

2/ Шимтгэл нөхөн төлөх арга хэмжээг улсын хэмжээнд нэг удаа явуулах зорилгоор хуулийн үйлчлэх хугацааг нэг жил буюу 2020 оны 01 дүгээр сарын 01-ээс

2021 оны 1 дүгээр сарын 01 хүртэл байхаар тооцов. Үүнтэй уялдуулан тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай ижил харилцааг зохицуулж байсан 2012 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийг хүчингүй болгох хуулийн төслийг тусад нь боловсруулав;

3/. Нийгмийн халамжийн болон цэргийн тэтгэвэр тогтоолгосон, мөн нийгмийн даатгалын хувь тэнцүүлсэн тэтгэвэр тогтоолгосон иргэд шимтгэл нөхөн төлж нийгмийн даатгалын бүрэн тэтгэвэрт шилжих боломжтой байна. Энэ тохиолдолд тэтгэврийн сангийн ачаалал эрс нэмэгдэх тул шимтгэл нөхөн төлөх арга хэмжээний хамрах хүрээнд хязгаарлалт хийх буюу нэгэнт өмнө нь хуулиар тэтгэвэр тогтоолгосон иргэдийг хамруулахгүй байх нэмэлтийг хуульд оруулахаар тусгасан;

Хуульд нэмэлт, өөрчлөлт орсноор 2020 онд 88.0 мянган малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч тэтгэврийн даатгалын санд 133.1 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж 42.0 мянган хүний тэтгэвэрт 65.1 тэрбум төгрөг зарцуулна. Хэрэв ХХДХ г тухайн үед тогтоосон хэмжээгээр хэвээр үлдээх тохиолдолд Тэтгэврийн даатгалын сангийн тооцоолсон орлого 70.0 тэрбум төгрөгөөр буурах ба энэ хэмжээгээр тэтгэврийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдана.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Малчны нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлээр дараах хуулиуд батлагдаад байна. Үүнд:

1/ Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар иргэний малчнаар ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн нэг жилийг нэг жил зургаан сараар тооцож 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр болсон.

2/ Мөн дээрх хуулиар малчны өндөр насны тэтгэвэр тогтоолгох насыг 5 жилээр наашлуулж малчин эрэгтэй 55 нас, эмэгтэй 50 нас хүрсэн бол тэтгэвэр тогтоолгох эрхтэй байх заалтыг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн.

3/Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн 1995 оноос хойших төлөөгүй хугацааны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлэх хууль 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжинэ.

Түүнчлэн, эхчүүдийн нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлээр Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хуулиар дараах өөрчлөлт хийгдсэн. Үүнд:

1/ Төрүүлсэн болон гурав хүртэл настайд нь үрчлэн авч зургаан нас хүртэл хүүхдээ өсгөсөн эхийн НДШ төлсөн нийт хугацаан дээр төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэд бүрийн тоогоор нэг жил зургаан сарыг нэмж тооцох;

2/ нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан эхийн жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг цалин хөлснийх нь 70 хувиар тооцож байсныг 100 хувиар тооцож олгох;

2/ Сайн дураар даатгуулсан эхийн хүүхдээ асрах хугацаанд төлбөл зохих шимтгэлийг өөрөө хариуцаж байсныг 100 хувь тэтгэмжийн даатгалын сангаас төлөх;

3/ нийгмийн даатгалд даатгуулаагүй эх хүүхдээ асрах хугацаанд төлбөл зохих шимтгэлийн 50 хувийг өөрөө, үлдэх 50 хувийг төрөөс.

Малчид болон эхчүүдэд олгосон дээрх хөнгөлөлтүүд нь улсын төсөв болон тэтгэмжийн даатгалын сангийн ачааллыг нэмэгдүүлэх, тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ нь даатгуулагчийн авч байсан цалин хөлс, төлсөн шимтгэлийн хэмжээ, хугацаатай уялдаатай байх зарчим алдагдах зэрэг сөрөг үр дагавар гарахаар байна.

Иймд малчны малчнаар ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн нэг жилийг нэг жил 6 сараар тооцох заалтыг хүчингүй болгох, сайн дураар даатгуулсан эхийн хүүхдээ асрах чөлөөтэй байх хугацааны тэтгэвэр, тэтгэмжийн төлбөл зохих шимтгэлийн 50 хувийг тэтгэмжийн даатгалын сангаас, 50 хувийг эх өөрөө хариуцан төлөхөөр Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл батлагдсанаар малчид болон эхчүүдийн нийгмийн хамгааллын баталгаа буурахгүй бөгөөд хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт нь нийгмийн даатгалын зарчимд нийцэх болно.

Хөнгөлөлттэй нөхцөлөөр эрт тэтгэвэр тогтоолгосон зарим эхчүүд, эмэгтэйчүүдийн тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл

Улсын Бага Хурлаас 1990 оны 11 дүгээр сард “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Тэтгэврийн хууль”-ийг шинэчлэн баталсан бөгөөд энэхүү шинэчлэлийн нэг өөрчлөлт нь эмэгтэйчүүдийг онцгойлон үзэж хөнгөлөлттэй нөхцөлөөр эрт тэтгэвэр тогтоолгох эрхийг хуульчилсан явдал байв.

Энэхүү хуулиар төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авсан дөрөв ба түүнээс дээш хүүхдээ 6 настай болтол нь өсгөсөн эх 20-иос доошгүй жил ажилласан бол нас харгалзахгүй тэтгэвэр тогтоох болзлыг шинээр оруулснаар 1991 онд 32.8 мянган эх насны тэтгэвэр тогтоолгож, тэдэнд 178.5 сая төгрөг зарцуулсан байна.

Мөн хуульд зарим иргэдийн тэтгэвэр тогтоолгох насыг наашлуулсан өөрчлөлт орсон ба улсад 27 жил ажилласан эмэгтэйчүүд өөрсдөө хүсвэл нас харгалзахгүйгээр тэтгэвэр тогтоолгох эрхтэй болсноор 1991 онд 19.3 мянган хүн шинээр тэтгэвэр тогтоолгон тэдэнд 134.2 сая төгрөгийн тэтгэврийг тухайн үед олгосон байна.

Нийгмийн даатгалын багц хууль 1994 онд хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор “Хүн амын нийгмийн хамгааллын талаар авах арга хэмжээний тухай” УИХ-ын 1997 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 5 дугаар тогтоолоор 1995 оноос өмнө Тэтгэврийн хуулиар насны тэтгэвэр тогтоолгосон бөгөөд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасан тэтгэврийн насны болзол, нөхцөлийг хангаагүй 44.4 мянган иргэдийн тэтгэврийг түдгэлзүүлж, авч байгаа тэтгэвэр,

нөхвөрийн нийлбэрийн хэмжээтэй тэнцэх “нөхөн олговор”-ыг тэдний өндөр насны тэтгэврийн эрх үүсэх хүртэлх хугацаанд хөдөлмөр зохицуулалтын албадаар дамжуулан сар бүр олгох шийдвэрийг гаргасан юм.

Үүнээс хойш 2017 он гэхэд дээр дурдсан 44.4 мянган иргэн өндөр насны тэтгэврийн насанд хүрснээр нийгмийн даатгалын тэтгэвэрт бүрэн шилжиж дууссан.

Эдгээр иргэдээс өнөөдөр 21.2 мянган хүн иргэн нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авч байгаа бөгөөд эдгээрийн 14.4 мянга буюу 67.9 хувь нь олон хүүхэд төрүүлсэн эхчүүд, 3.8 мянга буюу 17.9 хувь нь 27 жил ажиллан нас харгалзахгүй тэтгэвэр тогтоолгосон эмэгтэйчүүд байна.

Хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагчдын 4.8 мянга нь бүрэн тэтгэврийн доод хэмжээ /310.0 мянган төгрөг/-ний, 12.2 мянга нь 310.0-400.0 мянган төгрөгийн хооронд тэтгэвэр авч байна.

Энэ нь олон хүүхэд төрүүлсэн эхчүүд, эмэгтэйчүүд ажилласан жил цөөн, тэтгэвэр тогтоолгосон цалингийн хэмжээ бага байгаа нь тэтгэврийн зөрүү үүсэх нэг шалтгаан болж байгаа тул тэдний одоо авч байгаа сарын тэтгэврийн хэмжээг 50.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэх хуулийн төслийг боловсруулав.

Дээрх тэтгэвэр авагчдын тэтгэврийн хэмжээг 50.0 мянган төгрөгөөр, нэмэгдүүлэхэд жилд 12.7 тэрбум төгрөгийн нэмэлт санхүүжилт шаардлагатай.

САНГИЙН ЯАМ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны . . . дугаар
сарын . . .-ны өдөр

Улаанбаатар
хот

**МАЛЧИН, ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИЙН ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН
ШИМТГЭЛИЙГ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн “эрхэлж байсан” гэсний дараа “, хуульд заасан өндөр насны тэтгэвэр тогтоолгоогүй” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн зарим хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг:

“5.1.Энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан иргэний сард нөхөн төлөх нөхөн төлбөл зохих тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ нь эрх бүхий этгээдээс 2020 онд мөрдүүлэхээр тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 10 хувьтай тэнцүү байна.”

2/ 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг:

“8.1. Энэ хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл дагаж мөрдөнө.”

3 дугаар зүйл. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтын “тухайн үед мөрдөгдөж байсан” гэснийг “эрх бүхий этгээдээс 2020 онд мөрдүүлэхээр тогтоосон” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

**АЖИЛЛАСАН ЖИЛ, ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ
НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД
ТООЦОХ ТУХАЙ**

2019 оны . . . дугаар
сарын . . .-ны өдөр

Улаанбаатар
хот

1 дүгээр зүйл. 2012 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр баталсан Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны . . . дугаар
сарын . . .-ны өдөр

Улаанбаатар хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдөр баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн “19² дугаар зүйлийн” гэсний өмнө “3 дугаар зүйлийн 4 дэх хэсэг,” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдөр баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн “2/нийгмийн даатгалд сайн дураараа даатгуулсан эх энэ хуулийн 19¹ дүгээр зүйлд заасан тэтгэмж авах эрх үүссэн бол тэтгэмжийн даатгалын сангаас;” гэснийг “2/ нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан, энэ хуулийн 19¹ дүгээр зүйлд заасан тэтгэмж авах эрх үүссэн эхийн төлбөл зохих шимтгэлийн 50 хувийг тэтгэмжийн даатгалын сангаас, 50 хувийг эх өөрөө” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдөр баталсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 3 дугаар зүйлийн “4 дэх хэсгийн “хоёр сараар” гэснийг “зургаан сараар” гэж,” гэснийг хассугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХӨНГӨЛӨЛТТЭЙ НӨХЦӨЛӨӨР ЭРТ ТЭТГЭВЭР ТОГТООЛГОСОН ЗАРИМ ЭХЧҮҮД, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭГ НЭМЭГДҮҮЛЭХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1990 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр баталсан БНМАУ-ын Тэтгэврийн хуульд заасан дор дурдсан болзол, нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгосон эхчүүд, эмэгтэйчүүдийн сарын тэтгэврийн хэмжээг нэг удаа 50 000 төгрөгөөр нэмэгдүүлнэ:

1.1. Төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авсан дөрөв, түүнээс дээш хүүхдээ 6 нас болтол нь өсгөсөн, 15-аас доошгүй жил ажиллаж 50 насанд хүрсэн нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгосон эх;


1.2. Төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авсан дөрөв, түүнээс дээш хүүхдээ 6 настай болтол нь өсгөсөн, 20-иос доошгүй жил ажиллаж, нас харгалзахгүй нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгосон эх;

1.3. Нийтдээ 27-оос дээш жил ажиллаж нас харгалзахгүй нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгосон эмэгтэй.


2 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан тэтгэврийн нэмэгдлийг тооцож олгох журмыг Засгийн газар батална.


3 дугаар зүйл. Энэ хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ



**4.ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН
2020 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСӨЛ, ТАНИЛЦУУЛГА**





ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2020 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Хууль зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 4.1.51-д “Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв гэж Нийгмийн даатгалын тухай, Эрүүл мэндийн даатгалын хуулийн дагуу бүрдүүлж, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу зарцуулах, тухайн жилд Улсын Их Хурлаас баталсан төсвийг” гэж, мөн хуулийн 10.1.3-т “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж, мөн хуулийн 8.4.8-д “Улсын Их Хурал жилийн төсвийн төслийг хэлэлцэн жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор батлах” гэж, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9.1.9-д “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх зарим сэргээн засах үйлчилгээ, өдрийн эмчилгээ, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, оношилгоо, шинжилгээ”-г эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцна гэж тус тус заасан нь Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Практик шаардлага

1. Эрүүл мэндийн даатгалын бие даасан байгууллага байгуулж, даатгуулагч төвтэй тогтолцоо бий болгох замаар даатгуулагчид чанартай, хүртээмжтэй тусламж үйлчилгээг хүргэх зорилт Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрт тусгагдсан.

Энэхүү зорилтыг хэрэгжүүлэхийн тулд нэгдүгээрт, эрүүл мэндийн салбарт зориулсан нөөцийг хангалттай хэмжээнд нэмэгдүүлэх; хоёрдугаарт, хувь хүн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахад өөрөөсөө төлдөг шууд төлбөрийн хэмжээг багасгах, эрүүл мэндийн тусламж авахад саад болж байгаа санхүүгийн дарамтыг арилгах; гуравдугаарт, Эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалтыг илүү үр ашигтай, тэгш болгох шаардлага бий болоод байна.

2. Хүн амын өсөлтөөс үүдэлтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өргөжилт, эрэлт хэрэгцээ болон эмчилгээ үйлчилгээ, эмийн үнэ ханшийн өөрчлөлтөөс шалтгаалан эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх төрийн болон төрийн бус өмчийн эрүүл мэндийн байгууллагуудад олгох зардлын хэмжээг нэмэгдүүлэх шаардлага бий болоод байна.

Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төсөл 2 бүлэг, 5 зүйлтэй байх бөгөөд доор дурдсан агуулгатай байна.
Үүнд:

Нэгдүгээр бүлэгт: Хуулийн нийтлэг үндэслэл, зорилт, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хууль тогтоомжийн тухай;

Хоёрдугаар бүлэгт: Эрүүл мэндийн даатгалын санд 2020 оны төсвийн жилд Төсвийн ерөнхийлөн захирагчийн төвлөрүүлэх орлогын хэмжээ, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчийн зарцуулах төсвийн эрхийн хэмжээ болон хуулийг дагаж мөрдөх хугацааг тус тус тусгана.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн дагуу 2020 оны төсвийн жилд эрүүл мэндийн даатгалын сан бие даасан хэлбэрээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлж Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилт биелж, эрүүл мэндийн даатгалын сангийн эх үүсвэрийг бүрдүүлж зарцуулах эрх зүйн орчин бүрдэнэ.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай, Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулна. Хуулийн төслийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн төсөл боловсруулах шаардлагагүй болно.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2020 ОНЫ ТӨСВИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА



Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны орлого 2019 оны төлөвлөгөөтэй харьцуулахад 98.9 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр тооцож 2020 онд нийт 506.5 тэрбум төгрөг байхаар төсөвлөлөө. Үүнээс: 68.1 хувь буюу 345.0 тэрбум төгрөгийг ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн орлогоос, 16.6 хувь буюу 84.1 тэрбум төгрөгийг шимтгэлийг нь төр хариуцах иргэдийн шимтгэлийн орлогоос, 3.8 хувь буюу 19.4 тэрбум төгрөгийг шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг даатгуулагчийн шимтгэлийн орлогоос, 11.4 хувь буюу 58.0 тэрбум төгрөгийг бусад орлого буюу чөлөөт үлдэгдлийг банканд хадгалуулсны хүүгийн орлого, эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөх хугацаа хэтрүүлсэнд ногдуулсан алдангийн орлогоос бүрдүүлэхээр тус тус төлөвлөв.

Эрүүл мэндийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг зохистой удирдах, тухайн жилд санд төвлөрсөн шимтгэлийн орлогыг даатгуулагчид бүрэн зориулах зорилгоор сангийн орлого, зарлагыг тэнцүү байхаар 2020 онд сангийн зарлагыг 506.5 тэрбум төгрөгөөр төсөвлөлөө. Үүнээс : 58.8 хувь буюу 297.7 тэрбум төгрөгийг төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудад, 33.3 хувь буюу 168.8 тэрбум төгрөгийг төрийн бус өмчийн эрүүл мэндийн байгууллагуудад, 6.6 хувь буюу 33.3 тэрбум төгрөгийг эмийн сангуудад, 1.1 хувь буюу эрүүл мэндийн даатгалын сангийн үйл ажиллагааны зардалд, 0.1 хувь буюу 0.03

тэрбум төгрөгийг бусад зардалд зарцуулахаар тус тус төлөвлөв.

Хүснэгт. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлага /тэрбум төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2019 төсөв	2020 төсөл
ОРЛОГО	407.7	506.5
Аж ахуйн нэгжээс төлөх шимтгэл	100.6	133.6
Даатгуулагчаас төлөх шимтгэл	122.5	158.2
Төсөвт газраас төлөх шимтгэл	44.5	53.2
Төр хариуцах иргэдийн шимтгэл	83.9	84.1
Бусад даатгуулагчаас төлөх	16.8	19.4
Бусад орлого	39.3	58.0
ЗАРЛАГА	407.7	506.5
Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудад олгох	253.3	297.7
Үүнээс: Улсын төсөвт	244.6	246.3
Аж ахуйн тооцоот	-	42.6
Сум, тосгоны ЭМТ	8.7	8.7
Төрийн өмчийн бус эрүүл мэндийн байгууллагад олгох	114.7	168.8
Эмийн санд олгох	33.9	33.3
Үйл ажиллагааны зардал	5.4	5.4
Бусад	0.03	0.03
ТЭНЦЭЛ	-	-



Төр, хувийн хэвшлийн эмнэлэгт олгох тарифыг адил болгоно. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 3.1.16-д “Төр хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн даатгалын сангаас олгох зардлын ялгааг үе шаттайгаар арилгах” 3.1.17-д “Төр, хувийн хэвшлийн эмнэлэгт хийгдэх өндөр өртөгтэй мэс заслын эмчилгээний төлбөрийн зардалд эрүүл мэндийн даатгалын сангаас олгох

санхүүжилтийг үе шаттайгаар нэмэгдүүлэх” 3.3.20-д “Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний салбарт төр хувийн хэвшлийн түншлэлд суурилсан хамтын ажиллагааг өрнүүлэх...” гэсэн зорилтуудыг хэрэгжүүлэхээр заасан.

Ирэх 2020 онд төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын ЭМД сангаас санхүүжих тусламж үйлчилгээний тарифын ялгавартай байдлыг арилгаж, нэмэгдүүлэхээр төлөвлөлөө. Ингэснээр иргэд төрийн болон хувийн хэвшлийн эмнэлгийн эмчилгээ үйлчилгээний чанарыг харгалзан сонголт хийх боломжтой болох бөгөөд эмнэлгүүд өрсөлдөөний зарчмаар тусламж үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар сарын ...ны өдөр

Улаанбаатар хот

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2020 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Эрүүл мэндийн даатгалын санд 2020 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, төсөв зарцуулах эрх олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хууль тогтоомж

2.1.Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хууль тогтоомж нь Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2020 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА


3 дугаар зүйл.Эрүүл мэндийн даатгалын санд 2020 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчдын төвлөрүүлэх орлогын хэмжээг доор дурдсанаар баталсугай:

Д/д	Орлогын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	Эрүүл мэндийн сайд	506,538.3
	1.1 Аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх шимтгэл	133,598.5
	1.2 Ажиллагчдаас төлөх шимтгэл	158,202.3
	1.3 Төсөвт байгууллагаас төлөх шимтгэл	53,214.3
	1.4 Төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь хариуцах иргэдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэл	84,144.4
	1.5 Бусад даатгуулагчаас төлөх шимтгэл	19,425.8
	1.6 Бусад орлого	57,953.1
	Нийт орлого	506,538.3


4 дүгээр зүйл.Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид доор дурдсан төсөв зарцуулах эрх олгосугай:

Д/д	Зарлагын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	Эрүүл мэндийн сайд	506,538.3
	1.1 Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудад олгох	297,682.6
	Үүнээс: 1.1.1 Улсын төсөв	246,345.9
	1.1.2 Аж ахуйн тооцоот	42,629.4
	1.1.3 Сум, тосгоны эрүүл мэндийн төв	8,707.3
	1.2 Хувийн эмнэлэгт олгох	168,798.5
	1.3 Эмийн санд олгох	33,278.8
	1.4 Үйл ажиллагааны урсгал зардал	5,438.4
	1.5 Нийгмийн даатгалын байгууллагад олгох	1,100.0
	1.6 Бусад	240.0
	Нийт зарлага	506,538.3

5 дугаар зүйл.Энэ хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.



**5. ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН
ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН
НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ, ТАНИЛЦУУЛГА**





ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1. Хууль зүйн үндэслэл шаардлага

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 51 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.3.3 дахь дэд заалтад “Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтыг ил тод, хяналттай болгох,” гэж, мөн “Засгийн газрын тусгай сангуудын талаар авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 87 дугаар тогтоолоор Засгийн газрын тусгай сангийн тухай хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулахаар тусгагдсан.

1.2. Практик шаардлага

Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Засгийн газрын тусгай сангийн тухай хууль 2006 онд батлагдсан бөгөөд батлагдснаас хойш нийт 52 удаа нэмэлт, өөрчлөлт орсон. Уг хуулиар өнөөдрийн байдлаар нийт 29 тусгай санг байгуулан үйл ажиллагааг нь зохицуулж байна.

Сангийн яамнаас Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Тариаланг дэмжих сан, Мал хамгаалах сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Боловсролын зээлийн сан болон Авто замын сангийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийсэн ба Засгийн газрын бусад тусгай сангийн үйл ажиллагааг өмнөх онуудад хийгдсэн шалгалтын тайлан, төсвийн гүйцэтгэл зэрэгт үндэслэн судалсан. Засгийн газрын тусгай сангуудад хийсэн шалгалт, судалгааны үр дүнд зөрчилтэй олон асуудал үүссэн байх бөгөөд тодруулбал, зарим тусгай сангийн чиг үүрэг давхцалтай, эх үүсвэрийг зориулалтын бусаар ашигласан, түүнд тавих хяналтын чиг үүргийг хэрэгжүүлээгүй, сангийн хөрөнгийг үндэслэлгүй, хууль зөрчиж зарцуулсан зэрэг нийтлэг зөрчил гарсан байна.

Тухайлбал, зээл, татаас, урамшуулал олгодог сангууд болох Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Тариаланг дэмжих сан, Мал хамгаалах сангуудын зээл, санхүүгийн дэмжлэг нь хугацаандаа эргэн төлөгддөггүй, хугацаа хэтэрсэн өр төлбөртэй, өр төлбөрийг барагдуулах чиглэлээр ажилладаггүй, тодорхой төсөл арга хэмжээг сонгон шалгаруулалтгүй явуулсан, олон нийтийн хяналтгүй зээл олгодог, хоорондоо уялдаа холбоо муутай ажилладгаас үүдэн өөр өөр сангаас давхардуулан зээл олгосон, үйл ажиллагаандаа баримталж байгаа журам, дүрэм нь тодорхойгүй, эсхүл хүчингүй болсон зэрэг зөрчил, дутагдал үүссэн байна.

Тухайлбал, 2018 оны 9 дүгээр сарын 31-ний байдлаар Тариаланг дэмжих сангийн нийт өглөг 141.1 тэрбум төгрөг, авлага 131.9 тэрбум төгрөг байгаагаас хугацаа хэтэрсэн найдваргүй зээл 72.1 тэрбум төгрөг байна. Мал хамгаалах сангийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар нийт 29.9 тэрбум төгрөгийн зөрчил илэрсэн байна.

Иймд үйл ажиллагааны давхардлыг арилгах, иргэд, аж ахуйн нэгжид хүртээмжтэй болгох, үргүй зардлыг бууруулах, хяналт хариуцлагын тогтолцоог сайжруулах зорилгоор Тариаланг дэмжих сан, Мал хамгаалах санг татан буулгаж, хөрөнгийн эх үүсвэр, өмнө үүссэн өр, авлагыг нь одоогийн Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд шилжүүлж, үйл ажиллагааг сайжруулан, нэгтгэх байдлаар зохион байгуулах нь зүйтэй байна.

Мөн зарим сан огт үйл ажиллагаа явуулж байгаагүй, цаашид ашиглах боломжгүй, түүнчлэн бие даасан сан байх шаардлагагүй, тухайн чиг үүргийг төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт төсөл, хөтөлбөр хэлбэрээр хэрэгжүүлэх боломжтой зэрэг асуудал гарсан. Эдгээр санд Үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан, Олон улсын хамтын ажиллагааны сан, Монгол судлалыг дэмжих сан, Ирээдүйн тэтгэврийн нөөц сан, Эрсдэлийн сан, Засгийн газрын өрийн баталгааны сан, Агаарын бохирдлын эсрэг сан тус тус орж байна. Иймд эдгээр санг хаах буюу татан буулгах шаардлага үүссэн байна.

Дээр дурдсан тусгай сангуудаас гадна нийт тусгай сангуудын хөрөнгийн зарцуулалт, ажлын албаны үйл ажиллагаанд тавих хяналтыг боловсронгуй болгож, олон нийтэд нээлттэй, ил тод байх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зохицуулалтыг тусгаж мөрдүүлэх шаардлагатай байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д заасны дагуу хуулийн хэрэгцээ, шаардлагыг тандан судлахад эдгээр зөрчил, хийдлийг зөвхөн хуульд өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх боломжтой байна. Одоо хэрэгжиж байгаа Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн нийт заалтын 50-аас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орсон байх тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-т заасан үндэслэлээр хуулийн төслийг шинэчлэн найруулах нөхцөл бүрдсэн байна.

Хоёр. Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийн зорилго нь Засгийн газрын тусгай сангуудын чиг үүргийн давхардлыг арилгах, шаардлагагүй тусгай сангуудыг татан буулгах, зарим санг нэгтгэх, тэдгээрийн үйл ажиллагаа, удирдлагыг боловсронгуй болгож, ил тод байдал, хяналтыг сайжруулахад чиглэгдэнэ.

Хуулийн төсөл нь 6 бүлэгтэй байх бөгөөд доор дурдсан асуудлыг зохицуулна. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт Хуулийн зорилт, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль тогтоомж, нэр томъёоны тодорхойлолт болон хуулийн үйлчлэх хүрээг нарийвчлан тодорхойлно;

Хоёрдугаар бүлэгт Засгийн газрын тусгай сан, түүний төрлийг шинэчлэн тогтооно;

Гуравдугаар бүлэгт Засгийн газрын тусгай сангийн нийтлэг эх үүсвэрийг тусгана. Мөн тусгай сан тус бүрийн зориулалтыг нарийвчлан зохицуулж, тэдгээрийн эх үүсвэрийг бүрдүүлэх, хөрөнгийг зарцуулах үндэслэлийг тогтооно;

Дөрөвдүгээр бүлэгт Засгийн газрын тусгай сангаас санхүүжилт олгох хэлбэр, журмыг нарийвчлан зохицуулна;

Тавдугаар бүлэгт Засгийн газрын тусгай сангийн тайлагнал, ил тод байдал, хяналт тавих асуудлыг зохицуулна;

Зургаадугаар бүлэгт Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагаанд хориглох зүйл, хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага зэргийг тус тус тусгана.

Гурав. Хууль батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар Засгийн газрын тусгай сангуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, түүний зарцуулалтыг оновчтой, үр ашигтай, хүртээмжтэй бөгөөд ил тод болох, хяналт хариуцлагын тогтолцоо сайжирч, төсвийн сахилга бат улам нэмэгдэх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зэрэг нийгэм, эдийн засаг, хууль зүйн эерэг үр дагавар бий болно гэж үзэж байна.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомж

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах бөгөөд хуулийн зөрчил, хийдэл үүсэхгүй болно.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан Засгийн газрын тусгай сангийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Агаарын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Тариалангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай зэрэг хуулийн төслийг дагалдуулан боловсруулна.

---oOo---

ТАНИЛЦУУЛГА

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийг Монгол Улсын Их Хурлаас 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр баталсан бөгөөд түүнээс хойш нийт 52 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна. Өнөөдрийн байдлаар нийт 29 тусгай сан байгаа бөгөөд эдгээрээс 19 сангийн үйл ажиллагааг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар, бусад 10 сангийн үйл ажиллагааг тусдаа хуулиар зохицуулж байна.

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 51 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн 4.1.3.3 дахь дэд заалтад “Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтыг ил тод, хяналттай болгох,” гэж заасан бөгөөд “Засгийн газрын тусгай сангуудын талаар авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 87 дугаар тогтоолоор Засгийн газрын тусгай сангийн тухай хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, хэлэлцүүлэх асуудлыг чиглэл болгосон.

Энэ хүрээнд Сангийн яамнаас тусгай сангуудын санхүүгийн үйл ажиллагаанд газар дээрх хяналт, шалгалтыг гүйцэтгэж цөөнгүй зөрчил, дутагдал илрүүлсэн.

Засгийн газрын тусгай сангуудын үйл ажиллагаанд хийсэн шалгалт, судалгааны үр дүнгээр тусгай сангийн үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх, зөрчил дутагдлыг арилгах, ил тод хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх зорилгоор хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох зайлшгүй хэрэгцээ, шаардлага үүсч байна.

Иймд Засгийн газрын нийт тусгай сангуудын хөрөнгийн зарцуулалт, ажлын албаны үйл ажиллагаанд тавих хяналтыг боловсронгуй болгож, олон нийтэд нээлттэй, ил тод, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх асуудлыг зохицуулах, түүнчлэн огт үйл ажиллагаа явуулж байгаагүй, цаашид ашиглах боломжгүй, бие даасан сан байх шаардлагагүй сангуудыг татан буулгах, нэгтгэн зохион байгуулах болон Засгийн газрын тусгай сан, бусад төсвийн хөрөнгөөр санхүүждэг сан, төсөл, хөтөлбөрүүдийн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, эрсдэлийг бууруулах, хяналт, үр нөлөөг дээшлүүлэх талаарх зохицуулалтыг тусган Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсрууллаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлагын 30 орчим хувийг эзэлж байгаа Засгийн газрын тусгай сангуудын үйл ажиллагааг цэгцэлж, оновчтой зохион байгуулснаар төсвийн сахилга батыг нэмэгдүүлж, тусгай сангуудын эдийн засаг, нийгэмд үзүүлэх үр нөлөө дээшлэх ач холбогдолтой байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар дор дурдсан асуудлууд шийдэгдэх боломжтой болно:

-Мал хамгаалах сан, Тариаланг дэмжих сан, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангуудыг нэгтгэн зохион байгуулж, Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих сан

болгох бөгөөд Мал хамгаалах сан, Тариаланг дэмжих сангийн холбогдох зохицуулалтыг нь Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зохицуулалттай нэгтгэж тусгасан. Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих сангаас жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх, газар тариалан, мал аж ахуй эрхлэлтийг дэмжих зориулалтаар хөнгөлөлттэй зээл олгох, жижиг дунд үйлдвэрлэл, газар тариалан, мал аж ахуй эрхлэхэд бизнес инкубацийн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, сургалт, давтан сургалтад хамруулах зэрэг ажиллагааг санхүүжүүлнэ;

-Засгийн газрын тусгай сан, бусад төсвийн хөрөнгөөр санхүүждэг сан, төсөл, хөтөлбөрүүдийн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, эрсдэлийг бууруулах, хяналт, үр нөлөөг дээшлүүлэх талаарх зохицуулалтыг хуульд тусгасан. Тухайлбал, шаардлага хангасан банкаар дамжуулан зээл, санхүүжилтийг олгож байх, иргэд, хуулийн этгээдийн бизнес төлөвлөгөөтэй танилцах, тэдгээрийг сонгон шалгаруулах, үнэлэх үйл явцыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нээлттэй, ил тод зохион байгуулах, шинээр олгох зээлийн эх үүсвэрийн хэмжээ, сонгон шалгаруулалтын журам, тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг цахим хуудсаар дамжуулан мэдээлж, мэдээллийг тогтмол шинэчлэх зэрэг асуудал тодорхой зохицуулагдана;

-Засгийн газрын тусгай сангийн төрлүүдийг шинэчлэн тогтоож, тусгай сангийн нийтлэг эх үүсвэрийг шинэчлэн тодорхойлох бөгөөд үйл ажиллагаа явуулдаггүй, эсхүл тусдаа сан байх шаардлагагүй Үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан, Олон улсын хамтын ажиллагааны сан, Монгол судлалыг дэмжих сан, Ирээдүйн тэтгэврийн нөөц сан, Эрсдэлийн сан, Засгийн газрын өрийн баталгааны сан, Агаарын бохирдлын эсрэг сан гэсэн 7 тусгай сан татан буугдана;

-Киног урлагийг дэмжин хөгжүүлэх, дэлхийн зах зээл дээр гарган өрсөлдүүлэх замаар үндэсний түүх, өв соёл, ёс заншлаа дэлхийд сурталчлан таниулах, кино уран бүтээлчдийн хөгжлийг дэмжих, кино үйлдвэрлэлийг шинэ шатанд гарган хөгжүүлэх, үүнд чиглэсэн техник технологийг нэвтрүүлэх зорилгоор Кино урлагийг дэмжих санг шинээр нэмж байгуулна;

-Тусгай сангийн хяналт, олон нийтийн оролцоо, зарцуулалтын тайлагналын зохицуулалт боловсронгуй болж, зээлийн санхүүжилтийг төслийн хэрэгжилттэй холбож олгох буюу зээлдэгчийн худалдан авалт, төслийн гүйцэтгэлээр олгох, тусгай сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ сонгон шалгаруулах хороо, төслийн удирдах хороо болон хяналтын хорооны бүрэлдэхүүнд төрийн бус байгууллага, мэргэжлийн байгууллагын төлөөллийг оролцуулах бөгөөд тусгай сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагаанд хяналт тавихад олон нийтийн оролцоо хангагдах боломжтой болно.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах хүрээнд хөнгөлөлттэй зээл, санхүүжилт олгох замаар жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сайн туршлагыг хэрэгжүүлж байгаа улсууд болох Япон болон Бүгд Найрамдах Солонгос Улсын туршлагыг сонгон авч, олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгааг хийсэн болно.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах хүрээнд төрийн болон мэргэжлийн байгууллага, төслийн нэгжүүдийг оролцуулсан олон нийтийн хэлэлцүүлгийг танхимын болон цахим хэлбэрээр зохион байгуулж, холбогдох байгууллага, хуулийн этгээд, иргэдийн саналыг авч тусгасан.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсантай холбогдуулан Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Агаарын тухай хуулийн зүйлийг хүчингүй болсонд тооцох тухай, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тариалангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ойн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тамхины хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон Засгийн газрын тусгай сангийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүдийг тус тус боловсрууллаа.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН¹

Засгийн газрын тусгай сангийн тухай

Ерөнхий мэдээлэл:

Засгийн газрын тусгай сангийн (“ЗГТС”) тухай хуулийг 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр баталсан бөгөөд батлагдсан цагаас хойш нийт 52 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна. Засгийн газрын тодорхой чиг үүрэг, зорилтыг санхүүжүүлэх зорилгоор улсын нэгдсэн төсвөөс төвлөрүүлсэн хөрөнгө, түүнчлэн уг арга хэмжээнд зориулан олгосон хандив, буцалтгүй тусламжийн орлогыг Засгийн газрын тусгай сан /цаашид “Тусгай сан” гэх/ гэх ба ЗГТС тухай хуулиар өнөөдрийн байдлаар нийт 29 тусгай сан байна. Эдгээрээс 10 сангийн үйл ажиллагааг тусдаа хуулиар зохицуулж байна.

Тусгай сангуудын үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор 2018 онд 3.2 их наяд төгрөгийн төсөв батлагдаж байсан бол 2019 онд 3.6 их наяд төгрөг болж, даруй 400 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. /Үүнд: Ирээдүйн өв сан болон Төсвийн тогтворжуулалтын санд төвлөрөх орлогыг оруулж тооцоогүй болно/

Сангийн яамнаас Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Тариаланг дэмжих сан, Мал хамгаалах сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Боловсролын зээлийн сан, болон Гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгох сан, Авто замын сангуудын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт² хийсэн ба бусад 22 Засгийн газрын тусгай сангуудын үйл ажиллагааг өмнөх онуудад хийгдсэн шалгалтын тайлан, төсвийн гүйцэтгэл зэрэгт үндэслэн судалсан.

Дээрх шалгалт, судалгааны үр дүнд үндэслэн эдгээр болон бусад тусгай сангийн үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх, зөрчил дутагдлыг арилгах, ил тод хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх зорилгоор хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага байгаа юм.

Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-д тухайн хуулийн нийт заалтын 50-ас дээш хувьд нь нэмэлт, өөрчлөлт орсон бол хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулна гэж заасны дагуу ЗГТС тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэрэгцээ, шаардлагыг Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандах судлах аргачлал (цаашид “Аргачлал” гэх)-ын 2.1-д заасан үе шатын дагуу хийж гүйцэтгэлээ.

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ

1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээ:

¹ Судалгааг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу боловсруулав.

² Дэлгэрэнгүй тайланг <https://mof.gov.mn/article/entry/tailan-delgerengui> үзнэ үү.

Засгийн газрын тусгай сангуудад хийсэн шалгалт, судалгааны үр дүнг товч дурдвал:

Зээл, татаас, урамшуулал олгодог тусгай сангууд:

Зээл, татаас, урамшуулал олгодог Засгийн газрын 5 тусгай сан байна. Үүнд: Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан (“ЖДҮХС”), Тариаланг дэмжих сан (“ТДС”), Мал хамгаалах сан (“МХС”), Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан (“ХЭДС”) болон Боловсролын зээлийн сан (“БЗС”).

1. ЖДҮХС

ЖДҮХС-ийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь иргэд, аж ахуйн нэгжид хөнгөлөлттэй зээл олгох, аж ахуйн нэгжүүдийг жижиг, дунд үйлдвэр эрхлэгчээр бүртгэх зэрэг юм. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг товч дурдвал:

- Хөнгөлөлттэй зээлийг зориулалтын бусаар ашиглаж байхад хяналт тавьж ажиллаагүй;
- Шүүхийн шийдвэр гарсан, хугацаа хэтэрсэн өр төлбөрийг барагдуулах чиглэлээр ажилладаггүй, улсын төсөвт төлөх ёстой зээлийг төлж барагдуулдаггүй;
- Зээл олгох аж ахуйн нэгж, зээлийн хэмжээ, түүний хүүг сайдын тушаал, сонгон шалгаруулах хороогоор тогтоож олон нийтийн хяналтгүй олгодог, мөн журам зөрчиж, сонгон шалгаруулалтгүй хөнгөлөлттэй зээлийг олгосон;
- Хугацаа хэтэрсэн өр, төлбөрийг барагдуулах, эргэн төлөлтийг сайжруулах талаар авсан арга хэмжээ хангалтгүй бөгөөд хяналт, хариуцлагын тогтолцоо сул байна.

2. Тариаланг дэмжих сан:

Тариаланг дэмжих сангаас 2005-2018 оны хооронд нийт 585.3 тэрбум төгрөгийн үндсэн дэмжлэг, 157.4 тэрбум төгрөгийн урамшууллыг тариалан эрхлэгч иргэд, хуулийн этгээдэд олгосон байна. Тус сангийн 2018 оны 9 дүгээр сарын 31-ний өдрийн тайлангаар нийт өглөг 141.1 тэрбум төгрөг, авлага 131.9 тэрбум төгрөг байгаагаас хугацаа хэтэрсэн найдваргүй зээлийн үлдэгдэл 72.1 тэрбум төгрөг буюу нийт авлагын 56 хувийг эзэлж байна.

Тариаланг дэмжих сан нь тариалан эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжид үндсэн дэмжлэг буюу хүнсний буудай, үрийн буудай, шатахуун, тоног төхөөрөмж, ургамал хамгааллын бодис, жимс, жимсгэнийн суулгац зэргийг хүүгүй зээлдүүлдэг бөгөөд жил бүр тус сан болон гурилын үйлдвэрүүдэд буудай тушаасан иргэд, аж ахуйн нэгжид буудайн урамшуулал олгох ажлыг эрхлэн явуулдаг байна.

Сангийн яамнаас хийсэн санхүүгийн шалгалтын тайлангаас үзэхэд тус сангийн дэмжлэг үзүүлэх болон урамшуулал олгох үйл ажиллагаандаа баримталж байгаа журам, дүрэм нь тодорхойгүй эсхүл хүчингүй болсон, зээлийн эргэн төлөлт

маш муу, зээлийн барьцаа хөрөнгийн бүртгэл, хугацаа хэтэрсэн өр төлбөрийн барагдуулалт хангалтгүй, буудайн урамшууллыг хуурамч материал бүрдүүлэн авдаг, худалдан авах ажиллагааны хууль, дүрмийг баримтлан ажилладаггүй зэрэг олон тооны зөрчил, дутагдал илэрч, үйл ажиллагааны өндөр эрсдэлтэй гэж дүгнэгдсэн байна³.

Эндээс үзэхэд Тариаланг дэмжих сан нь олон жилийн хугацаанд үр ашиггүй, оновчгүй байдлаар ажилласаар ирсэн байх бөгөөд үйл ажиллагааг сайжруулж, шинэчлэн зохион байгуулах зорилгоор холбогдох хууль тогтоомжийн зохицуулалтад өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлагатай байна.

Тус сангийн эрхэлж буй үйл ажиллагааны төрөл, хэлбэрийг судлан үзэхэд хүүгүй зээл олгож буй үйл ажиллагааг ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг ЖДҮХС-д шилжүүлж, тариаланчдад урамшуулал олгох үйл ажиллагааг салбарын яаманд шилжүүлэх байдлаар сангийн одоогийн гаргаж буй үр ашиггүй зардлыг бууруулж, хяналт, хариуцлагын тогтолцоог сайжруулах боломжтой байна.

3. Мал хамгаалах сан:

Мал хамгаалах санд улсын төсвөөс 2016-2018 оны хооронд нийт 131.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд техник, технологийн болон эргэлтийн хөрөнгийн дэмжлэгийн зээл, мал амьтнаар олгох хөнгөлөлттэй зээл, тоног төхөөрөмжийн лизингийн үйлчилгээ үзүүлэхээс гадна ноос, ноолуур, арьс, ширний урамшууллыг малчид, иргэдэд олгох үйл ажиллагааг эрхэлсэн байна.

Тус сангийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар нийт 29.9 тэрбум төгрөгийн зөрчил илэрсэн байна. Мал хамгаалах сангаас зээлийн журам боловсруулж мөрдөөгүй, зарим аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд зээлийг дахин давтан олгодог, авсан зээлээ төлөөгүй байхад дахин зээл олгосноос гадна зээл олгох үйл ажиллагааны хяналт сул, баримт бичгийн бүрдүүлэлт хангалтгүй зэрэг зөрчлүүд илэрсэн байна⁴.

Эндээс үзэхэд мал хамгаалах сан нь олон жилийн хугацаанд үр ашиггүй, оновчгүй байдлаар ажилласаар ирсэн байх бөгөөд үйл ажиллагааг сайжруулж, шинэчлэн зохион байгуулах зорилгоор холбогдох хууль тогтоомжийн зохицуулалтад өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Тус сангийн эрхэлж буй үйл ажиллагааны төрөл, хэлбэрийг судлан үзэхэд зээл олгож буй үйл ажиллагааг ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг ЖДҮХС-нд шилжүүлж, урамшуулал олгох үйл ажиллагааг салбарын яаманд шилжүүлэх

³

https://mof.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/%D0%A8%D0%B0%D0%BB%D0%B3%D0%B0%D0%BB%D1%82%D1%8B%D0%BD_%D1%82%D0%B0%D0%B9%D0%BB%D0%B0%D0%BD-%D0%A2%D0%AD%D0%94%D0%A1.pdf

⁴

https://mof.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/%D0%A8%D0%B0%D0%BB%D0%B3%D0%B0%D0%BB%D1%82%D1%8B%D0%BD_%D1%82%D0%B0%D0%B9%D0%BB%D0%B0%D0%BD-%D0%9C%D0%A5%D0%A1.pdf

байдлаар сангийн одоогийн гаргаж буй үр ашиггүй зардлыг бууруулж, хяналт, хариуцлагын тогтолцоог сайжруулах боломжтой байна.

4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан:

Тус сан нь өөрийн орлогоороо зарлагаа нөхөх зарчмаар ажиллаж байна. Сангийн гол орлого нь гадаадаас Монгол Улсад ажиллаж байгаа иргэдийн ажлын байрны төлбөрийн орлого бөгөөд, зарлага нь улсын болон орон нутгийн төсөвт ачаалал үүсгэхгүйгээр ажилгүй болон зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, тэднийг байнгын болон түр ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлэхэд зориулагддаг Засгийн газрын тусгай сан бөгөөд хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх олон төрлийн үйлчилгээ, арга хэмжээ, хөтөлбөрүүдийг санхүүжүүлж байна.

Тус сан нь 2012-2018 оны хооронд нийт 375.3 тэрбум төгрөгийг зарцуулснаас иргэдэд олгох жижиг зээлд 102.4 тэрбум төгрөг, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээнд 159.9 тэрбум төгрөг, сум хөгжүүлэх санд 60.0 тэрбум төгрөг, Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих санд 21.3 тэрбум төгрөгийг тус тус хуваарилжээ. Тус сангийн авлага 2017 оны жилийн эцсийн тайлангаар 111.6 тэрбум төгрөг байна⁵.

Уг сангаас олгож буй зээлүүд нь арилжааны банкаар дамжин олгогдож байгаа боловч, зорилтот бүлэгтээ очих хүртэл банкинд хадгалагддаг тул сонгогдсон арилжааны банкууд эх үүсвэрийг зориулалт бусаар ашиглах өндөр эрсдэлтэй байна. Түүнчлэн, тус сангаас олгох жижиг зээлийн дээд хэмжээ болон хөтөлбөрүүдийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний зөвлөлөөс батлан мөрдүүлж байгаа нь эрсдэлтэй байгаа тул Засгийн газраас зээлийн хэмжээ, хөтөлбөрийг баталдаг байх зохицуулалтыг холбогдох хуульд оруулах шаардлагатай байна.

5. Боловсролын зээлийн сан:

Боловсролын зээлийн сан болон суралцагч, захиалагчийн хоорондын гэрээнд суралцагч үүргээ хэрэгжүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлага тодорхой бус байгаа нь төлбөр эргэн төлөгдөхгүй удаашрахад нөлөөлж байна. Түүнчлэн сургалтын зээл авч буй иргэдийн сургуулийн дипломыг нь зээлийн барьцаа болгон авч байгаа нь зээлийн барьцаа хөрөнгийн шаардлага хангахгүй, нийт зээлийн эргэн төлөлт хангалтгүй байх үндсэн нөхцөл болж байна. Иймд цаашид оюутны сургалтын зээлийн барьцаа хөрөнгө, эргэн төлөлтийн хөшүүргийг оновчтой болгох зохицуулалтыг тусгах шаардлагатай байна.

5

https://mof.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/3_%20%D0%A8%D0%B0%D0%BB%D0%B3%D0%B0%D0%BB%D1%82%D1%8B%D0%BD%20%D1%82%D0%B0%D0%B9%D0%BB%D0%B0%D0%BD-%D0%A5%D0%AD%D0%94%D0%A1.pdf

Эдгээр сангуудын зээл, санхүүгийн дэмжлэг хугацаандаа эргэн төлөгддөггүй, хугацаа хэтэрсэн өр, авлага үүссэн нийтлэг зөрчил дутагдал сангуудад хийсэн санхүүгийн үйл ажиллагааны шалгалтын хүрээнд илэрсэн⁶. Үүнээс гадна дээрх сангуудаар дамжуулан олгосон зээлийн мэдээллийг судлан үзэхэд, хоорондоо уялдаа холбоо муутай ажилладгаас үүдэн зарим аж ахуйн нэгжүүдэд өөр өөр сангаас давхардуулан зээл олгосон зөрчил илэрсэн. Иймд үйл ажиллагааны давхардлыг арилгах, үргүй зардлыг бууруулах, хяналт хариуцлагын тогтолцоог сайжруулах зорилгоор ТДС, МХС-г татан буулгаж, хөрөнгийн эх үүсвэр, өмнө үүссэн өр, авлагыг нь одоогийн ЖДҮХС-д шилжүүлж, үйл ажиллагааг сайжруулан, нэгтгэх байдлаар зохион байгуулах нь зүйтэй байна.

Үйл ажиллагаа явуулдаггүй, эсхүл тусдаа сан байх шаардлагагүй тусгай сангууд:

Дээр дурьдсан сангуудаас гадна үйл ажиллагаа огт явуулж байгаагүй, цаашид ашиглах шаардлагагүй болсон эсхүл тусдаа сан байх шаардлагагүй, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт хөтөлбөр хэлбэрээр суулган санхүүжүүлэх боломжтой дараах тусгай сангууд байна. Үүнд:

1. *Үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан:* Үйл ажиллагаа явуулж эхлээгүй бөгөөд ЖДҮХС-тай зарим үйл ажиллагааны хувьд давхардаж байна. Хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлэх томоохон төсөл хөтөлбөрүүдийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад тусгах замаар шийдэх боломжтой тул тусдаа сан байх шаардлагагүй.

2. *Олон улсын хамтын ажиллагааны сан:* Тус сангийн өнгөрсөн 3 жилийн гүйцэтгэлээс харахад зарцуулалтын 80 орчим хувийг гадаад албан томилолт, бичиг хэрэг, урамшуулал, болон бэлэг дурсгалын зардал эзэлж байна. Тусдаа сан байх шаардлагагүй бөгөөд, төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад шаардлагатай зардлуудыг тусгах замаар санхүүжүүлэх боломжтой. Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд Төсвийн захирагч “Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж”-ийг төсөл, арга хэмжээнд зарцуулж болно гэж заасан. Иймд хандивын орлогыг заавал сан үүсгэхгүйгээр төсөл, арга хэмжээнд зарцуулах боломжтой.

3. *Монгол судлалыг дэмжих сан:* Тус сангийн зарлагын гүйцэтгэл 2018 онд 504 сая төгрөг байсан бол 2019 оны төсөвт 852 сая төгрөгийг тусгаад байна. Тус сангийн зарлагын гүйцэтгэлээс харахад БСШУС-ын сайдын багцад хамаарах соёл, урлагийг дэмжих сан болон олон улсад Монгол улсыг сурталчлан таниулах төсөл хөтөлбөртэй үйл ажиллагаа, зориулалт, зарцуулалтын хувьд давхцаж байна. Тусдаа сан байх шаардлагагүй бөгөөд, төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад шаардлагатай зардлуудыг тусгах замаар санхүүжүүлэх боломжтой.

6

https://mof.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/4_%20%D0%A8%D0%B0%D0%BB%D0%B3%D0%B0%D0%BB%D1%82%D1%8B%D0%BD%20%D1%82%D0%B0%D0%B9%D0%BB%D0%B0%D0%BD-%D0%91%D0%97%D0%A1.pdf

4. *Ирээдүйн тэтгэврийн нөөц сан:* Монголбанкны эзэмшилд байгаа ипотекийн зээлийн хөрөнгийг зардлаар хааж, хариу төлбөргүй шилжүүлэхээр заасан нь Монголбанкны алдагдлыг нэмэгдүүлж, олон улсын санхүүгийн байгууллагуудтай хэрэгжүүлж байгаа хөтөлбөрт заасан нөхцөлүүдтэй зөрчилдөж байна. Түүнчлэн Монголбанкны алдагдлаар дамжин Засгийн газрын өрийн тогтвортой байдлыг хангахад сөрөг нөлөө үзүүлнэ.

5. *Эрсдэлийн сан:* Төсвийн орлого, зарлагыг тогтворжуулах оновчтой хэрэгсэл биш бөгөөд төсвийн тогтворжуулалтын сантай үүрэг, зорилго нь давхцаж байгаа, өмнө нь ашиглаж байгаагүй.

6. *Засгийн газрын өрийн баталгааны сан:* Өрийн удирдлагын тухай хуулиар Засгийн газрын өрийн баталгаатай холбоотой зардлыг төсвийн төсөлд тусгаж, санхүүжүүлэх тул тусдаа сан байх шаардлагагүй. Засгийн газрын өрийн баталгааны шимтгэлийн орлого нь үүрэг гүйцэтгэх шаардлага гарсан үед эрсдэлийг даах хэмжээнд байж чадахгүй байна.

7. *Агаарын бохирдлын эсрэг сан:* Үйл ажиллагаа явуулаагүй. 2019 оны төсөвт тусдаа агентлаг байхаар тусгагдсан тул сан байх шаардлагагүй болсон. Агаарын бохирдлын эсрэг авч хэрэгжүүлэх бүхий л арга хэмжээ, төсөв хөтөлбөрийн зардлыг шинээр байгуулагдах агентлагаар дамжуулан нэгдсэн зохион байгуулалтад оруулах тул санг татан буулгах шаардлагатай байна.

Дээр дурдсан шалгалт, судалгааны үр дүнгээс дүгнэхэд шийдвэрлэх шаардлагатай асуудлын мөн чанар, цар хүрээ нь дараах байдалтай байна:

1. Үйл ажиллагаа, үндсэн чиг үүрэг давхцал бүхий Мал хамгаалах сан, Тариаланг дэмжих сан болон Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг нэгтгэн, зохион байгуулах;
2. Үйл ажиллагаанд нь зөрчил илэрсэн зарим тусгай сангийн үйл ажиллагааг сайжруулах (Боловсролын зээлийн сан, Улсын авто замын сан болон Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан);
3. Үйл ажиллагаа явуулдаггүй, эсхүл заавал тусгай сан хэлбэрээр үйл ажиллагаа явуулах шаардлагагүй бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хөтөлбөр хэлбэрээр тусган хэрэгжүүлэх боломжтой сангуудыг хаах буюу татан буулгах.

1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд:

Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг		Нөлөөлж буй хэлбэр
1	Иргэд, аж ахуйн нэгж	Зээл, татаас, урамшуулал олгодог Засгийн газрын тусгай сангуудын үйл ажиллагаа ил тод бус, зохион байгуулалт муутай, үр ашиггүй, хяналт сул байгаа, мөн чанар хүртээмж хангалтгүй байгаа нь тэдгээрээс зээл тусламж, урамшуулал болон үйлчилгээ

		<p>авах хүсэлтэй иргэд, аж ахуйн нэгжийн эрх ашигт сөргөөр нөлөөлж байна.</p> <p>Иймд тухайн чиг үүрэг бүхий тусгай сангуудыг нэгтгэн зохион байгуулж, үйл ажиллагааг сайжруулснаар тэдгээр иргэдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах нөхцөл сайжирна.</p>
2	Төр, төрийн албан хаагчид	<p>Тусгай сангуудын үйл ажиллагаа хангалтгүй, хөнгөлөлттэй зээлийн эргэн төлөлт хяналтгүй байгаа нь улсын төсвийн сахилга батыг бууруулж, тусгай сангуудын нийгэм, эдийн засагт үр нөлөө үзүүлэх зорилгод үйлчилж чадахгүй байна.</p> <p>Мөн эрх зүйн зохицуулалтын оновчтой бус байдлын улмаас ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөлийг бүрдүүлж байна.</p> <p>Иймд нэгдсэн төсвийн нийт зарлагын 30 орчим хувийг эзэлж байгаа Засгийн газрын тусгай сангуудын үйл ажиллагааг цэгцэлж, оновчтой зохион байгуулснаар төсвийн сахилга батыг нэмэгдүүлж, тусгай сангуудын эдийн засаг, нийгэмд үзүүлэх үр нөлөөг дээшлүүлэх ба ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлнэ гэж үзэж байна.</p>

1.3. Асуудал үүссэн шалтгаан, нөхцөл

Засгийн газрын тусгай сангуудад хийсэн шалгалт, судалгаанаас үзэхэд дараах нийтлэг шалтгаан, нөхцөл харагдаж байна:

- Зарим сангуудын үйл ажиллагаа, чиг үүрэг давхцалтай, эсхүл үйл ажиллагаа явуулдаггүй, чиг үүргийг нь төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад тусган хэрэгжүүлэх боломжтой сангуудыг байгуулсан;

- Төсвийн хөрөнгөөс зээл, тусламж авсан, батлан даалт гаргуулсан, санхүүгийн дэмжлэг авсан этгээдүүдийн талаарх мэдээлэл, сонгон шалгаруулах журам ил тод биш, зээлийн санхүүжилтийн хяналт сул, хугацаа хэтэрсэн авлагыг барагдуулах арга хэмжээг авдаггүй, зохицуулалт тодорхой бус, ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлтэй байна.

Үүнээс дүгнэхэд тусгай сангуудын төрлийг оновчтой тодорхойлж, зохион байгуулалтыг сайжруулах замаар Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийг цаашид боловсронгуй болгох шаардлагатай гэж үзэж байна.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГО

Иймд Аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх зорилгыг дараах байдлаар тодорхойлж байна.

Дээр дурдсан асуудлуудыг шийдвэрлэх зорилго нь зээл, тусламж, урамшуулал олгодог сангуудыг нэгтгэн зохион байгуулж, иргэд, хуулийн этгээдэд хүртээмжтэй, үйл ажиллагаа нь ил тод, хяналттай байдлыг нэмэгдүүлэх замаар практикт үүсэж буй асуудлуудыг шийдвэрлэх, зарим сангуудын зохицуулалтыг боловсронгуй болгож үйл ажиллагааг нь сайжруулах, үйл ажиллагаа явуулдаггүй бөгөөд заавал тусгай сан байх шаардлагагүй сангуудыг татан буулгах, давхардлыг арилгах, төсвийн хөрөнгийг хэмнэх, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, мөн тусгай сангуудын эдийн засаг, нийгэмд үзүүлэх үр нөлөөг дээшлүүлэхэд оршино.

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЭРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Аргачлалын 5-д заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу хоёрдугаар хэсэгт заасан зорилгыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргалаа.

	Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1	Тэг хувилбар (ямар нэгэн арга хэмжээ авахгүй, одоогийн байдал хэвээр байх)	Өнөөгийн тулгамдаад буй бэрхшээл хэвээр үргэлжлэх бөгөөд хөрөнгийн ашиглалт, хяналтыг сайжруулах, төсвийн хэмнэлт, нийгэм, эдийн засагт түлхэц үзүүлэх зорилгод хүрэх боломжгүй.	Нэмэлт зардал гарахгүй ч сөрөг үр дагавар улам бүр нэмэгдэнэ	Үр дүн сөрөг
2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Нийтэд чиглэсэн ухуулга, сурталчилгааг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр явуулах, сонсгол, хэлэлцүүлэг зохион байгуулах, олон нийтийн цахим сүлжээ ашиглах, гарын авлага, мэдээллийн хуудас гаргах зэрэг нь сангуудыг нэгтгэх, үйл ажиллагааг сайжруулах, заримыг татан буулгах	Тодорхой хэмжээний зардал гарна. Асуудлыг үүсгэж буй гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаварыг бууруулж чадахгүй.	Үр дүн сөрөг

		асуудлыг шийдвэрлэхгүй тул энэ хувилбар зорилгод хүрэх арга болж чадахгүй юм.		
3	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Зах зээлийн механизмаар буюу татвар, хураамжийн бодлого, лиценз зөвшөөрөл болон квот зэргээр хязгаарлалт тогтоох зэрэг зах зээлийн эдийн засагт нөлөөлөхүйц арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь төслийн хувьд тохиромжгүй юм.	Тодорхой хэмжээний зардал гарна. Асуудлыг үүсгэж буй шалтгаан, нөхцөлийг арилгаж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй.	Үр дүнд хүрэхгүй
4	Төрөөс санхүүгийн интервенц хийх	Зорилгод хүрэхгүй.	Тодорхой хэмжээний зардал гарна.	Үр дүнд хүрэхгүй
5	Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүрэг гүйцэтгүүлэх	Төрөөс гүйцэтгэх тодорхой чиг үүргийг буюу зээл, тусламж олгох үйл ажиллагааг гуравдагч этгээд буюу төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх боломжтой.	Тодорхой хэмжээний зардал гарна. Асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг арилгахад цогцоор нөлөөлж, сөрөг үр дагаврыг бүрэн бууруулж чадахгүй. Мөн хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай болно.	Татан буулгах сангуудын хувьд үр дүнд хүрэхгүй.
6	Захиргааны шийдвэр гаргах	Нэгтгэх сангуудын хувьд боловч үр дүнд төдийлөн ахиц гаргаж чадахгүй. БЗС, ХЭДС, Улсын авто замын сангуудын хувьд үйл ажиллагааг нь сайжруулах зорилгоор холбогдох журмыг боловсронгуй болгосноор оролцогч талуудын хариуцлагыг нэмэгдүүлэх, хяналт сайжрах боломж бүрдэнэ. Харин зарим сангуудыг татан буулгах, нэгтгэх зохион байгуулах шийдвэр нь зөвхөн Улсын Их хурлын бүрэн эрхэд хамаарах тул захиргааны акт, захиргааны хэм хэмжээ тогтоосон актаар шийдвэрлэх эрх зүйн боломжгүй юм.	Асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг арилгахад цогцоор нөлөөлж, сөрөг үр дагаврыг бүрэн бууруулж чадахгүй.	Нэгтгэн зохион байгуулах болон татан буулгах сангуудын хувьд үр дүнд хүрэхгүй

7	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Зээл урамшуулал олгодог сангууд болон татан буулгах сангуудын үйл ажиллагаанд тулгамдаад байгаа бэрхшээл, асуудлыг шийдвэрлэх бөгөөд зорилгод хүрэх боломжтой.	Зардал гарах боловч энэ нь асуудлуудыг шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлнэ.	Үр дүнтэй
---	--------------------------------------	--	--	-----------

Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх замаар иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх, эсхүл төрөөс санхүүгийн интервенц хийх, захиргааны шийдвэр гаргаснаар тухайн асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэж, дэвшүүлсэн зорилгод хүрэх боломжгүй байна.

Иймд асуудлын мөн чанар, цар хүрээ болон Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-д заасны дагуу хуулийн нийт зүйл, заалтын талаас илүү хувьд нэмэлт, өөрчлөлт орж байсныг харгалзан ЗГТС тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хэлбэрээр хуулийн төслийг боловсруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Уг шинэчилсэн найруулгын төсөл боловсруулахтай уялдуулан Өрийн удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, Тариалангийн тухай хууль, Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль, Агаарын тухай хууль зэрэгт нэмэлт, өөрчлөлт оруулж, одоо хүчин төгөлдөр үйлчилж буй ЗГТС тухай хууль, Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох, ЗГТС тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл боловсруулах шаардлагатай гэж үзэж байна.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 6-д заасны дагуу өмнөх шатанд сонгон авсан хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг Хүснэгт 1, 2, 3, 4-өөс үзнэ үү.

4.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх		

	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй	хамааралгүй
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй	хамааралгүй
	1.2.Оролцоог хангах			
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	<input checked="" type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй	
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	<input checked="" type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй	
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхүүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	<input checked="" type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй	
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмийн талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	<input checked="" type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй	
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй	хамааралгүй
2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй	хамааралгүй
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй	хамааралгүй
3.Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	<input checked="" type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй	
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	шаардлагагүй
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй	хамааралгүй
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй	хамааралгүй
4.Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	<input checked="" type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй	
5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд	5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй	хамааралгүй
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй	хамааралгүй

нийцүүлсэн эсэх				
-----------------	--	--	--	--

4.2.Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
		<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	<input checked="" type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй	
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	

	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	<input checked="" type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй	
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	<input checked="" type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй	
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	<input checked="" type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй	ээрэгээр
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	<input checked="" type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй	
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	<input checked="" type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй	Дэмжлэг болно
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	<input checked="" type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй	Төсвийн зардал буурна
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	<input checked="" type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй	ээрэгээр
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	<input checked="" type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй	
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	<input checked="" type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй	

4.3.Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	<input checked="" type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй	

1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	<input checked="" type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй	Зарим татан буугдах сангийн ажлын алба тодорхой тооны ажилтнуудтай
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	<input checked="" type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй	зэрэг
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
5.Нийтийн эрүүл мэнд,	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	

аюулгүй байдал	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуучимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	

4.4.Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	

	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
3. Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1. Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
	3.2. Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
	3.3. Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
	3.4. Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
4. Усны нөөц	4.1. Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
	4.2. Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
	4.3. Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
5. Хөрсний бохирдол	5.1. Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
	5.2. Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
6. Газрын ашиглалт	6.1. Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
	6.2. Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
	6.3. Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
7. Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1. Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	
	7.2. Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	<input type="checkbox"/> Тийм	<input checked="" type="checkbox"/> Үгүй	

4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх.

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлд Монгол Улсын Засгийн газрын нийтлэг чиг үүрэг, үндсэн бүрэн эрхийг заасан бөгөөд Засгийн газрын тусгай сан нь Засгийн газрын тодорхой чиг үүрэг, зорилтыг санхүүжүүлэх зориулалттай юм. ЗГТС тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь энэхүү чиг үүрэг, бүрэн эрхийг үр ашигтай, шуурхай, ил тод хэрэгжүүлэхэд дэмжлэг болох тул Монгол Улсын Үндсэн хуулийн зарчим болон Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн агуулга, үзэл баримтлалтай нийцэж байна. Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагаа нь дотоодын хууль тогтоомжоор зохицуулагддаг бөгөөд олон улсын гэрээгээр зохицуулагддаггүй байна.

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Аргачлалын 7-д зааснаар хувилбарын эерэг болон сөрөг талуудыг

- Зорилгод хүрэх байдал;
- Зардал, үр өгөөжийн харьцаа;
- Хүний эрх, эдийн засагт, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө;
- Хууль тогтоомжтой нийцэж буй эсэх гэсэн шалгуураар дахин нягтлан үзэж дараах дүгнэлтийг хийлээ.

“Тэг” хувилбар: Энэ хувилбарыг сонгож Засгийн газрын тусгай сангийн асуудлыг шийдвэрлэхгүй орхиж болох боловч энэ нь Засгийн газрын тусгай сангуудын хөрөнгө, эх үүсвэрийн зарцуулалтыг үр ашигтай удирдан зохион байгуулах, хөрөнгийн ашиглалт, бүртгэл хяналтыг сайжруулах, төсвийн хэмнэлт, нийгэм, эдийн засагт түлхэц үзүүлэх зорилгод хүрэх боломжгүй болно.

Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх хувилбар: Нийтэд чиглэсэн ухуулга, сурталчилгааг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр явуулах, сонсгол, хэлэлцүүлэг зохион байгуулах, олон нийтийн цахим сүлжээ ашиглах, гарын авлага, мэдээллийн хуудас гаргах зэрэг нь Засгийн газрын тусгай сангуудын чиг үүргийн давхардал, илэрсэн зөрчлийг шийдвэрлэхгүй тул энэ хувилбар зорилгод хүрэх арга болж чадахгүй юм.

Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх хувилбар: Зах зээлийн механизмаар буюу татвар, хураамжийн бодлого, лиценз зөвшөөрөл болон квот зэргээр хязгаарлалт тогтоох зэрэг зах зээлийн эдийн засагт нөлөөлөхүйц арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь Засгийн газрын тусгай сангуудын эх үүсвэрийн ашиглалт, үйл ажиллагаанд зохицуулалт болохгүй тул зорилго биелэгдэхгүй юм.

Төрөөс санхүүгийн интервенц хийх хувилбар: Үйл ажиллагаа, чиг үүрэг давхцалтай сангуудыг нэгтгэх, үйл ажиллагааг сайжруулах, заримыг татан буулгах асуудлыг төрөөс санхүүгийн интервенц хийх хувилбараар шийдвэрлэхгүй тул энэ хувилбарыг сонгох боломжгүй юм.

Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүрэг гүйцэтгүүлэх хувилбар: Төрөөс гүйцэтгэх тодорхой чиг үүргийг гуравдагч этгээд буюу төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болох боловч асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг арилгахад цогцоор нөлөөлж, сөрөг үр дагаврыг бүрэн бууруулж чадахгүй тул энэхүү хувилбар нь тохиромжгүй юм.

Захиргааны шийдвэр гаргах хувилбар: Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт зааснаар тусгай санг хуулиар байгуулна. Иймд зарим сангуудыг татан буулгах, нэгтгэх зохион байгуулах шийдвэр нь зөвхөн Улсын Их хурлын бүрэн эрхэд хамаарах тул захиргааны акт, захиргааны хэм хэмжээ тогтоосон актаар шийдвэрлэх эрх зүйн боломжгүй.

“Хууль тогтоомжийн төсөл боловсруулах” хувилбар: Дээр дурдсанчлан Засгийн газрын тусгай санг хуулиар байгуулах тул түүнийг хаах буюу татан буулгах, нэгтгэн зохион байгуулах асуудлыг хууль тогтоомжийн төсөл боловсруулан цогцоор нь шийдвэрлэх боломжтой.

Нэгтгэн зохион байгуулах болон татан буулгах сангуудын хувьд дурдсан асуудлуудыг хууль боловсруулах замаар шийдвэрлэх боломжтой байна. Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-д заасны дагуу Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн нийт заалтын 50-аас дээш хувьд нь нэмэлт, өөрчлөлт орсон тул хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах шаардлагатай.

ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Тусгай санд эх үүсвэр төвлөрүүлэн зөвхөн тодорхой зорилгоор зарцуулах хэлбэрээр төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэх туршлага олон улсад түгээмэл ба тухайн улс, засгийн газруудын бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөө, хөтөлбөрөөр тодорхойлсон зорилтот салбаруудыг хөгжүүлэх, тэдгээрт дэмжлэг үзүүлэх зорилгоор тусгай сангуудын төрлийг тодорхойлон байгуулдаг байна.

Хуулийн төсөл боловсруулах замаар шийдвэрлэх асуудал бол тусгай сан байх шаардлагагүй сангуудыг татан буулгахаас гадна хөнгөлөлттэй зээл, тусламж олгодог сангууд буюу чиг үүргийн давхцалтай Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Тариаланг дэмжих сан болон Мал хамгаалах санг нэгтгэн зохион байгуулах юм.

Энэ хүрээнд хөнгөлөлттэй зээл, санхүүжилт олгох замаар жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сайн туршлагыг хэрэгжүүлж байгаа улсууд буюу Япон болон Бүгд Найрамдах Солонгос Улс (“БНСУ”)-ын туршлагыг сонгож авлаа.

Япон улсын туршлага:

Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиг үүргийг Японы Санхүүгийн корпораци⁷ хэрэгжүүлдэг бөгөөд энэ нь Засгийн газар 100% эзэмшдэг төрийн корпораци байна. 2008 оны 10 дугаар сарын 1-ний өдөр дараах 4 бодлогын санхүүжилтийн институцийг Японы Санхүүгийн корпораци болгон нэгтгэн зохион байгуулсан:

- Үндэсний санхүүжилтийн корпораци (National life finance corporation);
- Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуурын аж ахуйн санхүүжилтийн корпораци (Agriculture, Forestry and Fisheries Finance Corporation);

⁷ <https://www.ifc.go.jp/n/english/>

- Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх Японы санхүүжилтийн корпораци (Japan Finance Corporation for Small and Medium Enterprises);
- Олон улсын хамтын ажиллагааны Японы банкны Олон улсын санхүүгийн үйл ажиллагаа (The International Financial Operations of the Japan Bank for International Cooperation).

Энэхүү корпораци 495 санхүүгийн байгууллагатай бизнесийн хамтын ажиллагаатай ба нийт Жижиг, дунд үйлдвэрлэлийн санхүүжилтийн 4.2%-ийг бүрдүүлдэг байна. Корпорацийн үйл ажиллагааг Японы Санхүүгийн Корпорацийн тухай хууль (the Japan Finance Corporation Act)-иар зохицуулагддаг.

Корпорацийн үйл ажиллагааны цар хүрээ дараах 3 хэсэгт хуваагддаг байна⁸:

1. Бичил бизнес ба хувь хүмүүсийн хэлтэс: энэхүү хэлтэс гарааны бизнес болон жижиг бизнес эрхлэгчдэд зээл олгох, хувь хүмүүст боловсролын зээл өгөх ажиллагааг хариуцдаг,
2. Газар тариалан, ой болон загас агнуурын аж ахуй, хүнсний бизнесийн хэлтэс: энэ хэлтэс эдгээр салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээд, хувь хүмүүсийг дэмжиж, дотоодын Газар тариалан, ой болон загас агнуурын аж ахуйг хөгжүүлэх, хүнсний чанарыг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулдаг,
3. Жижиг, дунд үйлдвэрлэлийн хэлтэс: энэ хэлтэс зээл олгох, зээлийн даатгалын үйлчилгээ үзүүлэх замаар Японы эдийн засгийн гол тоглогч болох жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулдаг.

Газар тариалан, ой, загас агнуурын аж ахуй болон жижиг, дунд үйлдвэрлэлд зориулсан зээл, санхүүжилтийг Японы Санхүүгийн корпорациас шууд, эсхүл эрх олгосон банкаар дамжуулан олгодог ба зээлийн хэмжээ, хүү, хугацааг 3 жил тутам Японы Жижиг, дунд үйлдвэрлэлийн агентлагаас шинэчлэн баталдаг байна. Зээлийн хүсэлт, сонгон шалгаруулалт, зээлийн хяналтыг цахим хэлбэрээр хөтлөн явуулдаг бөгөөд тодорхой мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгадаг.

Эдгээр салбарыг дэмжих бодлого хэрэгжүүлэгч Японы Санхүүгийн корпорацийн бүтэц, үйл ажиллагааны дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 1-ээс харна уу.

БНСУ-ын туршлага:

Жижиг, дунд үйлдвэрлэлийг өргөн хүрээтэй тодорхойлсон⁹ бөгөөд электрон тоног төхөөрөмж, хувцас, тавилга, савхи, цаас, тамхи, хүнс, эмийн зэрэг 24 салбарын үйлдвэрлэл, уул уурхай, барилга, газар тариалан, ой, загас агнуур, худалдаа үйлчилгээ, тээвэр, хаягдал усны боловсруулалт, засвар, эрүүл мэнд, зочид буудал, санхүү, боловсролын үйлчилгээ зэрэг олон салбарыг хамардаг.

⁸ <https://www.jfc.go.jp/n/english/operations.html>

⁹ <http://www.kosmes.or.kr/sbc/SH/EHP/SHEHP024M0.do>

Эдгээр салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийг дэмжих зорилготой Жижиг, дунд бизнесийн корпораци¹⁰ ажилладаг. Тус корпорациас шууд болон банк, санхүүгийн байгууллагаар дамжуулан санхүүжилт олгодог байна.

БНСУ-ын Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэмжих бүтэц¹¹, үйл ажиллагааны дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 2-оос харна уу.

Дээрхээс дүгнэхэд Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх салбарт газар тариалан, хөдөө аж ахуйн салбарыг Япон болон БНСУ аль аль нь багтаан тооцдог ба нэгдсэн нэг бүтцээр хөнгөлөлттэй зээл олгон үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлдэг байна. Иймд хөнгөлөлттэй зээл олгодог сангууд болох ЖДҮХС, МХС болон ТДС-аас давхардуулан зээл авахаас сэргийлэх, үйл ажиллагааг нь оновчтой болгох зорилгоор нэгдсэн зохион байгуулалтад оруулах нь зүйтэй байна.

Энэхүү хөнгөлөлттэй зээл олгодог сангийн ажлын албаны бүтцийг төлөвлөхдөө Японы Санхүүгийн корпорацийн туршлагыг харгалзан үзэж, хэрэгжүүлэх чиг үүргийг тодорхой болгож, нээлттэй ил тод байдлыг хангах зорилгоор цахимжуулан, олон нийтэд тогтмол мэдээлж байх нь зүйтэй.

ДОЛОО. ЗӨВЛӨМЖ

ЗГТС тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлтийг тусгахдаа шинэчилсэн найруулгын төсөл боловсруулж, батлан гаргах хувилбарыг сонгох нь хууль тогтоомжид нийцсэн, хамгийн үр дүнтэй гэж үзэж байна.

Тус хуулиар дараах асуудлыг нарийвчлан зохицуулах шаардлагатай:

- Үйл ажиллагаа, чиг үүрэг давхцалтай сангуудыг нэгтгэн зохион байгуулах, үйл ажиллагааны хяналт, үр нөлөөг сайжруулах;
- Үйл ажиллагаа явуулдаггүй сангуудыг татан буулгаж, Засгийн газрын тусгай сангуудын төрлийг оновчтой тодорхойлон, нээлттэй ил тод болгох, хяналтын тогтолцоог сайжруулах.

“Хууль тогтоомжийн төсөл боловсруулах” хувилбарыг зохицуулалтын бусад хувилбартай хамтатган хэрэгжүүлэх нь үр дүнгүй бөгөөд уг хувилбарыг дангаар нь хэрэгжүүлэх бүрэн боломжтой.


САНГИЙН ЯАМ

_____оҮо_____

¹⁰ <https://www.mss.go.kr/site/eng/01/10106010000002017111504.jsp>

¹¹ https://www.unescap.org/sites/default/files/Panel%202-2.%20KODIT_Mr.%20Jong-goo%20Lee.pdf

Хавсралт 1. Япон улсын туршлага




Япон улсын туршлага /Зээлийн нөхцөл/

№	Зээлийн төрөл	Тусгай нөхцөл	Хэмжээ /сая иен/	Барьцаа хөрөнгө	Хүү %	Хугацаа /жил/
1	Шинэ бизнесийн зээл	Шинээр бизнес эхлүүлж байгаа, эмэгтэйчүүд, 30-аас доош насны залуучууд, 55-аас дээш насны иргэд, бизнесийн батлагдсан шинэ санаа	600-720	Шаардана	6.35, 4.40, 0.40	7, 10, 15, 20
2	Компанийн өрсөлдөх чадварыг сайжруулах зээл	Бөөний болон жижиглэн худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулдаг ААН-үүдэд хүчин чадлаа нэмэгдүүлэх, шинэчлэл хийхэд зориулж олгоно.	720	Шаардана	3.60, 0.40	7, 15
3	Эрчим хүч, байгаль орчны зээл	Байгаль орчны бохирдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлтийг бий болгох зорилготой ААН-д олгоно.	720	Шаардана	3.60, 0.40	7, 20
4	Эрсдэлээс хамгаалах зээл	Бизнес, санхүү, хуулийн орчны өөрчлөлтийг даван туулахад хүчдрэл бэрхшээлтэй тулгарч буй ААН-д олгоно	150, 300, 720	Шаардана	3.60, 0.40	8, 15
5	Компанийг дахин сэргээн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зээл	Үйл ажиллагааны дотолдолд орсон, хуулийн дагуу дампуурал зарлахад бэлэн, бизнесийн үйл ажиллагаа дотолдсон ААН-д олгоно.	720	Шаардахгүй	5.65, 4.05, 0.40	5, 7, 15, 20
6	Байгалийн гамшгийн үлмаас үйл ажиллагаа дотолдсон	Байгалийн гамшгийн улмаас бизнесийн үйл ажиллагаа дотолдсон ААН-үүдэд олгоно	300-720	Шаардахгүй	3.60, 0.40	15, 20

1. Зээлийг зөвхөн эрх олгосон банк эсвэл Японы санхүүжилтийн корпорацаар дамжуулан олгодог.
2. Зээлийн хэмжээ, хүү, хугацааг 3 жил тутамд Японы ЖДҮ-ийн агенлагаас шинэчлэн баталдаг.
3. Зээлийн хүсэлт, сонгон шалгаруулалт, зээлийн хяналтын цахим хэлбэрээр хөтлөн явуулдаг бөгөөд, тодорхой мэдээллийг олон нийтэд нээлттэй байшдаг байна.

Төрөл	1. Жижиг, дунд ААН		2. Бичил ААН	
	Нийт хөрөнгө /сая иен/	Ажилтны тоо	Ажилтны тоо	Ажилтны тоо
Үйлдвэрлэл	300 <	300 <	300 <	20 <
Бөөний худалдаа	100 <	100 <	100 <	5 <
Үйлчилгээ	50 <	100 <	100 <	5 <
Жижиглэн худалдаа	50 <	50 <	50 <	5 <

Хавсралт 2. БНСУ-ын туршлага



ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ АЖЛЫН ТАЙЛАН

Удиртгал

Энэхүү үнэлгээний ажлын гол зорилго нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зүйл, заалтад тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад оршино.

Үнэлгээ хийх хуулийн төсөл нь хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хувилбар байдлаар боловсруулагдсан болно.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн /цаашид “Хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”¹-д /цаашид “Аргачлал” гэх/ заасны дагуу дараахь үе шаттайгаар хийлээ.

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

Хуулийн төслийн нөлөөг үнэлэхдээ үндсэн 5 шалгуур үзүүлэлтийн хүрээнд тэдгээрийг шалгах хэрэгслийг ашиглан хуулийн төслийн зохицуулалтууд нь уг хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад нийцсэн эсэх, хуулийн төслийн зорилгод нийцсэн, түүнд хүрэх боломжтой байдлаар тусгагдсан эсэхэд дүн шинжилгээ хийсэн болно. Мөн хуулийн төслийн зохицуулалтууд нь ойлгомжтой байдлаар харилцан уялдаатай тусгагдсан эсэх тухай холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудаас санал авч, дээр дурдсан аргачлалын дагуу асуултад хариулах байдлаар дүгнэсэн бөгөөд, гарсан үр дүнд үндэслэн анхаарах асуудлын талаар хууль санаачлагчид зөвлөмж өгсөн.

НЭГ.ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

¹ <https://www.legalinfo.mn/annex/details/7335?lawid=11993>

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, зорилт, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан аргачлалд дурдсан 5 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Практикт хэрэгжих боломж;
3. Ойлгомжтой байдал;
4. Зардал²;
5. Харилцан уялдаа зэрэг болно.

Эдгээр шалгуур үзүүлэлтийг сонгохдоо дараахь үндэслэлийг харгалзан үзсэн. Үүнд:

1. “Зорилгод хүрэх байдал” Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайлан болон үзэл баримтлалд тусгасан дараах зорилгод тус тус хүрсэн эсэх:

1/ зээл, тусламж, урамшуулал олгодог сангуудыг нэгтгэн зохион байгуулж, иргэд, хуулийн этгээдэд хүртээмжтэй, үйл ажиллагаа нь ил тод, хяналттай байдлыг нэмэгдүүлэх;

2/ үйл ажиллагаа явуулдаггүй бөгөөд заавал тусгай сан байх шаардлагагүй сангуудыг татан буулгаж, давхадлыг арилган Засгийн газрын тусгай сангуудын төрлийг оновчтой тодорхойлох;

3/ Засгийн газрын тусгай санг нээлттэй ил тод болгох, хяналтын тогтолцоог сайжруулан төсвийн хөрөнгийг хэмнэх, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах.

2. “Практикт хэрэгжих боломж” Хуулийн төсөлд тусгагдсан асуудал болох ил тод мэдээлэх зохицуулалт нь практикт хэрэгжих эсэх;

3. “Ойлгомжтой байдал” Хуулийн төсөл нь ойлгомжтой, логик дараалалтай томъёологдсон эсэх, хуулийн төсөл түүний зохицуулалтыг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх боломжтой эсэхийг шалгах үүднээс холбогдох этгээдээс санал авч, хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэх;

4. “Харилцан уялдаа” Хуулийн төслийн зүйл, заалт нь өөр хоорондоо болон бусад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжтой нийцсэн эсэх, мөн төрийн байгууллагын чиг үүрэгтэй давхардсан, зөрчилдсөн эсэх зэргийг тус тусад нь шалгана.

ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

² Хуулийн төслийн “Зардал” гэсэн шалгуур үзүүлэлтийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зардлын тооцоо гэсэн хэсэгт тусад нь тооцож, үр нөлөөг нь үнэлсэн болно. Дэлгэрэнгүйг уг тайлангаас үзнэ үү

Энэхүү хэсэгт уг хуулийн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгээ тогтоож, сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох зүйл, заалтыг сонгосон. Энэхүү зүйл, заалтыг сонгохдоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа голлох ач холбогдол бүхий заалтуудыг сонгож авсан. Өөрөөр хэлбэл тухайн төслийн үр нөлөөг үнэлэхдээ цаг хугацаа, зардал хэмнэх үүднээс хуулийн төсөлд шинээр нэмж орж буй, голлох ач холбогдол бүхий заалтыг сонгож, тухайн сонгож буй зүйл, заалтын үр нөлөөг судаллаа.

Түүнчлэн хуулийн төсөл батлагдсанаар тодорхой зардал үүсгэж болохуйц, эсхүл тодорхой субъектэд үүрэг хүлээлгэсэн, тодорхой байгууллагад шинээр чиг үүрэг хүлээлгэж байгаа, мөн тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор шинээр хэлтэс, нэгж, байгууллага бий болгох шаардлагатай эсэх зэргийг харгалзан үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон.

Ингээд сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдлыг шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу авч үзье.

2.1. “Зорилгод хүрэх байдал”

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад хуулийн төслийн зорилго, зорилт, хуулийн төслийн зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийлээ.

Үзэл баримтлалд дурдсанаар Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь 1/ зээл, тусламж, урамшуулал олгодог сангуудыг нэгтгэн зохион байгуулж, иргэд, хуулийн этгээдэд хүртээмжтэй, үйл ажиллагаа нь ил тод, хяналттай байдлыг нэмэгдүүлэх, 2/ үйл ажиллагаа явуулдаггүй бөгөөд заавал тусгай сан байх шаардлагагүй сангуудыг татан буулгаж, давхардлыг арилган Засгийн газрын тусгай сангуудын төрлийг оновчтой тодорхойлох, 3/ Засгийн газрын тусгай санг нээлттэй ил тод болгох, хяналтын тогтолцоог сайжруулах гэсэн үндсэн зорилготой.

Иймд Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслөөс дээрх зорилтуудтай холбогдсон, эдгээр зорилтуудыг хангах зорилгоор тусгагдсан зүйл, заалтыг сонгон авч “зорилгод хүрэх байдал”-ийн үр нөлөөг нь тооцлоо. Үүнд:

№	Зорилгод хүрэх байдал	Сонгосон зүйл заалт
1	Зээл, тусламж, урамшуулал олгодог сангуудыг нэгтгэн зохион байгуулж, иргэд, хуулийн этгээдэд хүртээмжтэй, үйл ажиллагаа нь ил тод, хяналттай байдлыг нэмэгдүүлэх,	Хуулийн төслийн 16 дугаар зүйл, 21.4, 22.6, 22.7 ба 23.5 дахь хэсэг

2	Үйл ажиллагаа явуулдаггүй бөгөөд заавал тусгай сан байх шаардлагагүй сангуудыг татан буулгаж, давхардлыг арилган Засгийн газрын тусгай сангуудын төрлийг оновчтой тодорхойлох	Хуулийн төслийн 5.3 дахь хэсэг
3	Засгийн газрын тусгай санг нээлттэй ил тод болгох, хяналтын тогтолцоог сайжруулан төсвийн хөрөнгийг хэмнэх, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах	Хуулийн төслийн 3, 23 дугаар зүйл болон 20.2, 22.2 дахь хэсэг

2.2. “Практикт хэрэгжих боломж”

Практикт хэрэгжих байдал гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд ил тод мэдээлэх зохицуулалтыг сонгон “Практикт хэрэгжих байдал”-ын үр нөлөөг нь тооцсон болно. Сонгосон заалтыг хүснэгтээр үзүүлвэл:

№	Практикт хэрэгжих боломж	Сонгосон зүйл заалт
1	Ил тод мэдээлэхтэй холбоотой заалт	22.2.Тусгай сангийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэл, санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг холбогдох шийдвэрийн хамт тухайн шийдвэр гарсан сард нь нэгтгэн олон нийтэд нээлттэй тайлагнаж, Шилэн дансны тухай хуульд заасан журмын дагуу байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн цахим хуудсаар дамжуулан хуульд заасан хугацаанд тогтмол мэдээлнэ.

2.3.“Ойлгомжтой байдал”

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг хуулийн төслийн зүйл, заалтад бүхэлд нь дүн шинжилгээ хийж, Хууль тогтоомжийн тухай хуулийн Дөрөвдүгээр бүлэг болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг, түүнчлэн хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүд хуулийг нэг мөр ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байдлаар боловсруулагдсан эсэхийг шалган, үр нөлөөг тооцно. /Хуулийн төсөл 6 бүлэг, 26 зүйлтэй./

2.4.“Харилцан уялдаа”

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд тусгасан стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог

шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь сонгон авлаа. /Хуулийн төсөл 6 бүлэг, 26 зүйлтэй./

ГУРАВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараахь байдлаар харуулав:

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	16 дугаар зүйл, 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсэг 22 дугаар зүйлийн 22.6 ба 22.7 дахь хэсэг 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсэг, Хуулийн төслийн 5.3 дахь хэсэг, Хуулийн төслийн 3 дугаар зүйл, 20.2, 22.2 дахь хэсэг.	Зорилгод дүн шинжилгээ хийх
2	Практикт хэрэгжих боломж	22 дугаар зүйлийн 22.2	практикт одоо болж байгаа үйл явцад дүн шинжилгээ хийх, холбогдох этгээд тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж байгаа эсэхийг судлах
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийг бүхэлд нь тооцно.	Ойлгомжтой байдлыг судлах, ингэхдээ Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгаар хуулийн төслийг шалгах
4	Зардал	Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлалын дагуу тусад нь тооцно.	Зардлын тооцоо хийх
5	Харилцан уялдаа	Хуулийн төслийг бүхэлд нь тооцно.	Хуулийн төслийн уялдаа холбоог Хууль тогтоомжийн тухай хууль болон

			аргачлалд заасан асуулгуудаар шалгах
--	--	--	--------------------------------------

Дээрх урьчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараахь байдлаар үнэллээ:

3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал:

Энэ хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлагыг хуулийн төслийн зорилго, зорилт болон хуулийн зохицуулалттай харьцуулан үзлээ.

Зээл, тусламж, урамшуулал олгодог сангуудыг нэгтгэн зохион байгуулж, иргэд, хуулийн этгээдэд хүртээмжтэй, үйл ажиллагаа нь ил тод, хяналттай байдлыг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд хуулийн төслийн 16 дугаар зүйл, 21.4, 22.6, 22.7, 23.5 ба 24.2 дахь хэсэгт дүн шинжилгээ хийсэн байдал

Дээрх зорилгын хүрээнд хуулийн төслийн 1 дүгээр зүйлд “Энэ хуулийн зорилт нь Засгийн газрын тусгай сангийн төрлийг тогтоож, эдгээр санг бүрдүүлэх, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино” хэмээн ерөнхий зорилгыг тодорхойлж өгсөн байна.

Зээл, татаас болон урамшуулал олгодог сангууд болох Мал хамгаалах сан, Тариаланг дэмжих сан болон Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан нь 2006 онд батлагдсан Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн дагуу байгуулагдсан. Эдгээр сангийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхэд олон жилийн хугацаанд үр ашиггүй, оновчгүй байдлаар ажилласаар ирсэн байх бөгөөд үйл ажиллагааг сайжруулж, шинэчлэн зохион байгуулах зорилгоор холбогдох хууль тогтоомжийн зохицуулалтад өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага тулгарсан байна. Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандах судалсан судалгааны тайлангаас үзэхэд эдгээр сангууд нь чиг үүргийн хувьд давхцалтай бөгөөд хоорондоо уялдаа холбоо муутай ажилладгаас үүдэн зарим аж ахуйн нэгж хэд хэдэн сангаас давхардуулан санхүүжилт авах зөрчил практикт гарсан байна.

Энэхүү давхцал, зөрчлийг арилгах үүднээс 2006 онд батлагдсан Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд тусгагдсан Мал хамгаалах сан, Тариаланг дэмжих санг тус тус татан буулгаж, үйл ажиллагаа, эх үүсвэр болон хөрөнгийг Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд нэгтгэн, уг сангийн нэрийг “Үндэсний үйлдвэрийг дэмжих сан” гэж өөрчлөн хуулийн төслийн 16 дугаар зүйлд тусгасан байна. Энэхүү зүйлийг дагуу Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих сан нь жижиг, дунд үйлдвэрлэл, газар тариалан, мал аж ахуй эрхлэх үйл ажиллагааг дэмжих зориулалттай байх бөгөөд уг сангийн хөрөнгөөр дараах үйл ажиллагааг санхүүжүүлнэ гэж тусгасан:

- жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх, газар тариалан, мал аж ахуй эрхлэлтийг дэмжих зориулалтаар хөнгөлөлттэй зээл олгох;

- жижиг, дунд үйлдвэрлэл, газар тариалан, мал аж ахуй эрхлэхэд бизнес, инкубацийн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, сургалт, давтан сургалтад хамруулах;
- жижиг, дунд үйлдвэрлэл, газар тариалан, мал аж ахуйн чиглэлээр судалгаа, шинжилгээ хийх, мэдээллийн сан бүрдүүлэх;
- сангийн үйл ажиллагаа, үндсэн хөрөнгөтэй холбогдсон зардлыг санхүүжүүлэх.

Ийнхүү чиг үүргийн давхцалтай сангуудын заримыг татан буулгаж хуулийн төслөөр нэгтгэснээр зээл, тусламж, урамшуулал олгодог сангуудыг нэгтгэн зохион байгуулах зорилгыг хангасан байна.

Зээл, тусламж, урамшуулал олгодог сангуудаас олгох санхүүжилт нь иргэд, хуулийн этгээдэд хүртээмжтэй, үйл ажиллагаа нь ил тод, хяналттай байдлыг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд хуулийн төсөлд дараах зүйлүүдийг тусгасан байна. Үүнд:

Хуулийн төслийн 22.6 дахь хэсэгт заасны дагуу зээл, тусламж олгодог сангууд болох Боловсролын зээлийн сан, Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих сан болон Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь шинээр олгох зээлийн эх үүсвэрийн хэмжээ, сонгон шалгаруулалтын журам, тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг цахим хуудсаараа дамжуулан мэдээлж, мэдээллийг тогтмол шинэчилнэ. Мөн хуулийн төслийн 22.7 дахь хэсэгт эдгээр сангууд нь зээл авахаар хүсэлт ирүүлсэн иргэд, хуулийн этгээдийн бизнес төлөвлөгөөгөө танилцуулах, түүнийг сонгон шалгаруулах, үнэлэх үйл явцыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нээлттэй, ил тод зохион байгуулахаар зохицуулсан байна. Ингэснээр тухайн сангуудаас олгох зээлийн мэдээлэл болон бусад шаардлагатай мэдээллийг иргэд, хуулийн этгээд байгууллагын цахим хуудсаар дамжуулан авах боломжтой болох ба сонгон шалгаруулалтад хяналт тавих боломжтой болно.

Хуулийн төслийн 21.4 дэх хэсэгт заасны дагуу Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих сангаас олгох зээлийн санхүүжилтийг төслийн хэрэгжилттэй холбож олгох буюу зээлдэгчийн худалдан авалт, төслийн гүйцэтгэлээр олгоно гэж заасан байх бөгөөд ингэснээр зээлийн зарцуулалтыг хянах боломжийг бий болгосон байна.

Түүнчлэн хуулийн төслийн 23.5 дахь хэсэгт Боловсролын зээлийн сан, Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ сонгон шалгаруулах хороо, төслийн удирдах хороо болон хяналтын хорооны бүрэлдэхүүнд төрийн бус байгууллага, мэргэжлийн байгууллагын төлөөллийг оролцуулах ба тусгай сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагаанд хяналт тавихад олон нийтийн оролцоог хангах зохицуулалтыг оруулж өгсөн байна.

Үйл ажиллагаа явуулдаггүй бөгөөд заавал тусгай сан байх шаардлагагүй сангуудыг татан буулгаж, давхардлыг арилган, Засгийн газрын тусгай сангуудын төрлийг оновчтой тодорхойлох зорилгын хүрээнд хуулийн төслийн 5.3 дахь хэсэгт дүн шинжилгээ хийсэн байдал

Засгийн газрын тусгай санг хуулиар байгуулдаг бөгөөд 2006 онд батлагдсан Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасны дагуу нийт 29 тусгай сан байгаа.

Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайланд дурдсанаар хаах буюу татан буугдаж байгаа сангуудад Үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан, Олон улсын хамтын ажиллагааны сан, Монгол судлалыг дэмжих сан, Ирээдүйн тэтгэврийн нөөц сан, Эрсдэлийн сан, Засгийн газрын өрийн баталгааны сан, Агаарын бохирдлын эсрэг сан багтаж байгаа бөгөөд тусгай санг зөвхөн хуулийн дагуу байгуулдаг тул хуульд өөрчлөлт оруулах замаар хааж, татан буулгах боломжтой байна.

Хуулийн төслийн 5.3 дахь хэсэгт Засгийн газрын тусгайн сангийн төрлийг шинэчлэн тогтоож, дээр дурдсан сангуудыг хасан нийт 20 тусгай сан байхаар тодорхойлсон байгаа нь дээрх зорилгыг хангаж байна.

Засгийн газрын тусгай санг нээлттэй ил тод болгох, хяналтын тогтолцоог сайжруулан төсвийн хөрөнгийг хэмнэх, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах зорилгын хүрээнд хуулийн төслийн 3 дугаар зүйл болон 22.2 дахь хэсэгт дүн шинжилгээ хийсэн байдал

Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сан, Ирээдүйн тэтгэврийн нөөц сан, Нийгмийн халамжийн сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Ирээдүйн өв сан, Улсын авто замын сан, Үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан, Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас бусад тусгай сантай холбогдсон харилцааг 2006 онд батлагдсан Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар зохицуулна гэсэн заалттай байсан бол хуулийн төслийн 3 дугаар зүйлд хуулийн үйлчлэх хүрээг дараах байдлаар өөрчлөн томъёолжээ:

“3.1.Хуульд өөрөөр заагаагүй бол бүх тусгай сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, удирдлага, зохион байгуулалт болон хяналт тавих харилцаанд энэ хууль үйлчилнэ.

3.2.Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сан, Нийгмийн халамжийн сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Төсвийн тогтворжуулалтын сан, Ирээдүйн өв сан, Улсын авто замын сан, Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн бүрдүүлэлт, зарцуулалтын онцлогтой холбогдсон харилцааг тусгай хуулиар, нийтлэг харилцааг энэ хуулиар зохицуулна.”

Ийнхүү өөрчлөн томъёолсноор хуулийн төсөлд тусгасан ил тод байдал, хяналт тавихтай холбоотой зохицуулалтууд тусгай хуулиар зохицуулагдах сангуудад ч мөн адил хамаарах үр дагавартай болсон байна.

Түүнчлэн хуулийн төслийн 22.2 дахь хэсэгт “тусгай сангийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэл, санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг холбогдох шийдвэрийн хамт тухайн шийдвэр гарсан сард нь нэгтгэн олон нийтэд нээлттэй тайлагнаж, Шилэн дансны тухай хуульд заасан журмын дагуу байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн цахим хуудсаар дамжуулан хуульд заасан

хугацаанд тогтмол мэдээлнэ” гэж зааж өгснөөр бүх тусгай сангийн хөрөнгийн зарцуулалтын мэдээллийг ил тод авах боломж бүрдсэн байна.

Дээрхээс дүгнэхэд хуулийн төсөл нь түүнийг боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад бүрэн нийцэж байна.

3.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Хуулийн төслийн зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэхийг үнэлэхээр хуулийн төслөөс сонгож авсан дараахь зохицуулалтын талаар практикт одоо болж байгаа үйл явцад дүн шинжилгээ хийх, холбогдох этгээд тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж байгаа эсэхийг судлах замаар үр нөлөө судаллаа.

Хуулийн төслийн 22 дугаар зүйлийн 22.2, 22.5, 22.6 болон 22.7 дахь хэсэгт дүн шинжилгээ хийсэн байдал

Хуулийн төслийн 22 дугаар зүйл нь тусгай сангийн тайлагнал, ил тод байдлын талаар зохицуулсан. Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй 2006 оны Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд зөвхөн тусгай сангийн жилийн эцсийн зарцуулалтын тайланг аудитын дүгнэлтийн хамт уг тайлан гарснаас хойш 20 хоногийн дотор өдөр тутмын хэвлэлд нийтлэх замаар нийтэд мэдээлэх зохицуулалт бий. 2014 онд батлагдсан Шилэн дансны тухай хуулийн дагуу тусгай сангууд холбогдох мэдээллээ шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулж ирсэн. Харин хуулийн төслийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэгт заасны дагуу Тусгай сангийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэл, санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг холбогдох шийдвэрийн хамт тухайн шийдвэр гарсан сард нь нэгтгэн олон нийтэд нээлттэй тайлагнаж, Шилэн дансны тухай хуульд заасан журмын дагуу байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн цахим хуудсаар дамжуулан хуульд заасан хугацаанд тогтмол мэдээлнэ.

Шилэн дансны хуулийн дагуу тайлагнах боломжтой болсны зэрэгцээ байгууллага бүр өөрийн цахим хуудастай болсон одоо үед энэхүү зохицуулалт практикт хэрэгжих бүрэн боломжтой байна.

3.3. “Ойлгомжтой байдлыг судлах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Энэхүү шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг шалгалаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан.
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Уг шаардлагыг хангасан байна.
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Хуулийн төсөл зохицуулах харилцаа, хүрээнээс хальсан зүйл судалгаагаар тогтоогдоогүй.
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Уг шаардлагыг хангасан байна.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Хуулийн төслийн дурдсан бусад хуулиудыг зохих байдлаар ишэлсэн буюу хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх тул энэ шаардлагыг хангасан байна.

<p>29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;</p>	<p>Уг шаардлагыг хангасан байна.</p>
<p>29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;</p>	<p>Хуулийн төслийн 25 дугаар зүйлд хариуцлагын заалт болон тодорхой заалтыг дагаж мөрдөх журмын зохицуулалтыг зохих байдлаар тусгасан байх тул уг шаардлагыг хангасан байна.</p>
<p>29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;</p>	<p>Бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх тул уг шаардлагыг хангасан байна.</p>
<p>29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.</p>	<p>Уг шаардлагыг хангасан байна.</p>
<p>Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага</p>	
<p>30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;</p>	<p>Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.</p>
<p>30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;</p>	<p>Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.</p>

30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Уг шаардлагыг хангасан байна.
30.1.4.хүч оруулсан нэр томьёо хэрэглэхгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Уг шаардлагыг хангасан байна.

3.4.“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан дараахь асуудлуудыг тодорхойлох байдлаар хуулийн төслийн харилцан уялдаатай байдлыг үнэллээ.

д/д	Аргачлалд заасан асуулт	Хуулийн төслийг үнэлсэн байдал
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилго, зорилттой нийцэж байна.
2	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	Хуулийн төслийн 2 дугаар зүйлд заасан “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн байна.
3	хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх;	Хуулийн төслийн 4 дүгээр зүйлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байна.
4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Тийм
5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Үгүй
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Тийм

7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Үгүй
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Үгүй
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Хуулийн төслийн 23.5 дахь хэсэгт тусгай сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ сонгон шалгаруулах хороо, төслийн удирдах хороо болон хяналтын хорооны бүрэлдэхүүнд төрийн бус байгууллага, мэргэжлийн байгууллагын төлөөллийг оролцуулах зохицуулалт туссан.
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Үгүй
11	Хуулийн төсөлд тусгагдсан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх	Хуулийн төсөлд аливаа тусгай зөвшөөрөл олгох тухай заалт байхгүй.
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Үгүй
13	Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Тийм
14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Хуулийн төсөлд тусгайлан зохицуулалт тусгагдаагүй бөгөөд энэ асуудлыг Өрсөлдөөний тухай хуулийн хүрээнд зохицуулах боломжтой.
15	Авилга, хүнд суртлыг бий болгоход чиглэгдсэн заалт тусгасан эсэх	Үгүй
16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Тухайн хуулийн зохих заалтыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хууль, Төрийн албаны тухай хуультай нийцүүлэн, холбогдох бусад хуулиар зохицуулна гэж тусгасан.

ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

4.1.Баримтжуулалт

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үр нөлөөг үнэлэх зорилгоор дараах мэдээлэл, бичиг баримтыг цуглуулан үр нөлөөг тооцох ажиллагааны тайланд ашиглалаа:

1. “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолын 4 дүгээр зүйлийн 4.1.3.3 дахь дэд заалт,
2. “Засгийн газрын тусгай сангуудын талаар авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 87 дугаар тогтоол,
3. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл,
4. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандсан тухай тайлан,
5. Хуулийн төслийн боловсруулах үндэслэл, шаардлага, судалгаа хэлэлцүүлэгт оролцсон иргэд, төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын санал, албан бичиг,
6. Сангийн яамнаас Засгийн газрын тусгай сангуудын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн шалгалтын дэлгэрэнгүй тайлан³.

4.2.Үнэлэлт, дүгнэлт

Энэхүү үнэлгээний явцад Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах асуудлаар төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, иргэдтэй уулзаж ярилцах, хэлэлцүүлэг зохион байгуулах, холбогдох зохицуулалтад дүн шинжилгээ хийх зэрэг аргыг хэрэглэснээс гадна энэ асуудлын хүрээнд хийгдсэн албан ёсны шалгалтын дүн, судалгааг ашигласан болно.

Хуулийн төслийн үр нөлөөг шалгуур үзүүлэлт тус бүрээр дараах байдлаар үнэлж дүгнэлээ.

➤ **“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр:**

Хуулийн төслийн зорилго нь хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлүүдтэй нийцсэн эсэхэд мөн хуулийн төслийн зорилтыг уг хуулийн төслийн зохицуулалтууд хангаж, илэрхийлж чадахаар бүрэн гүйцэт томъёологдсон эсэхэд үнэлгээ хийхэд хуулийн төслийн зорилго, зорилт үзэл баримтлалд тусгагдсан хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлага, үндэслэлийг бүрэн илэрхийлж чадсан байна.

³ Дэлгэрэнгүй тайланг <https://mof.gov.mn/article/entry/tailan-delgerenqui> үзнэ үү.

Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төсөлд тодорхойлсон зорилтыг илэрхийлж үүнийг хэрэгжүүлэхэд чиглэгдэж чадсан эсэх талаар хуулийн төслийн 3, 16 ба 23 дугаар зүйл, 5.3, 20.2, 21.4, 22.6, 22.2, 22.7 ба 23.5 дахь хэсгүүдэд заасан заалтыг сонгож үнэлгээ хийхэд зээл, тусламж, урамшуулал олгодог сангуудыг нэгтгэн зохион байгуулж, иргэд, хуулийн этгээдэд хүртээмжтэй, үйл ажиллагаа нь ил тод, хяналттай байдлыг нэмэгдүүлэх, үйл ажиллагаа явуулдаггүй бөгөөд заавал тусгай сан байх шаардлагагүй сангуудыг татан буулгаж, давхардлыг арилган Засгийн газрын тусгай сангуудын төрлийг оновчтой тодорхойлох, Засгийн газрын тусгай санг нээлттэй ил тод болгох, хяналтын тогтолцоог сайжруулан төсвийн хөрөнгийг хэмнэх, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах зэрэг зорилтуудад нийцэж боловсруулагдсан байна гэж дүгнэлээ.

➤ **“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр:**

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг буюу “Тусгай сангийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэл, санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг холбогдох шийдвэрийн хамт тухайн шийдвэр гарсан сард нь нэгтгэн олон нийтэд нээлттэй тайлагнаж, Шилэн дансны тухай хуульд заасан журмын дагуу байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн цахим хуудсаар дамжуулан хуульд заасан хугацаанд тогтмол мэдээлнэ” гэсэн заалтыг холбогдох төрийн байгууллагууд хэрэгжүүлэх боломж байгаа эсэхийг судалсан. 2014 оны шилэн дансны тухай хуулиар шилэн дансны нэгдсэн цахим хуудас ашиглалтад орсон ба байгууллага бүр өөрийн цахим хуудастай тул энэхүү заалт хэрэгжих бүрэн боломжтой байна.

➤ **“Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтээр:**

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд төсөлд холбогдох байгууллагаас тусгайлсан санал ирээгүй бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан “Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага”, 30 дугаар зүйлд заасан “Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага хангасан эсэх” мөн Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалыг баримталсан эсэхийг судалж үнэллээ.

Дээрх байдлаар хуулийн төслийн ойлгомжтой байдлыг үнэлэхэд хуулийн төсөл нь нийтлэг байдлаараа хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагыг хангасан байна гэж дүгнэлээ.

➤ **“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр:**

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-д тусгагдсан асуултад хариулах замаар хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн бөгөөд хуулийн төслийн зохицуулалтууд нь өөр хоорондоо болон бусад хууль тогтоомжтой уялдаа холбоотой байдлаар тусгагдсан байна.

Хуулийн төсөлд тусгасан хориглосон зохицуулалтыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тусгасан бөгөөд хууль зөрчсөн этгээд “Төрийн албаны тухай”, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлыг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-д болон Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр тусгасан байна.

4.3.Зөвлөмж

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын тусгай сангийн төрлийг тогтоож, эдгээр санг бүрдүүлэх, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахаар боловсруулсан байна. Уг зорилгын хүрээнд “зээл, тусламж, урамшуулал олгодог сангуудыг нэгтгэн зохион байгуулж, иргэд, хуулийн этгээдэд хүртээмжтэй, үйл ажиллагаа нь ил тод, хяналттай байдлыг нэмэгдүүлэх, Засгийн газрын тусгай санг нээлттэй ил тод болгох, хяналтын тогтолцоог сайжруулан төсвийн хөрөнгийг хэмнэх, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах зорилт дэвшүүлэн шинэчилсэн найруулгын хуулийн төсөл боловсруулсан байна.

Хуулийн төслийн үр нөлөөг “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу үнэлэхэд “Засгийн газрын тусгай сангийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төсөл нь хуулийн төслөөр тавьсан зорилтдоо хүрэх боломжтой, хуулийн төсөл боловсруулах шаардлагад нийцсэн байдлаар боловсруулагдсан байна.

Иймд энэхүү хуулийн төслийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандсан тухай тайлан, үнэлгээний дүгнэлт, хуулийн төслийн үзэл баримтлал, бусад холбогдох бүрдлийн хамт хуулийн төслийг өргөн мэдүүлэх нь зүйтэй байна.

**ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ
ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

**/ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ/**

УЛААНБААТАР ХОТ

2019 ОН

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

НЭГ.ЕРӨНХИЙ ҮНДЭСЛЭЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн¹ 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ыг баримтлан гаргав.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, үүнийг хялбарчлах, бууруулах талаар санал боловсруулахад энэхүү тайлан чиглэгдэх болно.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зохицуулалтаар буюу хуулийн төсөл батлагдсанаар иргэн, төрийн байгууллагад тодорхой үүрэг бий болгосон, түүнийг хэрэгжүүлэхэд мөнгөн зардал бий болохоор шинэ зохицуулалт тусгагдаагүй байна. Харин хуулийн этгээдэд тодорхой үүрэг хүлээлгэсэн зохицуулалт тусгагдсан байна.

Хуулийн төслийн зардлыг тооцохдоо бодит статистик болон хугацааг шууд ашиглах боломжгүй тохиолдолд аргачлалын 2.5.2, 4.4.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн адил төстэй ажил, үйлчилгээ байгаа эсэхийг судалж, баримжаалах авах зэргээр хугацаа, тохиолдлын тоо зэргийг тогтоосон болно.

¹ “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2015 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 25 дугаарт нийтлэгдсэн

ХОЁР. ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ БАТЛАГДСАНААР ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Энэ хэсэгт Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар хуулийн этгээдийн эрхлэх үйл ажиллагаатай холбоотой гүйцэтгэх үүргийн улмаас үүсэх зардлыг мөнгөн дүнгээр тооцоолон гаргана. Ийнхүү үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт заасны дагуу дараахь үе шаттайгаар тооцоолно. Үүнд:

- хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох
- нэг бүрийн зардлыг тооцох
- тоон үзүүлэлтийг тооцох
- нийт зардлын дүнг тооцож гаргах
- хялбарчлах боломжийг шалгах
- нэмэлт зардлыг тооцох

2.1.Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох:

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хүрээнд хуулийн этгээдэд ямар үүргийг бий болгож байгааг тодорхойлж уг үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай баримт бичгийн агуулгыг тодорхойлсны үндсэн дээр зардлын тооцоог хийх болно.

Засгийн газрын 2019 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “ Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын 2.2-т “Хуулийн этгээдийн хувьд хууль тогтоомжид заасан үүргийг гүйцэтгэхтэй холбогдуулан гарах мөнгөн зардлыг тооцно” гэж заасан.

Хуулийн төслийн хүрээнд “хуулийн этгээд” гэдэгт харилцаа холбооны үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээдийг ойлгох бөгөөд түүнд хүлээлгэсэн үүрэгтэй холбоотойгоор үүсэх зардлыг тооцоолох болно.

Хуулийн төсөлд харилцаа холбооны үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэсэн агуулгатай дараах заалт туссан. Үүнд:

- Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгө нь харилцаа холбооны үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээдээс төвлөрүүлсэн хөрөнгөөс бүрдэнэ (9.2). Харилцаа холбооны үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээдээс төвлөрүүлэх хөрөнгө нь татварын дараах цэвэр ашгийн 3 хувьтай тэнцүү хэмжээтэй байна (9.3).

Хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэж буй дээр дурдсан үүрэг нь Хуулийн төслөөр хүлээлгэж буй шинэ үүрэг биш бөгөөд 2006 онд батлагдсан Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд тусгагдан мөрдөгдөж байсан гэдгийг энд дурдах нь зүйтэй.


2.2. Зардлыг тооцох

Энэ шатанд өмнөх шатанд тодорхойлсон хуулийн этгээдийн хүлээж буй үүрэг, түүнийг гүйцэтгэхэд хуулийн этгээдээс зарцуулах хугацааг мөнгөн дүнгээр илэрхийлж гаргана. Ингэхдээ дараахь дарааллыг баримтална. Үүнд:



Стандарт үйл ажиллагаа болон зарцуулах хугацааг тодорхойлохдоо Засгийн газрын 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтад заасан хугацааг харгалзан үзэхийн хамт бусад ижил төстэй ажлыг ердийн дундаж ажилтан гүйцэтгэх хугацааг мөн үндэслэсэн болно.

Ажлын хөлсийг тооцож гаргахдаа ажилтанд олгох сарын үндсэн цалинг ажиллах хугацаанд хувааж ажлын хөлсийг өдөр, цаг, минутаар гаргав. Үндэсний статистикийн хорооноос гаргасан судалгаагаар² сарын дундаж цалин 2019 оны I улирлын байдлаар дараах байна:



Ажиллах хугацааг тооцоолохдоо Хөдөлмөрийн тухай хуульд заасан хөдөлмөрийн цагийг үндэслэв.

Ажлын хөлс = Үндсэн цалинг : ажиллах хугацаа
$7,265\text{₮} = 1,278,700\text{₮} : 22 \text{ өдөр} : 8 \text{ цаг}$

Үйл ажиллагааг хэрэгжүүлэх хугацаа:

² Nso.mn

Хуулийн этгээдийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх хугацааг аргачлалын хүснэгт 1-т тодорхойлсон загварын дагуу доор байдлаар тодорхойлов:

№	Ерөнхий үйл ажиллагаа	Гүйцэтгэх хугацаа (минут)
1	Үүрэгтэй танилцах, судлах	15
2	Мэдээлэл цуглуулах	15
3	Маягт бөглөх, гарчиглах, тэмдэглэх	7
4	Тооцоо хийх	20
5	Мэдээлэл, өгөгдөхүүнийг нягтлах	5
6	Алдааг засах	10
7	Тоо баримтыг боловсруулах	15
8	Мэдээлэл шилжүүлэх болон нийтлүүлэх	2
9	Дотоод хуралдаан (зөвлөлгөөн)	30
10	Бусадтай хамтран хийх хуралдаан (зөвлөлгөөн)	60
11	Мөнгө шилжүүлэх үүрэг хэрэгжүүлэх	8
12	Олшруулах, архивлах, тараах	5
13	Төрийн захиргааны байгууллагаас шалгах	30
14	Төрийн захиргааны байгууллагын шалгалтын дүнгээс үүдэлтэй засвар, өөрчлөлт	90
15	Холбогдох байгууллагатай харилцахад хүндрэл үүссэнээс үүдэн мэдээлэл нэмж цуглуулах	15
16	Сургалт, давтан сургалтын арга хэмжээнүүд	15
	Нийт дүн	342

Нэг хуулийн этгээд үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд 342 минут буюу 5.7 цагийг зарцуулахаар байна.

Зардал (ҮА тус бүрийн)=Хугацаа × Ажлын хөлс
$41,410.5\text{₮} = 5.7 \times 7,265\text{₮}$

Нэг хуулийн этгээдийн зардал 41,410.5 төгрөг байхаар байна.

2.3.Тоон үзүүлэлтийг тогтоох:

Энэ үе шатанд өмнөх үе шатуудад тогтоосон Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчлсэн найруулгын төсөл батлагдан гарснаар бий болох дээрх үүргийг хичнээн хуулийн этгээд, жилд хэдэн удаа гүйцэтгэх вэ гэдгийг хуанлийн нэг жилээр тооцоолон гаргах юм.

Энэ үзүүлэлтийг гаргахын тулд тохиолдлын тоо болон давтамжийг холбогдох статистик мэдээ ашиглан тодорхойлж гаргах бөгөөд тэдгээрийн үржвэрээр “тоон үзүүлэлт” нь илэрхийлэгдэх юм.

Тохиолдлын тооны хувьд дээрх үүргийг хуулийн төслөөр зөвхөн харилцаа холбооны үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээд хүлээх ба Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санд хамаарах 578 зөвшөөрөл эзэмшигч байна. Давтамжийн хувьд жилд 4 удаа тайлагнаж хөрөнгийг төвлөрүүлнэ.

ТООН ҮЗҮҮЛЭЛТ = ТОХИОЛДЛЫН ТОО x ДАВТАМЖ
$2,312 = 578 \times 4$

2.4. Нийт зардлын дүнг тооцож гаргах:

Энэ үе шатанд өмнөх үе шатанд гаргасан үүрэг тус бүрт ногдох нэг бүрийн зардлыг “тоон үзүүлэлт”-ээр үржүүлснээр гаргах юм.

НИЙТ ЗАРДАЛ = ЗАРДАЛ x ТООН ҮЗҮҮЛЭЛТ
$95,741,076 = 41,410.5 \times 2,312$

2.5. Хялбарчлах боломж:

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбоотойгоор харилцаа холбооны үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээдээс гарах зардлыг бууруулах боломжийг дараах шалгууруудаар тодорхойлъё. Үүнд:

а) Хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломж байгаа эсэх:

Харилцаа холбооны тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн төсөлд заасан үүргийг хүлээх бөгөөд хамрагдах эдгээр хуулийн этгээдийг тоог бууруулах боломжгүй.

б) Мэдээллийн агуулга, давтамжийг багасгах боломж байгаа эсэх:

Хуулийн төсөлд давтамжийн талаар тодорхой зохицуулалт тусгагдаагүй ба албан татвар ногдох орлогыг тайлагнах хугацааг (жилд 4 удаа) баримталж давтамжийг тооцоолсон болно. Албан татвар ногдох орлогыг тайлагнах холбогдох хуульд заасан давтамж буурах тохиолдолд энэхүү хуулийн төслийн хүрээнд биелүүлэх үүргийн давтамж багасгах боломжтой.

в) Шинээр үүсэх үүргийг урьд байсан үүрэгтэй нэгтгэж болох эсэх;

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн төсөлд хуулийн этгээдэд шинээр үүрэг хүлээлгээгүй.

г) Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх;

Цахимаар тайлагнах боломж бүрдээгүй байна.

2.6. Нэмэлт зардлыг тооцох.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хуулийн этгээдэд өмнө байснаас үүрэг дээр нэмж үүрэг хүлээлгээгүй бөгөөд аливаа нэмэлт зардал гарахгүй болно.

ГУРАВ. ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ БАТЛАГДСАНААР ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДАЛ

Хуулийн төсөл батлагдсанаар иргэнд үүсэх зардлыг тооцоолохдоо дараахь дарааллыг баримтална. Үүнд:

- иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох
- цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох
- тоон үзүүлэлтийг тооцох
- нийт дүнг тооцож гаргах
- хялбарчлах боломжийг шалгах

3.1.Иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох:

Засгийн газрын тусгай сангийн тухай хууль нь Засгийн газрын тусгай сан буюу Засгийн газрын тодорхой чиг үүрэг, зорилтыг санхүүжүүлэх зориулалттай төсвийн тусгай дансыг бий болгох, төрлийг тогтоох, эх үүсвэрийг бүрдүүлэх, зарцуулах болон хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах тул иргэнд ямарваа нэг үүрэг хүлээлгэсэн заалтыг агуулаагүй байна.

Иймд хуулийн төсөл нь иргэнд зардал, ачаалал үүсгэхгүй бөгөөд бусад нэмэлт зардал үүсэхээргүй боловсруулсан байх тул аргачлалд дурдсан дарааллыг шалгах байлдлаар зардлыг тооцох шаардлагагүй гэж үзлээ.

ДӨРӨВ. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДАГУУ УЛСЫН ТӨСӨВТ ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор төрийн байгууллагын зүгээс гарах зардлыг аргачлалд зааснаар дараахь үе шаттайгаар тооцлоо.

4.1. Байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох

Хуулийн төслийн дагуу шинээр дараах үүрэг хүлээнэ:

- Тусгай сангийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэл, санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг холбогдох шийдвэрийн хамт тухайн шийдвэр гарсан сард нь нэгтгэн олон нийтэд нээлттэй тайлагнах, шилэн дансанд байршуулах;
- тусгай сан шинээр олгох зээлийн эх үүсвэрийн хэмжээ, сонгон шалгаруулалтын журам, тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг цахим хуудсаараа дамжуулан мэдээлж, мэдээллийг тогтмол шинэчилэх.

4.2. Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох;

Дээр тодорхойлсон үүргийг ямар ямар төрийн байгууллага хэрэгжүүлэн, гүйцэтгэхийг тогтооё. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд зааснаар дараах тусгай сангууд байх ба эдгээрийг дараах төсвийн ерөнхийлөн захирагч хариуцна:

№	Сангийн нэр	ТЭЗ
1	Байгаль орчин, уур амьсгалын сан;	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд

2	Боловсролын зээлийн сан;	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд
3	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан;	Ерөнхий сайд
4	Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан;	Хууль зүй, дотоод хэргийн сайд
5	Засгийн газрын нөөц сан;	Сангийн сайд
6	Зэвсэгт хүчний хөгжлийн сан;	Батлан хамгаалахын сайд
7	Ирээдүйн өв сан;	Сангийн сайд
8	Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан;	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
9	Нийгмийн даатгалын сан	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
10	Нийгмийн халамжийн сан;	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
11	Соёл, урлагийг дэмжих сан;	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд
12	Спортыг дэмжих сан;	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд
13	Төсвийн тогтворжуулалтын сан;	Сангийн сайд
14	Улсын авто замын сан;	Зам, тээврийн хөгжлийн сайд
15	Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих сан;	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
16	Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан;	Гадаад харилцааны сайд
17	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан;	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
18	Шинжлэх ухаан, технологийн сан;	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд
19	Эрүүл мэндийг дэмжих сан;	Эрүүл мэндийн сайд
20	Эрүүл мэндийн даатгалын сан	Эрүүл мэндийн сайд

Эдгээр төсвийн ерөнхийлөн захирагч нарын эрхлэх асуудлынх нь хүрээнд мэргэжил, арга зүй, эрх зүй, техник, зохион байгуулалтын үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх холбогдох яамд, агентлаг, ажлын албаны ажилтан/мэргэжилтэн дээрх үүргийг гүйцэтгэхээр байна. Хүний нөөцийн хэрэгцээг албан хаагчдийг чиг үүрэг, тухай үүргийг гүйцэтгэх үүрэг бүхий албан хаагчдын тоо зэрэг мэдээлэлд үндэслэн баримжаалан тооцлоо. Мөн 3 тусгай сан ажлын албатай байх бөгөөд тухайн ажлын албадын хүний нөөцийн хэрэгцээг харгалзаж үзсэн болно.

Тодорхойлсон үүргийг гүйцэтгэх стандарт үйл ажиллагааг дараах байдлаар тодорхойллоо.

Үүргийг хэрэгжүүлэх байгууллага	Гүйцэтгэх үүрэг	Стандарт ажиллагаа үйл	Зарцуулах хугацаа /минут/
Яамд, албад ажлын	Тусгай сангийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэл, санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг холбогдох шийдвэрийн хамт тухайн шийдвэр гарсан сард нь нэгтгэн олон нийтэд нээлттэй тайлагнах, шилэн дансанд байршуулах	Мэдээлэл хүлээн авах	10
		Мэдээллийг нэгтгэн, нягтлах	60
		Байгууллагын цахим хуудас болон шилэн дансанд байршуулж, тайлагнах	15

	тусгай сан шинээр олгох зээлийн эх үүсвэрийн хэмжээ, сонгон шалгаруулалтын журам, тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг цахим хуудсаараа дамжуулан мэдээлж, мэдээллийг тогтмол шинэчилэх	Мэдээлэл хүлээн авах	10
		Мэдээллийг нягтлах	60
		Байгууллагын цахим хуудсанд байршуулах	15
Нийт			170

Тусгай сан тус бүр буюу 20 тусгай санг хариуцах тул нийт 3,400 минут (20 x 170) зарцуулахаар байна.

Тусгай сангийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэл, санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг холбогдох шийдвэрийн хамт тухайн шийдвэр гарсан сард нь нэгтгэн олон нийтэд нээлттэй тайлагнах, шилэн дансанд байршуулах болон тусгай сан шинээр олгох зээлийн эх үүсвэрийн хэмжээ, сонгон шалгаруулалтын журам, тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг цахим хуудсаараа дамжуулан мэдээлж, мэдээллийг тогтмол шинэчилэх үүргийн хувьд тус тус тохиолдлын тоог тогтоох боломжгүй байна.

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд тусгагдсан ажиллах цагийн горимтой харьцуулан харьцуулан авч үзлээ. Ингэхдээ нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлав:

1 жил = ажлын 200³ өдөр

1 өдөр = ажлын 8 цаг

1 цаг = ажлын 60 минут

Жилд 200 ажлын өдөр буюу (200 x 8) 1,600 ажлын цаг буюу (1,600 x 60) 96,000 минут ажиллана гэсэн үг.

Хариуцах нэгж	Хүний нөөцийн хэрэгцээ /минут/	Жилд шаардагдах ажлын цаг /минут/	Нэмэгдэж буй ачаалал /орон тоо/
Яамд, ажлын албад – нийт 20 нэгж	170*20 =3,400	96,000	0,03

Тодорхойлсон үүргийг гүйцэтгэхэд төрийн байгууллагуудад шинэ чиг үүрэг нэмэгдээгүй бөгөөд орон тооны ачаалал нэмэгдэхгүй байна. Иймд уг хуулийн төслийг баталснаар төрийн байгууллагын зардал буюу улсын төсөвт ачаалал үүсэхгүй.

--oo00oo--

³ Хуанлийн 365 өдрөөс Хөдөлмөрийн тухай хуульд заасан нийтээр амрах баярын өдөр, ээлжийн амралт, амралтын өдрийг хасаж тооцов.

**ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД ОЛОН НИЙТИЙН
ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БОЛОН ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГА, ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН
САНАЛЫН ТОВЪЁОГ**

д/д	Хаанаас	Ирүүлсэн санал	Ирсэн бичгийн дугаар, огноо	Тусгасан байдал
1.	Мэдээлэл холбооны операторуудын ассоциаци ТББ	<p>1. Хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 9 дүгээр зүйлд Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн зохилцуулалтыг тусгасан байх бөгөөд 9 дүгээр зүйлийн 9.1-т “Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан нь төрийн бодлогы н хүрээнд харилцаа холбооны зайлшгүй шаардлагатай үйлчилгээг алслагдсан орон нутаг болон үйлчилгээ хүрээгүй хүн амд бодит үнээр хүргэх, шинээр сүлжээ байгуулах, өргөтгөх, шинэчлэх зориулалттай байна” гэжээ. БНҮҮС-аар хэрэгжүүлсэн төслүүдийн хүрээнд сонгон шалгаруулалтад оролцож шалгарсан компани зөвхөн сүлжээгээ оруулах төдийгөөр хөрөнгө оруулалтыг шийдэж өгдөг, тухайн сүлжээний ашиглалт, үйлчилгээтэй холбоотой зардлыг сангаас олгодоггүйгээс сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээтэй холбоотой хүндрэлтэй асуудлууд үүсч, төслийн чанарт сөрөгөөр нөлөөлдөг. Ялангуяа интернетийн үйлчилгээ эрхлэх зарим компаниуд хөдөө орон нутагт байнгын ажиллагаатай салбар байхгүйтэй холбоотойгоор сүлжээ байгуулсны дараах ашиглалт, үйлчилгээг орхигдуулснаас 2011-2014 онд байгуулсан цамхаг, утасгүй интернетийн сүлжээ хэрэглээнээс гарсан тохиолдлууд ч байгаа. Тиймээс хуулийн 9.1 дэх заалтад “Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан нь төрийн бодлогын хүрээнд харилцаа холбооны зайлшгүй шаардлагатай үйлчилгээг алслагдсан орон нутаг болон үйлчилгээ хүрээгүй хүн амд бодит үнээр хүргэх, шинээр сүлжээ байгуулах, ашиглалт, үйлчилгээг хариуцах, өргөтгөх, шинэчлэх зориулалттай байна” гэж нэмж найруулах саналтай байна.</p>	<p>2019.06.18 №16</p>	<p>Хуулийн төслийн 9.5 дахь хэсэгт ашиглалт, засвар үйлчилгээг тухайн байгууламжийг үйл ажиллагаандаа ашиглаж байгаа харилцаа холбооны үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээд хариуцахаар оруулсан ба ашиглалт, үйлчилгээг сангаас санхүүжүүлэх боломжгүй юм.</p>
2.		<p>2. Хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 9 дүгээр зүйлийн 9.3-т “Энэ хуулийн 9.2-т зааснаар харилцаа холбооны үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээдээс төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ нь тухайн этгээдийн албан татвар ногдох орлогын 2 хувьтай тэнцүү байна” гэсэн нь уг санд</p>		<p>“... хуулийн этгээдээс төвлөрүүлэх хөрөнгө нь</p>

		<p>хөрөнгө төвлөрүүлэгчдийн хууль ёсны ашиг сонирхолд ихээхэн харшилж байна. Учир нь бодит байдал дээр уг сангийн хөрөнгийн 90%-ийг үүрэн холбооны 4 оператор компани бүрдүүлдэг. Эдгээр компаниуд нь ААНОАТ 25 хувь хүртэл шатлалтай төлөхийн зэрэгцээ, Гаалийн татвар, НӨАТ, нийгмийн даатгалын шимтгэлийг үргэлж нэмэгдүүлсэн хувиар төлдөг. Үүний зэрэгцээ Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн дагуу татварын өмнөх орлогоос 2 хувийн татварыг Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санд төвлөрүүлэх нь бидний хувьд татварын нэмэлт дарамт үүсгэж байна. Татварын өмнөх орлогоос ямарваа хэмжээгээр санд хөрөнгө төвлөрүүлэх нь бизнесийн зарчимд нийцээгүй, Монгол Улсын Үндсэн хууль, татварын багц хууль тогтоомжоос гадуур зохицуулалт болж байна гэж үзэж байна. Иймд уг 2 хувийг 1 хувиар тогтоох, эсхүл татвар ногдуулсны дараах тайлант үеийн нийт ашгаас тооцох байдлаар хуульд өөрчлөлт оруулах саналтай байна.</p>	<p>татварын дараах цэвэр ашгийн 3 хувьтай тэнцүү хэмжээтэй байна” хэмээн томъёолж, саналыг тусгав.</p>
3.		<p>3. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасны дагуу Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санд төвлөрүүлсэн хөрөнгийг Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан албан татвар ногдох орлогоос хасагдах зардалд тооцон оруулах саналтай байна. Одоогийн хуулийн зохицуулалтаар БНҮҮС-нд төвлөрүүлсэн хөрөнгийг албан татвар ногдох орлогоос хасагдах зардалд оруулан тооцуулах зохицуулалт байхгүй байгаагаас бид 2006-2019 он хүртэл БНҮҮС-нд төлсөн төлбөрөө татвар ногдох орлогоос хасуулж чадахгүй байгаа нь бидэнд татварын ихээхэн дарамт үүсгэж байгаа юм</p>	<p>Хуулийн төсөлд “татварын дараах цэвэр ашгаас” тооцохоор тусгасан тул саналыг тусгах боломжгүй.</p>
4.		<p>4. БНҮҮС-ийн олон улсын туршлагаас үзэхэд уг сан нь харилцаа холбооны зохицуулах байгууллага хариуцан ажилладаг. Учир нь зах зээлийн либеральчлалын бодлогыг хэрэгжүүлдэг зохицуулалтын арга хэрэгслүүдийн нэг юм. Либеральчлалын эхэн үед төрийн өмчит компаниудад үүрэг хүлээлгэх, дотаци өгөх замаар бүх нийтийн үйлчилгээг хүргэдэг. Либеральчлал гүнзгийрэхийн хирээр үйлчилгээний хүртээмж сайжирдаг тул үүрэг хүлээлгэх аргыг хэрэглэхээс бага багаар татгалзаж, шинэ технологи, үйлчилгээ нэвтрүүлэх, зах зээлд тулгуурласан реформ хийх зохицуулалтын арга хэрэгслүүдийг ашиглаж эхэлдэг. Либеральчлалын үйл явц хэрхэн өрнөж, өрсөлдөөний үр дүнд сүлжээ, үйлчилгээний хамрах</p>	<p>Уг асуудлыг энэхүү хуулийн төслөөр зохицуулахгүй тул саналыг тусгах боломжгүй.</p>

		<p>хүрээ, хүртээмж хэрхэн нэмэгдэж байгаагаас хамааран дээр дурьдсан реформ ажиллаагүй хэсэгт чиглүүлэх байдлаар бүх нийтийн үйлчилгээг хүргэх бодлого нь шинэчлэгдэж, зах зээлийн зохицуулалтын бусад арга хэрэгсэлүүдтэй хослуулан ажиллаж байж амжилтанд хүрдэг. Одоогийн байдлаар БНҮЭС ажилладаг 69 орны 45-д нь буюу зохицуулах байгуулагатай улс орнуудад зохицуулах байгууллага нь хариуцан ажиллаж байна. Түүнчлэн Монгол Улс Дэлхийн худалдааны байгууллагын Олон талт худалдааны хэлэлцээрийн Цахилгаан холбооны тухай хавсралтыг https://www.wto.org/english/strator_e/serve_e/telecom_e/tel23_e.htm/ хүлээн зөвшөөрч дээрх хэлэлцээрт нэгдэн орсон бөгөөд энэхүү Хавсралтааар БНҮҮ-ийн хэрэгжүүлэх нь зохицуулалтын хамрах хүрээний асуудал хэмээн тодорхойлсон байдаг. Тиймээс БНҮҮС-ийн зарцуулалтыг олон улсын жишгийн дагуу Харилцаа холбооны зохицуулах хорооны мэдэлд шилжүүлэх талаар уг хуулийн төсөлд тодорхой заалт оруулах саналтай байна.</p>		
5.		<p>5. Хуулийн төслийн 23 дугаар зүйлд 23.6 дахь заалт болгон “Энэ хуулийн 5.3.3-д заасан тусгай сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төслийн удирдах хороо болон хяналтын хорооны бүрэлдэхүүнд сангийн хөрөнгийн 15 хувиас дээш хөрөнгийг төвлөрүүлэгч этгээдийн болон мэргэжлийн төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулж, сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагаанд хяналт тавих нөхцлийг бүрдүүлнэ” гэж нэмэх саналтай байна.</p>		<p>Журмаар зохицуулах боломжтой тул хуулийн төсөлд тусгах боломжгүй.</p>
6.	Иргэн Я.Жамбалдорж	Эрүүл мэндийг дэмжих санг хасах		Саналыг тусгах боломжгүй
7.		Сангийн зарцуулалтыг ил тод болгох, хөндлөнгийн хяналт тавьж болохоор болгох		Хуулийн төслийн 22.2, 22.7, 23.5 зэрэг заалтуудаар ил тод байх асуудлыг тусгав.
8.		Гадаад, дотоодод суралцагчдийн сургалт, туршлага судлах зардалд Эрүүл мэндийг дэмжих сангаас мөнгө зарцуулахыг хориглох заалт оруулах		Саналыг тусгав.
9.	Харилцаа	Тус газраас Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн		Бүх нийтийн

	<p>холбоо, мэдээллийн технологийн газар</p>	<p>шинэчилсэн найруулгын төслийг зарчмын хувьд дэмжиж байгаа бөгөөд хуулийн төслийн 20.2 дахь хэсэг, 21.1 дэх хэсгийн "... 5.3.2" гэсний дараа "5.3.3" гэж нэмэх саналтай байна.</p> <p>Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан нь алслагдсан орон нутгийн үйлчилгээ хүрээгүй хүн амд харилцаа холбооны үйлчилгээ хүргэдэг улсын төсвөөс санхүүждэггүй, харилцаа холбооны тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс төвлөрүүлсэн хөрөнгөөр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлдэг бөгөөд 2012 оноос хойш ажлын алба ажиллуулж ирсэн.</p> <p>Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн санал авах, боловсруулах, нарийвчилсан судалгаа хийх, төслийн явцын шатанд танилцах, гүйцэтгэлийг хүлээж авах, төслийн үр дүнд бий болсон техник, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, найдвартай ажиллагааг хангах, төсөл, хөтөлбөрийн үр дүн, хэрэгжилтийг хянан шалгах хүрээнд жилдээ 10-аас доошгүй удаа төсөл хэрэгжүүлсэн цэг хүрч ажилладаг тул ажил хавсран гүйцэтгэх боломжгүй бөгөөд зайлшгүй тусдаа орон тооны ажилтан, ажлын албатай байх шаардлагатай байгаа болно.</p>		<p>үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах ажиллагаанд ажлын албатай байх шаардлагагүй тул саналыг тусгах боломжгүй.</p>
<p>10.</p>	<p>Юнивишн ХХК</p>	<p>Хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 9 дүгээр зүйлийн 9.3-т "Энэ хуулийн 9.2-т заснаар харилцаа холбооны үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээдээс төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ нь тухайн этгээдийн албан татвар ногдох орлогын 2 хувьтай тэнцүү байна" гэсэн нь уг санд хөрөнгө төвлөрүүлэгчдийн хууль ёсны ашиг сонирхолд ихээхэн харшилж байна. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийг дагуу татварын өмнөх орлогоос 2 хувийн татварыг Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санд төвлөрүүлэх нь бидний хувьд татварын нэмэлт дарамт үүсгэж байна.</p> <p>Хэдийгээр хуульд санд төвлөрүүлсэн хөрөнгө гэсэн нэр томъёогоор байгаа боловч үнэн хэрэгтээ үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжээс шууд авч байгаа татвар мөн юм. Ийнхүү татвар авах нь Монгол Улсын Үндсэн хууль, татварын багц хууль тогтоомжоос гадуур зохицуулалт болж байна гэж үзэж байна. Иймд хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 9 дүгээр зүйлийн 9.2, 9.3-т заасан харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчээс санд хөрөнгө төвлөрүүлэхтэй холбоотой хэсгийг хасч өгнө үү.</p>	<p>2019.06.14 01/438</p>	<p>Саналыг тусгах боломжгүй</p>

11.	Юнител ХХК	<p>1. Хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 9 дүгээр зүйлд “Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан нь төрийн бодлогын хүрээнд харилцаа холбооны зайлшгүй шаардлагатай үйлчилгээг алслагдсан орон нутаг болон үйлчилгээ хүрээгүй хүн амд бодит үнээр хүргэх, шинээр сүлжээ байгуулах, өргөтгөх, шинэчлэх зориулалттай байна” гэжээ. Одоогоор үүрэн холбооны сүлжээ ороогүй сум, суурин газар байхгүй / аль нэг операторын сүлжээ бүрэн орсон/ тул уг зорилгыг шинэчилж, дараа үеийн дэвшилтэт технологийн сүлжээ оруулах, нэгэнт оруулсан сүлжээний ашиглалт, үйлчилгээг хариуцахтай холбоотой зорилгыг шинээр оруулж өгөх нь зүйтэй гэж үзэж байна. Учир нь одоогийн зохицуулалтаар Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөр алслагдсан бүх нутагт сүлжээ оруулах тохиолдолд сонгон шалгаруулалтад оролцож шалгарсан компани зөвхөн сүлжээгээ оруулах төдийгөөр хөрөнгө оруулалтыг шийдэж өгдөг бөгөөд оруулсан сүлжээний ашиглалт, үйлчилгээтэй холбоотой асуудал байнга үүссээр байна. Иймд хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалтыг “Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан нь төрийн бодлогын хүрээнд харилцаа холбооны зайлшгүй шаардлагатай үйлчилгээг алслагдсан орон нутагт хүргэх, нэгэнт үйлчилгээ орсон газарт зайлшгүй шаардлагатай ашиглалт, үйлчилгээг хариуцах, харилцаа холбооны дараа үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, өргөтгөх, шинэчлэх зориулалттай байна” хэмээн өөрчлөх саналтай байна.</p>	<p>2019.06.14 01/1138</p>	<p>Хуулийн төслийн 9.1 дэх хэсэгт “харилцаа холбооны дараа үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх” гэсэн хэсгийг нэмж, саналыг тусгав.</p>
12.		<p>2. Хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 9 дүгээр зүйлийн 9.3-т “Энэ хуулийн 9.2-т заснаар харилцаа холбооны үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээдээс төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ нь тухайн этгээдийн албан татвар ногдох орлогын 2 хувьтай тэнцүү байна” гэсэн нь уг санд хөрөнгө төвлөрүүлэгчдийн хууль ёсны ашиг сонирхолд ихээхэн харшилж байна. Учир нь бодит байдал дээр уг сангийн хөрөнгийн 90%-ийг үүрэн холбооны 4 оператор компани бүрдүүлдэг. Эдгээд компаниуд нь ААНОАТ, 25 хувь хүртэл шатлалтай төлөхийн зэрэгцээ, Гаалийн татвар, НӨАТ, нийгмийн даатгалын шимтгэлийг үргэлж нэмэгдүүлсэн хувиар төлдөг. Үүний зэрэгцээ Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн дагуу татварын өмнөх орлогоос 2 хувийг татварыг Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санд төвлөрүүлэх нь бидний хувьд татварын нэмэлт дарамт үүсгэж байна. Татварын өмнөх орлогоос ямарваа хэмжээгээр санд хөрөнгө төвлөрүүлэх нь бизнесийн зарчимд нийцээгүй, Монгол Улсын Үндсэн хууль, татварын багц хууль тогтоомжоос гадуур зохицуулалт болж байна гэж үзэж байна. Иймд</p>	<p>“... хуулийн этгээдээс төвлөрүүлэх хөрөнгө нь татварын дараах цэвэр ашгийн 3 хувьтай тэнцүү хэмжээтэй байна” хэмээн томъёолж, саналыг тусгав.</p>	

		уг 2 хувийг 1 хувиар тогтоох, эсхүл татвар ногдуулсны дараах тайлант үеийн нийт ашгаас тооцох байдлаар хуульд өөрчлөлт оруулж өгнө үү.			Хуулийн төсөлд "татварын дараах цэвэр ашгаас" тооцохоор тусгасан тул саналыг тусгах боломжгүй.
13.		3. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасны дагуу Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санд төвлөрүүлсэн хөрөнгийг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан албан татвар ногдох орлогоос хасагдах зардалд оруулан тооцуулах зохицуулалт байхгүй байгаагаас бид 2006-2019 он хүртэл БНҮҮС-нд төлсөн төлбөрөө татвар ногдох орлогоос хасуулж чадахгүй байна. Энэ нь бидэнд татварын ихээхэн дарамт үүсгэж байна.		2019.06.14 01/20	"... хуулийн этгээдээс төвлөрүүлэх хөрөнгө нь татварын дараах цэвэр ашгийн 3 хувьтай тэнцүү хэмжээтэй байна" хэмээн томъёолж, саналыг тусгав.
14.	Орбитнет ХХК	Хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 9 дүгээр зүйлийн 9.3-т "Энэ хуулийн 9.2-т заснаар харилцаа холбооны үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээдээс төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ нь тухайн этгээдийн албан татвар ногдох орлогын 2 хувьтай тэнцүү байна" гэсэн нь уг санд хөрөнгө төвлөрүүлэгчдэд ихээхэн дарамт болж байна. Татварын өмнөх орлогоос ямарваа хэмжээгээр санд хөрөнгө төвлөрүүлэх нь бизнесийн зарчимд нийцээгүй, Монгол Улсын Үндсэн хууль, татварын багц хууль тогтоомжоос гадуур зохицуулалт болж байна гэж үзэж байна. Иймд уг 2 хувийг 1 хувиар тогтоох, эсхүл татвар ногдуулсны дараах тайлант үеийн нийт ашгаас тооцох байдлаар хуульд өөрчлөлт оруулж өгнө үү.		2016.06.13	Саналыг тусгах боломжгүй.
15.	Монголын аж олгогч эздийн нэгдсэн холбоо ТББ-ын төлөөлөл А.Цэнгэлсайхан	Сангуудыг татан буулгаж байгааг дэмжиж байна. Соёл, урлагийг дэмжих сангийн зорилго, чиглэл Боловсролын зээлийн сантай ижил тул энэ санг татан буулгах санал гаргаж байна.		Олон нийтийн хэлэлцүүлэгт гаргасан санал	
16.	Мэдээлэл холбооны операторуудын ассоциаци ТББ-ын гүйцэтгэх	1. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сантай холбоотой саналаа бичгээр өгнө. 2. Үндэсний контентийг хөгжүүлэх сан гэж байгуулахаар ярьж байгаа. Энэ сан нь Соёл, урлагийг дэмжих сантай давхцал үүсгэхээр байна.		2016.06.13 Олон нийтийн хэлэлцүүлэгт	-

17.	захирал У.Тамир Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Д. төлөөлөл Жавзмаа	Гэмт хэргийг хохирогчдоод нөхөн төлбөр олгох сангийн зохицуулалтад тусгасан гэмт хэргийн төрлөөс практикт гурван төрөлд л нөхөн олговор олгож байгаа. Бусад гэмт хэргийг төрлөөс хасах саналтай байна. Мөн УИХ-ын эмэгтэй гишүүдээс хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй холбоотойгоор сангаас нөхөн төлбөр олгох санал тавьдаг. Энэ саналыг оруулах	гаргасан санал 2016.06.13 Олон нийтийн хэлэлцүүлэгт гаргасан санал	ХЗДХЯ-аар дамжуулан гэмт хэргийн төрлийг нэмэх санал өгсөн ба тухайн саналыг тусгасан.
-----	---	--	--	--

-----o0o-----



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр,
Утас/Факс: (976-51) 26 75 33, E-mail: foreign@mojha.gov.mn,
<http://www.mojha.gov.mn>

2019.09.18 № 1-1/3443

танай 2019.07.09-ны № 8-2/4828-Т

**САНГИЙН САЙД
Ч.ХҮРЭЛБААТАР ТАНАА**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзэв.





МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД


15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26-74-68, <http://www.mpf.gov.mn>

2019.07.18 № 8-Э/4951

танай _____-ны № _____-т

**МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Л.ОЮУН-ЭРДЭНЭ ТАНАА**

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон бусад дагалдах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд холбогдох яамдын саналыг авч, эцэслэн боловсруулсан бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг үүгээр зөвшөөрч байна.


Ч.ХҮРЭЛБААТАР



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26-74-68, <http://www.mpf.gov.mn>

2019.07.18 № 8-Э/4959

танай _____-ны № _____-т

**МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Л.ОЮУН-ЭРДЭНЭ ТАНАА**

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон бусад дагалдах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд холбогдох яамдын саналыг авч, эцэслэн боловсруулан үүгээр хургалдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хавсралт ¹⁵² хуудастай.

Ч.ХҮРЭЛБААТАР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

САНГИЙН ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн хуралдааны 33 дугаар тэмдэглэлд:

"Ү.ХЭЛЭЛЦСЭН нь: Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэн дэмжээд Засгийн газрын гишүүдээс хуралдаан дээр гаргасан саналыг тусган Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов." гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар сарын
...-ний өдөр

Улаанбаатар хот

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ /шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Засгийн газрын тусгай сангийн төрлийг тогтоож, эдгээр санг бүрдүүлэх, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Хууль тогтоомж

2.1.Засгийн газрын тусгай сангийн тухай хууль тогтоомж нь Төсвийн тогтвортой байдлын тухай хууль¹, Төсвийн тухай хууль², Өрийн удирдлагын тухай хууль³, Шилэн дансны тухай хууль⁴, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Хуульд өөрөөр заагаагүй бол бүх тусгай сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, удирдлага, зохион байгуулалт болон хяналт тавих харилцаанд энэ хууль үйлчилнэ.

3.2.Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сан, Нийгмийн халамжийн сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Төсвийн тогтворжуулалтын сан, Ирээдүйн өв сан, Улсын авто замын сан, Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн бүрдүүлэлт, зарцуулалтын онцлогтой холбогдсон харилцааг тусгай хуулиар, нийтлэг харилцааг энэ хуулиар зохицуулна

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

¹ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль – “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2010 оны 30 дугаарт нийтлэгдсэн.

² Төсвийн тухай хууль – “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 3 дугаарт нийтлэгдсэн.

³ Өрийн удирдлагын тухай хууль – “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2015 оны 09 дугаарт нийтлэгдсэн.

⁴ Шилэн дансны тухай хууль - “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2014 оны 26 дугаарт нийтлэгдсэн.

4.1.1.“Засгийн газрын тусгай сан” /цаашид “Тусгай сан” гэх/ гэж Засгийн газрын тодорхой чиг үүрэг, зорилтыг санхүүжүүлэх зориулалттай төсвийн тусгай дансыг;

4.1.2.“эргэн төлөгдөх зээл” гэж тодорхой хугацааны дараа төсөвт эргүүлэн төвлөрүүлэх нөхцөлтэйгөөр олгож буй улсын төсвийн шилжүүлгийг;

4.1.3.“эргэн төлөгдөх нөхцөлгүй олгосон эх үүсвэр” гэж урсгал зардал, хөрөнгийн зардлыг санхүүжүүлэх зориулалттай улсын төсвийн шилжүүлгийг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Засгийн газрын тусгай сан, түүний төрөл

5 дугаар зүйл. Засгийн газрын тусгай сан, түүний төрөл

5.1.Тусгай сангийн орлого, зарлагын тайлан нь Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна.

5.2.Тусгай санг хуулиар байгуулж, татан буулгана.

5.3.Тусгай сан дараахь төрөлтэй байна:

5.3.1.Байгаль орчин, уур амьсгалын сан;

5.3.2.Боловсролын зээлийн сан;

5.3.3.Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан;

5.3.4.Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан;

5.3.5.Засгийн газрын нөөц сан;

5.3.6.Зэвсэгт хүчний хөгжлийн сан;

5.3.7.Ирээдүйн өв сан;

5.3.8.Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан;

5.3.9.Нийгмийн даатгалын сан

5.3.10.Нийгмийн халамжийн сан;

5.3.11.Соёл, урлагийг дэмжих сан;

5.3.12.Спортыг дэмжих сан;

5.3.13.Төсвийн тогтворжуулалтын сан;

5.3.14.Улсын авто замын сан;

5.3.15.Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих сан;

сан; 5.3.16.Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах

5.3.17.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан;

5.3.18.Шинжлэх ухаан, технологийн сан;

5.3.19.Эрүүл мэндийг дэмжих сан;

5.3.20.Эрүүл мэндийн даатгалын сан;

5.3.21.Кино урлагийг дэмжих сан.

5.4.Энэ хуулийн 5.3.4, 5.3.5, 5.3.7 болон 5.3.13-т заасан сангаас бусад Засгийн газрын тусгай сан нь зөвхөн Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд туссан үйл ажиллагааг санхүүжүүлэхэд чиглэдэг байх зарчим баримтална.

ГУРАВДУГААР БҮЛЭГ **Тусгай сангийн эх үүсвэр, зарцуулалт**

6 дугаар зүйл.Тусгай санг бүрдүүлэх нийтлэг эх үүсвэр

6.1.Тусгай сан нь дараахь нийтлэг эх үүсвэрээс бүрдэнэ:

6.1.1.Улсын төсвийн хөрөнгө;

6.1.2.Хандив, тусламж;

6.1.3.Тусгай сангийн өөрийн үйл ажиллагаанаас олсон орлого;

6.1.4.Зээлийн хүүгийн орлого.

6.2.Энэ хуулийн 6.1.1-д заасан улсын төсвийн хөрөнгө дараах төрөлтэй байна:

6.2.1.эргэн төлөгдөх зээл;

6.2.2.эргэн төлөгдөх нөхцөлгүй олгосон эх үүсвэр.

6.3.Энэ хуулийн 6.1.2-т заасан хандив, тусламжид гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн хандив, тусламж орно.

6.4.Энэ хуулийн 6.1.3-т заасан орлогод тусгай сангийн үндсэн болон туслах үйл ажиллагаанаас олсон орлого орно.

7 дугаар зүйл. Байгаль орчин, уур амьсгалын сан

7.1.Байгаль орчин, уур амьсгалын сан нь байгаль орчныг хамгаалах, байгалийн гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад дэмжлэг үзүүлэх зориулалттай байна.

7.2.Байгаль орчин, уур амьсгалын сангийн хөрөнгө энэ хуулийн 6.1.2 - 6.1.3 ба 6.2.2-т зааснаас гадна дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

7.2.1.тусгай хамгаалалттай газар нутагт байгалийн аялал, жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх эрхийн бичиг олгосны хураамж болон тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх ажил үйлчилгээний нэг удаагийн хөлс;

7.2.2.Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн⁵ 13.2 дахь хэсэгт заасан мөнгөн хөрөнгө;

7.2.3.Усны тухай хуулийн⁶ 3.1.32-т заасан ус бохирдуулсны төлбөрийн орлого;

7.2.4.иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас байгаль орчин болон байгалийн нөөц баялагт учруулсан хохирлын нөхөн төлбөрийн орлого;

7.2.5.Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд ашиглаж хураалгасан зэвсэг, тээврийн хэрэгсэл, унаа хөсөг, техник, тоног төхөөрөмжийг борлуулсны орлого;

7.2.6.хууль бусаар бэлтгэсэн байгалийн баялгийг борлуулсны орлого;

7.2.7.Агаарын тухай хуулийн⁷ 3.1.14-т заасан агаарын бохирдлын төлбөрийн орлого;

7.2.8.Ойн тухай хуулийн 31.1-д заасан хандивын орлого.

7.3.Сангийн хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

7.3.1.байгалийн баялгийн нөөц, байгаль орчны төлөв байдлын хувьсал, өөрчлөлтийн байдлыг судлан тогтоох, мэдээллийг хуримтлуулж боловсруулах, дүгнэлт гаргах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх;

7.3.2.байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд үзүүлэх хортой нөлөөллийг багасгах дэвшилт арга, хоргүй, бохирдолгүй, хаягдалгүй, эрчим хүчний хэмнэлттэй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг урамшуулах;

7.3.3.хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх олон нийтийн боловсролыг дээшлүүлэх, сургалт, сурталчилгаа зохион байгуулах;

⁵ Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2012 оны 22 дугаарт нийтлэгдсэн.

⁶ Усны тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2012 оны 22 дугаарт нийтлэгдсэн.

⁷ Агаарын тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2012 оны 22 дугаарт нийтлэгдсэн.

7.3.4.Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн⁸ 56 дугаар зүйлд заасан экологийн боловсрол, хүмүүжил олгох ажлыг дэмжих;

7.3.5.хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг мөрдөхөд шаардлагатай үнэлгээ, шинжилгээ, шинжээчийн болон лабораторийн зардлыг санхүүжүүлэх;

7.3.6.уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, хүлэмжийн хийг бууруулахад дэмжлэг үзүүлэх;

7.3.7.ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн байгуулах;

7.3.8.агаар, орчны бохирдлыг бууруулах нэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

7.3.9.мэрэгч, хөнөөлт хортон шавьж устгах;

7.3.10.усыг хамгаалах, усны бохирдлыг арилгах, хяналт-шинжилгээ хийх, нөхөн сэргээх;

7.3.11.байгалийн гамшигт үзэгдлээс учирч болох эрсдэлийг бууруулах чиглэлээр олон нийтийн боловсролыг дээшлүүлэх, танин мэдэхүйн үйл ажиллагааг дэмжих.

7.4.Байгаль орчин, уур амьсгалын сангийн зохион байгуулалт, сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмыг Засгийн газар батална.

8 дугаар зүйл.Боловсролын зээлийн сан

8.1.Боловсролын зээлийн сан нь санхүүгийн дэмжлэг, тэтгэлэг, сургалтын төлбөрийн зээл олгох замаар дээд боловсрол эзэмших хүсэлтэй тодорхой шалгуур, шаардлагыг хангасан иргэдийг төрөөс дэмжих бодлогыг хэрэгжүүлэх зориулалттай байна.

8.2.Боловсролын зээлийн сангийн хөрөнгө нь энэ хуулийн 6.1-д заасан эх үүсвэрээс бүрдэнэ.

8.3.Сангийн хөрөнгийг Засгийн газраас баталсан журмын дагуу иргэдэд олгох сургалтын төлбөрийн зээл, хуулиар тогтоосон бусад санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээ болон сангийн үйл ажиллагаа, үндсэн хөрөнгөтэй холбогдсон зардлыг санхүүжүүлэхэд зарцуулна.

8.4.Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмыг Засгийн газар батална.

9 дүгээр зүйл. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан

9.1.Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан нь төрийн бодлогын хүрээнд харилцаа холбооны зайлшгүй шаардлагатай үйлчилгээг алслагдсан орон нутаг болон үйлчилгээ хүрээгүй хүн амд бодит үнээр хүргэх, шинээр сүлжээ байгуулах,

⁸ Байгаль орчныг хамгаалах тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1995 оны 5-6 дугаарт нийтлэгдсэн.

харилцаа холбооны дараа үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, өргөтгөх, шинэчлэх зориулалттай байна.

9.2.Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгө нь энэ хуулийн 6.1.2 ба 6.1.3-т заасан эх үүсвэр болон харилцаа холбооны үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээдээс төвлөрүүлсэн хөрөнгөөс бүрдэнэ.

9.3.Энэ хуулийн 9.2-т зааснаар харилцаа холбооны үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээдээс төвлөрүүлэх хөрөнгө нь татварын дараах цэвэр ашгийн 3 хувьтай тэнцүү хэмжээтэй байна.

9.4.Сангийн хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

9.4.1.зайлшгүй шаардлагатай харилцаа холбооны үйлчилгээг алслагдсан орон нутагт болон үйлчилгээ хүрээгүй хүн амд хүргэх;

9.4.2.харилцаа холбооны сүлжээ шинээр байгуулах, өргөтгөх, шинэчлэх.

9.5.Сангийн хөрөнгөөр баригдсан барилга байгууламжийн ашиглалт, засвар арчилгааг тухайн байгууламжийг үйл ажиллагаандаа ашиглаж байгаа харилцаа холбооны үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээд хариуцна.

9.6.Сангийн хөрөнгөөс аливаа татаас, урамшуулал, дэмжлэг олгохыг хориглоно.

9.7.Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг бүрдүүлэх, зарцуулах журмыг Засгийн газар батална.

10 дугаар зүйл.Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан

10.1.Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан нь Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн, энэ хуулийн 10.3-т заасан гэмт хэргийн улмаас амь насаа алдсан этгээдийн гэр бүлийн гишүүн, хүнд гэмтэл учирсан хохирогчдод нөхөн төлбөр олгох зориулалттай байна.

10.2.Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан нь энэ хуулийн 6.1.1 болон 6.1.2-т зааснаас гадна дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

10.2.1.шүүхээс ногдуулсан торгох ялыг биелүүлж, төсөвт тушаасан мөнгөн хөрөнгийн 60 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө;

10.2.2.шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр энэ хуулийн 10.3-т заасан гэмт хэрэгт гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдээс хохирол барагдуулсан төлбөр.

10.3.Эрүүгийн хуулийн⁹ 10.1 дүгээр зүйл/Хүнийг алах/, 11.1 дүгээр зүйл /Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах/, 11.4 дүгээр зүйл /Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах/, 12.1 дүгээр зүйл /Хүчиндэх/, 12.3 дугаар зүйл /Бэлгийн мөлжлөг/, 13.1 дүгээр зүйл /Хүн худалдаалах/, 13.2 дугаар зүйл /Хүн хулгайлах/, 13.3 дугаар зүйл /Хүн барьцаалах/, 13.4 дүгээр зүйл /Хүнийг

⁹ Эрүүгийн хууль - "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2016 оны 07 дугаарт нийтлэгдсэн.

хүчээр алга болгох/, 15.3 дугаар зүйл /Хүний цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авах/, 15.5 дугаар зүйл /Хууль бусаар үр хөндөх/, 16.1 дүгээр зүйл /Хүүхдийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах/, 16.3 дугаар зүйл /Хүүхдийг хаях, төөрүүлэх, тэнүүчлэлд хүргэх/, 16.6 дугаар зүйл /Хүүхэд худалдах/, 16.7 дугаар зүйл /Хүүхэдтэй хэрцгий харьцах/, 16.11 дүгээр зүйл /Хүүхдийг асран хамгаалах үүргээ үл биелүүлэх/, 17.2 дугаар зүйл /Дээрэмдэх/, 19.3 дугаар зүйл /Төрийн өндөр албан тушаалтны амь биед халдах/, 21.12 дугаар зүйл /Эрүү шүүлт тулгах/, 29.1 дүгээр зүйл /Түрэмгий дайныг төлөвлөх, бэлтгэх, өдөөх, дэгдээх/, 29.8 дугаар зүйл /Террор үйлдэх/-д заасан гэмт хэргийн улмаас амь насаа алдсан этгээдийн гэр бүлийн гишүүн, түүнчлэн хүнд гэмтэл учирсан хохирогчийн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрт заасан дор дурдсан хохиролд нөхөн төлбөр олгоход зарцуулна:

10.3.1.эмчилгээний зардал;

10.3.2.оршуулгын зардал;

10.3.3.хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлого.

10.4.Гэмт хэргийн хохирогчид олгох нөхөн төлбөрийн хэмжээ нь хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх тухай шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тодорхойлогдоно.

10.5.Сангаас гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох журмыг Засгийн газар батална.

11 дүгээр зүйл. Засгийн газрын нөөц сан

11.1.Засгийн газрын нөөц сан нь тухайн жилийн төсөвт урьдчилан тооцож төлөвлөн тусгах боломжгүй, хойшлуулшгүй цаг үеийн шинжтэй арга хэмжээ болон Гамшгаас хамгаалах тухай хуулийн¹⁰ 4.1.15-д заасан гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагааг шат дараатай зохион байгуулах зорилгоор улс, орон нутгийн төсвийн гамшгаас хамгаалах арга хэмжээний зардлын хүрэлцэхгүй хэсгийг санхүүжүүлэх зориулалттай байна.

11.2.Засгийн газрын нөөц сан нь энэ хуулийн 6.1.1 болон 6.1.2-д заасан эх үүсвэрээс бүрдэнэ.

11.3.Засгийн газрын нөөц санд төвлөрүүлэх хөрөнгийн нийт хэмжээ нь тухайн төсвийн жилд төлөвлөгдөж байгаа дотоодын нийт бүтээгдэхүүний 1 хувиас ихгүй байна.

11.4.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 11.1-д заасан зориулалтаар өмнөх онд гарсан зардлын гүйцэтгэл, байгаль, цаг уурын болзошгүй өөрчлөлтийн талаарх судалгаа, урьдчилсан таамаглал, экспорт, импортын бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дэх үнийн хэлбэлзэл, цаашдын төлөв, төсвийн орлогын боломж, чадавхыг харгалзан тухайн жилд улсын төсвөөс нөөц санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг төлөвлөнө.

¹⁰ Гамшгаас хамгаалах тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2017 оны 07 дугаарт нийтлэгдсэн.

11.5. Сангийн хөрөнгийг дараах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

11.5.1. Гамшгаас хамгаалах тухай хуульд¹¹ заасан гамшиг, аюулт үзэгдэл тохиолдсон, нийтийг хамарсан цөмийн болон цацрагийн осол гарсан үед түүний хохирлыг бууруулах, тархалтыг хязгаарлах, үр дагаврыг арилгах;

11.5.2. үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс барилга байгууламж, шугам, сүлжээ, тоног төхөөрөмж эвдрэх, тээврийн хэрэгсэл сүйрэх, Гамшгаас хамгаалах тухай хуульд¹² заасан цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах зэрэг техникийн холбогдолтой томоохон осол гарсан тохиолдолд түүнийг таслан зогсоох, хохирлыг арилгах;

11.5.3. алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд учирсан хохирлыг арилгах;

11.5.4. төсвийн жилийн явцад шинээр батлагдсан хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нэмэлт зардал;

11.5.5. Засгийн газар олон улсын шүүх, арбитраг хариуцагчаар татагдсан буюу тэдгээрээс гарсан шийдвэрийг биелүүлэхэд шаардагдах зардал;

11.5.6. олон улсын гэрээний дагуу Монгол Улс төлж барагдуулах тухайн жилийн төсөвт тусгагдаагүй татвар, төлбөр, хураамж.

11.6. Засгийн газрын нөөц сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмыг Засгийн газар батална.

12 дугаар зүйл. Зэвсэгт хүчний хөгжлийн сан

12.1. Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, зэвсэгт хүчний үүрэг гүйцэтгэх чадавхыг дээшлүүлэх зориулалттай байна.

12.2. Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн хөрөнгө нь энэ хуулийн 6.1.1, 6.1.2-д зааснаас гадна дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

12.2.1. энхийг дэмжих ажиллагаанд оролцсоны нөхөн төлбөрийн Засгийн газраас тогтоосон зохих хэсэг;

12.2.2. энхийг дэмжих ажиллагаанд Монгол Улсын зэвсэгт хүчнээс ашиглуулж байгаа үндсэн болон туслах зэвсэглэл, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, материал хэрэгслийн нөхөн төлбөр;

12.2.3. зэвсэглэлээс хасагдаж акт тавигдсан зарим төрлийн техникийг худалдаж борлуулсны орлого;

12.2.4. улсын хэмжээний бүтээн байгуулалтад цэргийн анги, салбар, нэгжийг оролцуулснаас олсон ашиг;

¹¹ Гамшгаас хамгаалах тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2017 оны 07 дугаарт нийтлэгдсэн.

¹² Гамшгаас хамгаалах тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2017 оны 07 дугаарт нийтлэгдсэн.

12.2.5.энхийг дэмжих ажиллагааны сургалт, бэлтгэлийн нөхөн төлбөр;

12.2.6.гадаад оронтой байгуулсан цэргийн болон цэрэг-техникийн хамтын ажиллагааны хүрээнд олгосон хандив, тусламжийн орлого.

12.3.Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн хөрөнгийг дараахь зориулалтаар зарцуулна:

12.3.1.зэвсэгт хүчнийг энхийг дэмжих ажиллагаанд оролцох чадавхыг нэмэгдүүлэх;

12.3.2.террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох, Гамшгаас хамгаалах тухай хуульд¹³ заасан гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон, аюул бий болсон үед, бусад олон талт үүрэг гүйцэтгэхэд хүн, байгаль орчны аюулгүй байдлыг хангах, орон нутгийн хамгаалалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний сургалт болон бэлтгэлийг хангуулах;

12.3.3.зэвсэгт хүчний зэвсэглэл, техникийг сэргээн сайжруулах, шинэчлэх, сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх;

12.3.4.энхийг дэмжих ажиллагаанд оролцохтой холбогдсон бусад үйл ажиллагааг санхүүжүүлэх;

12.3.5.энхийг дэмжих ажиллагаа, хүмүүнлэгийн сургалтыг Монгол Улсад зохион байгуулах;

12.3.6.батлан хамгаалах салбарт ажиллаж байгаа офицер, ахлагч, ажилчин, албан хаагчдын нийгмийн хамгааллыг сайжруулах;

12.3.7.олон улсын гэрээний заалтын дагуу зориулалт зааж олгосон хандив, тусламжаас бусад орлогын 70-аас доошгүй хувийг энэ хуулийн 12.3.1-12.3.5-д заасан зориулалтаар.

12.3.8.энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэхэд оролцогч цэргийн алба хаагч амь насаа алдсан тохиолдолд цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу түүний ар гэрт нэг удаагийн тэтгэмжийг олгох.

12.4.Энэ хуулийн 12.2.6-д заасан орлого, түүний зарцуулалтыг тухайн талтай байгуулсан гэрээний нөхцөл, болзолтой холбогдуулан Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасан нууцын зэрэглэлд хамааруулж болно.

12.5.Зэвсэгт хүчний хөгжлийн санг бүрдүүлэх, зарцуулах журмыг Засгийн газар батална.

13 дугаар зүйл.Соёл, урлагийг дэмжих сан

¹³ Гамшгаас хамгаалах тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2017 оны 07 дугаарт нийтлэгдсэн.

13.1.Соёл, урлагийг дэмжих сан нь соёл, урлагийг хөгжүүлэх, сурталчлан таниулах, соёлын өвийг бүртгэх, судлах, хадгалан хамгаалах, сэргээн засварлах, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах зориулалттай байна.

13.2.Соёл, урлагийг дэмжих сангийн хөрөнгө нь энэ хуулийн 6.1-д заасан эх үүсвэрээс бүрдэнэ.

13.3.Сангийн хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

13.3.1.соёлын өвийг хадгалж хамгаалах, сэргээн засварлах, сурталчлах, мэдээллийн нэгдсэн сан байгуулж, баяжуулах;

13.3.2.урлаг, утга зохиолын шинэ уран бүтээл туурвих, нийтийн хүртээл болгох төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

13.3.3.төсвийн хөрөнгөөр бүтээх үндэсний уламжлалт бөгөөд сонгодог урлагийн бүтээл туурвих;

13.3.4.соёлын өв, үндэсний соёл, урлагийг гадаадад болон өөрийн оронд сурталчилсан дуу авианы бичлэг хийх, ном хэвлүүлэх, соёл, урлагийн мэргэжлийн сонин, сэтгүүл гаргахад дэмжлэг үзүүлэх;

13.3.5.соёл, урлагийн тоглолт хийх, түүх, соёлын дурсгалт зүйл, уран бүтээлийн үзэсгэлэнг гадаадад болон өөрийн оронд зохион байгуулах;

13.3.6.хүүхдэд уран сайхан, гоо зүйн мэдлэг олгох уран бүтээл туурвих, соёл, урлагийн арга хэмжээ зохион байгуулах;

13.3.7.соёл, урлагийн байгууллагад онцгой шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хөгжмийн зэмсэг худалдан авах;

13.3.8.хөгжмийн том хэмжээний болон дүрслэх урлаг, ном хэвлэлийн шилдэг бүтээлийг улсын санд худалдан авах;

13.3.9.олон улсын хэмжээний соёл, урлагийн наадам, тэмцээн, үзэсгэлэн, номын яармагт уран бүтээлчдийг оролцуулах, оролцож онцгой амжилт гаргасан соёлын ажилтан, уран бүтээлчдийг шагнаж урамшуулах;

13.3.10.үндэсний соёл, урлагийг хөгжүүлэх, соёлын өвийг хадгалж хамгаалахад хувь нэмэр оруулсан аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг алдаршуулах;

13.3.11.Монгол судлаачдыг бэлтгэх, Монгол судлаач, эрдэмтдийн шилдэг бүтээлийг шалгаруулж, хэвлүүлэх, сурталчлахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх.

13.4.Соёл, урлагийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмыг Засгийн газар батална.

14 дүгээр зүйл. Спортыг дэмжих сан

14.1. Спортыг дэмжих сан нь нийтийн биеийн тамир, хүн амын идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх, өндөр зэрэглэлийн тамирчин, дасгалжуулагчийг шинжлэх ухааны үндэслэлтэй бэлтгэх, үндэсний спортын төрлийг хөгжүүлэх, сэргээшний эсрэг хяналтыг хэрэгжүүлэх, сэргээшний эсрэг үйл ажиллагааны сургалт, сурталчилгааг зохион байгуулах, биеийн тамир, спортын чиглэлээр судалгаа, шинжилгээ хийх зориулалттай байна.

14.2. Спортыг дэмжих сангийн хөрөнгө нь энэ хуулийн 6.1.2, 6.1.3 ба 6.2.2-т заасан нийтлэг эх үүсвэрээс бүрдэнэ.

14.3. Сангийн хөрөнгийг доор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

14.3.1. нийтийн биеийн тамир, хүн амын идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэхэд чиглэсэн төсөл, арга хэмжээ;

14.3.2. өндөр зэрэглэлийн тамирчин, дасгалжуулагчийг шинжлэх ухааны үндэслэлтэй бэлтгэх, хөгжүүлэхэд чиглэсэн төсөл, арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх;

14.3.3. үндэсний спортын төрлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

14.3.4. үндэсний хэмжээний тэмцээн, наадмын сэргээшний эсрэг хяналтыг хэрэгжүүлэх, сэргээшний эсрэг үйл ажиллагааны сургалт, сурталчилгааг зохион байгуулах.

14.4. Спортыг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, хяналт тавих журмыг Засгийн газар батална.

15 дугаар зүйл. Төсвийн тогтворжуулалтын сан

15.1. Төсвийн тогтворжуулалтын сан нь нэгдсэн төсвийн дунд болон урт хугацааны тэнцвэртэй, тогтвортой байдлыг хангах, төсвийн тэнцвэржүүлсэн горимыг хэрэгжүүлэхэд санхүүгийн хэрэгслийн үүрэг гүйцэтгэнэ.

15.2. Төсвийн тогтворжуулалтын санг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:

15.2.1. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан нөхцөлөөр тодорхойлсон төсвийн тэнцвэржүүлсэн орлогоос давсан төсвийн орлого;

15.2.2. төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн ашиг;

15.2.3. Засгийн газрын нөөц сангийн өмнөх жилийн зарцуулагдаагүй чөлөөт эх үүсвэр;

15.2.4. Төсвийн тогтворжуулалтын сангийн санхүүгийн үйл ажиллагаанаас олсон орлого;

15.2.5. бусад орлого.

15.3. Сангийн хөрөнгөөс дор дурдсан санхүүжилт хийх зориулалтаар улсын төсөвт шилжүүлж болно:

15.3.1. урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурч төсвийн тэнцэл баталсан хэмжээнээс дотоодын нийт бүтээгдэхүүний 4 хувиар нэмж буурсан тохиолдолд үнэ болон биет хэмжээ нь төлөвлөснөөс буурсан гол нэр төрлийн эрдэс баялгийн Төсвийн тогтворжуулалтын санд өмнө хуримтлагдсан хөрөнгөөс зөвхөн тэнцвэржүүлсэн үнэ болон зах зээлийн үнийн зөрүүгээс үүссэн төсвийн орлогын тасалдлыг;

15.3.2. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан тохиолдлын улмаас үүссэн төсвийн санхүүжилтийн нэмэлт эх үүсвэр.

15.3.3. төсвийн гол нэр төрлийн эрдэс баялгийн зах зээлийн үнэ төсөвт туссан тэнцвэржүүлсэн үнээс буурсан болон гол нэр төрлийн эрдэс баялгийн экспортын биет хэмжээ төсөвт туссан биет хэмжээнээс 20 хувиар буурсан тохиолдолд уг үнэ болон биет хэмжээ нь төлөвлөснөөс буурсан гол нэр төрлийн эрдэс баялгийн Төсвийн тогтворжуулалтын санд өмнө хуримтлагдсан хөрөнгөөс зөвхөн тэнцвэржүүлсэн үнэ болон зах зээлийн үнийн зөрүүгээс үүссэн төсвийн орлогын тасалдлыг.

15.3.4. тухайн жилийн төсвийн алдагдлыг нөхөх.

15.4. Энэ хуулийн 15.3.1-д заасан зөрүүг нөхөн зарцуулалт хийх шийдвэрийг Засгийн газар гарган хэрэгжүүлж, төсвийн гүйцэтгэлд тусгана.

15.5. Төсвийн тогтворжуулалтын сангийн хөрөнгө нь энэ хуулийн 15.3.1-д заасан төсвийн алдагдлыг бүрэн санхүүжүүлэхэд хүрэлцэхгүй тохиолдолд уг алдагдлыг санхүүжүүлэх зориулалтаар Засгийн газар Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т заасан хязгаарт багтаан зээл авч болно.

15.6. Төсвийн тогтворжуулалтын сангийн хөрөнгийг энэ хуулийн 15.3-т заасан зориулалтаар санхүүжилт хийхэд байнга хөрвөх чадвартай байлгах, эрсдэлээс хамгаалах, олон улсын санхүүгийн зах зээлд үр ашигтай хөрөнгө оруулалт хийхэд чиглэсэн санхүүгийн нөөцийн удирдлагыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.

15.7. Энэ хуулийн 15.6 дахь хэсгийн хэрэгжилтийг Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгаж Улсын Их Хуралд танилцуулна.

15.6. Төсвийн тогтворжуулалтын сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмыг Засгийн газар батална.

16 дугаар зүйл. Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих сан

16.1. Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих сан нь жижиг, дунд үйлдвэрлэл, газар тариалан, мал аж ахуй эрхлэх үйл ажиллагааг дэмжих зориулалттай байна.

16.2. Сангийн хөрөнгө нь энэ хуулийн 6.1 ба 16.4-т заасан эх үүсвэрээс бүрдэнэ.

16.3.Жижиг, дунд үйлдвэрлэлийн бодит өсөлт, мөнгөний ханшны өөрчлөлтийг харгалзан тухайн жилд улсын төсвөөс Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих санд нэмж олгох, зээлийн эргэн төлөлтөөс олгох зээлийн хэмжээг Засгийн газрын саналыг үндэслэн Улсын Их Хурал тухайн жилийн төсөвт тусгаж батална.

16.4.Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих санд орон нутгийн төсвөөс хөрөнгө олгож болох бөгөөд түүний хэмжээг аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн жилийн орон нутгийн төсөвт тусгаж батална.

16.5. Энэ хуулийн 16.4-т заасан эх үүсвэрийг тухайн орон нутгийн энэ хуулийн 16.1-д заасан арга хэмжээнд зарцуулна.

16.6.Сангийн хөрөнгийг дараахь арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

16.6.1.жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх, газар тариалан, мал аж ахуй эрхлэлтийг дэмжих зориулалтаар хөнгөлөлттэй зээл олгох;

16.6.2.жижиг, дунд үйлдвэрлэл, газар тариалан, мал аж ахуй эрхлэхэд бизнес, инкубацын зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, сургалт, давтан сургалтад хамруулах;

16.6.3.жижиг, дунд үйлдвэрлэл, газар тариалан, мал аж ахуй, бэлчээрийг усжуулах чиглэлээр судалгаа, шинжилгээ хийх, мэдээллийн сан бүрдүүлэх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

16.6.4.сангийн үндсэн болон өр барагдуулахтай холбогдсон үйл ажиллагаа, үндсэн хөрөнгөтэй холбогдсон зардлыг санхүүжүүлэх;

16.6.5.жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид зориулсан үндэсний болон олон улсын хэмжээний үзэсгэлэн, худалдаа, чуулга уулзалт зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх;

16.6.6.энэ хуулийн 23.7 дахь хэсэгт заасан үйл ажиллагааг санхүүжүүлэх;

16.6.7.шаардлагатай тохиолдолд улсын төсвийн хөрөнгөөр худалдан авсан жижиг, дунд үйлдвэрийг дэмжихэд чиглэсэн тоног төхөөрөмжийн санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа эрхлэх.

16.7.Сангаас мал амьтнаар зээл олгохыг хориглоно.

16.8.Энэ хуулийн 16.6.1-т заасан хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журмыг Засгийн газар батална.

16.9.Энэ хуулийн 16.6.1-т заасан хөнгөлөлттэй зээлийг банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтмол ханган ажиллаж байгаа, хөдөө орон нутагт салбартай банкаар дамжуулан олгоно.

16.10.Энэ хуулийн 16.9 дахь хэсэгт зааснаас гадна банканд тавих нэмэлт шаардлага, нөхцөлийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтоож болно.

17 дугаар зүйл. Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан

17.1.Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан нь хилийн чанадад ажиллаж, амьдарч, сурч байгаа иргэдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалж, эрх нь зөрчигдсөн тохиолдолд хууль, эрх зүйн туслалцааг шуурхай үзүүлж, иргэний бүртгэл, нотариатын болон консулын үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах зориулалттай байна.

17.2.Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн хөрөнгө нь энэ хуулийн 6.1.2 ба 6.2.2-т заасан эх үүсвэрээс бүрдэнэ.

17.3.Сангийн хөрөнгийг дараах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

17.3.1.хилийн чанадад нас барсан иргэний гэр бүл нь түүний шарил буюу чандрыг эх оронд нь авчрах зардалгүй, эсхүл гэр бүл, төрөл садан нь тогтоогдоогүй тохиолдолд түүний шарилыг хадгалах, чандарлах, шарил болон чандрыг эх оронд нь буцаах буюу тухайн улсад нь нутаглуулах;

17.3.2.хилийн чанадад байгалийн онц аюултай гамшиг, терроризм, зэвсэгт мөргөлдөөнд өртсөн, эсхүл осол, гэмт хэргийн улмаас хүнд гэмтэл авсан, сэтгэцийн өвчтэй болсон, амь насанд нь аюул учирсан иргэнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, эх оронд нь буцаах;

17.3.3.хилийн чанадад хорих ял эдэлж байгаад, эсхүл албадан саатуулагдаж байгаад суллагдсан иргэн эх орондоо буцах зардалгүй тохиолдолд нутаг буцаах;

17.3.4.гэмт хэргийн улмаас хохирсон буюу эд хөрөнгөө хаяж гээгдүүлсний улмаас төлбөрийн чадваргүй болсон иргэнийг эх оронд нь буцаах;

17.3.5.энэхүү Хуулийн 17.3.1-17.3.4-т заасан иргэнд үндэсний гадаад паспорт буюу буцах үнэмлэх олгох, эх оронд нь буцаахтай холбогдсон бусад үйлчилгээ үзүүлэх;

17.3.6.хилийн чанадад гэмт хэргийн улмаас хохирсон иргэнтэй холбоотой асуудлыг тухайн улсын холбогдох хууль, хяналтын байгууллагаар шалгуулах, хянуулах, эрх ашгийг нь хамгаалахад шаардагдах өмгөөлөгч, орчуулагчийг хөлслөх;

17.3.7.хилийн чанадад хорих ял эдэлж байгаа иргэнийг Дипломат төлөөлөгчийн газраас эргэх;

17.3.8. гадаад улстай байгуулсан эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээнд заасан Монголын талын төв байгууллагаас гадаад улсад хүргүүлэх эрх зүйн туслалцааны хүсэлт болон холбогдох баримт бичгийг гадаад хэл үрүү орчуулах төлбөрийг гаргах.

17.4.Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмыг Засгийн газар батална.

18 дугаар зүйл.Шинжлэх ухаан, технологийн сан

18.1.Шинжлэх ухаан, технологийн сан нь шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлийн онолын суурь судалгаа гүйцэтгэх, шинжлэх ухаан, технологийн болон инновацын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, эрдэм шинжилгээний ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх зориулалттай байна.

18.2.Шинжлэх ухаан, технологийн сангийн хөрөнгө нь энэ хуулийн 6.1.1, 6.1.2 ба 6.1.3-т заасан эх үүсвэрээс бүрдэнэ.

18.3.Сангийн хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

18.3.1.шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлийн онолын суурь судалгаа хийх;

18.3.2.Засгийн газрын /улсын/ захиалгатай шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэхэд тэтгэлэг олгох;

18.3.3.эрдэм шинжилгээний ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх;

18.3.4.инновацын төсөл хэрэгжүүлэх, гарааны санхүүгийн дэмжлэг олгох, технологи, үйлдвэрлэлийн туршилт, зүгшрүүлэлтэд дэмжлэг үзүүлэх;

18.3.5.Сангийн үйл ажиллагаа, үндсэн хөрөнгөтэй холбогдсон зардлыг санхүүжүүлэх;

18.3.6.Шинжлэх ухаан, инновацийн үр дүнд бий болсон бүтээгдэхүүн, үйлчилгээг олон улсад сурталчлах, борлуулахад дэмжлэг үзүүлэх.

18.4.Сангийн хөрөнгөөс аливаа татаас, урамшуулал олгохыг хориглоно.

18.5.Шинжлэх ухаан, технологийн сангаас тэтгэлэг олгох, сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмыг Засгийн газар батална.

19 дүгээр зүйл.Эрүүл мэндийг дэмжих сан

19.1.Эрүүл мэндийг дэмжих сан нь эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх зориулалттай байна.

19.2.Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгө нь энэ хуулийн 6.1.2 ба 6.2.2-т заасан эх үүсвэрээс гадна дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

19.2.1.архи, согтууруулах ундааны онцгой албан татварын 1 хувь, эмийн импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын 2 хувь болон тамхины онцгой албан татварын 2 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө.

19.3.Сангийн хөрөнгийг дараахь чиглэлээр эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг зохион байгуулах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

19.3.1.халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх;

19.3.2.халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх;

19.3.3.орчны эрүүл мэндийг хамгаалах;

19.3.4.осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, эрүүл аюулгүй амьдралын орчныг бүрдүүлэх;

19.3.5.сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, архи, тамхи, мансууруулах бодисын хорт нөлөөллөөс сэргийлэх;

19.3.6.эмийн зохистой хэрэглээг сурталчлан таниулах;

19.3.7.эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, эрүүл мэндийн байгууллагын ил тод байдал, хариуцлагыг дээшлүүлэх.

19.4.Сангийн хөрөнгөөс аливаа татаас, урамшуулал, тусламж олгохыг хориглоно.

19.5.Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, хяналт тавих журмыг Засгийн газар батална.

20 дугаар зүйл. Кино урлагийг дэмжих сан

20.1.Кино урлагийг дэмжих сан нь кино урлагийг хөгжүүлэх, үйлдвэрлэх, түгээн таниулахад дэмжлэг үзүүлэх зориулалттай байна.

20.2.Кино урлагийг дэмжих сангийн хөрөнгө нь энэ хуулийн 6.1-д заасан эх үүсвэрээс бүрдэнэ.

20.3.Сангийн хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

20.3.1.Монгол болон хамтарсан кино бүтээх зориулалтаар хөнгөлөлттэй зээл олгох;

20.3.2.кино үйлдвэрлэл, дэд бүтцийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх;

20.3.3.олон улсын кино наадам, үзэсгэлэнд Монгол киног оролцуулах, Монгол Улсад олон улсын кино наадам зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

20.3.4.улсын захиалгаар уран сайхны болон баримтат кино, хүүхэд залуучуудад зориулсан кино бүтээл туурвихад дэмжлэг үзүүлэх;

20.3.5.кино урлагийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, мэргэшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх.

20.4.Кино урлагийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмыг Засгийн газар батална.

20.5.Энэ хуулийн 20.3.1-д заасан хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмыг Засгийн газар батална.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Тусгай сангийн удирдлага, санхүүжилт

21 дүгээр зүйл.Тусгай сангийн удирдлага, зохион байгуулалт

21.1.Тусгай сангийн эх үүсвэр нь төрийн сангийн нэгдсэн дансанд байршина.

21.2.Хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 5.3.7, 5.3.9, 5.3.10, 5.3.13, 5.3.20-д заасан тусгай сангийн мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн эрсдэл хамгийн бага байх хэлбэрээр удирдах үйл ажиллагааг санхүү, төсвийн болон тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран хэрэгжүүлнэ.

21.3.Энэ хуулийн 5.3.2, 5.3.15, 5.3.18-д зааснаас бусад тусгай санд зориулан ажлын алба байгуулахыг хориглоно. Ажлын албаны орон тооны хязгаарыг Засгийн газар батална.

21.4.Энэ хуулийн 5.3.15-т заасан тусгай сан нь хугацаа хэтэрсэн өр авлагыг барагдуулах зорилгоор дэргэдээ өр, авлага барагдуулах нэгжтэй байж болно.

21.5.Харъяалах төсвийн ерөнхийлөн захирагч нь тусгай сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтыг хариуцан удирдаж, энэ хуульд заасан журмын дагуу хяналт тавьж, тайлагнана.

21.6.Төсвийн ерөнхийлөн захирагчдаас энэ хуульд заасны дагуу тусгай санд төвлөрүүлэхээр төлөвлөсөн хөрөнгийн хэмжээг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Төсвийн тухай хуульд заасан журмын дагуу хянаж, тухайн жилийн төсвийн хүрээний мэдэгдэл болон улсын төсвийн төсөлд тусгана.

22 дугаар зүйл.Тусгай сангаас санхүүжилт хийх хэлбэр

22.1.Энэ хуулийн 3.2-т заасан тусгай сан болон энэ хуулийн 5.3.2, 5.3.5, 5.3.15-д заасан тусгай сангаас бусад тусгай сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилтийг тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрийг үндэслэн дараах хэлбэрээр олгоно:

22.1.1.урьдчилгаа олгож гүйцэтгэлээр санхүүжүүлэх буюу тухайн ажил, үйлчилгээний онцлог, шаардагдах хөрөнгийн хэмжээтэй уялдуулан үе шаттайгаар санхүүжүүлэх;

22.1.2.шууд санхүүжүүлэх буюу ажил, үйлчилгээг гүйцэтгэсний дараа санхүүжилтийг бүрэн хэмжээгээр нэг удаа олгох.

22.2.Засгийн газрын нөөц сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, гүйцэтгэх ажил, үйлчилгээний онцлог, зарцуулах хөрөнгийн хэмжээг харгалзан санхүүжилтийн хэлбэрийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

22.3.Засгийн газрын нөөц сангаас олгох санхүүжилтийг тухайн төсөл, арга хэмжээ, ажил, үйлчилгээг хэрэгжүүлж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүний харилцах дансанд шууд шилжүүлэхийг хориглоно.

22.4.Энэ хуулийн 5.3.15-д заасан тусгай сангаас олгох зээлийн санхүүжилтийг төслийн хэрэгжилттэй холбож олгох буюу зээлдэгчийн худалдан авалт, төслийн гүйцэтгэлээр олгоно.

22.5.Тусгай сангийн санхүүжилтийг Төсвийн тухай хуульд заасан журмын дагуу хийнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ

Тусгай сангийн тайлагнал, ил тод байдал, хяналт

23 дугаар зүйл.Тусгай сангийн тайлагнал, ил тод байдал

23.1.Төсвийн ерөнхийлөн захирагч нь тусгай сангийн зарцуулалтын тайланг хагас, бүтэн жилээр гаргаж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасан тайланд тусган санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

23.2.Тусгай сангийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэл, санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг холбогдох шийдвэрийн хамт тухайн шийдвэр гарсан сард нь нэгтгэн олон нийтэд нээлттэй тайлагнаж, Шилэн дансны тухай хуульд заасан журмын дагуу байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн цахим хуудсаар дамжуулан хуульд заасан хугацаанд тогтмол мэдээлнэ.

23.3.Тусгай сангийн зарцуулалтын тайланд Төрийн аудитын тухай хууль¹⁴д заасны дагуу аудит хийж, дүгнэлт гаргана.

23.4.Засгийн газрын нөөц сан, Төсвийн тогтворжуулалтийн сангийн зарцуулалтын тайланг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Төсвийн тухай хуулийн 54.4-т заасан тайланд тусгаж Засгийн газар болон Улсын Их Хуралд тайлагнана.

23.5.Тусгай сангийн жилийн эцсийн зарцуулалтын тайланг аудитын дүгнэлтийн хамт уг тайлан гарснаас хойш 20 хоногийн дотор байгууллагын шилэн данс, цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.

23.6.Энэ хуулийн 5.3.2, 5.3.15 болон 5.3.17-д заасан тусгай сан шинээр олгох зээлийн эх үүсвэрийн хэмжээ, сонгон шалгаруулалтын журам, тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг цахим хуудсаараа дамжуулан мэдээлж, мэдээллийг тогтмол шинэчилнэ.

23.7.Энэ хуулийн 5.3.2, 5.3.15, 5.3.17 болон 5.3.18-д заасан тусгай сангаас зээл, буцалтгүй тусламж, санхүүгийн дэмжлэг авахаар хүсэлт ирүүлсэн иргэд, хуулийн этгээдийн бизнес төлөвлөгөөгөө танилцуулах, түүнийг сонгон шалгаруулах, үнэлэх үйл явцыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нээлттэй, ил тод зохион байгуулна.

24 дүгээр зүйл.Тусгай сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих

24.1.Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасан журмын дагуу тусгай сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт, шалгалт хийнэ.

¹⁴ Төрийн аудитын тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2003 оны 2 дугаарт нийтлэгдсэн.

24.2.Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо шаардлагатай гэж үзвэл тусгай сангийн хөрөнгийн зарцуулалтын тайланг хэлэлцэж болно.

24.3.Засгийн газрын нөөц сангийн хөрөнгийн зарцуулалтын явцад санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина.

24.4.Төсвийн ерөнхийлөн захирагч нь Засгийн газрын нөөц сангийн санхүүжилтээр тухайн салбарт хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, хөрөнгийн зарцуулалтад хяналт тавина.

24.5.Энэ хуулийн 5.3.2, 5.3.15 болон 5.3.17-д заасан тусгай сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ сонгон шалгаруулах хороо, төслийн удирдах хороо болон хяналтын хорооны бүрэлдэхүүнд төрийн бус байгууллага, мэргэжлийн байгууллагын төлөөллийг оролцуулах ба тусгай сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагаанд хяналт тавихад олон нийтийн оролцоог хангана.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ **Бусад зүйл**

25 дугаар зүйл.Тусгай сангийн үйл ажиллагаанд хориглох зүйл

25.1.Тусгай сангийн хөрөнгийг батлагдсан төсвөөс хэтрүүлэх, хуульд зааснаас өөр зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно.

25.2.Тусгай сангийн эх үүсвэрээр төсөл, арга хэмжээ санхүүжүүлэх шийдвэр гаргах албан тушаалтан ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд¹⁵ заасан журмын дагуу тухай бүр авч хэрэгжүүлнэ.

26 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

26.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль¹⁶-д заасан хариуцлага хүлээлгэнэ.

26.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль¹⁷, эсхүл Зөрчлийн тухай хууль¹⁸-д заасан хариуцлага хүлээлгэнэ.

27 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

27.1.Энэ хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

¹⁵ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2012 оны 8 дугаарт нийтлэгдсэн.

¹⁶ Төрийн албаны тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2018 оны 01 дугаарт нийтлэгдсэн.

¹⁷ Эрүүгийн хууль - "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2016 оны 07 дугаарт нийтлэгдсэн.

¹⁸ Зөрчлийн тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2017 оны 24 дугаарт нийтлэгдсэн

ДАГАЛДАХ ХУУЛИЙН ТӨСЛҮҮД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар хот

**ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬ
ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр баталсан Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Засгийн газрын тусгай сангийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар хот

**ИРЭЭДҮЙН ТЭТГЭВРИЙН НӨӨЦ САНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ
ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. 2016 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр баталсан Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Засгийн газрын тусгай сангийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар хот

ӨРИЙН УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Өрийн удирдлагын тухай хуулийн 37 дугаар зүйлийн гарчгийг “Засгийн газрын өрийн баталгааны төлбөр гүйцэтгэх” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Өрийн удирдлагын тухай хуулийн 35.6 дахь хэсгийн “баталгааны санд” гэснийг, 37.1 дэх хэсгийн “Засгийн газрын өрийн баталгааны сангаас” гэснийг, 37.3 дахь хэсгийн “Засгийн газрын өрийн баталгааны сангаас” гэснийг, 37.5 дахь хэсгийн “сангаас” гэснийг, 34.3.4 дэх заалтын “сангийн” гэснийг тус тус хассугай.

3 дугаар зүйл. Өрийн удирдлагын тухай хуулийн 36 дугаар зүйл, 9.1.13 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Засгийн газрын тусгай сангийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар хот

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төсвийн тухай хуулийн 34.1.5 дахь зүйлийг “хууль болон гэрээнд зааснаар Засгийн газрын өрийн баталгааны төлбөрийн үүргийг гүйцэтгэхэд Засгийн газрын өрийн баталгааны хөрөнгө хүрэлцэхгүй болсон” гэж өөрчлөн найруулсугай.

2 дугаар зүйл. Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийг “хуульд өөрөөр заагаагүй бол зөвхөн дор дурдсан нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага энэ хуульд заасан журмын дагуу хандив, тусламж авч болно” гэж өөрчлөн найруулсугай.

3 дугаар зүйл.Төсвийн тухай хуулийн 8.4, 8.6, 8.8, 8.9, 21.1, 32.1 дэх хэсэг, 9.1.2, 12.1.2, 19.6.1, 42.3.3 дахь заалтын “төсөв, Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн төсөв,” гэснийг, 33.1 дэх хэсгийн “төсөв, болон Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн төсөв”, 71.5 дахь хэсгийн “8 дугаар зүйлийн 8.4, 8.6 дахь хэсэг, мөн зүйлийн 8.6.3 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.6.1 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэг, 42 дугаар зүйлийн 42.3.3 дахь заалтын “Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн” гэснийг, 8 дугаар зүйлийн 8.8, 8.9 дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалтын “Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн төсөв,” гэснийг, 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн “болон Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн” гэснийг 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс” гэснийг, 8.6.3 дахь заалтын “Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн жилийн төсөв,” гэснийг тус тус хассугай.

4 дүгээр зүйл.Төсвийн тухай хуулийн 4.1.54 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг Засгийн газрын тусгай сангийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар хот

**ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬ
ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдөр баталсан Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Засгийн газрын тусгай сангийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар хот

**АГААРЫН БОХИРДЛЫН ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 5.6 дахь хэсэгт “Агаарын бохирдлын эсрэг санд” гэснийг “Байгаль орчин, уур амьсгалын санд” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Засгийн газрын тусгай сангийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар хот

**АГААРЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗҮЙЛИЙГ ХҮЧИНГҮЙ
БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Агаарын тухай хуулийн 29¹ дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Засгийн газрын тусгай сангийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар хот

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 11 дүгээр зүйлийн гарчиг болон 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан” гэснийг “Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих сан” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсгийн “14.6-д” гэснийг “16.8-д” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.7 дахь хэсгийг “Сангаас олгох зээлийг банкаар дамжуулж олгоно. Банкйг сонгон шалгаруулахдаа Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.9 болон 16.10-т заасан шаардлагад нийцүүлнэ” гэж өөрчлөн найруулсугай.

4 дүгээр зүйл. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4, 11.8, 11.9 ба 11.10 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1.2.в ба 8.1.2.г дахь дэд заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл. Энэ хуулийг Засгийн газрын тусгай сангийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар хот

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн 5.1.4 дэх хэсгийг “Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих сан” гэж Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.3.15-д заасныг” гэж өөрчлөн найруулсугай.

2 дугаар зүйл.Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, 13 дугаар зүйлийн 13.2, 13.3 ба 13.4 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Засгийн газрын тусгай сангийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар хот

ТАРИАЛАНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Тариалангийн тухай хуульд дор дурдсан утгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/19 дүгээр зүйлийн 19.12 дахь хэсэг:

“19.12.Тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харъяанд тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих чиг үүрэг бүхий төрийн өмчит хуулийн этгээдийг Засгийн газрын тогтоолоор байгуулна. Төрийн өмчит хуулийн этгээд нь энэхүү хуулийн 19.3-т заасан эх үүсвэрээс санхүүжиж болох бөгөөд энэ хуулийн 19.5.1, 19.5.2, 19.5.6-19.5.8-д заасан арга хэмжээг санхүүжүүлж болно.”

2/19 дүгээр зүйлийн 19.13 дахь хэсэг:

“Энэ хуулийн 19.5.3-19.5.5-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор олгох хөнгөлөлттэй зээлийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан тусгай сангаас санхүүжүүлнэ.”

3/19 дүгээр зүйлийн 19.3.5 дахь заалт:

“19.3.5.өөрийн үйл ажиллагаанаас олох орлого”

4/19 дүгээр зүйлийн 19.5.7 дахь заалт:

“19.5.7.Тариалангийн үйл ажиллагааг дэмжихэд шаардлагатай зардлыг санхүүжүүлэх;”

5/19 дүгээр зүйлийн 19.5.8 дахь заалт:

“19.5.8.Энэ хуулийн 19.12-т заасан байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй барилга, байгууламж, техник тоног төхөөрөмжид засвар үйлчилгээ хийхэд шаардагдах зардлыг санхүүжүүлэх.”

2 дугаар зүйл. Тариалангийн тухай хуульд дор дурдсан утгатай үг нэмсүгэй:

1/19 дүгээр зүйлийн 19.5.2 дахь заалт:

“19.5.2 дахь заалтын “нөхөн сэргээх” гэсний дараа “тариалангийн үйлдвэрлэлийг технологийн хугацаанд явуулахад шаардлагатай шатахууны зээл олгох”

3 дугаар зүйл. Энэ хуулийг Засгийн газрын тусгай сангийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар хот

УСНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Усны тухай хуульд дор дурдсан утгатай зүйл, заалт нэмсүгэй:

1/10¹ дугаар зүйл:

“10¹. дүгээр зүйл. Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх:

10¹.1. Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь усны харилцааны асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10¹.1.1. бэлчээрийг усжуулах зориулалтаар инженерийн хийцтэй худаг байгуулах, уст цэг тогтоох хайгуулын ажлыг улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх төлөвлөгөө боловсруулах, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах.

10¹.1.2. инженерийн хийцтэй худаг, энгийн болон инженерийн хийцтэй услалтын системийн барилга байгууламжийг ашиглах, эзэмших, шинээр барих, сэргээн засварлахтай холбогдсон журам, зааврыг боловсруулж, батлах.”

2/3 дугаар зүйлийн 3.1.35 дахь заалт:

“3.1.35. “уст цэг” гэж булаг, худаг, цооног, усан сан, хөв, цөөрмийг;

3/3 дугаар зүйлийн 3.1.36 дахь заалт:

“3.1.36. “худаг” гэж бэлчээр, хадлангийн талбайн усан хангамжийн зориулалттай инженерийн хийцтэй худаг;”

2 дугаар зүйл. Усны тухай хуулийн “10 дугаар зүйлийн 10.1.3-т заасан “уст цэг” гэсний дараа “инженерийн хийцтэй худаг” гэж, “усны барилга байгууламжийг” гэсний дараа “шинээр барих, сэргээн засварлах” гэж, “ашиглах, эзэмших” гэсний дараа “санхүүжүүлэх” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Засгийн газрын тусгай сангийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар хот

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “12 дугаар” гэснийг “7 дугаар” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 10 дахь хэсгийн “12 дугаар” гэснийг “7 дугаар” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 11 дэх хэсгийн “Байгаль хамгаалах журмын эсрэг” гэснийг “Хүрээлэн байгаа орчны эсрэг” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 9 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл. Энэ хуулийг Засгийн газрын тусгай сангийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар хот

**ОЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Ойн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.5 дахь хэсгийн “5.4.2-т заасан” гэснийг “5.3.1-т заасан” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Засгийн газрын тусгай сангийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар хот

**ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Тамхины хяналтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийг “Сан нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэгт заасан эх үүсвэрээр бүрдэнэ” гэж өөрчлөн найруулсугай.

2 дугаар зүйл. Тамхины хяналтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсгийг “Сангийн хөрөнгийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэгт заасан зориулалтаар зарцуулна” гэж өөрчлөн найруулсугай.

3 дугаар зүйл. Тамхины хяналтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Засгийн газрын тусгай сангийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар хот

**АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8 дахь заалтыг “Спортыг дэмжих санд спортын холбоо, клубийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор өгсөн 10 сая хүртэлх төгрөгийн хандив” гэж өөрчлөн найруулсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Засгийн газрын тусгай сангийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар хот

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл.Засгийн газрын тусгай сангийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр үйлчилж эхлэхээс өмнө санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай байгуулсан дамжуулан зээлийн гэрээгээр гадаадын зээл, тусламжийн хүрээнд олгосон тоног төхөөрөмж, техник хэрэгсэлтэй холбоотойгоор Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас олгосон санхүүгийн түрээсийн зээлийн эргэн төлөлтийг тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих чиг үүрэг бүхий төрийн өмчит хуулийн этгээдэд төвлөрүүлнэ.

2 дугаар зүйл.Засгийн газрын тусгай сангийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр үйлчилж эхлэхээс өмнө Мал хамгаалах сан, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгосон улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн санхүүгийн түрээсийн зээлийн эргэн төлөлтийг Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих санд төвлөрүүлнэ.

3 дугаар зүйл.Засгийн газрын тусгай сангийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 3.2 дахь хэсэг болон 23.4 дэх хэсэгт “Төсвийн тогтворжуулалтын сан” гэснийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

4 дүгээр зүйл.Засгийн газрын тусгай сангийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 15 дугаар зүйлийг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл дагаж мөрдөнө.

5 дугаар зүйл.Энэ хуулийг Засгийн газрын тусгай сангийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг



6.ТООЦООЛЫН ХАВСРАЛТУУД

	НЭГДСЭН ТӨСӨВ	УЛСЫН ТӨСӨВ	НДС	ЭМДС	ОРОН НУТАГ
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	31.71	23.84	6.62	1.25	8.11
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	0.31	0.31	0.00	0.00	0.00
ИРЭЭДҮЙН ӨВ САН	2.40	2.40	0.00	0.00	0.00
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	29.00	21.13	6.62	1.25	8.11
1. Татварын орлого	26.19	17.04	5.63	1.25	3.25
1.1. Орлогын албан татвар	6.80	4.55	0.00	0.00	2.25
1.1.1. Хувь хүний орлогын албан татвар	2.25	0.00	0.00	0.00	2.25
1.1.2. Аж, ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар	4.55	4.55	0.00	0.00	0.00
1.1.3. Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	0.00	0.00	0.00	0.00	0.00
1.2. Нийгмийн даатгалын орлого	5.91	0.00	5.63	1.25	0.00
1.3. Хөрөнгийн албан татвар	0.41	0.00	0.00	0.00	0.41
1.4. Нэмэгдсэн өртгийн албан татвар	6.45	6.45	0.00	0.00	0.00
1.5. Онцгой албан татвар	2.34	2.34	0.00	0.00	0.00
1.6. Тусгай зориулалтын орлого	0.04	0.04	0.00	0.00	0.00
1.7. Гаалийн албан татвар	2.15	2.15	0.00	0.00	0.00
1.8. Бусад татвар (төлбөр, хураамж)	2.10	1.51	0.00	0.00	0.59
2. Татварын бус орлого	2.81	4.09	0.98	0.00	4.86
2.1. Нийтлэг татварын бус орлого	2.44	2.12	0.00	0.00	0.31
2.2. Хөрөнгийн орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
2.3. Тусламжийн орлого	0.37	0.37	0.00	0.00	0.00
2.4. Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.00	1.60	0.98	0.00	4.55
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	34.10	26.68	6.17	1.25	8.11
А. УРСГАЛ ЗАРЛАГА	24.43	18.54	6.17	1.25	6.58
1. Бараа, үйлчилгээний зардал	11.72	7.21	0.07	0.01	5.16
1.1. Цалин, хөлс	6.46	3.46	0.04	0.00	2.95
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл	0.00	0.33	0.01	0.00	0.40
1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал	5.26	3.43	0.02	0.01	1.81
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	2.36	2.36	0.00	0.00	0.00
3. Татаас ба урсгал шилжүүлэг	10.35	8.97	6.10	1.23	1.42
3.1. Татаас	0.77	1.39	0.00	0.12	0.24
3.2. Урсгал шилжүүлэг	9.58	7.57	6.10	1.11	1.18
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9.04	7.51	0.00	0.00	1.53
1. Барилга байгууламж	6.05	5.95	0.00	0.00	0.10
2. Их засвар	0.30	0.30	0.00	0.00	0.00
3. Тоног төхөөрөмж	0.91	0.91	0.00	0.00	0.00
4. Бусад хөрөнгө	1.74	0.31	0.00	0.00	1.43
5. Стратегийн нөөц хөрөнгө	0.04	0.04	0.00	0.00	0.00
В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	0.63	0.63	0.00	0.00	0.00
1. Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл	-0.07	-0.07	0.00	0.00	0.00
2. Эргэж төлөгдөх гадаад цэвэр зээл	0.70	0.70	0.00	0.00	0.00
ТӨСВИЙН ТЭНЦЭЛ (ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГООР ТООЦСОН)	-5.10	-5.54	0.45	0.00	0.00
ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН	40,683,122.5	40,683,122.5	40,683,122.5	40,683,122.5	40,683,122.5

МОНГОЛ УЛСЫН 2020 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ҮР ДҮНГИЙН ТЭЗҮҮЛЭЛТ

	Саяагаар / 100,000,000 MNT												ДНБ-д эзлэх хэмжээ (%)														
	2012			2013			2014			2015			2016			2017			2018			2019			2020		
	Гуяц	Гуяц	Төсөл	Гуяц	Гуяц	Төсөл	Гуяц	Гуяц	Төсөл	Гуяц	Гуяц	Төсөл	Гуяц	Гуяц	Төсөл	Гуяц	Гуяц	Төсөл	Гуяц	Гуяц	Төсөл	Гуяц	Гуяц	Төсөл	Гуяц	Гуяц	Төсөл
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН																											
ТОТОРЖУУЛАЛТЫН САН																											
ИРЭЭДЭЙН ӨВ САН																											
ТӨСВИЙН ТЭНЦЭЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН																											
1. Татварын орлого																											
1.1. Орлогын албан татвар																											
1.1.1. Хувь хүний орлогын албан татвар																											
1.1.2. Аж, ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар																											
1.1.3. Зарим бүтээгдэхүүний үнийн осалтийн албан татвар																											
1.2. Нийгмийн даатвалын шилгэл, хураамж																											
1.3. Хөрөнгийн орлогын албан татвар																											
1.4. Наяагдсан өргөний албан татвар																											
1.5. Онцгой албан татвар																											
1.6. Тусгай зориулалтын орлого																											
1.7. Гаалийн албан татвар																											
1.8. Бусад татвар (төлбөр, хураамж)																											
2. Татварын бус орлого																											
2.1. Нийтлэг татварын бус орлого																											
2.2. Хөрөнгийн орлого																											
2.3. Түрэмжийн орлого																											
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (ТЭНЦЭЭРЖҮҮЛСЭН ОРЛОГОД НИЙЦҮЛСЭН)																											
А. УРСГАЛ ЗАРЛАГА																											
1. Баруа, үйлчилгээний зардал																											
1.1. Цалин, хөлс																											
1.2. Бараа, үйлчилгээний бусад зардал																											
2. Зээлийн үйлчилгээний төлбөр																											
3. Тагаас ба урсгал шилжүүлэлт																											
3.1. Тагаас																											
3.2. Урсгал шилжүүлэлт																											
Б. ӨРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ																											
1. Барилга байгууламж																											
2. Илчлэвэр																											
3. Тонг төхөрөмж																											
4. Бусад хөрөнгө																											
5. Стратегийн нөөц хөрөнгө																											
6. Төсвөөс эргэн төлөгдөх хөрөнгө оруулалт																											
1. Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл																											
